

Ц.Дэмбэрэл

**МОНГОЛЧУУД ОЮУНЫ  
ЧАДАВХИАРАА ДЭЛХИЙД  
ТЭРГҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ**

Улаанбаатар хот

Ц.Дэмбэрэл

## **МОНГОЛЧУУД ОЮУНЫ ЧАДАВХИАРАА ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ**

Эхийг хэвлэлд бэлтгэсэн Т.Батчимэг

Хавтасны зургийг Г.Баяр

Хавтасны зургийн тайлбар:

*Боломжгүй цонхны тавцан дээр боломжгүй шоо барин  
бодлогоширон суугаа бяцхан эр бодит амьдралд  
тааралдах уу?*

Хан-Уул дээд сургууль дээр эхийг бэлтгэж, Ган Принт ХХК-д хэвлэв.

## Оюун ухааны чиглүүлэгч

Олон нийтэд хэн болохоо харуулж яваа хүний нэг бол Цэрэнгийн Дэмбэрэл. Түүний хүчин чармайлт манай боловсрол, оюун сэтгэлгээний салбарт хамааралтайгаар хурц тод илэрч байна. Өргөн хүрээний сонирхолтой тэрбээр оюуны салбарыг өөрийн орон зайгаа болгон сонгожээ. Өнөөгийн дэлхий ертөнц оюунжихын “ ариун дайн” —ы хөлд дарагдаад байна. Монгол ч мөн тийм аянд морджээ. Дэлхийн болон үндэсний энэхүү эрчимт хандлагад Ц.Дэмбэрэл манлайлах үүрэгтэй оролцохыг зорилгоо болгосон аж. Ингэснээрээ тэр хүний хөгжлийн асуудлыг сууриар нь барьж авсан манай бараг ганц хүн боллоо. Тэр 1990 оны үеэс нийгэмд зугуухан ил гарч ирсэн. Орчлонт ертөнцийн үүсэл гарвал, зүй тогтлын тухай түүний бичсэн өгүүллүүд нь уншигчдаас өндөр үнэлэлт авч эхэлсэн юмдаг. Гэхдээ тэр үед одоохтой нь харьцуулахад тэр хэн ч биш байсан. Харин тэр сэтгэлгээний хувьд биежиж улам тодорхой болсоор байв. Түүнд манай эдийн засагт онцгой анхаарч байсан үе бий.. Монголын эдийн засагт шугаман бус шинж илэрсээр байгааг тэмдэглэн, тодорхойгүй төлөв байдал удаан үргэлжлэвэл сүйрэлд хүргэдэг тухай онолоор П. Жасрайн Засгийн газрын эдийн засгийн бодлогыг авч үзэж байсан нь содон, шинэлэг байв. Ганц хоёрхон төрлийн экспорт шүтдэг улс орон нэг л өглөө босоход хорвоо эргэчихсэн мэт болдог бусдын гашуун сургамжийг тэр нийгэмд сануулж байсан. Түүний тэдгээр шүүмжлэлт сануулгууд одоо ч хуучирч улиг болоогүй шив шинэхнээрээ л байна. Энэ бол алсыг харах чадвар, тогтвортой бөгөөд жинтэй үндэслэл эзэмшсэнийх юм. Тэгэхэд л тэр оюун санааны хөдөлмөртөө нэгэнт батлагдчихсан шинжлэх ухааны сонгомол аргагүйг ашигладаг, жишээ баримтыг дэлхийн хаа нэгтэйгээс олдог цар хүрээтэй нэгэн болохоо харуулж байв.

---

1993, 1994 оноос тэрвээр дэлхийн боловсролын тогтолцоонд бидний анхаарлыг хандуулж, монголын дээд боловсролд Кредит үнэлгээний технологийг оруулж ирсэн бөгөөд бүр цаашлан элит боловсрол олгодог тийм нэгэн нууцлаг супер төвүүд Америк, Япон бусад улсад байдаг юм байна шүү, одоо манайх яах вэ?, ингэвэл онох юм биш биз? гэж бичиж, анхааруулж байлаа. Оюуны сонирхолтой хүмүүс Дэмбэрэлийг адармаатай өвөрмөц бөгөөд үр ашигтай хурц сэтгэдэг хүн гэж хэлдэг бол прагматикууд түүнийг бодож олсноо амьдруулдаг хүн гэж үнэлдэг. Цэцэн мэргэн ухаан, сэтгэгч гэдэг заавал эртний цаг үед хамааралтай биш бидэнтэй хамт ч сэтгэгчид байна, жишээлбэл, Хан-Уулын Дэмбэрэл байна гэж Доржийн Эрдэмбилэг хэмээх хүн хэлж байсан. Яруу найрагч Гун-Аажавын Аюурзана Дэмбэрэлийг сэтгэгч хэмээн нэрлэж хүний оюун санааны амьдралын нарийн ширийн асуудлаар түүнтэй ярилцлага хийж байв. Эрчим хүч зохицуулах газрын мэргэжилтэн Д. Лувсаншарав түүнийг номлолоо бодит соён гэгээрүүлэх ажилтай амьд холбосон үлэмжхэн бүтээлч сэхээтэн гэж үзэж байгаа юм. Чулуунбатын Эрдэнэ вээр Дэмбэрэлийг “Олон талын эрэлт сонирхолтой хурц судлаач” гэсэн. Ингэж тэр нийгэмд илт танигдаж, нийтэд тустай амьдарч хүмүүсээр хүрээлүүлж явна. Гэхдээ энэ хэлхээ холбоо, харилцан үйлчлэл нь өргөн хүрээтэй, хэтийн төлөвтэй, өөрийн түвшинтэй юм. Дэмбэрэлийг тодорхойлж буй дээрх хүмүүс ч оюун ухааны салбарт дур сонирхолтой, тэр чиглэлд ажилладаг өөр өөрийн үүрэгтэй, хүрээлэлтэй гэрэл гэгээтэй билээ.

Нийтэд танигдсан хүний мөн чанар нь цаад уг гаралтайгаа холбоотой байдаг нь гарцаагүй. Дэмбэрэл 1950-иад оны дундуур Увсад төржээ. Эцэг тал нь Чингүнжавын хотгойд, эх тал нь Завханы сартуул аж. Түүний эх нь эцгээс нь үе мултарсан эгч байж. Тэр эцгийгээ 20 хүрээгүй байхад, харин эхийгээ гучин хэдтэй байхад энэ хорвоод иржээ. Ховор тохиолдох насны энэ зөрүү Дэмбэрэлийг сонирхолтой хүн болоход генийн өгөгдөхүүн болсон байж болох уу? Ямартай ч түүний эх болон нагац талынхан нутагтаа алдартай цэцэн цэлмэг, ухаалаг хүмүүс байж. Эхийн гал халуун илч хүч, ухаан сэтгэхүйн боломж хүүд өвлөгдсөн байж болох. Түүний хүүхэд нас сонирхолтой шүү. Хэлд орохоосоо өмнө дохио зангаагаар санаагаа дажгүй илэрхийлдэг байж, ердөө л долоохон хоногийн дотор дуржигнатал ярьж сурсан гэдэг. Багаасаа мэдэгдэм өвөрмөц хүүхэд байсан учир ах Уртнасан нь элдэв бодлого бодуулан оюун ухааныг нь хөгжүүлэн задалж байжээ. Дэмбэрэл таван

ойтойдоо сургуульд орсон, улсын математикийн 8-р олимпиадад түрүүлсэн, хоёр их сургууль төгссөн, гурван дээд мэргэжил эзэмшсэн хүн. Тэрээр ШУА, МУИС-д ажиллаж байгаад Хан-Уул дээд сургууль байгуулсан нь түүнээс оюун санааны чиглэлд тавьж байсан эрмэлзлэлийн бодит биелэл болсон байна. Хан-Уулын төгсөгчдөд ажил олдохгүй байхын зовлон үгүй аж. Тэд банк болон эдийн засгийн байгууллагууд, програм хангамжийн салбаруудад сайтар бэлтгэгддэг байна. Одоогийн Хан-Уул манай боловсрол, оюуны салбарын нэгэн өвөрмөц цөм болжээ. Энэ хамт олон 2001 онд Монголын эдийн засгийн сэтгэлгээний шинэчлэлийг зарлан тунхагласан билээ. Тэд шинэ эриний оюунлаг эдийн засагчдыг бэлтгэдэг онцлогтой. Хан-Уулын хоёр залуу багш энэ оны ЭВРИКА эрдэм шинжилгээний уралдааны хоёр салбарт хоёуланд нь түрүүлжээ, багш нар нь энэ зун НҮБ-ийн АНДОЭЗНК-ийн захиалгаар “ Монгол улсад даяарчлалын удирдлагын чадавхи буй болгох нь : үнэлгээ, судалгаа “ төслийг гүйцэтгэж Гадаад хэргийн яаманд гэрээний дагуу шилжүүлсэн байна. Мөн энэ сургууль дээр “Ирээдүй судлалын төв”, “Оюуны хөгжлийн IQ төв” ажиллаж, “Математик” сонин хэвлэгдэж байна. Эдгээр байгууллагууд “монголыгоо оюунжууля” уриан дор нэгдсэн байна. Эдүгээ Оюуны хөгжил-IQ хичээлд бүх аймгийн төв, 200-аад сум, 3000 хол давсан багш, 25000 орчим сурагч хамрагджээ. Зөвхөн сүүлийн хоёр жил эднийх оюун ухаан, сэтгэхүй, хүнийг төгөлдөржүүлэхийн холбогдолтой дэлхийн түвшний шилдэг ном 20 гаруйг хэвлүүлсэн юм. Дэлхийд сэтгэлгээний ур чадварын төвийг тэргүүлж буй эрдэмтэн Эдвард де Боногийн номыг тэднийхэн саяхан орчуулжээ. Бас түүний бие төлөөлөгчтэй сургуулийн багш нар нь уулзаад санал солилцсон байна. Хан-Уул дээд сургуулийн энэ бүтээлч цогцолбор бүрдэл нь захирлын чин эрмэлзлэлийн илрэл дүр төрх юм. Удирдлага нь хэн байна, сургууль нь тийм байдаг гэдэг. Тэрвээр боловсролыг академик болон прагматик 2 туйлшралаас нь салгаж, жинхэнэ бүтээлч, оюунлаг болгохыг туйлаас эрмэлзэж байгаа хүн. Ингэхдээ дэлхийгээс, тухайлбал, оюуны хүрээнд Америкаас суралцахыг уриалж байна.

Сургалтыг огцом өөрчилж улмаар оюунжсан, бүтээлч сэтгэлгээтэй боловсон хүчин бэлтгэж болдгийг энэ эрхэм өөрийн сургуулиар нэгэнт нотолжээ. Гэвч үүндээ доктор маань сэтгэл ханасангүй. Түүний оюун ухаан сэтгэлгээний хүрээг хамарсан баталгаа нотолгоо ихтэй урамтай лекцүүд оюутан багш нарын эрэлт хэрэгцээ болж байна. Туурвисан ном, өгүүлэл,

лекцүүд нь дэлхийн тэргүүлэх онол баримтад тулгуурласан, оюуны эрх чөлөөг тунхагласан, монгол хүний унаган чадварыг дээдэлсэн, нийгмийн сэтгэлгээг эрүүлжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Цаг үеэ эзэлсэн ийм оюуны ажилбар бүтээх нь ховор тохиолдол. Ямартай ч энэ цаг үе Дэмбэрэлийг төрүүллээ, Профессор Дэмбэрэлийн бүтээлч үйл ажиллагаа манай нийгмийн цэгцрэн төгөлдөржихөд жинтэй хувь нэмэр оруулах нь гарцаагүй болов. Монголыг оюунжуулах амин судас энэ хүний гарт тэмтрэгдсэн бололтой, тэгвэл юутай сайн, Монголд оюуны сэргэн мандалт ирэх ч юм билүү?, доктор, профессор Цэрэнгийн Дэмбэрэлийг оюун ухааны чиглүүлэгч хэмээсний учир энээ.....

Олон улсын сэтгүүлч,  
Бөхөл овогт Шагдарсүрэнгийн Цэрэнпил

## Монгол улсын иргэдээ!

Монголчууд нь төрөлхийн оюуны өндөр чадавхитай үндэстэн ажээ. Үүнийг барууны эрдэмтдийн судалгаа нотлов. Үүнийг манай орны улс төр, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлсэн, өөрчлөлт шинэчлэлийн өвөрмөц амжилт нотлов... Үүнийг монгол хүнтэй уулзаж ярилцсан, дэлхийн нэрт улс төрчид хэлэх болов... Үүнийг монгол залууст хичээл заасан гадаадын профессорууд хүлээн зөвшөөрч байна. Хөршүүд маань бидний тухайд “Монголчуудын арга ухаан гүйцэгдэшгүй” гэдэг. Энэ нь эрхбиш нэгийг өгүүлнэ.

Оюуны төрөлхийн өндөр чадавхи, билиг ухааныг эрхэмлэн дээдлэх нандин чанар бол монголчуудын үндэстний бахархал төдийгүй XXI зуунд та бидний өмнөө барьж урагшлах нэрийн хуудас, туг мөн.

Монголчууд эрт дээр үеэс оюун ухааныг эрхэмлэн шүтэж, түүнийг цаг хугацаа ба орон зайн хослолд гайхалтай мэргэнээр томъёолон баталгаажуулсан нь Мөнх тэнгэрийн хүчин дор, Их суу залийн эгээгэн дор болой.

Модун шаньюй, Чингис богд, Хувилай сэцэн, бичгийн их мэргэд В.Инжинаш, Бямбын Ринчин, төрийн холч хараатай улс төрчид оюун билгийг өргөмжлөн тахидаг байж.

Эдүгээ цаг дор манай эрдэмтэд, улс төрчид, төрийн албан хаагчид, хөдөлмөрчид нөхцөл байдлыг ухаалгаар мэдэрч, оюун билгийг дээдлэх болон “Оюуны хөгжил- IQ” хичээлийн ач холбогдлын талаар урамтай сайхан үг хэлж, ард түмнээ уриалан дуудах боллоо. Тухайлбал:

Оюун ухаан бол хөгжлийг тэтгэх мөнхийн хөдөлгүүр юм.

*П.Очирбат (Монгол улсын анхны ерөнхийлөгч)*

Хүмүүн төрөлхтөн хүний хөгжлийн тулгуур үндсийн нэг болсон оюуны хөгжлийг эрхэмлэн дээдэлж, оюун ухаан-сэтгэлгээ-мэдлэг-боловсрол хэмээх бие биеэс нарийн хамааралтай эрэмбэлэгдсэн орчилд хүний оюуныг идэвхжүүлэх өвөрмөц арга барилыг бий болгосноор хөгжил дэвшлийн үсрэнгүй амжилт олсон билээ.

*Н.Багабанди (Монгол улсын ерөнхийлөгч)*

...Монгол орон оюун ухааныг шүтэж сэргэн мандана.

*Д.Бямбасүрэн (Монгол улсын 17 дахь ерөнхий сайд)*

Билиг оюунаа хурцлан хөгжүүлэхийн хамт, бүтээлчээр сэтгэх урлагт шамдан суралцах хэрэгтэй.

*Н.Энхбаяр (Монгол улсын 23 дахь ерөнхий сайд)*

Оюун ухааны чадавхи (IQ) бол өмнөхөөсөө өвлөж, өөрөө өргөжүүлж, дараагийнхдаа дамжуулдаг, өсдөг, өргөждөг, сэлбэгддэг, сэргээгддэг, төрмөл бөгөөд таримал баялаг мөн.

*Л.Түдэв (Хөдөлмөрийн баатар, төрийн соёрхолт, эрдэмтэн-зохиолч)*

Саад бэрхшээлийг оюуны ачаар л даван туулна.

*Л.Шагдар (Ардын багш, академич)*

Үдээстэй цаас мэт хуулийн хүчин чадал мэргэшсэн хуульчийн оюунаар амилна.

*Г. Совд (Үндсэн хуулийн цэцийн анхны дарга,  
гавъяат хуульч, профессор)*

Бид супер компьютер бүтээж чадахгүй, дуунаас хурдан онгоц үйлдвэрлэж чадахгүй. Ийм болохоор монголчууд оюуны салбарт хүчээ үзэж болох цорын ганц түүхэн боломж үлдэж байна.

*Х.Намсрай (Төрийн соёрхолт, академич, онолын физикч)*

Оюун ухаанаа хөгжүүлэх нь насан туршийн үйлс мөн. Шинжлэх ухаан түргэн хөгжиж, мэдлэг түргэн хуучирч байгаа өнөө үед сэтгэлгээгээ байнга хөгжүүлж байхыг сурагч багачуудаасаа хүсье.

*А.Цанжид (БСШУ-ны сайд (2000-2004 он))*

Билиг ухаанаа ирлэн байж бусдын зэрэгт хүрнэ. Оюун ухаанаа ямагт бялдаржуулж бай гэж залуу үеийнхэндээ зөвлөө.

*Ж.Болдбаатар (академич, түүхч)*

Сургуулийн мэдлийн цагийг сурагчдын оюун ухаан, IQ-г өсгөхөд зориулах ёстой.

*Г.Батболд (БСШУЯ-ны Бага дунд боловсролын  
бодлого зохицуулалтын газрын дарга(2000-2004 он))*

Одоо цагт оюунлаг нөхдөө бүхнээс дээдэлдэг боллоо. Оюун ухаан нь хөгжлийн эх булаг гэж ойлгосных..

*Б.Гүнжилам (Хөдөлмөрийн баатар, төрийн шагналт, нэхмэлчин)*

Монголчууд олон зууны туршид эх орон, улс үндсээ эзэгнэн хамгаалсаар XXI зуунтай золгов. Бидний туулсан зам толигор дардан байсангүй. Та бид байгаль, нийгмийн хувьсал, дарамт шахалтад өртөж, хатуу бэрхийг даван

туулж, тэвчээр хатуужилтай, хүлээцтэй, ухаалаг чанарыг өөртөө шингээж, сэтгэлийнхээ хүчээр мянгыг дийлсээр цагийн сорилтыг давлаа.

Монголчууд харийн орны нөлөөгөөр өөрсдийнхөө оюунлаг дээд хэсгийг удаа дараа хэлмэгдүүлэн ширвүүлсэн хэдий ч үе удмаа залгуулан төлжүүлсээр энэ цаг үетэй золголоо.

Бурхнаас заяасан төрөлх нутгийнхаа байгаль, дэлхийг хайрлан хамгаалж, шүтэн дээдэлж, зохицон амьдрах их чадвар нь монголчуудын оюун ухааны төрмөл шинж мөн ажээ. Монгол хүн оюун ухааныхаа энэ сайхан чанарыг улам хөгжүүлэн бүтээлчээр ашиглах аваас эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулах эрхэм дээд зорилгоо эндэлгүй биелүүлж чадах билээ. Монголын эдийн засаг тогтворжих хэрээр төрөөс явуулах хөгжлийн бодлогын гол ноён нуруу аажмаар тодорч байна. Тэр нь оюун ухааныг эрхэмлэн дээдлэхэд орших ажээ.

Монгол хүн өөрийгөө дахин шинээр нээж, оюун ухааныхаа онцгой давуу талыг мэдэрч, ашиглаж чадвал эх орон маань богино хугацаанд цэцэглэн хөгжих бүрэн боломжтой. Монголчуудыг оюун ухаан нэгтгэн зангидаж, хурдтай, тулхтай хөгжил рүү чиглүүлж байна. Одоогийн даяаршиж буй дэлхий ертөнцөд аль ч үндэстэн хөгжил дэвшлийн замыг олж, аз жаргалтай амьдрахын үндсэн нөхцөл нь оюуны хөгжил мөн гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Монгол улсын Оюуны чадварын IQ төвийн сүлжээ 2002 оноос тус улсын бүх аймаг, хотыг бүрэн хамарсан бөгөөд эдүгээ 20000 гаруй сурагч багачууд, 1000 гаруй багш нарын удирдлагаар Оюуны хөгжил- IQ хичээлд идэвхийлэн суралцаж байна.

Эдгээр багш, сурагчид оюуны чадавхиа өсгөхийн сацуу бүтээлчээр сэтгэх шинэлэг арга загваруудыг эзэмшиж, цаашдаа илүү үр нөлөөтэй ажиллаж амьдрах нөөц боломжоо нэмэгдүүлж байгаа юм.

Ийнхүү **Монгол улсад оюуны мандал бадралын шинэ үе эхэллээ.**

Монголчууд бид хөдөлмөр бүтээлээ улам оюунжуулж, хөгжил дэвшлээ тогтворжуулж, бие сэтгэл, байгаль дэлхийгээ ариусгаж, тогтвортой хөгжлийн боловсролоор түмэн олноо гэгээрүүлж, хөгжлийн манлайд хүрэх нь энэ зуунд бүтээх эрхэм их үйлс мөн бөлгөө. Үүнийг ухаарагтун.

Монголчууд аа! Хайрт эх орондоо оюуны сэргэн мандлын үрийг хамтын хүчээр тарьцгаая. Энэ чухал үйлсэд хүн бүрийн хүчин зүтгэл хэрэгтэй болохыг санагтун. Бидний улс оюун ухааныг эрхэмлэн дээдлэж, эв санаагаа нэгтгэн зүтгэвээс хүрэхгүй чадахгүй гэх газаргүй бөгөөд цэнгэлийн манлайг олж чадмой.

## *МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫГ ОЮУНЖУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛД*

---

Одоогийн монголын боловсрол нь ерөнхий, тусгай, дунд, дээд аль ч шатандаа ихээхэн хийсвэр шинжтэй байна. Энэ нь монголд академик боловсролыг он удаан жил бурханчлан шүтэж ирсэнтэй холбоотой юм. Академик боловсролыг ингэж бурханчлан шүтэх эдийн засгийн хөрс суурь байсан юм. Манжийн колончлолоос гарсны дараа марксист үзлийг хүлээн авч түүнд тулгуурласан боловсролын хөгжлийн үзэл баримтлалыг ашигласан билээ. Энэхүү марксист үзэл баримтлалын үндсэн санааг “Матери анхдагч, ухамсар хоёрдогч, иймд материаллаг талаа хөгжүүлчихвэл түүндээ тулгуурлаад ухамсар нь хөгжчихнө. Ерөөсөө ухамсрын хөгжил нь нийгмийн хөгжилд төдий л даацтай нөлөө үзүүлдэггүй. Учир иймд харин ч ухамсрын асуудлыг анхаарахгүй байх нь зүйд нийцнэ, ухамсар нь хөгжиж өөрчлөгдсөн хүн л элдвийн үг хэл гаргаж, жижиг хөрөнгөтний үзэл санааг номлодог. Иймээс боловсролыг бүхий л шатанд нь аль болох оюунжуулахгүйг эрмэлзэх ёстой” хэмээн томьёолж болно.

XIX зууны дунд үе буюу 1860-аад оны үед энэхүү үзэл баримтлал баруун Европд үеэ өнгөрөөсөн байна. Харамсалтай нь Монгол Улсын боловсролын тогтолцоонд одоо хүртэл хадгалагдан хэвээр үргэлжилж багагүй сөрөг үр дагаврыг авчирлаа. Сурагч, оюутны ухамсар оюун санааг хоцрогдсон үзлийн сур дээсээр чивчрүүлэн баглаж байх нь тухайн үеийн үзэл суртлын хэрэгцээ байжээ. Ийм нөхцөлд боловсролыг оюунжуулах асуудал үндсэндээ орхигдсон байна. Жишээ нь, нийгэм судлалын хичээлүүд гэхэд л сурагч оюутныхаа оюун ухааныг хөгжүүлэх биш харин ч тэдний балчир уураг тархийг үзэл суртлын дэмий хоосон баримт фактуудаар дүүргэдэг бөлгөө. Үүний уршгаар сурагч оюутнууд ердөө л сурах бичиг болон багшийн хэлсэн зүйлийг тотьчтлон давтдаг, өөрөөр хэлбэл хувилагч машин, ханан хад мэт болж хувирсан. Байгалийн шинжлэлийн хичээлүүдийн хувьд бас

ийм байдал буй болжээ. Математик, физик, хими, биологи, газарзүй зэрэг хичээлүүд амьдралын бодит үзэгдлээс тасарч шинжлэх ухааны мэдээллийг дамжуулагч идэвхгүй хэлбэр төдий болов. Энд мөн л тотъчилон давтдаг сурагч оюутны үнэлгээ дээгүүр гардаг болсон юм. Тойргийн уртын томъёог цээжээр мэддэг атлаа гэрийнхээ хаяавчны уртыг олж чаддаггүй сурагч оюутан олшров, сонгодог уран зохиолоос нэгийг ч уншаагүй атлаа сонгодог зохиолчдын нэр, төрсөн, нас барсан онг алдаагүй цээжилчихсэн сурагч таарах юм. Ийм хүмүүс биеэ тоох занд автах бөгөөд ихээхэн хийсвэр сэтгэлгээтэй, өнгөц хоосон мэдээлэлд дуртай, хий хоосон зүйлд итгэмтгий, нилээд шазруун зантай болдог ажээ. Энэ бол бидний өнөөгийн бодит дүр төрх.

Хүмүүсийн оюун сэтгэхүйд байгаа хоцрогдол ихэд амь бөхтэй байдаг нь сүүлийн жилүүдэд тодорхой харагдлаа. Монголд ардчилал зах зээлийн тогтолцоо айлчлан ирээд 10 гаруй жил болж байхад ерөнхий болон дээд боловсролын сурах бичигт хичээлийн агуулга болон стандартын чанарын дорвитой өөрчлөлт орсонгүй. 2002 онд ЕБС-д хэрэглэж буй уран зохиолын сурах бичгийг сөхөхөд л энэ нь тод мэдрэгдэнэ. Тэнд хувьсгалын, ардын ардчилсан ба социалист шатны үеийн үеийн уран зохиол, тэдгээр зохиол дахь эерэг ба сөрөг баатруудыг шүүмжлэхийн ач холбогдол гэх мэтийн марксист номлолын элементүүд олноороо таарч байна. Багш нарын сэтгэхүйд ч дорвитой өөрчлөлт гараагүй байна, ердөө л хуучныхаа агуулгын нэрийг нь өөрчлөх төдийгөөр амиа аргацаасаар байх ажээ.

Төгсөлтийн шалгалтыг оюунжуулах нь монголын боловсролыг оюунжуулах цогц асуудлын хүрээнд л томъёологдох учиртай. Эхлээд агуулгын стандартыг өөрчлөх ёстой. Энэхүү өөрчлөлт гэдэг нь одоогийн зааж буй хичээлийн агуулгыг анги хооронд дахин хуваарилах асуудал биш юм. Энэхүү өөрчлөлт гэдэг нь суурийн шинж чанартай гүнзгий өөрчлөлт юм. Өөрөөр хэлбэл бүх хичээлийг оюунжуулах явдал юм.

Төгсөлтийн шалгалтыг оюунжуулахын тулд хичээл зааж буй багш нарыг оюунжуулсан байх ёстой. Энэ маш том зорилт, магадгүй нэг үеийг нөгөө үеэр сольж байж ч хэрэгжих асуудал байх. Та бидний өмнө ийм том зорилт байна. Энэ зорилтыг шийдвэрлэх зайлшгүй шаадлагатай бөгөөд наанаас нь алхам алхмаар ахих учиртай. Үүнтэй холбогдуулан зарим саналыг давшүүлье. Үүнд:

1. Монголын боловсролыг оюунжуулах стратегийн хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай байна. Одоогоор манай судлаачдын зүгээс

боловсролын хөгжлийн асуудлаар дэвшүүлж буй санаа оноо нь үндсэндээ тооны өөрчлөлтийг хамарч байгаа. Тухайлбал, боловсрол гэж юуг хэлэх вэ?, оюун ухааны эринд боловсролын ямар хэлбэр илүү зохимжтой вэ?, түүнд тохирсон боловсролын стандарт нь аль нь вэ? зэрэг суурь асуудлуудыг шийдэхгүйгээр 11-12 жилийн сургалтанд шилжиж болох уу? Эсвэл боловсролын хуучирсан академик хэлбэрийг улам бүр баталгаажуулах гэж байна уу?

Сүүлийн жилүүдэд ЕБС-ийн стандартыг удаа дараа өөрчилсөн боловч дорвитой ахиц гараагүй нь баримт юм.

2. Төгсөлтийн шалгалт гэдэг ойлголтыг тодруулах хэрэгтэй байна. Заасан зүйлээ буцааж шалгахыг би үгүйсгэхгүй байна, тэгэхдээ энэ арга хоцрогдсон гэдгийг хэлэх ёстой. Учир нь заасан зүйл гэдэг ямагт өнгөрсөн цагт харъяалагдана. Гэтэл төгсөлтийн шалгалт гэдэг маань уг төгсөгч ирээдүйд хэрхэн амжилттай байхын баталгааг өгөх ёстой. Өнгөрсөн цагийн үзэгдлийг сайн мэднэ гэдэг нь тэр хүний ирээдүй сайн байхын хүрэлцээтэй нөхцөл биш, харин зайлшгүй нөхцөл юм. Энэ утгаар нь авч үзвэл төгсөлтийн шалгалт нь мэдлэгийг шалгах бас чадварыг шалгах зорилготой байх ёстой. Одоогийн манай төгсөлтийн шалгалт нь мэдлэгийг шалгах шалгалт мөн.
3. Багш нарын мэргэжил дээшлүүлэх асуудалд чанарын ахиц гаргах хэрэгтэй байна. Одоогийн мэргэжил дээшлүүлж буй арга барил үндсэндээ хоцрогджээ. Хуучирсан мэдээллийг хэдийчинээ сайн цээжилсэн, өөрийнхөө сэтгэлгээг хязгаарлагдмал хайрцагт оруулж, өөрийгөө боомилох тутам тийм багшийн үнэлгээ дээгүүр болдог болжээ. Бид хуучнаасаа татгалзаж шинэ рүү ахих ёстой атал мэргэжил дээшлүүлэх тогтолцоо маань хуучныгаа улам бүр лавшруулахад чиглэсээр байна. Үүний уршгаар хуучнаа санагалзсан ахмад багш нарын байр суурь бэхжиж, нөгөө талд нь залуу багш нарын байр суурь ганхаж, улмаар шинэ сэтгэлгээтэй залуус аль ч шатны сургуульд багшлахаас зайлсхийдэг боллоо.
4. Багш нарын хичээл заах арга барилыг шинэчлэж, оюунлаг бүтээлч шинж төлөвтэй болгох шаардлагатай. Оюунлаг буюу IQ өндөртэй багш ямар ч хичээлийг ойлгомжтой товч тодорхой сайхан заадаг. Хэрвээ багшийн IQ доогуур бол ямар ч хялбар хичээлийг нэн

ойлгомжгүй болгож чаддаг. Эндээс хичээл заах арга барилын ард багшийн оюуны чадвар байгаа гэдэг нь харагдана.

5. Монголын боловсролын стандартыг сууриар нь өөрчлөх шаардлагатай. Хүүхдэд хэрэг багатай их мэдээлэл өгснөөр тэдний оюун ухаан хөгжих биш харин ч буурдаг бөгөөд улмаар нийгэмд бүтээлч бус сэтгэлгээ нэлэхүйдээ төлөвшихөд нөлөөлдөг байна.

Эдгээр том зорилтуудыг хэрэгжүүлэх онолын үндэслэл болгож дараах тодруулгуудыг хийж байна.

## ОЮУН УХААН ГЭЖ ЮУ ВЭ?

А. “Оюун ухаан оршин байна” гэж Платон хэлжээ. 90-ээд оноос өмнө их сэтгэгч Платоныг идеалист гүн ухааны эцэг, ухамсрыг материас өмнө тавьсан буруу номтон хэмээн хараан зүхдэг байлаа. Платон вээр “Оюун ухаан оршин байна” гэж хэлэхдээ матери оршин байдаггүй гэж нотлоогүй юм. Платоны энэ үгийг чухамхүү хүний ертөнцтэй холбож ойлговол зохино.

Орчин үеийн байгалийн шинжлэлийн гарцаагүй нотолсон зүйл нь:

Орчлон гурван язгуур үндэстэй

1. Орчлонгийн нэгэн язгуур үндэс нь махбод мөн
2. Орчлонгийн нэгэн язгуур үндэс нь эрчим мөн
3. Орчлонгийн нэгэн язгуур үндэс нь онч дохио мөн.
4. Махбод, эрчим, онч дохионы аль нь ч анхдагч бус бөгөөд аль нь ч зонхилогч бус.

Ингэхлээр Платон *Оюун ухаан оршин байна* хэмээхдээ онч дохио нь хүний хувьд оюун ухааны хэлбэрээр илэрнэ гэж томъёолсон хэрэг. Энд Платон зөрчилтэй зүйл хэлээгүй байна. Харин тэрээр хүн таныг өргөмжилж хүн та бол оюун ухаантайгаараа бусдаас ялгарна хэмээсэн байна.

Б. “Оюун ухаан бол аз жаргалын төрцүлсэн эх нь юм” гэж Софокл хэлжээ. Эндээс оюун ухаанаа орхигдуулсан тэр хүн аз жаргалаас холдоно гэдэг дүгнэлт гарна. Монгол хүн аз жаргал гэдгийг оюун ухаантай, сэтгэлийн цэнгэлтэй холбож ойлгодоггүй, харин албан тушаалтай, эд хөрөнгөтэй холбон ойлгодог болсон нь нэн гунигтай. Үүний үндэс нь монголын боловсролд байгаа чиг баримжааны ноцтой алдаа юм.

В. “Оюун ухаан бол тэнгэр газрын хаан нь юм” гэж Сократ хэлжээ. Энэ үг бидний хувьд анхаарууштай санаа юм. тухайлбал монголчууд тэнгэрийг

шүтэж, тэнгэр бурхандаа мөргөж, бас газраа уудалж, ашигт малтмалаа түүхийгээр нь бусдад зарж амьдарна хэмээн сэтгэх бөлгөө. Гэтэл тэрхүү шүтээн болсон тэнгэр, шүүж шүүрдэж амиа зогоодог газар хоёрын хаан нь оюун ухаан ажээ.

*Асуулт:* Энэхүү ХААН хэмээгдэх оюун ухаан хаана байна?

*Хариулт:* Түүнийг өөр хаанаас ч эрэх хэрэггүй, зөвхөн өөрөөсөө эрцгээе. Оюун ухаан хүн танд байна. Тэгэхлээр та өөрөө тэнгэр газрын хаан нь юм.

*Дүгнэлт:* Тэнгэр газрын хаан болсон хүнийг боловсруулж, мэдлэгжүүлж, жинхэнэ хүн болгодог боловсролын чин зорилго нь ОЮУН УХААН-ыг дээдлэхэд оршино.

Эндээс дараах мөрдлөгөөнүүд гарна.

1. Оюун ухааныг дээдэлдэггүй боловсрол нь боловсрол биш.

2. Мэдээлэл дамжуулдаг боловсрол нь боловсрол биш.

3. Мэдээлэл дамжуулдаг боловсрол нь сурагч оюутныхаа хүний мөн чанарыг алдагдуулж тэднийг хүн биш болгох замд нь хөтөлнө.

4. Мэдээлэл дамжуулдаг багш нь оюутан сурагчдыгаа тэнэг мунхаг болгоно. Тэрээр оюутан сурагчдынхаа амьдралын чиг баримжааг гажуудуулагч мөн (Энэ үгийг Дорнод аймагт ажиллаж буй Канадын мэргэжилтэн Helene Canesson надад хэлж өгсөн юм).

Г. “Оюун ухаан гэдэг нь хүний амьдралын замыг заагч тэр зүйл мөн” гэж Л.Толстой хэлжээ. Монголын боловсрол оюун ухаанаасаа хөндийрсөн гэдэг нь нүднээ тод харагдана. Эндээс дараах дүгнэлт урган гарна.

◆ Монголын боловсрол сурагч, оюутнуудыгаа амьдралынх нь замыг заагч тэрхүү зүйлээс нь салган холдуулжээ.

◆ Монголын боловсрол монгол хүний амьдралын мөн чанар, агуулгатай зөрчилдөж, суралцагсдынхаа хөгжилд саад болох аюултай тулгарчээ.

Д. “Оюун ухааныг өөрөөсөө гадна хайна гэдэг нь дээд зэргийн тэнэглэл мөн” гэж Кахта хэлжээ. Би олон хүнд “Та оюун ухаанаа хөгжүүлнэ үү” хэмээн зөвлөж оюун ухааны талаар харилцан яриа өрнүүлэхэд тэдгээр хүмүүсийн олонхи нь энэхүү оюун ухаан гэгчээс айн цэрвэдэг болсон нь ажиглагдсан. Монгол хүн оюун ухаанаас дөлдөг болсны учрыг холоос хайх хэрэгтэй. Сүүлийн гурван зуун жилд монголчууд бидэнд өөрийн гэсэн Төр Засаг байсангүй. Манжийн дарлалд 231 жил (1690-1921), Коминтерн, Зөвлөлт оросын дарлалд 69 жил (1921-1990) байсны харгайгаар олон үе дамжиж монгол хүний оюун сэтгэхүй хаагдмал, боогдмол байв. Энэ хугацаанд (300 жил) өөрийнхөөрөө сэтгэсэн монгол хүн бүр хэлмэгдэн тамлагдаж байжээ.

*Дүгнэлт:* Монгол хүн арван үе дамжиж оюун ухаанаасаа холдсон буюу монгол хүний оюун ухааныг гадаадын төр засаг арван үеийн туршид хүнээс нь салган хөндийрүүлжээ. Та бидний сэтгэхүйд “Оюун ухаан надаас гадна байдаг, оюун ухааныг өөр газрын хүмүүс бидэнд авчирч өгдөг” хэмээх ойлголт 300 жилийн туршид хоногшиж ижилдэн дасчээ.

Е. “Их мэдэх нь чухал бусаа, гол нь оюун ухаанаа хөгжүүлэх” гэж Демокрит хэлжээ. Үүнтэй холбогдуулан дараах тодруулгыг хийж байна.

1. Мэдлэг гэж юу вэ? Мэдлэг нь заавал хэрэглэгдэх ёстой. Хэрэглэдэггүй мэдлэг бол мэдлэг биш. Мэдлэгийг хэрэглэж чаддаггүй хүн, эсвэл цаг үеэсээ хоцорсон, хуучирсан мэдлэг, эсвэл цаг үеэсээ түрүүлсэн хэтэрхий шинэ мэдлэг, эсвэл цаг үетэйгээ зохицож чадахгүй байгаа хэрэгцээгүй мэдлэг гэж байна. Монголын боловсрол нь суралцагсдадаа хүрэлцэхүйц мэдлэг олгодог. Гагцхүү энэ мэдлэг нь ихэвчлэн цаг үеэсээ хоцорсон буюу цаг үеэсээ тасарсан байдаг. Ийм мэдлэгийг мэдлэг гэхгүй, ийм мэдлэгийг хоосон мэдээ баримт гэнэ. Жишээ нь: намайг хөдөөгүүр явж байхад ЕБС-ийг гайгүй сайн төгссөн, физик математикийн хичээлээр заагддаг олон томъёо цээжилсэн атлаа хувьчлалаар олгосон цөөн малаа нэг мотоциклоор сольж, мотоциклоо унаж яваад гэмтээж устгасан, тэгээд хоосорсон, гэхдээ сархад гайгүй зооглодог хүн хэд хэд таарч байлаа. Энэ хүн мэдлэгтэй хүн мөн үү? Томъёо хэрэглэж мал маллах уу?

2. Монголын боловсрол суралцагсдынхаа оюун ухааныг хэр хөгжүүлдэг бол? Хариултыг танд үлдээе. (Монгол хүн тухайлбал багш сурган хүмүүжүүлэгч та нөхөд бусдаас будаа идэх, бусдын үгийг тотъчилон давтах гэж оролдох хэрэггүй. Та оюун ухаантай хүн, тэгэхээр та өөрөө өндийх ёстой. Харамсалтай нь ингэж чадахгүй байна. Нэг нь хэлж зааж байдаг, нөгөө нь хэлүүлж, заалгаж байдаг мэт болжээ. Энэ нь та бид оюун ухаанаасаа холдсоны шинж мөн юм.)

Ж. “Оюун ухааныг НАР гэвэл Боловсрол нь нарны дагуул, гариг эрхэс юм” гэж Артур Шопенгауэр хэлжээ. ЕБС-ийн байгалийн шинжлэлийн хичээлээр нарыг гариг эрхэс нь дагаж эргэдэг, эсвэл сарыг дэлхий тойрч, дэлхийг нар тойрдог гэж заадаг билүү?, аль нь билээ? Энгийн нүдээр харахад нар нь дэлхийг тойрч буй мэт харагддаг, гэвч тийм биш гэдгийг ЕБС-ийн хичээл бидэнд хэлж өгдөг. Энэхүү зөв баримтлалыг оюун ухаан ба боловсрол дээр буулгавал ОЮУН

УХААН нь НАР юм, ГАРИГ ЭРХЭС нь БОЛОВСРОЛ юм. Артур Шопенгауэр зөв хэлжээ. Харин бид буруу хэрэглэж байгаа мэт. Учир нь ГАРИГ ЭРХЭС болох БОЛОВСРОЛ-ыг шүтэж, НАР болох ОЮУН УХААН-ыг орхигдуулжээ. Монголын боловсрол ингэтлээ амьдралаас тасарсан бөлгөө.

3. “Боловсрол нь хэзээ ч зорилго байж таарахгүй” гэж Х.Г.Гадамер хэлжээ. Монгол улсын хувьд боловсролыг зорилго болгон туйлшруулж, энэ нь 90-ээд оноос хойш бүр ч эрчээ авч эдүгээ ЕБС-ийн бүх төгсөгчид ямар ч хамаагүй үнээр ямар нэг цаасан диплом олж авахын төлөө тэмүүлдэг болж, үүнийг нь хэрэгжүүлж, суралцагсдын өмнөөс диплом үйлдвэрлэдэг сургуулиуд олшров. Сүүлийн жилүүдэд бакалавр, магистр, докторын зэрэгтэнгүүдийн тоо эрс нэмэгдэв. Гэтэл ард түмний аж байдал тэр хэмжээнд хүрсэнгүй. харин ч дордох аясыг олов. Эндээс дараах дүгнэлтийг хийж байна. Ард түмний аж байдлыг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд монголын боловсрол тус дэм болж чадахгүй байна. Харин ч чөдөр тушаа болж байна. Энэ бол боловсролыг зорилго болгон туйлшруулж, Х.Г.Гадамерын хэлсэн санамжийг умартсаны үр дагавар мөн.

Одоо ОЮУН УХААН буюу ИНТЕЛЛЕКТ-ийн талаар зарим тодорхойлолтуудыг сонирхъё.

**Тодорхойлолт 1.** Танд бусдаас давуу ямар нэг тал, оюунлаг байдал байна уу? Байвал түүнийг интеллект гэнэ. Жишээ нь, 2 хүн ярилцъя. Нэг нь арай илүү байдаг. Санаа нь, үгний найруулга нь . . . . гэх мэт. Тэгэхлээр ОЮУН УХААН хүн бүрт бий, гагцхүү хэмжээ нь янз бүр.

Интеллект буюу ОЮУН УХААН гэхээр заримдаа хүний оюуны шинжийг хэлээд байгаа, заримдаа тэр хүнийг ч хэлээд байгаа, аль нь ч зөв юм. Хүнийг биеэс нь ангид ойлгож болно, бас биетэй нь хамт ойлгоно.

**Тодорхойлолт 2.**

- а) Мэдлэг олж авах болон мэдлэгийг эргэцүүлж тунгаах оюуны чадвар
- б) Эргэцүүлэн бодох чадвартай хүн юм уу оюуны өндөр чадвар

**Тодорхойлолт 3.** Интеллект нь хийсвэрлэн сэтгэх чадвар

**Тодорхойлолт 4.** Танин мэдэхүйн төрөлхийн нийтлэг чадваруудыг оюун ухаан буюу интеллект гэнэ.

**Тодорхойлолт 5.** Интеллект нь асуудлыг өгөгдсөн программын дагуу биш, харин бүтээлчээр шийдвэрлэх чадвар юм.

Хүний оюун ухаан 5 язгуур үндэстэй.

- Таньж мэдэхүйн ухаан
- Бүтээж туурвихын ухаан
- Харьцахуйн ухаан
- Хайрлаж дурлахуйн ухаан
- Урлахуйн ухаан

/Д.Бямбасүрэн “Орчлонгийн хүрд” номын 174-р талд/

Оюун ухааныг олон талаас нь тодорхойлж болдог. Үүнийг олон талт интеллект гэнэ. эрдэмтэд ОЮУН УХААН-ИНТЕЛЛЕКТ-ийн 120 орчим чадвар бий гэж үздэг байна. Түүний 70 гаруйг нь IQ тестийн тусламжтайгаар хэмжиж болдог ажээ.

ОЮУН УХААНЫ төрлүүд:

- хэл зүйн интеллект
- логик математикийн интеллект
- хараа-орон зайн интеллект
- бие бялдар, хөдөлгөөний интеллект
- хөгжим хэмнэлийн интеллект
- бие хүний дотоодын интеллект
- нийгмийн интеллект

ОЮУН УХААН-тай холбогдуулан сэтгэлгээг тодруулья. Одоогоор сэтгэлгээний дараах 4 төрөл мэдэгдэж байна Үүнд:

Вертикал сэтгэлгээ - 10%

Каузал сэтгэлгээ - 20%

Латерал сэтгэлгээ - 30%

Визуал сэтгэлгээ - 40%

*Дүгнэлт:* Монголын боловсрол эдүгээ сэтгэлгээний айгаас дөнгөж 20 орчим хувийг нь идэвхжүүлж байгаа юм.

*Мөрдлөгөө:* Монголын боловсролыг оюуны хөгжлөөр дэмжиж чадвал сэтгэлгээний үлдэх 80%-ийг нь идэвхжүүлэх боломжтой.

# *БҮТЭЭЛЧ БУС, ХИЙСВЭР АКАДЕМИК БОЛОВСРОЛООС БҮТЭЭЛЧ БӨГӨӨД ОЮУНЛАГ ЧАДВАРЫН БОЛОВСРОЛ РУУ*

---

Өдрийн сонин 2002. 09. 20 №228, 235, 236

**Боловсрол нь нийгмийн хөгжлийн хурдасгуур мөн** гэдэг үзэл баримтлал манай нийгмийн сэтгэхүйд гүн бат шингэжээ. Энэхүү баримтлал нь ерөнхий утгаар нилээд бүрхэгдүү томъёологдсон бөгөөд нийгмийн хөгжилд энэ бүрхэг байдлаараа нөлөөлж, түүний уршгаар сөрөг үр дагаврууд ажиглагдаж байна. Тухайлбал ард олон БОЛОВСРОЛ—ыг сохроор шүтэх, түүний хэлбэрийг нь үл харгалзан хамаагүй даган харайж хөлөө гэмтээх, бухимдахаараа буруугаа бусадруу чихэх, улмаар боловсролыг бүхэлд нь үгүйсгэх өнгө аяс цухалзах болов. Үүнд боловсрол буруугүй ээ. . .

**НЭГ: Монголын боловсрол нь АКАДЕМИК боловсрол мөн.** Эдүгээ манай ерөнхий боловсролын дунд ба ахлах улмаар дээд боловсрол нь бүхэлдээ академик шинжтэй байна. Харин бага боловсрол нь хараахан ийм биш ажээ. Академик боловсролыг хавтгайруулах тохиолдолд сургалт нь бодит байдлаас тасарч, амьдралаас холдож, хоосон номчирхолын хэлбэрт орж, ингэснээр суралцагсадынх нь оюун сэтгэлгээ хүлэгдэн баглагдаж, алсын амьдрах чадвар нь сулардаг байна. Үүнийг манай боловсролын практик нотоллоо. Зохиомол үзэл сурталтай, хиймэл бүтэцтэй, тэжээвэр эдийн засагтай, уриа лоозонгийн нийгэм байгуулж байх үед академик боловсролын дээрхи дутагдал илрэн харагддаггүй харин ч тохирч байх мэт нууцлагдсан байжээ, одоо эдийн засгийг бодит амьдралаас нь ургуулж, уриа лоозонгоосоо татгалзаж эрүүл хөрсөндөө бууж өөрөө өөрийгөө авч явах болохоор байдал бишдэж, боловсролын маань өнгөний хуурамч будаг нь хууран унаж, цаанаас нь гууль цухуйлаа.

**ХОЁР.** Боловсрол гэж ерөнхий ярих нь энэ цаг үеийн шаардлагатай нийцэхгүй байна, одоо чухамхүү боловсролын ямар хэлбэр-төрөл вэ гэдэгт анхаарлаа хандуулж асуудлыг их тодорхой ярих ёстой. Боловсрол нь эрин үеийнхээ эрэлт хэрэгцээнд нийцэх учиртай.

**Асуулт:** Боловсрол нь ямар хэлбэрүүдтэй вэ?

**Хариулт:** Боловсрол нь АКАДЕМИК, ПРАГМАТИК, ЧАДВАРЫН гэх мэт хэлбэрүүдтэй .бөгөөд хэлбэр тус бүр нь оюунлаг шинжээрээ ялгарна.

**Асуулт:** Монголын одоогийн боловсрол нь энэ цаг үеийн шаардлагад нийцэж байна уу?

**Хариулт:** Шууд хэлэхэд “Монголын одоогийн боловсрол нь энэ цагийн шаардлага, эрин үеийн дуудлага, мэдээллийн нийгмийн эрэлтэд тэр бүр нийцэхгүй байна. Тэрээр манай нийгмийн хөгжлийг дэмжиж чадахгүй байгаагаар үл барам харин ч чөдөр тушаа болох янзыг олов.

**Асуулт:** Монголын боловсрол нь хөгжүүлэх боловсрол мөн үү?

**Хариулт:** Монголын боловсролд хөгжүүлэх боловсролын олон шинжүүд үгүйлэгдэж байна, тухайлбал, манай боловсрол нь төгсөгчиддөө өөрчлөлт шинэчлэлийг хүлээн авах бодит чадварыг тэр бүр зохих хэмжээнд олгож чадахгүй байгаагаар үл барам өөрөө өөрчлөгдөхдөө тун дургүй юм.

Шинэчлэгдэх бодит чадваргүй хүмүүс л өөрчлөлт шинэчлэлтийг нэг бол хуй салхи мэт хийсвэр түргэн, эсвэл огт салхигүй мэт тайван болхи байдал хэмээн ойлгодог байна. Үүнээс уламжлан нийгмийн хөгжилд саад тотгор учирдаг ажээ.

**Дүгнэлт:** Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлийн алдаа бүтэлгүйтэл, удаашрал саармагжилтын учир шалтгааныг боловсролтой холбон тайлбарлах үндэслэл байна.

**ГУРАВ.** Монголын боловсрол нь эдийн засгийн эцсийн үр дүнг чиглэхдээ тун тааруу байх бөгөөд бодит үр нөлөө нь сул байх ажгуу.

Монголын боловсрол эдийн засгийнхаа хөрс сууринаас тасран хөндийрчээ, үүнийг жил бүр олон мянган охид хөвгүүд дээд боловсролтой болж байхад эдийн засагт ахиц ажиглагдахгүй, дипломтой ажилгүйчүүдийн нөөц арми үүссэн, тэгсэн атлаа ажлын байр эзнээ хүлээсээр байгаа бодит байдал хөдлөшгүй нотолж байна.

Үр ашиг муутай аливаа тогтолцоо улс төрийн хайр ивээл, бусдын дэм тусыг горьдож амьдардаг. Энэ утгаараа манай боловсрол улс төр үзэл суртлын хүлээсэнд оржээ. Нэг талаас боловсрол нь улс төрдөө долигнож, нөгөө талаас улс төр нь боловсролыг амин хувийн атгаг зорилгодоо хортойгоор ашиглан панз үсэргэж сонгуулийн пайз болгожээ. Боловсрол нь улс төрийн намуудын хувьд жинхэнэ утгаараа “НОХОЙД БАРЬДАГ МОД- СОНГОГЧДОД ХАРУУЛДАГ САМБАР” болов. Үүний нөлөөгөөр боловсролын тогтолцооны харьцангуй бие

даасан байдал нь алдагдав. Монголын боловсрол нь хэтэрхий тэжээвэр, улс төрийн бодлогоос дэндүү хараат болж, цаашдын амьдрах чадвараа улам бүр алдлаа. Боловсролыг улс төрийн золиос болгосны уршиг дагавар ихэслээ.

**ДӨРӨВ: Манай боловсрол ихээхэн хийсвэр шинжтэй бөгөөд голдуу цээжлэх, хуулбарлахыг урьдал болгодог дутагдалтай. Ийм үед суралцагчдын сэтгэлгээний логикт гажиг үүсэж зөвхөн вертикал сэтгэлгээг шүтэж туйлшрах хандлагад автдаг байна.** Багшийн заасныг яг таг цээжлэж түүнийгээ буцаан хэлж дүн авдаг сурагч оюутнуудын оюун сэтгэлгээ нилээд хэмжээгээр хийсвэр болдог нь тогтоогджээ. Тийм залуус амьдралыг цээжлэж хуулбарлаж болдог зүйл мэтээр гэнэн өнгөц хэлбэрээр нь төсөөлж, амьдрал ахуйгаа зохион байгуулахдаа энэ хандлагаа лавшруулдаг байна. Тэдний хувьд амьдрал нь дуураймал хиймэл зүйл болон хувирах нь олонтаа аж. Монгол хүн угаасаа дуураймал байсан уу, эсвэл манай боловсрол биднийг ийм хачин дуураймал болгосон уу гэдгийг бодох цаг ирэв бололтой. Хийсвэр, дууриамал сэтгэхүйтэй болсон хүмүүс аль ч ажлыг гүйцэтгэхдээ бас л өнгөц хийсвэр хандаж эцэст нь өрх гэрээс нь эхлээд улс гэр нь хүртэл хөгжлийн хүндрэл бэрхшээлтэй учирдаг гэдгийг манай туршлага нотоллоо. Олон улсын ач холбогдолтой энэхүү туршлагаас дараахь суурь дүгнэлтийг хийж байна: **МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН УГ СУРВАЛЖ НЬ МАНАЙ БОЛОВСРОЛЫН ДОТОР НИЛЭЭД ГҮНД НЬ БАЙНА.**

**ТАВ: Монголын боловсролд бүтээлч чанар үгүйлэгдэж байна.**

Амьдрал нь мөн чанараараа бүтээлч байдаг, үүнийг та бид сайн мэднэ, бас бүтээлч бус сургалт, бүтээлч бус элдвийн бусармаг үйлдлүүд л хүүхэд залуусыг бүтээлч бус болгодог гэдгийг ч мэднэ. Хүний бүтээлч бус чанарын ард нь тэр хүний сэтгэлгээний бүтээлч бус чанар нуугдаж байгаа юм, ингэхлээр монгол хүнийг бүтээлч болгоё гэвэл эхлээд хүнийхээ сэтгэлгээг бүтээлч болго, үүний тулд боловсролоо бүтээлч болго, тэгж байж хүн нь бүтээлч сэтгэдэг болно, түүний дараа л бүтээлч үйл өрнөнө гэсэн дарааллыг цаг үе та бидэнд тулгаж байна.

Монгол хүний сэтгэлгээг бүтээлч бус талдаа гэж гадаадынхан ярьдаг юм билээ, бид яагаад ийм үгийг бусдаас сонсох болов, үүний эх үндэс гарцаагүй боловсролтой холбогдож таарна, учир нь сургуулиар дамжаагүй монгол хүн маш цөөхөн байх бөлгөө.. **ДҮГНЭЛТ: Монгол хүний бүтээлч бус чанар нь монголын боловсролоос эхтэй ажгуу.**

**ЗУРГАА:** Монголын боловсрол нь суралцагсаддаа бусдын төлөө бүү хэл өөрийнхөө төлөө хариуцлага үүрэх чадварыг суулган өгч чадахгүй байна. Энэ бол эзэн биегүй хийсвэр юм их заасны гай. Монгол хүн аливаа хариуцлагаас мултран гарахуйц бүтэц, зохиомжийг бодож олохдоо муутгүй бололтой, уншигч та төрийнхөө бүтцийг нэг сайн хардаа, УИХ-Засгийн газар-Ерөнхийлөгч-УИХ гэсэн битүү тойрог үүсгэсэн тогтолцоо . . .

Зуд боллоо, буруутан нь хүн биш, байгаль газар хоёр болдог, ажил уналаа, буруутан нь явж явж хууль болдог, тэгээд УИХ-руу орчихно, ингээд нөгөөх хөгийн битүү цагираг. Нэг л хүн гаргачихаж дөнгөх шийдвэрийн төлөө олуулаа хуралдаад л байна, хариуцлагаас мултрах гэж тэр, нэг л үнэн үг хэлэхийн төлөө тойроод дүлээд л байна, асуудалд өртчих вий гэж айсных...төрийн секторт хүнд суртал дэндүү газар авчээ, энгийн асуудлыг хүртэл ямар ч түшмэл өөрөөсөө холдуулаад дээд дарга руугаа л түлхээд байдаг, дээд дарга нь доошоогоо л чихээд байна, эцэст нь механизм гэдэг юм руу шидчихнэ, болоо, хэн ч хариуцлага үүрэхгүй. **ТААМАГЛАЛ:** Эзэн биегүй их юмыг хамаа намаагүй заахаар ингэдэг байж мэдэх юм, энэ ер нь судлууштай сэдэв

**ДОЛОО:** Гадаадруу явсан залуус эргэж ирэхгүй тэндээ шингэж байна, хүүхдүүд бөөн бөөнөөрөө оргож зугтан дайждаг болов, ийм үзэгдэл академик боловсролыг туйлшруулан шүтсэн Орос тэргүүтэй орнуудад гойд хурцаар илэрч байх аж. Судлаачид академик боловсролыг хүйтэвтэр гэдэг юм билээ. Хүйтэндүү зэвэргэн боловсролоор халуун дулаан сэтгэлтэй хүнийг төлөвшүүлж чадах уу? Аль эрт мэргэн Аристотель бээр “Их юм мэддэг атлаа ёс суртахуунгүй хүнээс бага юм мэддэг хэрнээ ёс суртахуунтай нь дээр” хэмээсэн билээ. Монголоо гэсэн чин сайхан сэтгэл зөв ёс суртахуун нь манай боловсролын хөрс суурь байх ёстой.

**ДҮГНЭЛТ:** Академик боловсролыг хавтгайруулсаны харгайгаар манай залуусын зүрх сэтгэл ерөнхийдөө хүйтэн талруугаа хазайжээ.

**НАЙМ:** Монголын боловсрол нь дунджийг баримжаалсан, дунд зэргийн суралцагчид тохирсон боловсрол юм. Ийм нөхцөлд чадвартай суралцагч төдийгүй чадвар сул нь давхар хохирдог байна. Одоогоор манайд авъяаслаг хүүхдийг сургадаг ЭЛИТ боловсролын тогтолцоо бүрэлдээгүй байна, энэ тухайд төрийн бодлого алга. Ийм нөхцөлд анги курсын доторхи чадварлаг хүүхдүүд нэг бол ялгаран гадуурхагдах, эсвэл өөрийгөө мохоож өрөөлд уусахад хүрдэг байна, эндээс нийгмийн эрхэмлэх үнэт зүйлсийн үнэлэмжид гажиг гарч, саарал дунджийг

шүтэх хандлага газар авч, тэр нь даамжирсаар эцэстээ өөдөө гарах гэж оролдсон нэгийгээ матаж сөгдүүлдэг, өмчтэй болох гэж зүтгэсэн найзаа татаж унагадаг, аль өнгөтэй өөдтэйгээ нүд үзүүрлэдэг хүмүүс төлөвшин бойждог байна,

**ЕС:** Дундаж сэтгэлгээтэй дундаж хүмүүс нь аливаад ихээхэн хүлээцтэй ханддаг давуу талтай бөгөөд барагтай бол хөдөлдөггүй, хөдөлбөл их удаан, энэ утгаараа нийгмийн хөгжилд тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэнэ. Тэд тогтвортой тайван байдлыг хүсэмжилнэ, улс орныг амьтантай зүйрлэвэл дундчууд нь их бие, нуруу, хаа, гуя юм. Их биегүй амьтан гэж байхгүй, тэгэхлээр манай боловсрол нь “монгол улс” гэдэг амьтны их биеийг дажгүй сайн бүтээж байгаа ба энэ утгаараа төр засаг, ард түмнээсээ өндөр үнэлгээ авч байна, гагцхүү нөгөөх бүтээсэн “амьтан” маань толгойгүй байх ажээ.

**ДҮГНЭЛТ:** Монголын боловсрол нь монголынхоо хөгжлийг ядуу буурай байдалд нь тогтворжуулан барих, өөрчлөлт шинэчлэлийг арагш нь чангааж саармагжуулах үүргээ амжилттай сайнаар гүйцэтгэж байна. Монгол улсад дундаж хүн үнэд орж, дундаж үнэлгээ газар авч, эцэстээ нийгмийн сэтгэлгээ үнсэн саарал өнгөтэй орог зэвхий болсон нь боловсролоос эхтэй байна.

**АРАВ:** Монголчуудыг ерөнхий боловсролын талдаа гайгуу гэлцдэг, төр засаг нь ч үүнд их анхаардаг. Ер нь монгол хүн угаасаа аливаа зүйлд ерөнхийлэх дуртай, сэтгэлгээний хэв шинж нь ч ерөнхийгөөс тусгайруугаа чиглэдэг онцлогтой, ямартаа л гадаадынхан монголчуудыг “ерөнхийлж ерөнхийлж байгаад ерөнхийлсгээд л орхичихдог ерөнхий хүмүүс” гэхэв. Ерөнхийлэхэд учир бий. Юмны учрыг олоогүй байж ерөнхийлэх нь юу ч мэдэхгүйн шинж бөгөөд хоосон хоцрохын цондон, ийм хүмүүс хааяагүй таардаг, тэдний сэтгэлгээ нь мохон мөлийж, торгон мэдрэмжээ алдсан нь мэдрэгддэг, торгон мэдрэмжээ алдана гэдэг нь тухайн хүний хувьд **МӨХӨЛ**.

Ерөнхий боловсрол гэдэг үг моодноос гарч байх бололтой. Ийм мэдээ гадаадын хэвлэлд олонтаа таарах болов. Ерөнхий боловсрол гэдэг нь ерөнхий нэр бөгөөд түүний оронд **ЧАДВАР**-ын боловсрол гэж яривал илүү тодорхой болох учиртай аж. Олон оронд **ЧБС** /чадварын боловсролын сургууль/ -ыг хөгжүүлж байна.

**АРВАННЭГ:** Манайхан чадвартай мэргэжилтэн бэлтгэе гэж сүүлийн үед нилээд сөхөж ярих болсон нь сайшаалтай, гагцхүү ямар чадвартай юу хийж чаддаг хүний тухай яриад байгаа нь тодорхой бус байгаа юм, ерөнхийлсөний гай энэ л дээ. Хүн бол нэг ёсны чадварын уут юм, тухайлбал, амьдрах чадвар, ажиллах чадвар, сэтгэх чадвар, сэрэх чадвар, мэдээллийг хүлээн авах чадвар, түүнийгээ

хэрэглэх чадвар, бас хоосон цээжлэж дүн авах чадвар, тэгээд маргааш нь мартаж чадвар, бусдыг унатал нь дэгээдэх чадвар, бусдаар магтуулж урагшлах чадвар, худал амлах чадвар, хуурамчаар уйлах чадвар гэх мэт... Би энд 12 чадварыг дурдав, та 120 болгоорой...

**АРВАНХОЁР:** Чадвар нь тодорхой байдалтай гойд холбогдоно, "Тэр гуай чадвартай хүн шүү" гэдэг үг нь араасаа Тэр гуай чухам юу чаддаг хүн вэ гэдэг асуултыг дагуулна, учир нь энэ дэлхий дээр бүгдийг чаддаг хүн гэж нэгээхэн ч үгүй бөлгөө. Харин "Тэр гуай ер нь их чадварлаг хүн шүү" гэвэл тэр нь тухайн хүний оюунлаг байдлыг заах талдаа илүү ойртоно Ингэхлээр чадвар гэдэг нь тодорхой байдлаар нөхцөлдсөн оюун ухааны талын ойлголт болж байна. Хэрвээ та оюун ухаанаас ангид байдаг чадварын тухай ярина гэвэл тэр нь хүний чадварын хүрээнээс халина, ингэвэл чадвар биш дадал болно, ийм дадлыг амьтад амьдралын шаардлагын улмаас хүнээс илүү эзэмшсэн байх нь олонтаа, тухайлбал, хүн та загас шиг усанд сэлж, шувуу шиг агаарт нисэж чадах уу? Ингэхлээр та бид энэ удаад хүний чадвар, тодруулбал, хүний оюуны чадварын тухай ярьж байна, энэ бол Чадварын боловсролын амин сүнс билээ.

**ДҮГНЭЛТ: Чадварын боловсрол гэдэг нь мөн чанартаа ОЮУНЫ ЧАДВАР-ын боловсрол мөн**

**АРВАНГУРАВ:** Оюуны чадвар нь боломж ба бодит байдал гэсэн хоёр түвшинтэй юм. Боломж гэдэг нь уг хүн хаана хэзээ төрсөнөөс үл хамаарч хүн бүрт бараг адил заяасан тэрхүү оюуны чадварыг хэлж байна. 1000 хүний лавтайяа 992 нь (ойролцоогоор) эхээс төрөхдөө адил тэнцүү оюуны боломжтой байдаг нь онол практикийн аль ч талаасаа ягштал нотлогдсон юм. /Монголын хувьд 1000 хүний 886 нь оюуны чадварын хувьд ижилэвтэр гэсэн судалгаа бий/. Энэ бол хүнийг байгаль эх алагчлан гадуурхаагүйг харуулах сайхан баримт билээ. Бодит чадварын хувьд бол байдал нилээд өөр, яагаад гэвэл хүн байгалаас өөрт нь өгөгдсөн тэр сайхан боломжийг янз бүрээр ашигладаг, ингээд хүмүүс хооронд чадварын ялгаа үүснэ, үүсэж ч байна. Төрөлхийн усан тэнэг, төрөлхийн ухаантан хоёрыг эс тооцвол хүний оюуны чадварын коэффициент IQ нь 70 аас 130 ийн заагт байдаг бөгөөд сурагч оюутныхаа IQ –г аль болохоор өсгөх нь боловсролын үндсэн зорилго байх учиртай. Энэ зорилгоо манай боловсрол биелүүлж чадаж байгаа бол уу?

**ДҮГНЭЛТ: Монголын боловсрол бол оюунлаг бус боловсрол гарцаагүй мөн.** Энд дараах тодотголыг хийх нь зүйтэй. Академик боловсрол нь оюунлаг бус учраас манай боловсрол нь оюунлаг бус болсон гэж ерөнхий

дүгнэж болохгүй, академик боловсролыг мөн чанараараа оюунлаг бус байдаг гэвэл алдаа болно, гагцхүү бид энэхүү боловсролын хамрах хүрээг онож тогтоогоогүйгээс бэрхшээлтэй учирсан хэрэг, ийм учраас би вээр манай боловсрол, монголын боловсрол гэж илэрч буй хэлбэрийн талыг нь барьж тодруулж байгаа болой

**АРВАНДӨРӨВ:** Хийсвэр чадвар гэж байхгүй, чадвар ямагт тодорхой байна, чадвар ямагт бодит биет зүйл дээр илэрнэ, иймд Чадварын боловсрол нь ямагт тодорхой бөгөөд бодит хандлагыг шаардана. Энэ бол чадварын боловсролын давуу тал нь, бас хэцүү тал нь. Манайд чадваргүй мэргэжилтэн, чадваргүй эрдэмтэн олширлоо гэж хүмүүс хааяагүй шүүмжилж байгаа нь үнэний хувьтай. Монголд яг мэргэжлээрээ ажиллаж гоц үр дүнд хүрсэн хүн хэр олон бол? манай улс төрчдийн дотор улстөрчийн дипломтой хүн хэд бол?, намын олон ажилтан ламын ажилруу шилжлээ, лам нар нь дажгүй бизнес хийж сурав, биохимич нэгэн вээр эдийн засагчдыг аман дотроо зажлаж сууна, нөгөөдүүл нь таг, чадвар нь дутуу юм чинь арга алга. Ерээд онд “чадаж байгаа юманд арга байхгүй” гэсэн хэллэг гарч залуусын дэмжлэг авсныг та санаж байна уу? Тэр чинь чадварын боловсролыг хүлээн авах хөрс нийгэмд бүрэлдэж эхэлсэний дохио ажгуу. Зах зээлийн нийгэм нь чадварыг гайхалтай сайхнаар урамшуулдаг ба энэ нь зах зээлийн эдийн засгийн тулгуур зарчим бөлгөө. Чадварыг урамшуулсан нийгэм, ард түмэн, төр засаг, улс гүрэн нь хөгжиж, урамшуулаагүй нь сөнөж, мөхөж, ингэж хүн төрөлхтөний түүх үргэлжилсээр өдгөөтэй золгоод цаашдаа улам эрчлэн манарах авай...

**АРВАН ТАВ:** Манай эцэг эхчүүд хүүхдээ их юм мэддэг хүн болгохсон гэж, багш нар маань шавьдаа их эрдэм заахсан гэж хоёр талаас зүтгэсээр өдий хүрсэн бөгөөд үр дүн нь санаанд хүрэхгүй байгааг өмнө дурдсан. Яагаад ингэв гэвээс та бидний зүтгэл багадсандаа бус, харин зүтгэлийн маань зүг чиг зөрсөнд байгаа юм. Эрдэм мэдлэг гэдэг нь заавал чадвараар баталгаажиж байж амь ордог учиртай. Уг нь монгол хэлний **ЭРДЭМ** гэдэг үг нь мэдлэгтэй бус чадвартай илүү холбоотой юм билээ, "**ЭРДЭМ ЧАДАЛ**" гэхээр хүний чадлын тал нь илүү тодордог, "тэрвээр их эрдэмтэй хүн шүү" гэвэл тэр хүн заавал доктор-академич байх албагүй, нарийн яривал тэгж ч ойлгогдохгүй, түүн дээрээ хүрвэл "гүтгэх эрдэм, гүжирдэх эрдэм, хуурах эрдэм, хутгах эрдэм, хувьчлах эрдэм, хусах эрдэм, дэгээдэх эрдэм, дэвслэх эрдэм," гэх мэтчилэн ярьдаг ч, хэрэгжүүлдэг ч биз дээ. Тэгэхлээр цаашдаа **ЭРДЭМ**

**МЭДЛЭГ** гэдэгт зөвхөн чадварт хувилдаг тийм мэдлэгийг л ойлгодог болцгооё, өөр зам байхгүй, үүнийг дагаад чадварт хувилдаггүй мэдээллийг сурагч оюутанруугаа дамжуулдаг сургалтын одоогийн **КИРРИКЮЛИМЫГ** хянан өөрчлөж таарах нь ээ, өөр зам байхгүй.

**АРВАН ЗУРГАА:** Хүний чадварыг оюунлаг ба оюунлаг бус гэж хоёр хувааж оюунлаг бусыг нь амьтны чадвартай адилтгах үндэстэй юм. 1970-аад оноос эхлэн оюуны чадвар сулавтар хүүхдийг ТМС-д шилжүүлж мод харуулах шавар зуурах мэтийн энгийн чадварт сургадаг байв, үүнээс болоод ТМС-ийн нэр хүнд унасан билээ. Хүүхдийнхээ IQ-г хөгжүүлэхгүй зөнд нь орхил гэж бодох эцэг эх хаана байхав. Энэ бол түүх. Гэтэл сүүлийн үед ТМС-ийг дахин сэргээх ухааны номлол хүчтэй яригдах болов. Одоо ТМС-ийг хуучин төрхөөр нь сэргээнэ гэвэл ноцтой алдаа болно, харин оюунлаг ТМС гэвэл арай өөр. Үүнийг мэдэрсэн хэд хэдэн МСҮТ-ийн хамт олон “Оюуны хөгжил-IQ” хичээл, СОРТ хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангасан нь сайшаалтай.

**АРВАН ДОЛОО:** Чадварын боловсрол нь дулаан, халуун юм. Түүний энэ шинж нь чадварын боловсролын бүтээлч чанараас эхтэй. Ер нь бүтээлч үйл ажил өрнүүлдэг, ажилсаг хүмүүсийн яриа хөөрөө нь хүртэл цаанаа л нэг халуун дулаан, элдвийн хиймэл зохиомол маяггүй, наалдацтай, энгийн бөгөөд үнэнд ойр байдаг шүү дээ. Тэр хүн хэрэгцээгүй олон хотын нэр, хэрэглэдэггүй бөөн томъёог цээжлээгүй байж болно, гагцхүү сэтгэл нь дулаан байвал тун учиртай даа...ядаж л өөрийгөө борлуулна, орчин тойрноо гэмтээхгүй. Сүүлийн үед зүрх сэтгэлтэй хүнийг төлөвшүүлэх тухай их ярих боллоо. Их сэтгэгч Жан- Жак Руссо “Ихийг мэдэхээс сайныг мэдэх нь илүү чухал” хэмээсэн нь чухамхүү бидэнд хандсан сануулга бус уу. Хүнийг сургах, хүнийг төлөвшүүлэх ажлын нэгдлийг чадварын боловсрол л хангаж чадах ажгуу.

**АРВАН НАЙМ:** Хүн нь хэзээд хувь хүн байсан, өөрийн гэсэн өнгө төрхтэй, үзэл бодолтой, асуудалд өөрийнхөөрөө ханддаг, амьдралаа өөрөө зохион байгуулдаг, хүний энэ онцгой чанарыг үгүйсгэж, хүмүүсийг нэг үзэл бодолтой, ижилхэн сэтгэдэг болгоно гэвэл дэндүү гэнэн, дэндүү болхи, хүнийг хэтэрхий басамжилсан үйл ажиллагаа болон хувирдаг байна. Хувь хүний өөрийнх нь хөгжил хичнээн дорой байлаа ч гэсэн хүнийг басаж, доромжилж болохгүй. Харамсалтай нь манай боловсролд ийм шинжүүд бий, хичээл дээр багшийн дэвшүүлсэн асуудалд сурагч оюутнууд өөрийнхөөрөө хандаж чөлөөтэй сэтгэх нь одоо хүртэл хориотой хэвээрээ байна,

өөрөөр сэтгэж, өөрийнхөө үзэл бодлыг хамгаалах зориг зүрх манай залууст илт дутагддаг, үүний уршгаар залуус маань нэг л өнгө муутай, доогуур харцтай, идэвхгүй, үлбэгэр сулбагар болов. Энэ нь манай залуусыг гадаадын хөгжингүй орныхонтой харьцуулах үед л их тод мэдрэгддэг юм билээ. Хүмүүсийн өөртөө итгэх итгэл алдагдаж, бусдыг дуурайх, тэднийг царайчлах, бусдад амьдралаа даатгах, тэдний төлөө төрсөн мэт бодох, төр засгаасаа шан харамж нэхэх, түүнд хэтэрхий найдаж ихийг хүсэн хүлээх, тэгээд эцэст нь бурууг өөрөөсөө бус өрөөлөөс, голдуу төр засаг, түүний удирдлагаас хайж, өширхөх, сонгуульд нөгөө этгээдэд нь саналаа өгснөөр уур бухимдлаа тайлдаг гаж араншин төлөвшиж байна

**АРВАН ЕС:** Монголын боловсролыг шинэчлэхсэн, илүү үр дүнтэй болгохсон гэж энэ салбарт ажилладаг хүн бүр санаа тавьж, чадах ядахаараа оролдож, анхны үр дүнгүүд гарч, багш нарын идэвхи сайжирч, шинэ санал санаачлагууд өрнөх болов. 2001-2002 оны хичээлийн жилд улсын хэмжээгээр 21 аймгийн 113 IQ клубын 1203 багш 12531 сурагч багачуудыг “Оюуны хөгжил- IQ” хичээлд хамран сургав, Дархан-Уул аймгийн Ж.Эрхэмсайхан захиралтай 22-р сургуулиас эхлээд хот хөдөөгийн нилээд хэдэн ЕБС “Оюуны хөгжлийн чиг баримжаа” бүхий туршилтын загвар сургууль болохоор өөрсдөө хөөцөлдөн түрүүч нь холбогдох шийдвэрээ гаргуулан ажилдаа орлоо. CoRT курсыг МУНИС-ийн харъяа Хан-Уул дээд сургуулийн 4 ба 5-р ангид өнгөрсөн хичээлийн жилд тус бүр 60 цагийн багтаамжтай 3 кредит цагийн өгөлттэй заалаа, БСШУЯ-ны дэмжлэг, АХБ-ны БСХХ-ийн санхүүжилтээр их дээд сургуулийн 100 гаруй багшийг хамарсан сургалт зохион байгуулж 60 гаруйд нь CoRT хичээл заах эрхийг нээж сертификат олголоо. Бидэнд боломж нөөц байна, төр засгийн дэмжлэг байна, сургуулиудын бие даасан байдал нь бэхжиж өөрийн хэв шинжээ өөрөө тогтоож өөрийгөө удирдах эрхтэй болов, тэгэхлээр одоо ажиллах л үдлээ, гэхдээ эрчимтэй ажиллах ёстой, учир нь бусад орон дэндүү хол тасран түрүүлжээ.

**ХОРЬ:** Сэхээтнүүд ээ?, Ажилчин анги тэргүүлж малчид дагалдаж сэхээтнүүд араас нь шогшино гэдэг үзэл баримтлал үеэ өнгөрөөлөө. Одоо цөмөөрөө хамтдаа урагшилах үе, гэхдээ оюунлаг сэхээтнүүд тэргүүлэх цаг. Энэ тухайд 1970-1980-аад оны манай ажилчин ангийн шилдэг төлөөлөгч, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, төрийн шагналт Б.Гүнжлхамын “Одоо цагт оюунлаг нөхдөө бүхнээс дээдэлдэг боллоо. Оюун ухаан нь хөгжлийн эх булаг гэж ойлгосных “ хэмээснийг ишлэл болгоё. Сэхээтнүүд л бусдаасаа

түрүүлж сэхээрнэ, учир нь тэд л сэхэж сэхээрч чаддаг хүмүүс бөгөөд чухамхүү энэ онцгой давуу чанарынхаа ачаар сэхээтнүүд хэмээн нэрлэгдсэн түүхтэй билээ. Монголын хөгжлийн алдаа оноог гаднаас бус дотроосоо, бусдаас бус өөрсдөөсөө хайцгаая, та бид алдаагаа түүхрүү чихэх ёсгүй, ингэвэл хөгжил дэвшил ойртох бус холдоно, алдаа оноо энэ цаг үе дээр та бидний дунд байна, ингэж сэтгэвэл ядаж л “одоо яах вэ?” гэсэн бодол төрнө, шийдлийг нь хайж эхлэнэ, эрвэл эрхбиш юм юм олдоно, ингэж байж л хөгжинө.

Ямар ч ард түмэн ачааныхаа хүндийг аль ухаалаг, чадварлаг, өнгөтэй өөдтэй цөөнхдөө үүрүүлдэг. Манай боловсролын салбарт ажиллагсад нь энэхүү цөөнх мөнөөсөө мөн. Ухаалаг хүмүүст нэг сонин чанар байдаг, тэр нь бурууг өөр дээрээ үүрч бусдыгаа хамгаалах чадвар юм. Ийм чадвар чухамхүү манай боловсролын салбарынханд байгаа гэдэгт эргэлзэх юун. Тэгэхлээр алдааг өөр дээрээ татаж, ачааны хүндийг үүрээд зүтгээд байхаас өөр эрхэм зорилго гэж юу байхсан билээ.

*МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АЖИЛЛАЖ БУЙ ТА  
БИДНЭЭС МОНГОЛ ОРНЫ ХУВЬ ЗАЯА ШУУД ХАРААТ БАЙГАА  
ТӨДИЙГҮЙ ЭНЭ ОРНЫ ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР НЬ ТА БИДНИЙ  
ГАРТ БАЙНА.*

**БҮТЭЭЛЧ БУС, ХИЙСВЭР  
АКАДЕМИК БОЛОВСРОЛЫГ ХУМЬЖ  
БҮТЭЭЛЧ БӨГӨӨД ОЮУНЛАГ ЧАДВАРЫН  
БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЬЕ.**

## *БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ХОМСДОЛ*

---

Өнөөдөр 2002. 10. 12 №242 (1674)

Хүний оюун ухааны төрөлхийн заяагдмал шинж чанаруудад өөрчлөлт орсноор уураг тархи нь мэдээллийг ялгахгүйд хүрч, гадны хогон мэдээллийг үржүүлэгч болон хувирч, бүтээлчээр сэтгэх чадвараа алдах үйл явцыг «бүтээлч сэтгэлгээний хомсдол» гэнэ. Дэлгэрэнгүй бичвэл «Бүтээлч сэтгэлгээний олдмол дутмагшлын хам шинж» товчоор «БОХ».

Би ийм өвчинд нэрвэгдсэн олон хүнийг танина, тэднийг БОДХАНЖ - нэг, хоёр, гурав гэх мэтчилэн дугаарлан нэрлэе. Бодханж нь «бүтээлч сэтгэлгээний олдмол дутмагшлын хам шинж»-ээс үүсгэсэн нэр үг.

Бодханж-1 гуай эдүгээ нас сүүдэр 60 гарсан бөгөөд «БОХ» өвчний нянг он удаан тээж буй ясны архаг өвчтөний бүртгэлд оржээ. Бодханж-1, багаасаа багшийн заасныг яг үсэгчлэн цээжлээд буцаан хэлдэг томоотой тоть болсоны хүчээр ЕБС-ийг гайгүй дүнтэй төгсөж их сургуульд элссэн, дараа нь их сургуулиа амжилттай дүүргэхийн тулд профессорын хэлснийг яг дагаж донгоддог уран хөхөө болсон, үр дүн нь ч гарч тэрээр их сургуульдаа багшаар үлдсэн, тэгээд дэд эрдэмтэн болохын тулд нэгэн жүүдийн бичсэн зохиолыг үг үсэг алдалгүй арваад жил хуулсан, дараа нь докторын зэргийг уржнан хойно хамгаалсан, чаддаг юм нь үр нөлөөгүй зэрэг цол хамгаалах, өрөөлд түүнийгээ бэлэглэх . . .

Бодханж-2 нь нас 50, төрийн өндөр албыг олон жил хашиж, засгийн ордон дотор насаа элээж буй хүн. Тэрээр сайн хүн үү гэвэл аргагүй «сайн» хүн, үг хэл гаргахгүй, нам төрийн бодлогыг л сурталчилна, үе үе гоё нэртэй хурлуудыг зохион байгуулж дээд даргаасаа оноо авна, элдвийн ой тэмдэглэх, хүмүүсийг одон медальд тодорхойлох хообийтой, үүндээ гаршсан гэдэг нь жигтэйхэн, түүнийг төрийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах арга ухааны мастер гэхэд буруудахгүй.

Бодханж-3 бол өмнөхөөс арай өөр, эдүгээ 40 шүргэж яваа, хамгийн

сайн чаддаг юм нь бусдыг уруу татаж үймүүлэх, түүндээ сүүлийн арав гаруй жил гаршин «дээд мэргэжлийн улс төрч» болсон, одоо нэгэн улс төрчийн хормой дор хярчихсан нөгөө нам руу нь чулуу шиддэг ажилтай. Тэрээр бүтээхийг бус бүрэлгэхийг уриалдаг хүн.

Бодханж-4 нь нас 30, их сургууль төгссөн, бас магистр хамгаалсан, уг нь сайн охин л доо, даанч мэдсэнээ ашиглах чадвараар дэндүү сул, одоо ажилгүй, нөхөргүй.

Бодханжуудыг би вээр манай өнөөгийн сэхээтний нийтлэг дүр төрх гэж яаран дүгнэмээргүй байна, харин бага бус хувийн жинтэй тодорхой хэсгийн төлөөлөл гэвэл онох биз. Асуудлын гол нь Бодханжид байгаа юм биш, асуудлын гол нь хүнийг Бодханж болгож буй, түүнийгээ өмгөөлөн хамгаалж тэтгэж буй тогтолцоонд байгаа юм. Бодханжууд бол манай нийгмийн биет бүтээгдэхүүн мөнөөсөө мөн, ийм бүтээгдэхүүний тоо сүүлийн жилүүдэд олширсон уу гэхээс цөөрөөгүй ээ.

Монголын боловсрол нь оюун ухаан, сэтгэлгээг олон жилийн туршид үл хэрэгсэж, хиймэл дүр бүхий хоосон мэдээллийг шүтэж, үзэл суртлын золиос болж, хөндий цээжлүүлэх сургалтын хоцрогдсон технологийг ягштал мөрдсөний уршгаар төгсөгчдийнх нь оюун ухаан царцанги болж сэтгэлгээнийх нь бүтээлч чадвар хомсдолд өртсөн байна.

Монголын нийгэм өөрчлөлт шилжилтийн ирмүүн үедээ байна, харамсалтай нь энэхүү шинэчлэл маань төдийлэн ахиц дэвшилд хүрэхгүй байгаа төдийгүй зарим чиглэлээр ухрах төлвийг олоо, яагаад ийм болов гэдгийг хүн бүр өөрөө өөрөөсөө асуух ёстой, өөрөө өөрсдийгөө шүүж дүгнэх ёстой, миний ойлгосноор: нийгмийн шинэчлэл гэдэг нь гойд адармаатай, маш гүнзгий, түүнд хэлбэрдэх төдийгөөр өнгөц хандвал эцсийн үр дагавар нь сөрөг болж мэдэх, ерөөсөө өөрчлөлт гэдэг нь явж явж эцэстээ хүн дээр очиж тулдаг, хүнийг өөрчлөнө гэдэг нь хүний сэтгэлгээг өөрчлөхийг хэлдэг, нэн ялангуяа манай орны хувьд давын өмнө бүтээлч сэтгэлгээний өөрчлөлт гойд чухлаар шаардагдаж байгаа бөгөөд энэ ажил нь боловсролын шинэчлэлээр эхлэж шатлан гүнзгийрэх ёстой, ингэхлээр монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэл гэдэг нь ихээхэн тэвчээр, олон жилийн шургуу ажиллагаа шаардсан тасралтгүй үргэлжлэх үйл явц байх нь ээ

Сэтгэлгээний шинэчлэл рүү ойртохын тулд юуны өмнө одоогийн төлөв байдлаа тун ултай оношлох ёстой, хамгийн чухал нь «Бүтээлч сэтгэлгээний

хомсдол»-оос гарах арга замыг сайтар тунгаан бодох учиртай. Ямар ч гэлээ эхлээд манай нийгэм энэ аюултай өвчинд нилэнхүйдээ яггүй гүнзгий нэрвэгдсэн гэдэг үнэнийг ил тод хэлж сурцгаа, түүнд боловсролын одоогийн академик шинжтэй хийсвэр сургалт шууд нөлөөлсөн гэдгийг хүлээн зөвшөөрө, өвчнийхөө оношийг өвчтөн өөрөө мэдэх нь эмчлэхэд дэм тус болдог гэдэг утгаар үүнийг ил тод хэлж байна. Энэ өвчнийг анагаах арга нь боловсролын шинэчлэлтэй гойд холбогдоно.

«БОХ» өвчнийг эсэргүүцэх сэтгэлгээний дархлаа уг нь хүн бүрт бий нь бий, хүүхэд багадаа их оролдомтгой, юм юмыг шинээр өөрөө хийх сонирхолтой, бүтээлч чадвартай, өөрийгөө зөвтгөх зөнтэй, зөрүүд зантай, мөрөөдөмтгий байх бөгөөд залуудаа гал халуун сэтгэлтэй зоригтой зүрхтэй байдаг, харин нас ахих тусам энэ чанараа гээж дархлаа нь буурдаг. Бүтээлч сэтгэлгээний дархлаагаа аль болох удаан хадгалахыг хүн бүр эрмэлзэх учиртай, үүнд нь боловсрол дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, монголын боловсрол энэ үүргээ биелүүлж чадаж байгаа бол уу?, Бодханжуудын бүтээлч сэтгэлгээний дархлаа яагаад тэгтлээ эрт, бага залууд нь буурав?

Бүтээлч сэтгэлгээний хомсдол нь удамших аюултай гэж сэтгэл зүйчид үздэг байх юм, учир нь өрхийн эзэн ийм өвчтэй бол тэрээр үр хүүхдээ өөрийн энэ муухай замаар оруулах гэж ихэд мэрийдэг, хүүхдүүд учир мэдэхгүй болохоор эцэг эхийн энэ байдал нь тэдэнд таалагдаж, ийм замаар «БОХ» өвчин удамшина. Энэ өвчин бас халдвартай, хамт ажиллагсадын дотор нэг ийм өөдгүй хүн байхад л бусаддаа хүчтэй нөлөөлнө, ялангуяа багш нар энэ өвчнөөр өвдвөл сурагч оюутандаа халдаах магадлал ихтэй. Бүтээлч сэтгэлгээний СОРТкурсэд хамрагдаагүй, багаасаа «Оюуны хөгжил-IQ» хичээлээс хол хөндий байсан хүмүүсийн сэтгэлгээ энэ аюултай өвчний нянг ямарч эсэргүүцэлгүйгээр шууд хүлээн авдаг байна, яагаад гэвэл, тэдний уураг тархинд буй дархлалын эсүүд нь унтаахай төлөвт орсон байдаг ажээ.

Хүний бүтээлч сэтгэлгээ хомсдох өвчин 1870-аад оны үеэс анх мэдрэгдсэн байна. Тэгмэгц барууны орнууд боловсролоо элитийн ба массын гэж хоёр хуваагаад элитийн боловсролыг академик руу, массын боловсролыг прагматизм руу хандуулж, ингэснээр нийгмийнхээ хөгжлийг цөөнх нь чиглүүлж, араас нь олонхи масс нь дэмждэг тогтолцоонд шилжиж чадсан байна. Харин энэ хугацаанд колони болон буурай хөгжилтэй орнууд .ялангуяа ЗХУ-ын хараанд байсан Монгол мэтийн цөөн улс хийсвэр, бүтээлч бус боловсролыг хавтгайд

нь хөгжүүлж, энэ нь эргээд улс орных нь эдийн засгийн хөгжлийг нь чөдөрлөн тушжээ.

1960-аад оноос барууны орнуудад, прагматик боловсролын дутагдал хурцаар илрэх болов, тэр нь оюутан сурагчдын сэтгэлгээний оюунлаг тал хоцрогдож байгаагаар мэдэгдсэн байна. Үүнийг прагматизмаас эхтэй бүтээлч сэтгэлгээний хомсдол гэх бөгөөд тэдгээр улсад ихээхэн газар авчээ. Прагматизмээс эхтэй «БОХ» (товчилсон тэмдэглэл нь П-БОХ), академикээс үүдэлтэй «БОХ»-ын (А-БОХ) хооронд зарим ялгаа бий. Тухайлбал, манай Бодханж-1,2,3 нар нь А-БОХ ын вирус тээгч, тэд өдөржингөө ярьсан ч эцэхгүй, яриад л, ухуулаад л, онолдоод л байж чадна. Гэтэл Бодханж-2-н дүү Подханж нь бүр өөр. Подханж нь 70-аад онд ТМС төгссөн, барилгын ажилд морь нохой мэт зүтгэсний буянаар, бас ахын дэмжлэгээр олон том одонтой болсон ч зүүх биеэ барж, эдүгээ хэвтэрт, тэгээд ч чаддаг юм нь ганцхан шавар зуурах, тэгэхдээ зөвхөн хүрээр шүү, ингэхлээр монголд ч гэсэн П-БОХ-ын вирус тээгч бас байх шиг. Монголд газар авсан нь А-БОХ, баруунд газар авсан нь П-БОХ. Энэ тухайд XIV Далай лам Данзанжамц вээр «Манай боловсролын тогтолцоо бүхэлдээ хоцорчээ. Бүх юм бидний санаж бодсоноос өөрөөр эргэж хараа хяналтаас гарч байна» гэсэн билээ.

Бүтээлч сэтгэлгээний хомсдол «БОХ»-ын эсрэг вакцин хийх гэж эрдэмтэд олон жил шургуу ажилласны ачаар 1970-аад онд түүний нэг хувилбарыг олж СОРТ хэмээн нэрлэжээ. СОРТ-ыг монголоор Оюун ухааны хүрээлэн гэж орчуулав. СОРТ-ыг нээсэн эрдэмтэнийг Эдвард де Боно гэдэг, тэрээр дэлхийн түвшинд нэр нь цуурайтсан профессор бөгөөд эдүгээ алдарт Кембрижийн их сургуулийн дэргэдэх «Сэтгэлгээний ур чадварын төв»-ийг тэргүүлдэг. Кембрижийн их сургууль нь хүний оюун сэтгэлгээг гойд үнэлдэг газар л даа.

Энэ зуны тухайд Эдвард де Боногийн бие төлөөлөгч Питр де Боно БНХАУ-д хоёр сар ажиллав. Манай улсаас «Монгол улсын Оюуны Чадварын IQ төв»-ийн гүйцэтгэх захирал Д.Өлзийбадрах биечлэн очиж уулзсан байна. Боно гуай манай төлөөлөгчид «Танай Монгол мэт буурай хөгжилтэй, цөөн хүн амтай оронд хийсвэр академик боловсрол үр өгөөжөөр бага юм, та нар дэлхийн шинжлэх ухааныг хөгжүүлнэ гэхээсээ өмнө өөрсдөө хөгжихөө бод, робот хийж дэлхийг эзэгнэх гэж байгаад өөрсдөө робот болчихуузай, бодит байдлаа сайн хар, ер нь та нөхөд нилээд бүтээлч бус сэтгэж байж мэднэ,

учир нь бүтээлч сэтгэлгээ дутсанаас л улс гэрийн хөгжил дэвшил гацдаг, монгол хүн англи биднээс бие махбодийн хувьд дутуу биш шүү дээ, гагцхүү бүтээлч сэтгэлгээний хомсдолд л нэрвэгдсэн байх, боловсролоо шинэчлэх шаардлагатай, оюун ухаанаа хөгжүүлэхийг чухалчил, сургуулиудад энэ чиглэлийн хичээлийг ахиу оруул, ахлах ангиудад СОРТ курсыг ашиглаарай, бид туслая» гэж хэлсэн байна. Энэхүү СОРТ курсыг одоогоор дэлхийн олон орон ахлах сургуулийнхаа (IX, X, XI ангиуд) албан ёсны хичээл болгон хэрэглэж .байгаа аж. Зөвхөн Венесуэль улс гэхэд л СОРТ курсыг заах 200000 багш бэлтгэсэн гэнэ. Тэнд сурагч оюутнууд өдөр бүр хичээлийн хоёр цагийг сэтгэж сурахад албан ёсоор зориулдаг ажээ.

Монголчууд «өвчин хэлж ирдэггүй, хийсэж ирдэг» гэлцдэг, үнэн худал нь бүү мэд, ямартай ч эрдэмтдийн хэл ярианд хийсэж ирдэг өвчин гэсэн ойлголт байдаггүй, өвчин хийсэж ирдэггүй, хэлж ирдэг, тэгэхлээр «БОХ» нь хэлж ирсэн төдийгүй, манай боловсролоос өөрөөс нь ургасан өвчин, өвчинг гуйж явуулахгүй, хөөж явуулна, иймд «БОХ»-ыг хамтын оюун ухаанаар хөөн зайлуулцгаая.

Бүтээлч сэтгэлгээний хомсдолоос салах цаг айсуй, салхи хөдлөв бололтой...

**БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ХОМСДОЛЫГ ҮЛДЭН ХӨӨХ ИХ  
САЛХИ НИЖИГНЭНХЭН ХӨДӨЛТҮГЭЙ**

## *ГАДНЫХАН МОНГОЛЧУУДЫГ АМЬТАНЛАГ СЭТГЭХҮЙТЭЙ ГЭЖ ДҮГНЭДЭГ*

---

Монголын нэг өдөр 2002. №04

*Та хувийн дээд сургуулиудыг нэгтгэх асуудлыг санаачлан хөндөж тавьж байгаа гэсэн. Энэ асуудлыг чинь хувийн их дээд сургуулиудын зөвлөл хэр дэмжиж хүлээн авч байна вэ?*

Олон хүний эрх ашиг хөндөгдөх болохоор нэлээд эмзэглэж байгаа тал байгаа байх. Энэ талаар бид материал бэлдээд тараачихсан байна. Үүнийг сонирхож байгаа олон ч хүн байна. Яагаад ингэж байна вэ гэхээр манай Монгол улсын боловсрол маш тархай бутархай, хоосон цээж болчихсон юм. Жишээ нь намайг саяхан Увс аймагт явж байхад нэг өвгөн надтай тааралдаад хэлж байна л даа. Би 3 охин, 1 хүүтэй хүн. Хүү маань ТМС төгсөөд мужаан болсон юм. Эрэгтэй юм чинь өөрийгөө болгох байлгүй гээд нэг их дэмжээгүй. Харин 3 охиноо гурвууланг нь сая гаран төгрөг зарж байж их сургууль төгсгөлөө. Гэтэл гурван охин маань өнөөдөр ажилгүй байна. Миний гурван охиныг миний тэр мужаан хийдэг хүү л тэжээж байна. Тэгэхээр нь би хариулсан л даа. Зах зээлийн үед дипломоор мөнгө олдоггүй юм. Манай томоохон компаний нэг Мобиком корпораци хүмүүсийг ажилд авахдаа дандаа оюун ухааныг нь шалгадаг болсон. Диплом дээр ямар ч дүн тавигдсан байж болно. Ямар ч дүнтэй төгсөж болно. Та үүнийг бодоорой гэсэн. Ийм нөхцөлд чанартай боловсон хүчин бэлтгэх хэрэгтэй. Өнгөрсөн хавар хуулийн мэргэжлээр төгссөн 100 бакалаврын 99 нь ажилгүй байна шүү дээ. Хов хоосон л байгаа байхгүй юу. Манайханд худлаа хөөрцөглөж ажил хийдэг нэг зуршил байна. Даган дууриаж хөөрсөн, савангийн хөөс шиг ийм нөхцөлд хувийн сургуулиудын тоо ч зуу хол давлаа. Бас хувийн сургуулийн хэсэг хүмүүс ашгийн төлөө ажиллаж байна. Үүнээс болж олон хувийн сургууль дампуурч таарна байх.

*Хүний өмч гэдэг бол оюуны чадавхи гэдэг. Монгол хүний ой ухаан, санамж хэр түвшинд байдаг юм бэ?*

Яг потенциал боломжийн хувьд Монгол, Америк, Хятад хүн гурвуул

адилхан. Гэтэл амьдрал дээр энэ боломжоо хэр ашиглаж байна вэ гэвэл тэр Америк, Японд бол үндсэндээ бараг 100 хувь дөхүүлж ашиглаж байна. Гэтэл манай орны иргэд оюун ухааныхаа боломжийн 20 орчим хувийг идэвхжүүлж байна.

*30-аад оны цөийн хэлмэгдүүлэлтийн цээр манайхан арай дөнгүүр хүмүүсээ нударчихсан. Одоо төрийн толгойд байгаа хүмүүсийн оюуны чадамж хэр түвшинд байдаг юм бол?*

Гадаад орнууд хуучин ч гэсэн одоо ч мөн адил өөрийн харъяалалдаа байгаа орныхоо аль адтай хэсгийг нь нударчихдаг байжээ. Тэгвэл толгойгүй болчихож байна гэсэн үг л дээ. Толгойгүй ард түмнийг юугаар ч хуурч залж болно. Энэ утгаараа манай оюуны торгон элитүүдийг хоёр хөрш маань гоочилсон юм. Өнгөрсөн зуунд буюу түүнээс өмнө манай оюуны элитийг хооронд нь хэрэлдүүлдэг, дундуур нь яс хаяж мөргөлдүүлдэг төрийн том бодлого явж. Дараа нь энэ байдлыг ард түмэн мэдээд байхлаар ингэж устгадаг нь буруу юм байна гээд уусгачихъя гэдэг болсон. Уусгая гэдэг нь өөрийнхөө охидыг өгөх, эсвэл өөрийнхөө оронд аль багаас нь сурган хүмүүжүүлээд, орос авгай аваад өгчих гэх мэт. Тэгэхээр зэрэг Монголд төрсөн, орос хүн байгаа биз дээ. Харин одоо бол огт өөр болсон. Оюун ухаантай хүмүүс гараад ирэхээр нь сайн нөхцөлөөр татаад авдаг болсон. Дотор нь ч орох хэрэггүй, сургууль байгуулж өгөх ч хэрэггүй, алж болохгүй, зүгээр сайн нөхцөлөөр нь татаад авдаг болсон. Манайхаас гадаадад төрийн хөрөнгөөр 400 гаран хүүхэд сурч байгаагаас 11-хэн хүүхэд эргэж ирсэн. Ирсэн хэд нь энд ажил хийж байна уу? Харин тэгж ярьвал тэр орнуудынхаа гар хөл болчихсон, энд янз бүрийн зээл гэх мэтийг суурилуулж өгдөг, баталгааг нь гаргуулж өгдөг ийм ажил хийж яваа болов уу. Тэд улс төрд ч, шашинд ч явж байж мэднэ шүү. Тэр талаас нь харвал гадныхан маш зөв бодлого явуулж байнаа даа. Ерөөсөө л оюун ухаантай хэсэг нь буурайгаа дарлаад ашиглаад, монжоод байгаа юм. Үүний эсрэг төрийн маш уран нарийн бодлого хэрэгтэй боловч харамсалтай нь манайд энэ бодлого алга.

*Ер нь төрийг их ухаантай хүн удирддаг юм уу, ажил сайн гүйцэтгэдэг хүн удирддаг юм уу?*

Хоёулаа л хослох ёстой. Ухаан муутай хүн шоргоолж шиг ажиллаад ч нэмэргүй. Ухаан ихтэй хүн сэтгэл нь хүйтэн байвал тэгээд өнгөрөө.

*Дорнын улсууд голдуу төрийн хар хайрцагны бодлогоо их*

*эрхэмлэдэг. Энэ тал дээр та ямар бодолтой байдаг вэ?*

Хуучин удам дагаж төр барьдаг хаанчлалын тоталитар нийгмийн үед ийм байсан. Одоо бол удамлахгүй, оюун ухаанаа дээдэлж төрийн бодлого хөгжсөөр байгаа юм. Манайд батлан хамгаалах систем гэж байнаа даа. Гэтэл манай батлан хамгаалах систем өнөөдөр махбодийг хамгаалах систем болчихсон байна шүү дээ. Газар нутгаа хамгаална, танк буу зэвсэг барина. Үүнийг байхыг үгүйсгэхгүй. Гэвч энэ чинь харин дэндэж байна. Ингэж их хөрөнгө шидэмгүй байна. Оюун ухааныг нь аваад явчихвал махбодийг манаад яах вэ дээ. Одоо үед чулуу хүнийг хамгаалахгүй шүү. Ухаантай хүнийг л хүн хамгаалах ёстой болохоос биш.

*Далайн амьтан, ургамал идэхээр их ухаантай болдог гэсэн яриа байдаг. Гэтэл манай орон тэр далайгаас чинь их хол хөндий шүү дээ?*

Энэ талаар маш нарийн судалгаа шаардлагатай. Одоогоор энэ чиглэлийн ажлын комиссууд гарах гэж байх шиг байна. Ямар ч байсан иод дутагдахад хүний оюуны хөгжил хоцордог нь тодорхой. Иод чинь өөрөө далайн загсанд их байна шүү дээ. Монголд үүнийг орлуулагч юу байна. Мөн хоёрдугаарт монгол хүний биенд иодын дутагдлыг нөхдөг механизм байж мэднэ шүү дээ.

*Дэлхий нийтэд еврей хүмүүс гэж золигийн ухаантай хүмүүс байдаг. Хаана том нээлт болно тэнд еврей байж л байдаг. Энэ тал дээр та юу хэлэх вэ?*

Энд хоёр хүчин зүйл байна. 1-рт еврей хүнд төрөлхийн өөрийн нутаг гэж байгаагүй. Газар газраар тэнэж явдаг. Уугуул нутаггүй хүн чинь олон дотор оршин байхын тулд тэмцэлддэг. Харин тэмцэлдэхдээ хар хөлсөөрөө, бяраараа тэмцэнэ гэж байхгүй. 2-рт еврей хүмүүс хүүхдээ бараг гарахаас нь эхэлж оюуны хөгжилд нь гойд анхаардаг, еврей айлд ээж, аав хоёр нь хүүхдүүддээ уран цэцэн үг, сэтгэлгээ бүгдийг багаас нь зааж хөгжүүлдэг. Удамшигчсан оюуны гимнастикийг байнга хийдэг гэсэн үг. Одоо жишээ нь оросын банкирууд гэхэд л үндсэндээ еврей нар байна шүү дээ.

*Ухаантай хүмүүсийн генийг авч үлдэх тухай яригдаж бүр ген банк байгуулах тухай яригдаж байсан. Энэ асуудал юу болсон бэ?*

Генийн банк байгуулах асуудал их төвөгтэй. Энэ ерөөсөө орчлон ертөнцийн хөгжлөөр бол тусгай үүлдрийн хүмүүс гаргана гэсэн үг. Сайн үүлдрийн хүмүүс гаргана гэдэг бол төвөгтэйгээр барахгүй баталгаатай зүйл биш. Хөгжлийн зүй

тогтлыг эвдэж болдоггүйд учир нь байна. Ухаантай айлын хүүхэд ухаантай, ядуу айлаас тэнэгдүү хүүхэд гардаг гэж ойлгож болохгүй. Тийм учраас монголын нөхцөлд хөдөө орон нутагт явж байхад хүүхдийн оюун ухааныг нь хөгжүүлэх асар их боломж байна. Миний мэдэж байгаагаар хөдөөгийн хүүхэд хотынхоос яавч оюун ухаан нь дутуу биш. Мөн манайхны нэг дутагдал бол хар тэнхээг оюун ухаанаас илүүд үздэг. Чи бод доо. Морины тухай дуу лав л 1000 гарсан байна. Гэтэл энэ чинь надаас ангид байгаа, тэгээд амьтан шүү дээ. Өнөөдөр морь унасанаараа гайхуулдаг үе өнгөрчихөөд байна. Гэтэл Монгол оронд оюун ухааныг дээдэлсэн дуу хэд байна. Бас нэг жишээ байна. Хурдан морины уралдаанд түрүүлээд ирж байгаа соёолон морины хөлсийг духандаа түрхдэг. Гэтэл миний ойлгож байгаагаар их хэмжээний хөлс, давсыг л ам хамар луугаа чихчихээр чинь тэр хэмжээгээр хордоно биз дээ. Үүнээс болж хүний хийморь сэргэдэг юм уу. Би сая сумаараа ороод ирлээ. Тэнд маш их цастай байна. Тэд өнгөрсөн жилийн соёолон морины хөлсөөр цөмөөрөө л нүүрээ арчсан гэж ярьж байна. Тэгээд зуднаас хамгаалагдаад мал нь сайн болсон нь хаа байна. Харин түүний оронд оюун ухаан нь хөгжсөн хүний хөлснөөс аваад түрхчихвэл би арай дээр гэж бодож байна.

# *ОЮУН УХААН, СЭТГЭХ ЧАДВАР БА МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫН ХОЛБООНЫ ТУХАЙ*

---

Өдрийн сонин 2002. 11. 12 №276

Сүүлийн үед хүмүүс оюуны чадварын коэффициент IQ —гээ өсгөхийг ихэд чухалчилдаг болсон нь мэдрэгдэнэ, энэ сайн хэрэг, бас сэтгэлгээгээ хөгжүүлэх, сэтгэлгээний шинэ төрлүүдийг эзэмших хөдөлгөөн хөдөө хотгүй өрнөх болов, энэ бүр ч сайн хэрэг, харин мэдлэг боловсролын тухайд хүмүүсийн ам тийм ч сайнгүй байх шиг..., үүнтэй холбогдуулан оюун ухаан, сэтгэх чадвар, мэдлэг боловсрол гэсэн гурван ойлголтын хоорондох холбооны талаар дараахь тодруулгыг хийж байна.

Оюун ухаан гэдэг нь хүний анхдагч мөн чанар юм. Хүнийг амьтны аймгаас оюун ухаан л ялган тодруулсан, энэ утгаараа ХҮН гэдэг ухагдахууныг оюун ухаанаас ангид авч үзэх ямар ч боломж байхгүй. Оюун ухаан бол хүний тухайд суурь чанартай ухагдахуун мөн

Оюун ухаан нь хүнд БОЛОМЖ байдлаар анхнаасаа заяагдана, энэхүү боломжийг хөгжүүлэх, эс хөгжүүлэх, ашиглах, эс ашиглах нь тухайн хүний сэтгэх чадвараас ихэд хамаарна.

Кембрижийн их сургуулийн профессор Эдвард де Боно “Сэтгэлгээ нь туршлагатай хавсран оюун ухааны үйлчлэх чадвар юм. Зүйрлэвэл, IQ —нь авто машины хүчин чадал бол сэтгэлгээ нь жолоочийн ур чадвар болж байна...., Би хэдэн зуун мянган бизнес эрхлэгчид, эрдэмтэд, инженерүүд, багш нар гэх мэт олон хүмүүст лекц уншиж байв. Тэдгээр нөхөд сэтгэлгээг бие даасан хичээл болгон заахын ач холбогдлыг онцлон тэмдэглэж байлаа” гэжээ. Та хүн учраас оюун ухаанаараа ажил хийх ёстой, өөрөөр хэлбэл, та сэтгэх чадварыг эзэмших ёстой, ингэж байж сая үр дүнд хүрнэ.

Оюун ухаан, сэтгэх чадвар хоёр нь мэдлэг боловсролтой ихэд холбогдоно, ялангуяа, мэдлэг нимгэн бол яаж ч чармайгаад хол явахгүй, та бидний дунд оюуны дажгүй чадвартай атлаа мэдлэг боловсрол нимгэнтэй, үүнээсээ болоод, хүн малын тоосонд дарагдан нийгмийн дунджаас доогуур амьдарч яваа эгэл борчууд элбэг таардаг.


Үүнийг хэн хүнгүй харж, мэдэрч байгаа болохоор боловсрол мэдлэгийн араас хошуурах үзэгдэл хавтгайрсан, энэ нь ч зөв юм. Хүн төрөлхтөн их юм мэдэхийн төлөө, сайн мэдлэг боловсролтой болохын төлөө эцэж цуцахыг мэдэхгүй зүтгэж, хөдөлмөрлөж, бүтээсээр хөгжлийн ийм өндөрлөгт хүрсэн нь баримт юм шүү. Мэдлэг боловсролыг үгүйсгэх нь, тэр тусмаа мэдлэгийн эрин хэмээгдэх энэ цаг үед байж болшгүй, гойд уршиг дагавартай зүйл мөн. Ихийг мэдэх, боловсролтой болохын шаардлага ийм буюу.

Мэдлэг боловсрол гэдэг холбоо үгийг та бас анхааралдаа аваарай, учир гэвэл боловсрол нь мэдлэг дээр тулгуурлаж байж амилна, мэдлэгээсээ хөндийрсөн боловсрол нь үндсэндээ хоосон болой. Сүүлийн үед мэдлэг багатай атлаа боловсролын зэргийн диплом өвөртөлсөн залуус олшрох аястай байх шиг, тэр ч ёстой муу даа...

Оюун ухаан, сэтгэх чадвар, мэдлэг боловсролын хооронд яг нэгэн утгатай холбоо бас ч гэж байхгүй юм, өөрөөр хэлбэл, эдгээрийн нэгийг нь нөгөөгөөр нь орлуулан хялбарчилж болохгүй. Тэр тусмаа байрыг нь сольж бүр ч болохгүй, дарааллын хувьд оюун ухаан нь анхдагч, сэтгэх чадвар нь хоёрдогч, мэдлэг боловсрол нь гуравдагч юм, та эхлээд сайн боловсролтой болж аваад дараа нь IQ –гээ хөгжүүлчихнэ гэж бодуузай, төөрч байгаа чинь тэр шүү, бас IQ –гээ өсгөчихвөл л болох нь тэр, боловсрол ч яамай гэж бодуузай, эндүүрч байгаа чинь тэр, харин IQ –гээ өсгөх явцдаа сэтгэх чадвараа давхар хөгжүүлээд мэдлэг боловсролоо ахиульа гэвэл өөр хэрэг, ингэвэл ононо. Та бидний дунд дажгүй боловсролтой атлаа сэтгэлгээний хувьд явцуу хүмүүс бас ч гэж бий шүү, тэднийг “ Сэтгэлгээний хомсдолд өртөгсөд ” гэе, бас өмнө дурдсан гайгуу IQ-тэй атлаа боловсрол нимгэн хүмүүс бий, тэднийг “ Боловсролын хомсдолд нэрвэгдэгсэд ” гэе, бас боловсролын сүрхий зэрэгтэй атлаа мэдлэг нимгэнтэй хүмүүс бий, тэднийг “ Мэдлэгийн хомсдолд автагсад ” гэе, бас ....үүнийг уншигч та өөрөө бодож ол.

Хүн та энэхүү олон хэлбэрийн хомсдолын алинд нь ч өртөхгүй байхыг чармайгтун, тодруулбаас, IQ-гээ ч өсгө, сэтгэлгээгээ ч хөгжүүл, мэдлэгээ ч арвижуул, боловсролоо ч дээшлүүл...

Оюуны чадвар IQ, Сэтгэлгээ, Мэдлэг боловсрол гэсэн гурвалын хоорондох холбоог схемээр үзүүллээ, энэхүү схем нь барууны орнуудад хэрэглэгдсээр гойд алдаршиж, эдүгээ хүн бүрийн мэддэг, ашигладаг нэгэн төрлийн “хоол” болжээ.



Энэхүү схемийг сайтар ажиглаваас дараах хэдэн зүйл тодрон байх бөлгөө.

Нэг. Та бид өнгөрсөн жилүүдэд IQ, сэтгэлгээ, мэдлэг боловсрол гэсэн гурвалын зөвхөн мэдлэг боловсрол хэмээх нэгийг нь хэтэрхий онцлоод нөгөө хоёрыг нь орхигдуулсан ажээ. Схемтэй холбон тайлбарлавал, та бид хүүхдийн оюун ухааныг

хөгжүүлэх буюу энэхүү савны хэмжээг томсгох ажлыг мартсан байна. Үүний уршгаар хүүхэд багачууд, сурагч оюутнуудын оюуны чадварын коэффициент IQ нь харьцангуй доогуур болох аюул нүүрлэв, бага саванд бага л юм багтана биз дээ, уг нь савны хэмжээг тэлэх ажил хамгийн эхэнд байх учиртай.

Хоёр. Сэтгэлгээ хэмээх цорго аль болох нээлттэй байх ёстой, эс тэгвэл, үр дүн нь бага болно. Цорго хаалттай юмуу эсвэл тэр цоргоны дөнгөж 20 хувь нь нээлттэй бол хичнээн их юм мэдлээ гээд гарах үр дүн нь их бодож л 20 хувьтай байх болно. Монголд ийм байгаа юм шүү дээ. Хашир хүмүүс “Энэ хүүхдүүд сураад л байдаг, сураад л байдаг, бодит үр дүн гарахгүй нь гээч, сэтгэх сүв нь бөглөрчихсөн юм биш биз?” гэж асууж байна, эцэг эхчүүд үүнийг зөнгөөрөө мэдрээд байгаа бололтой.

Гурав. Савны дотор ер нь юу гээч юм байгаа бол, миний багцаалснаар, савны дотор байгаа мэдлэг боловсрол гэдэг юмны лавтайяа 50 хувь нь цаг үеэсээ хоцорсон бололтойдог, би үүнийг зөнгөөрөө мэдрээд байгаа хүн л дээ... Ингээд та бид дараах дүгнэлтэд хүрлээ.

### ДҮГНЭЛТ:

Нэг. Оюун ухаан, сэтгэх чадвар, мэдлэг боловсрол гурав нь салшгүй амин холбоотой бөгөөд энэ гурвын аль нэгийг нь туйлшруулан шүтэж нөгөө хоёрыг нь орхигдуулж болохгүй.

Хоёр. Монголд энэ гурвын сүүлчийнхийг нь хэтрүүлж, эхний хоёрыг нь орхижээ, гэхдээ харамсалтай нь мэдлэг боловсролынхоо мэдлэг талыг нь бас орхигдуулаад дан боловсролыг нь шүтчихжээ, хэтрүүлнэ, хэтрүүлнэ гэхэд

арай дэндсэн байгаа биз, ёстой л хэлэх үг олдохгүй байна даа... .

Монгол хүнийг янз бүрийн олон юм мэддэг, тэгсэн атлаа түүнийгээ хэрэглэх чадвараар сул гэж гадаадынхан дүгнэдэг юм билээ, энэ үнэн байх. Оюун ухаан, сэтгэлгээ хоёрыгоо орхичихоод ганцхан боловсролыг, тэр тусмаа хийсвэрдүү бөгөөд хүйтэндүү хэлбэрийг нь туйлшруулан шүтчихээр ийм болдог биз. Номонд “ Оюун ухаан ба сэтгэлгээг орхигдуулсан улсын иргэд нь их ярьж, бага хийж, их үймүүлж, бага бүтээдэг гаж араншинтай болно, үүний хор уршгаар улс гэр нь дэлхийн хөгжлөөс хоцрогдон гээгддэг” гэж бичсэн байна. Бид бага ярь, их хий, бага үймүүл, их бүтээ гэж ярьсаар байгаа боловч үнэн хэрэгтээ одоогийн боловсрол маань хүмүүсийг их ярьж багыг бүтээдэг занд сурган зүгшрүүлж байх бөлгөө, үүнийг ам ажлын зөрөө гэнэ, ийм зөрөө та бидний алхам дутамд таарч байна.

Одоогийн байдлаар улсын хэмжээгээр нилээд олон цэцэрлэг, ЕБС дээр “Оюуны хөгжил- IQ” хичээл явагдаж байна, үүний үр дүнд сурагч багачуудын оюуны илтгэцүүр IQ-нь өсөх аясыг олов, цаашид энэ ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх учиртай. Хүүхэд 16 нас хүртлээ “Оюуны хөгжил-IQ” хичээлд жил бүр хамрагдан суралцах шаардлагатай нь онолын хувьд төдийгүй практикийн талаасаа яг таг тогтоогдсон байна, учир нь хүүхдийн оюун ухаан энэ насыг хүртэл тогтвортой өсөн нэмэгдэх боломжийг агуулдаг ажээ.

***Асуулт: Хүүхдийг хэдэн наснаас нь эхлэн оюуны хөгжлийн хичээлд хамруулах ёстой вэ?***

Хариулт: Хүүхдийг аль болох багаас нь, чадвал эхээс гармагц нь оюун ухааныг нь хөгжүүлж эхлэх ёстой, манай зарим ээжүүд нярай хүүхдээ бага гэлгүй өмнөө гар дээрээ манцуйтай нь барьчихсан харилцан яриа өрнүүлж байдаг нь гойд ач холбогдолтой юм, энэ бол манай уламжлалт арга технологи дотор шалгарсан сайн аргууд цөөн бус байгааг гэрчилнэ, гагцхүү сүүлийн жилүүдэд нилээд мартагдах янзтай болов, одоо сэргээх шаардлагатай. \Венесуэль улсад хүүхдийг эхийн хэвлийд хөдөлж эхэлмэгц нь эхээр нь дамжуулан, АНУ-д хүүхдийг хэвлийд олдохоос нь бүр өмнө эх эцэг хоёроор нь дамжуулан ийм хичээлд хамруулдаг хөтөлбөрүүд бий\

***Асуулт: Манай хүүхэд 13 настай, ингэхлээр оюун ухаан нь хөгжих боломжгүй болсон уу?***

Хариулт: Та нилээд цаг алдсан нь илт байна, гэхдээ одоо нэмж цаг алдвал бүр дордоно, иймд алдсан цагийн төлөө, өнгөрсөний төлөө санаа

зовж байхаар маргаашийнхаа төлөө санаа тавь, өөрөөр хэлбэл нэг өдрийн өмнө ч болов шалавхан шиг хүүхдээ “Оюуны хөгжил-IQ” хичээлд оруул. Таны хүүхэд бас ч гэж гайгуу байна, миний бага хүү 15 наснаасаа эхлэн IQ хичээлд орж эдүгээ 3 дахь жилдээ суралцаж байна.

Сүүлийн үед сэтгэлгээний курс CORT гэж ярьж бичих боллоо. Энэ нь зургаар үзүүлж буй схемийн ЦОРГО —той холбогдоно. Монголын хувьд энэхүү цоргоны дөнгөж 20 % буюу нээгдэх ёстой нийт хэмжээний тавны нэг нь нээлттэй, үлдэх 80 % нь буюу тавны дөрөв нь хаалттай байгаа юм, харамсмаар хэрэг шүү, сурагч оюутнууддаа багш бид нар хичнээн их зүйл заадаг билээ, тэгсэн атал эцсийн үр дүн нь санасанд хүрэхгүй байгаа биз дээ, гарц нь гавьдаггүйн учир энд байгаа ажээ, одоо л нэг учир нь олдов бололтой, олдсон нь л яамай, одоо ажиллахаас өөр зам байхгүй.

### *Асуулт: Яаж ажиллах вэ?*

Хариулт: Уг нь 16 — аас дээш настай бүх хүнийг сэтгэлгээний курс CORT-д хамрах ёстой, ийм сургалтыг төрөөс тодорхой хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг нь гадаадын жишээнээс харагдана, гэхдээ, иргэн та өөрөө өөрийнхөө төлөө эхлээд хөдлөх учиртай, CORT курсийн хичээлд суу, хамгийн дөт зам энэ, та бусдыг хараад нэмэр бага, харин тэд тантай өрсөлдөг..., ийм аргаар та ч хөгжинө, бусад чинь бас хөгжинө, нийгэм ч хөгжинө.

Зургаар үзүүлсэн схемийг машинтай зүйрлэе, тэгвэл одоогийн байдлаар манай монгол машины эд ангиуд нь энд тэнд салан гээгдсэн, мотор нь ойрдоо дэгэн догон ажиллах болсон, бас жолооч нь байхгүй, тэгсэн атлаа тэвшин дээр нь баахан ачаа аччихсан байдалтай, тэр ачааны ихэнх нь хуучирсан таваар байх бөлгөө, ийм юм гэж байх уу?, та энэ машинаар их ажил хийж чадах уу? Одоо хоёулаа хамтарч дараах гурван ажлыг хийе, Үүнд:

1. машинаа \оюун ухаанаа\ засан сэлбэж ,тос бензинийг нь хийж ,асаан шалгаж замд гарахад нь бэлтгэе, уг нь манай монгол машин тийм ч муу эд биш шүү.

2. жолоочоо \сэтгэлгээ\ хайж олъё, тэр нөхөр лавтайяа ихэд атаршин эмнэгшсэн байх

3. ачаагаа \мэдлэг, боловсрол\ дахин сайтар шалгаж, хэрэг бага атлаа зай их эзэлдэг, хуучирч муудсан бөгөөд замд ялзран мууддаг зүйлсийг нь ялган хаяж, шинэлэг мэдээллээр сольё....

Оюун ухаан, сэтгэх чадвар, мэдлэг боловсрол гурвыг дэс дарааллаар нь зөв холбон идэвхжүүлэхийн учир зүй ийм байх ажээ.

## *ОНОЛЫН ХУВЬД МОНГОЛЫН 2 САЯ 400 МЯНГАН ХҮН ДОТОР АУГАА СУУТАН БАЙХ МАГАДЛАЛ МАШ БАГА*

---

Улаанбаатар таймс 2003. 01. 07 № 03 (799)

*-IQ гэдэг нэр томъёог манайд хэдийнээс хэрэглэж эхэлсэн бэ?*

-Сүүлийн гурван жил манайд энэ нэр томъёог хэрэглэж байна. Ер нь дэлхий дахинд бол оюуны чадвар гэдэг нь 1890-ээд оноос яригдаж, судлагдсан зүйл. XX зуунд барууны орнууд IQ гэдгийг жирийн хоол мэт хэрэглэдэг болсон. Оюуны хөгжлийн дасгалуудыг хийгээд бүр хэвшчихсэн гэсэн үг. Барууны их дээд сургуулийн профессорууд өдөрт хоёр цагийн турш оюун ухааны дасгалыг байнга хийж байна. Өндөр настай хүн ч энэ дасгалыг хийдэг. Ерөөсөө хэрэглээ болсон байна л даа.

*- IQ гэж чухам юу болох, түүний тухай товч ойлголт өгөхгүй юу?*

-IQ нь англиар intelligence quotient буюу монголчилбол оюуны илтгэцүүр, оюуны хөгжлийн үзүүлэлт гэсэн үг. Өөрөөр хэлбэл IQ нь тухайн хүүхдийн оюун ухааных нь ерөнхий хөгжил, төрөлхийн өгөгдөхүүн, гоц авьяас чадвар зэргийг харуулдаг багц үзүүлэлт юм. Хүн төрөлхтний 0,4 хувь нь 140-өөс дээш IQ-тай буюу сод ухаантай гений, 0,4 хувь нь 70-аас доош IQ-тай буюу оюун ухааны хомсдолтой байдгийг эрдэмтэд тооцоолон гаргасан байгаа юм.

*-Манайд үүнээс өмнө оюун ухаанаа хөгжүүлье гэдэг ч юм уу, IQ гэсэн ойлголт байгаагүй гэсэн үг үү?*

-Манай улсын сэтгэл судлалын сурах бичигт 1960-аад оноос IQ гэдэг ойлголт орж ирсэн. “Баруунд IQ гэж юм байдаг. Хүний оюун ухааныг хэмждэг. Хөрөнгөтнүүд нь өндөр IQ-тэй болоод бусдыгаа дарлаж байдаг болжээ. Социализмын үеийн бүх хүн адилхан төрнө. Төрөхдөө дээд зэргийн оюун ухаантай байдаг” гэж бичсэн байх юм. Зөвхөн бичээд л орхисон. Юу ч хийгээгүй, нэг ч тест зохиогоогүй байгаа юм. Өнөөдөр IQ гэхлээр зарим сэтгэл судлаачид сүрхий эмзэглэдэг. Тэд зөвхөн Оросын сэтгэл судлалын сургууль төгссөн, орос боловсролтой, социалист сэтгэл судлаачид юм. Өнөөдөр жинхэнэ шинжлэх ухаанч сэтгэл судлалыг гаргаж ирэх шаардлагатай байгаа юм.

**-Та аль нутгийн хүн бэ?**

-Би Увс аймгийн Завхан сумын хүн. 1955 оны 01 дүгээр сарын 01-ний 01 цагт төрсөн байгаа юм. Ээж маань Цэрэн гэдэг хүн байсан. Их цэцэн цэлмэг, нутагтаа ухаантай гэдгээрээ алдартай хүн байлаа. Ээжийг маань нутгийнхан Цэрэн гэдэггүй Цэцэнхүү гэдэг байлаа. Оёж урлах тал дээр алдартай. Би өнөөдрийг хүртэл ээжийн ухаантай дүйх тийм хүнтэй тааралдахгүй яваа юм даа. Би ээжийнхээ 33, аавынхаа 19 насан дээр төрсөн. Их өвөрмөц, ховор тохиолдол шүү.

**-Та багадаа тоонд сүрхий хүчхэд байв уу? Бага насны дурсамжаасаа хуваалцахгүй юу?**

- Би нэг ах, нэг эгчтэй. Ах маань надаас 12 насаар ах. 4 дүгээр ангиа онц төгссөн хүн л дээ. Ээж маань мал дээр гаргачихсан юм. Намайг үүрээд л явж байдаг. Тоо зааж өгнө. Юм цээжлүүлнэ. Ой тогтоолт гайгүй байсан шиг байгаа юм. Таван настайдаа сургуульд орсон. Би багадаа хэлд орохгүй их удсан гэдэг. Манай нутгийнхан их сайхан хүү юм. Даанч хэлгүй юм гэдэг байсан юм гэнэ лээ. Тэгээд гэнэт л нэг өдөр ээжийгээ тэмээ саагаад зогсож байхад нь -Ээж гэсэн гэдэг. Тэгээд ээж маань мээмээ заагаад энэ юу вэ гэхэд мээм гэсэн. Ингээд долоо хоногийн дотор дуржигнатлаа ярьж сурсан гэнэ лээ. Ямар нэгэн саад л байсан шиг байгаа юм.

10 дугаар ангидаа Улсын математикийн олимпиадад түрүүлж байсан. МУИС, ШУТИС-ийг төгссөн. Арваад жил тоо, эдийн засаг, инженерийн чиглэлээр суралцсан. Ном их уншиж байлаа. Өөрийгөө хөгжүүлэх хамгийн найдвартай, ганцхан арга нь сайн номтой нөхөрлөх юм шүү дээ.

**-Ямар чиглэлийн номонд илүү ач холбогдол өгдөг вэ?**

-Гүн ухааны ном. Уран зохиолын ном их уншдаг. Үүнийг хоёр хуваана. Оюун ухааныг хөгжүүлдэг мөн балайртуулдаг гэж. Оюун ухааныг хөгжүүлдэг нь дэлхийн сонгодог зохиол. Би чамайг орж ирэхээс өмнө Лев Толстойн “Дайн ба энх” -ийг /англи хэл дээр/ уншиж байлаа.

“Дайн ба энх” -ийг уншина гэдэг тийм ч амар наадгай биш. Залуу хүн үүнийг уншаад бүрэн ойлгоно гэдэг амаргүй. Би энэ номыг тав дахиа уншиж байна. Ер нь таваас найман жилийн дотор нэг унших ёстой л доо.

**-Та социализмын цөийн хүн. Англи хэл дээр уран зохиолын ном уншиж байхыг бодоход англи хэлийг тун бузгай сурчээ. Хаана ингэж сурав?**

-Би оюутан байхын үг их тогтоодог. Англи үг 10 мянга, 20 мянгыг тогтооно.

Тэгснээ болиод герман үг тогтоож байсан. Ой тогтоолтоо сайжруулж байхгүй юу.  
**-Оны эцсээр оюуны өндөр чадвартай 10 хүнийг тодруулсан. Тэдгээр хүмүүсийг яаж шалгаруулсан бэ? Эсвэл тест авсан уу?**

-Монгол улсын оюуны чадварын IQ төвөөс оюуны төрөлхийн өндөр чадвартай 10 хүнд батламж гардуулсан. Гол нь бүтээлээр нь үнэлсэн. Энэ хүмүүсийн оюуны чадвар нь 130-аас дээш байна гэдгийг бүтээлээр нь тодруулсан юм. Жирийн хүмүүсийнх бол 70-130-ын хооронд байдаг. 70-аас доош болохоор тэнэг болдог байхгүй юу.

**- Газар нутгийн онцлог нь хүний оюуны чадварт нөлөөлөх үү?**  
**Жишээ нь Увс аймгийн хүүхдүүд ихэвчлэн ТОО физикт сайн байх нь ажиглагддаг.**

- Тийм байж болно. Увс нутгийнхан хэл зүйн интеллект талдаа тааруу. Харин логик интеллект сайтай. Дундговьд гэхэд хэл зүйн интеллект сайн байх жишээтэй. Оюун ухааны чадварын 160 орчим шинж

байдаг. Зарим газраас дуучид, тоочид төрж байхад, заримаас нь уран дархад төрж байна. Маш нарийн судалгаа хийж үүнийг хөгжүүлэх хэрэгтэй юм. Аль нутгаас ямар авьяас төрж байна вэ гэдэг дээр <sup>1</sup> бодолцох ёстой. Оюуны өндөр чадвар гэдэг нь нэгдүгээрт боломж, нөгөө талаас бодит байдал. Жишээ нь математикийн улсын олимпиадад түрүүлж байгаа хүүхэд маш өндөр чадвартай байгаа нь мэдрэгдэж байна. Гэвч энэ чадвар бүтээл болж гарах уу гэдэг асуудал байна. Гарахгүй байна шүү дээ. Эдгээр чадвартай хүүхдүүд нэг бол гадагшаа гараад “алга болж байна”. Эсвэл өөр мэргэжил рүү ороод биеэ тоосон, үр дүн багатай хүн болж байна. Бид энэ чадвартай хүнээ ашиглах ёстой. Гэхдээ манайд ашиглах механизм ч сул байна даа.

**-Танай IQ төв нийслэлээс гадна өөр газар цйл ажиллагаа явуулж байна уу?**

-IQ төв улс даяар ажиллаж байна. Салбарууд маань хүрээгээ их тэлж байгаа. Том сүлжээ ажиллаж байна шүү дээ. Манай төвийн ард дэлхийн тос сүлжээ буй.

**-Сүлжээний бизнес гэдэг шиг танайх оюуны сүлжээнд холбогдохжээ?**

-Тэгэлгүй яахав. Яах аргагүй оюуны том сүлжээ явагдаж байна.

**-Авьяасын тухай асуухгүй өнгөрч болохгүй нь. Авьяас удамшдаг уу?**

-Авьяасанд удамших шинж байна. Гэхдээ 60-70 хувьтай. Түүнийг нээж гаргаж өгөх ёстой юм л даа. Баруунд бол хүүхэд олохоос хоёр жилийн

өмнө аав, ээж нь биеэ эрүүлжүүлнэ. Бүх өвчнөө анагаана. Сүүлийн нэг жил нь сэтгэл санаагаа маш тайван байлгана. Мөн сүүлчийн нэг сар симфони сонсох жишээтэй. Тэгээд хүүхдийг гэдсэн дотор байхад эхтэй нь ажиллаж эхэлнэ. Төрөх хүүхдэдээ маш их анхаарал тавьж байна.

**-Баруунд ч зогсохгүй манай урд хөрш ганц хүүхдийг “генечный” төрцүлэх асуудал дээр онцгой анхаардаг гэсэн?**

-Зян Зэмин, Ху Зинтао, Дэн Сяопинь нар Шанхай талын хүмүүс. Шанхайд ихэвчлэн хятадын элит гэр бүл байдаг. Ху Зинтао-гийн эмэг эх нь Шанхайн оюуны хөгжлийг эрхэмлэдэг холбооны ерөнхийлөгч байсан хүн байгаа юм.

**-Хоёулаа яриагаа эргээд оюуны чадвар руу шилжцүлье. 130 хуртэлх IQ-тай хүн жирийн хүмүүс гэлээ. Түүнээс дээш хэрхэн ангилдаг вэ?**

-131-140 ухаалаг, 141-160 гоц авьяастан, 161-180 сод ухаантан, 181-200 суут, 201-ээс дээш аугаа суутнууд байдаг. Бидний тодруулсан арван хүн бол 130-аас дээш IQ-тай хүмүүс юм шүү дээ. Онолын хувьд монголын 2 сая 400 мянган хүн дотор аугаа суут хүн байх магадлал маш бага. Суут хүн бараг байхгүй. Сод ухаантан байвал нэг л байна. Дэлхийн статистик байдаг. Тэдэн сая хүнээс тэдэн суут, ухаантан төрнө гэж.

**-Ерөөсөө байж болох магадлалыг л ярьдаг юм байна. Тийм үү?**

-Тийм ээ. Манай улсад гоц авьяастан 48 орчим байх магадлалтай. Энд төрөлхийн авьяас заавал яригдана. Жирийн хүнийг жирийн биш болгоно гэж байхгүй. Яруу найргаар бол “галтай” гэсэн үг. Зарим яруу найргийг уншихад эрс мэдэгдэм “галтай” байхад, зарим нь дууриаж бичсэн байдаг биз дээ.

**- Нэг хувийн авьяас, ерэн есөн хувийн хөдөлмөр гэж ярьдаг. Үнэхээр бүх хүнд авьяас байдаг гэж үү?**

-Энэ бол үнэн л дээ. Авьяасгүй бол хэцүү.

**-Танай IQ төв хүүхдүүдийг зөвхөн сэтгэлгээний дасгалаар “нүддэг үү”?**

-Оюун ухааныг хөгжүүлэх янз бүрийн аргууд байдаг. Түүгээрээ хөгжүүлнэ. IQ-ийн хичээлд 60 цаг явахад хүүхэд юманд хандах хандлага нь огт өөр болж байна гэж эцэг эхчүүд ярьж байна. Эхлээд хүүхдийн оюун ухааныг нь хөгжүүлж, дараа нь сэтгэлгээг хөгжүүлдэг. Үүний хойно

мэдлэг олж авсаны үндсэн дээр боловсрол эзэмших юм. Боловсрол гэдэг дөрөвдүгээрт орж байгаа биз.

***-Өнөөдөр оюун ухааныг ярихаас илүү боловсрол олж авах гэж хошуурдаг болжээ?***

-Энэ засагдах ёстой зүйл. Их, дээд сургууль төгссөн хүмүүсийг хөндлөнгийн магадлан итгэмжлэлд оруулаад, суралцах чадварын тест авдаг болно. Энэ тестээр зэс нь цухуйгаад эхэлнэ дээ.

***-Ноднин хавар арав ОРЧИМ хувийн их, дээд сургууль нэгдэж Монголын Нэгдсэн Дээд Сургуулийг байгуулсан. Энэ ажил өнөөдөр ямар шатанд яваа вэ?***

-Ахиц байна. Гэвч харьцангуй удаан үргэлжлэх ажил шүү дээ. Энэ жилийн хувьд багш нар бие биеэ ойлгох, нэгдэхийн давуу талыг ямар нэг хэмжээгээр мэдэрч байна. Зөвхөн нэгдэнэ гэдэг тушаал гараад нэгдчихгүй. Практикаар хэрэгжих ажил. Зайлшгүй нэгдэхэд хүргэсэн оньс механизм ажилд орох шаардлагатай байна.

Ямар ч гэсэн сургуулиуд, мөн багш нар нэгдэх нь ашигтай гэдгийг ойлгосон. Бид нэгдсэн их сургууль байгуулах бодит хөрс суурийг тавьж байна.

***-Тооны чиглэлийн сургуульд элсэх нь дурын нэг хэлний ч юмуу бөхийн ч юмуу сургуульд орохоос арай өөр зүйл байдаг байх. Танай оюутнуудын хүйсний харьцаа ямар байдаг вэ?***

-Өнөөдөр Хан-Уул дээд сургуулийг хүмүүс ойлгодог болсон. Үнэхээр сонирхолтой хүүхэд л төлбөрөө төлөөд сурч байгаа. Харин бид номын сандаа их ном оруулж байх үүрэгтэй.

Ном цөөдөж байна гэж байгаа шүү. Өнгөрсөн хавар гучин гурван хүүхэд төгссөн. Хорин хоёр нь хүү. Сая программ хангамжийн инженерээр 5 охин, 5 хүү төгслөө. Оюутны хүйсийн харьцаа 1:1.

***-Хөвгүүд тоонд илүү байдгийн учрыг та лав ажигласан л байх даа?***

-Сэтгэлгээ талдаа хөвгүүд яах аргагүй илүү. Энэ нь нэг талаар тархины хэмжээтэй ч холбоотой байх аа. Гүн ухаан, математик, “холын хараа”-нд эрэгтэйчүүд тэргүүлдэг. Гэвч сүүлийн үед охид эрс ахиж байна.

Улсын математикийн олимпиад 37 удаа болсон байх юм. Эдгээрт ердөө ганц л охин түрүүлсэн байдаг. Нэлээн дээхэн үед юм шүү дээ. Олимпиадын

бодлого, тест өнөөдөр маш чанга болсон. Жинхэнэ оюунлаг болсон гэж дүгнэж болно.

Манай сургуулийг төгссөн охид очсон газраа дарга болох юм. “Датаком” - д гэхэд гурван дарга байна. Энэ юу гэсэн үг вэ гэхээр, сайн суурь өгөх нь чухал гэдгийг хэлж байна.

*-Танайх хэдэн хүүхэдтэй вэ? Хэр тоочид байх юм?*

-Манайх дөрвөн залуутай Том нь IQ-ийн төвд ажилладаг. Дараагийнх нь менежер, нэг хүү Солонгосын сургуульд сурч байна. Бага маань дунд сургуулийн сурагч. Манай хүүхдүүд их уншдаг Манайх эрх биш телевизортой байх. Бид барагтай телевиз үздэггүй.

*-Яагаад?*

-Юу үзэх вэ дээ. Телевиз үзэхээр цаг алдана. Түүний оронд ширээгээ тойрч суугаад Достоевскийн “Тэнэг” ч юм уу, “Дайн ба энх” -ийг хэлэлцэж суувал дээр байхгүй юу. Зохиолд задлал хийгээд ярих жишээтэй. Мөн гүн ухааныг их үзнэ.

Ухаануудаас илүү нь гүн ухаан байна шүү дээ. Би хааяахан Галкины “Саятан” нэвтрүүлэг, эсвэл гадаад мэдээ сонсдог доо.

*-Та IQ төвийг яагаад байгуулах болов?*

-Манай монгол хүүхдүүд оюун ухааны хөгжлөөр хоцрогдож байна. Хийсвэр боловсрол руу зүтгэж, бодож сэтгэдэг хүн нь цөөрсөн. Үүнийг л засах шаардлагтай. IQ төвийг байгуулсан гол зорилго энэ. Баруунд энэ үзэгдэл 1870 онд илэрч арга хэмжээ авсан байгаа юм. Бид 130 жилээр хоцорч байна шүү дээ

# *ТАМД БАЙДАГ МОНГОЛЧУУДЫН ТОГОО МАНААЧГҮЙ БАЙДАГ НЬ ЛАТЕРАЛ СЭТГЭЛГЭЭНД СУРАЛЦААГҮЙНХ . . .*

---

Зууны мэдээ 2003. 01. 18 № 15 (1213)

Монгол орноо хөгжүүлэе гэж хүн бүр санаа бодлоо уралдуулж , аль байдаг, чаддаг бүхнээ шавхаж байна. Ард түмэн нуруу тэнийхгүй шахам хөдөлмөрлөж , улс төрчид маань чөмгөө дундартал зүтгэж байна, гэтэл эцсийн бодит үр дүн санаанд хүрэхгүй байх юм. Энэ юуных бол. Энэ бол монгол хүнд латерал сэтгэлгээ дутагдсаных .

Гадаадынхан та бидний тухайд дараах зүйлийг хэлдэг байх юм, “ Тамд байдаг монголчуудын тогоо манаачгүй байдаг. Учир нь тэд өөрсдөө өөрсдийгөө татаад унагачихдаг хүмүүс, тэдний дунд жижигхэн яс хаячихад л гүйцээ, хоорондоо өширхөн зодолдоод насаа бардаг харалмарууд “. Энэ үнэн бол юунаас үүдэлтэй вэ. Энэ бол та бид ЛАТЕРАЛ сэтгэлгээнд суралцаж амжаагүйнх

Монгол улс хоёр хөрштэйгээ ч, холын садантайгаа ч сайн харилцаатай байх нь ерөөсөө зүй тогтол баймаар санагдана. Гэтэл улс төрийн намууд маань хөрш болоод садангуудаа хаа гуяар нь хуваан авсан бололтой. Энэ нь минийх, тэр нь танайх гэж булаацалдан бусдын доог болох юм. Ийм улс төр гэж байх ёсгүй дээ. Энэ юуных вэ. Энэ бол монголын улс төрийн намууд ЛАТЕРАЛ сэтгэлгээний хомсдолд өртсөнийх.

Улс төрийн намууд «чи, би»-дээ тулан тэмцэлдэж, би засгийн эрхэнд орчихвол энэ орныг чинь дөрөвхөн жилийн дотор унасан шавраас нь гаргаад бүр цааш нь бар, луу болгочихно гэх юм. Гэтэл арван хоёр жил болоход бар, лууны бараа тасрав , Энэ юуных вэ. Энэ бол манай улс төрчид ЛАТЕРАЛ сэтгэлгээний СОРТ курсэд хамрагдаагүйнх

Монголчууд бид олон зуун жилийн урт түүхтэй, бүтээж өвлүүлж ирсэн өвөг дээдэстэй хүмүүс. Гэтэл тэдний маань өвлүүлсэн эд юмс, эрдэм ном хаачив, яахаараа өвөг дээдсийнхээ өгсөнийг өөд нь татаад авсангүй вэ. Яалаа гэж тэднийхээ бүтээснийг бүрэлгэн устгав. Үр хүүхэд маань бас ийм

болох вий. Тэгвэл та бид өнөөдөр ингэтлээ зүтгэхийн хэрэг байна уу. Олон түмэн яагаад ийм хачин, үрэлгэн болдог вэ. Энэ бол ард олныг ЛАТЕРАЛ сэтгэлгээнд сургаагүйнх.

Монгол хүүхэд багын сэргэлэн цовоо л доо, гагцхүү энэ онцгой зан нь бүтээх талдаа бус бүрэлгэх талдаа илүүтэй тодордог. Гар хөлөөрөө заавал нэг юмыг эвдэж өшиглөж, эрэг шургийг хүртэл салгаж ялгаж байдаг. Гэтэл япон хүүхэд шал өөр. Гурван настай монгол, япон хоёр хүүхдийн эцэг, төрийн түшмэл нэгэн вээр гадаадад сарын томилолтоор явжээ гээ. Монгол хүүхэд тийм, ийм тоглоом надад авчраарай гэж эцэгтээ захиана. Бас хувцас хунар, бүр хэтрээд хоол ч захиж мэднэ. Эх нь түүнийг нь өөгшүүлэн турхирна. Өөрөө бас гархи, чулуу хавчуулна, ирсэнийх нь дараа бэлэг, ээмэг бөгжний бөөн үг хэл. Гэтэл япон хүүхэд шал өөр, “... аав та ажлаа л сайн хийгээрэй, ядруузай, ээж бид хоёрт бэлэг сэлт хайж, хурал семинараасаа оргон дэлгүүр хэсүүзэй, төрийн ажил цалгардаж эх орны маань нэр нүүр хэцүүднэ” гэдэг байх юм. Ялгаа байгаа биз? Энэ жишээг япон хүүхдэд ЛАТЕРАЛ сэтгэлгээ төлөвшүүлдэг зуны сургуулийн нэгэн сурах бичгээс авлаа. Яагаад монгол, япон хоёр хүүхдийн сэтгэлгээний бүтээлч байдал ингэтлээ эрс өөр байна вэ. Энэ бол монгол хүүхэд төрөлхийн бүтээлч бус араншинтай бус, эцэг эхчүүд та бид хүүхдээ багаас нь зөнд нь хаяж, сэтгэлгээнийх нь амьтанлаг араншинг өдөөн турхирдаг, тэднийгээ латерал сэтгэлгээний хичээлд хамруулаагүй орхисноос эх үүсвэртэй юм.

Гурван настай энэ хүүхэд найман нас хүрч сургуульд оров. Багш нь энэ сурагчийг номхон бай, хөдөлж үл болно, миний заасныг яг давтан хэлээрэй, тэгвэл онц тавина, Миний үгнээс зөрөв, тэгвэл арга хэмжээ авна хэмээн сургамжилна. Хичээл дээр аливаа асуудалд олон талаас нь хандах, сурагч, оюутнууд өөрийнхөө санаа бодлыг хэлэх, түүнийгээ хамгаалах нь хориотой. Үүний үр нөлөөгөөр манай багачууд жинхэнээсээ тоть шувуу болдог. Хэдий чинээ сайн тоть болнов, дээд боловсролтой болох магадлал нь төдий чинээ нэмэгддэг. Төгсөлтийн болон элсэлтийн шалгалт үүнд бүрэн үйлчилж байна. Монголын боловсрол нь хүнийг хүн бус шувуу болгодог байна. Яагаад ийм гунигтай байдал үүсэв. Энэ бол монголын аль ч шатны сургуульд одоо болтол латерал сэтгэлгээний хичээл албан ёсоор ордоггүйтэй холбоотой юм. Энэ ялдамд латерал сэтгэлгээний СОРТ курсыг 2001 оноос Хан-Уул дээд сургуульд зааж байгааг тэмдэглэе.

Монголоор дүүрэн эрдэмтэн, энгэрээр нь дүүрэн одон тэмдэг, их гавъяа

байгуулсан бололтой юмаа янз нь. Төр, засаг аль байдгаараа л дэмжих юм. Харамсалтай нь хариу нь гардаггүй ээ. Судлаад л байдаг, судлаад л байдаг, дуусдаггүй, дууссан нэг нь төрдөө том гээчийн хавтас атгуулчихна, болоо. Хэрэггүй тайлан, хэсэг цоохор цаасыг үр дүн гэх үү. Учрыг асуухаар, шинжлэх ухаанд зориулсан хөрөнгө багадсанаас ийм болов гэж онолддог. Гэтэл заавал их хөрөнгө зарж байж л үр дүнд хүрнэ гэсэн онол таарахгүй байна. Тэгэхлээр энэ тайлбар нь өөрийгөө хамгаалах арга л юм шиг. Хоёр тэрбум төгрөгийг хөдөлгөж чадахгүй байж 200 тэрбумыг эргүүлэх юм гэнэ. Ёстой гайгүй байлгүй, юунд тэгж худал хэлнэ вэ. Түүний оронд үнэнээ хүлээвэл зохино, Манай эрдэмтдийг бүтээлч сэтгэлгээний хомсдол хэмээх аюулт өвчин нэлэнхүйд нь нэрвэчихээд хэцүүдэж байна. Энэ өвчинд нэрвэгдсэн судлаач нь бүтээдэггүй, бүрэлгэдэг болдог ажгуу. Иймд эхлээд эрдэмтдийгээ энэ муухай өвчнөөс салгая. Салгах арга нь тэднийг бүтээлч сэтгэлгээнд сургах, үүний тулд бүх докторуудыг латерал сэтгэлгээний SORT курсэд албадан суулгаад тун шударга шалгаад, унасныг нь цомхотгоод. . . Түүний дараа л төсөл зарлая. Бүтээлч бус сэтгэлгээтэй хүнд ард түмний хөрөнгөнөөс төслийн нэрээр төгрөг атгуулах нь ёроолгүй саванд сүү юүлэхтэй агаар нэгэн бусуу.

Аливаа юмс үзэгдэл ямагт цогц шинжтэй, олон талтай, бусадтайгаа шүтэн барилдахуйн хэлхээ холбоонд оршин байдаг. Үүнийг гүн ухаанд учир шалтгааны номлолоор тайлбарладаг. Юмс үзэгдлийг аль өнцгөөс нь яаж харах вэ? гэдэгт их учир бий. Зөвхөн нэг өнцгөөс нь харчихаад түүнийгээ туйлын үнэн мэтээр хүлээн авах нь өрөөсгөл дүгнэлтэд хүргэдэг байна.

Эртний Энэтхэг орноо арваад сохор амьдран суудаг байжээ. Тэд нэг өдөр цуглан цэц ухаанаа сорьж гэнэ. Зааныг тал талаас нь тэмтрэн үзжээ. Нэг нь энэ бол банз гэв. Тэрээр зааны гуяыг тэмтэрсэн ажгуу. Нөгөөх нь энэ бол олс гэв, бодвол хошууг нь тэмтэрсэн биз. Энэ мэтээр хүн бүр өөр өөрөөр таажээ. Улмаар ганцхан минийх л зөв хэмээн хоорондоо маргалдан, зодолдож нэр нүүрээ барсан гэдэг. Бидний монголчууд энэ хэдэн сохроос ялгагдах юмгүй байх шиг ... Арга ч үгүй биз, латерал сэтгэлгээнд суралцаагүй юм чинь...

Монголчууд та бидний ажил үйлс нэг л явц муутай байх юм. Хүн алдаж болно. Дандаа ононо гэж хаана байх билээ. Гол нь алдаагаа дахин давтахгүй байх л чухал, үүний тулд алдаанаасаа сайтар суралцах учиртай. Харамсалтай

нь та бид алдаанаасаа сурахын оронд алдсан хүнийг олж шийтгэх нөр их ажилтай болжээ. Онцлог нь тэр этгээд нь өөрөө биш ямагт өрөөл бусад байдаг. Буруутанг хайгаад л байна, хайгаад л байна, бүр олдохгүй бол байгаль, газар, цаг агаар руу чихчихнэ. Өөрөө болохоор ямарч алдаагүй, өө сэвгүй цэвэрхэн хүмүүс болчихно. Хүмүүс нь алддаггүй юм бол яагаад ажил нь ахицгүй байна вэ. Энэ бол хүн бүрийг, иргэн бүрийг латерал сэтгэлгээнд сургахын шаардлага.

Монгол хүн унаган багаасаа хээр гадаа төрж үрждэг, талын сэтгэлгээтэй. Ер нь л хээрийн амьтан, хаашаа ч хамаагүй хандсан зүг рүүгээ хахируулж одно, Шувуун саарлын туурайнаас гал маналзана, Сүрэнхүүгийн цээжнээс салхи манарна... Гэтэл цаг эргэлээ. Хөдөөнөөс хотруу чиглэсэн их нүүдэл эхэллээ,... Сүрэнхүү хот газар бараадав, иргэншсэн хүн болов. Адуучин Сүрэнхүү малтай харилцдаг байсан бол тэрэгчин Сүрэнхүү хүнтэй харилцдаг болов. Тэрээр хандсан зүг рүүгээ ташуурдах бус хажуудах хүнийхээ аясыг дагахад хүрэв. Хуучнаараа сэтгэж, хөдөлж болохгүй болов. Талын сэтгэлгээг хотын сэтгэлгээ болгон өргөжүүлэх шаардлагатай тулгарав. Хөдөөгийн эрмэг догшин араншингаа хотын эелдэг дөлгөөн харьцаагаар баяжуулахаас өөр гарцгүй болжээ. Мань эр латерал сэтгэлгээний ном сугавчилчихсан СОРТ-ын хичээл рүү харайлгаж явна... Сүрэнхүүдээ баяр хүргэе.

Монгол улс даяаршлагадаж, та бид орон дэлхийгээр аялж, өндөр хөгжилтэй орны ихэмсэг, эмзэг хүмүүстэй нүүр тулан уулзаж, ажил төрөл ярилцах, тэднийг урьж аялуулж жуулчлуулах болов. Ийм үед та бидний бусадтай харилцдаг сэтгэлгээний уламжлалт арга барил гологдон гадуурхагдаж байна. Энэ нь толгой дохихоос эхлээд л юм юман дээр тодорно. Арга ч үгүй биз. Нэг чиглэлтэй, ганц хувилбартай, түүнийгээ шууд тулгадаг вертикал сэтгэлгээ нь /монгол хүн вертикал сэтгэдэг/ олон чиглэлтэй, цөөн бус хувилбартай, нөхцлүүдийг шавхдаг латерал сэтгэлгээнд гологдох нь зүй юм. Үүнээс гарах арга зам тодорхой байна. Тэд бидэнд зохицох бус, бид тэдэнд зохицох ёстой, учир гэвэл вертикал сэтгэлгээ нь явцуу бөгөөд шугаман бол латерал сэтгэлгээ нь өргөн бөгөөд шугаман бус билээ. Тодруулбал, латерал сэтгэлгээний тухайн нэг л тохиолдол нь вертикал сэтгэлгээ бөлгөө.

Эдүгээ цагт ганц хүний хийдэг юм, цөөн хүний бүтээдэг үйл гэж бараг алга болжээ. Олуулаа нийлж олны хүчээр урагшилдаг болов. Гэтэл манайхан болохоор тун өөр. Эхлээд л хашаа хороогоо бариад өөрийгөө бусдаасаа

тусгаарлан хавхдаад авна. Цаашаа хараад л ганцаараа ум хумгүй зүтгээд байдаг, үр дүн бага, бие нь туйлдаж гүйцнэ. Тэгээд л бусадруугаа агсарч гарна даа. Уг нь олуулаа тал талаасаа хүч аргаа нийлүүлсэн бол амархаан бүтчих юм шүү дээ. Нэг хүнээс багахан хүч гаргаад л болчих юманд юунд тэгтлээ өөрийгөө зовооно вэ. Ганцаараа дэлхийг эзэгнэнэ гэж бодоогүй баймаар. Энэ нь мэдээж хэрэг, жалга дов даган тус тусдаа аж төрж, зөвхөн өөрийгөө бөөцийлж амиа аргацааж ирсний сүүдэр байх л даа. Улс гэр маань намуудад, намууд нь бүлэглэлүүдэд хуваагджээ. Бүлэглэл нь дотроо бас задарна гээч. Залуучуудын төдийгүй оюутнуудын байгууллагууд ийм болов. Тэд ном уншихын оронд намчирхан талцаж, хэрэлдэж суудаг боллоо. Ингэж ч хөгжихгүйдээ. Салж сарних бус, нийлж нэгдэж байж хөгжинө. Монгол хүнийг энэ өвөрмөц араншингаас нь салгая гэвэл хий хоосон уриалах бус биетэй бодитой ажил хийх ёстой. Уриа лоозонгоор улс гэрээ төвхнүүлэх гэж цаг алдаж хөрөнгө урсадаг хуучинсаг сэтгэлгээнээсээ салмаар байна.

Одоо тэгээд яавал дээр бол. Ямар ч гэсэн та латерал сэтгэлгээний хичээлд суугаад үз. Төрийн ордноосоо эхлээд ТҮЦ мухлагийнхан хүртэл бүгдээрээ бүтээлч сэтгэлгээ төлөвшүүлдэг СОРТ курсэд хамрагдъя. Тэгвэл байдал эрхбиш дээрдэнэ. Ядаж л аливаад туйлшран туйлдаг омголон догшин зангаа хазаарладаг болно. Бусдын сүүдрийг бус гэрлийг нь олж харахад суралцана. Хүн бүрт гэрэл гэгээ байдаг юм шүү, гагцхүү түүнийг нь олж харах л чухал. Та бид бие биенийхээ сайн талыг олж харж чадвал тэр талаараа нэгдэж нийлнэ, хагарсан ан цав ард хоцорно. Энэ л эцсийн дүндээ монголын хөгжлийн тулгуур хүчин зүйл мөнөөсөө мөн гэдэгт эргэлзэх юун.

# ***ЧИНГИС ХААНЫ ОЮУНЫ ИЛТГЭЦҮҮРИЙН ДООД ХЭМЖЭЭ 204 ГЭДГИЙГ МОНГОЛД АНХ УДАА ТОГТООЖ ЗАРЛАЛАА***

---

Шар сонин 2003 №20(371)

***Оюун ухаан биднийг жолоодож байна уу?, бид оюун ухааныг жолоодож байна уу?***

Онолын хувьд оюун ухаан биднийг жолоодож байгаа юм. Харин амьдрал дээр бид оюун ухааныг жолоодож болох хандлага байж болох юм. Оюун ухаан гэдэг ертөнцийн үүсгүүр, том тэнцүүлэгч юм даа. Тэр нь хүн дээр хэлэгддэг байхгүй юу. Тэгэхлээр ертөнцийн зүй тогтол болсон оюун ухаан хүн бидэн дээр илэрч байна.

***Ухаантай хүнийг таних хамгийн эхний асуулт юу байж болох вэ?***

Ганцхан асуултаар хүний ухаантайг дүгнэх хаашаа юм. Гэхдээ нэг асуулт асуугаад түүний хариултанд дүгнэлт хийх чадвартай байх нь л чухал. Хүн өөрөө өндөр IQ- тай байх албагүй. Харин хоёр өгүүлбэр сонсоод хоёр хүний энэ нь ухаантай юм байна гэдгийг мэдэх чадвартай байх хэрэгтэй. IQ бол хүн бүхэнд байдаг, харин ухаантай хүний яриа бол өөр ш дээ. Хүний ухаан гурван өгүүлбэр дээр л танигдана гэсэн үг байдаг.

***Таныг ХУДС -ын захирал, IQ төвийн тэргүүн гэж хүн бүхэн мэддэг болсон. Харин хувь хүний хувьд та ямар хүн бэ? Хувийнхаа амьдралаас танилцуулаач.***

Би хувийн амьдрал ярих дургүй, яагаад хүмүүс хувийн амьдрал яриад байдаг юм гэхлээр оюун ухаан нь ярих юмгүй болчихоороо, сэтгэлгээ нь доогуур байгаа хүмүүс л хэн хэнтэй сууж вэ, чих нь ямар байна, хамар нь яасан зэргээр ярьж бичдэг л байхгүй юу даа. үүнийг бид нар ойлгож байна. Манай эхнэрийг Цогзолмаа гэдэг инженер ажилтай мэдээж сайн хань байж таараа, манайх 4 хүүтэй, хоорондоо 2-3 жилийн зайтай гарсан, их номын айл байгаа юм. Том хүү 8 —р ангиа төгсөөд “Хан уул” ДС -д орж төгсөөд одоо IQ төвийн гүйцэтгэх захирал хийж байна. Дараагийн хүү мөн тус сургуулийг төгсөөд бизнесийн салбарт ажиллаж байна. Дараачийнх нь Хан-Уул дээд

сургуульд сурч байгаа. Бид хоорондоо оюун ухаан л ярьдаг. Дандаа л бие биенийгээ давсан, давж сэтгэсэн юм хэлэлцэнэ энэ утгаараа жирийн сонин, нэвтрүүлэг бол манай хэрэгцээг хангахгүй байгаа ш дээ. Ер нь хүний оюун ухаан хөгжих тусам үзэж хардаг зүйл нь өөр болно. Би ер нь оюунлаг юмыг түрүүлж харж мэдэрдэг юм шиг байгаа юм. Өөрөөр хэлбэл хоёр хүн ярьж суухад арай илүү ухаантай нь миний нүдэнд түрүүлж тусдаг.

*Та түрүүн хэллээ, оюун ухаан нь ярих юмгүй болчихоороо, сэтгэлгээ нь доогуур байгаа учраас хүмүүс хувийн амьдрал сонирхдог гэж. Гэтэл өнөөдөр монголын ард түмний 70-80% нь чөлөөт сонин уншиж, хүмүүсийн хувийн амьдралын талаар илүүтэй сонирхдог, тэгэхлээр бидний дийлэнх нь таны хэлж байгаагаар оюун ухаан нь доогуур, сэтгэлгээний чадвар муутай хүмүүс болж байна уу?*

Хүний дундаж IQ=100 байх ёстой. Нийгэмд цоохор мэдээ сонсдог, сонирхдог хүмүүс арай олон байна ш дээ, ямагт нийгмийн цөөнхи нь оюун ухаантай байна. Жишээ нь пирамид хэлбэртэй гэж хэлж болно. Хамгийн гол нь дээшээ явж, оюунжиж байгаа хүнээ л хүлээн зөвшөөрч, түүнийхээ үгэнд ордог байх хэрэгтэй. Нэгэнт өөрөө олж хараагүй байгаа бол харсан хүндээ итгэх л хэрэгтэй. Тэр чинь ухаантай хүн байна шүү дээ. Одоо оюунлаг хүний үгийг хүлээн авч дэмжих цаг нь болсон. Энэ тал дээр монголчууд жаахан дутагдаад байгаа. Ухаантай хүнээ хойш нь татдаг, атаархдаг, муулдаг.

*Хүүхдийн IQ -г хэдэн наснаас нь тогтоож хөгжүүлэх ёстой юм бэ? Та хүүхдүүдийнхээ IQ-ийн түвшинг тогтоосон уу?*

Яг онолын хувьд, барууны орнууд хүүхдийг олдохоос нь өмнө IQ -г нь хөгжүүлдэг гэж байгаа юм. 3-5 жилийн өмнө IQ -г хөгжүүлнэ гэсэн чинь юу гэсэн үг вэ? гэхлээр 5 жилийн дараа хүүхэдтэй болохын тулд одооноос аав, ээж нь оюунжсан, бие нь эрүүл, ухаан нь саруул байх ёстой юм байгаа юм биз дээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх гээд байгаа юм ш дээ. Гэтэл одоо яаж байна. Хүүхэд олдчихлоо гэхэд гэдсэн дотор нь оюунжуулж өгөх хэрэгтэй. Тухайлбал хүүхэдтэйгээ ярина, хөгжим сонсоно, мэдээллийг зөв хийнэ.

*Чингис хааны оюуны чадварын илтгэцүүр 204 гэж зарлалаа. Үүнийг яаж тогтоосон юм бэ? Та өөрийнхөө IQ-г тогтоосон уу? Таных 130 гэж сонссон.*

Чингис хааны IQ=204 гэж хоёр жилийн судалгааны үндсэн дээр тогтоолоо. Дэлхийн олон эрдэмтдийн судалгаан дээр үндэслэн тэдний аргачлалыг харсан.

үүнд хамгийн өндөр IQ -тай хүмүүсийн нэрс, суут ухаантнуудын тоонд орж уу? орсон бол хэдэд нь байна гээд гарна ш дээ, тэгээд дээрээс нь эхлээд хамгийн ухаантай 100 хүнээ гаргачихаад түүнээсээ тогтоодог журамтай. Чингисийн IQ хамгийн доод тал нь 204 байна гэж тогтоогдсон. Харин би өөрийнхөө IQ-г 130 гэж тогтоогоод зарлаад байсан юм байхгүй. Иймэрхүү IQ-тай хүн монголд олон бий. Ер нь 10 мянга гаруй ухаалаг хүн бий гэж боддог. Энэ нь манай 2,6 сая хүн дотор л байгаа байхгүй юу. Төр засагтаа эднээс оруулж, тэднээр удирдуулан чиглүүлж явахгүй бол дуртай хүн нь УИХ, ЗГ-ын гишүүд болж болохгүй шүү дээ. Хүн өөрөөсөө доош ухаантай хүнийг хүлээж авдаггүй л байхгүй юу. Тэгэхлээр удирдлага нь доод ажилчдаасаа илүү ухаантай байж амжилтанд хүрнэ. Одоо оюун ухаан муутай хүнд амьдрах орон зай ер нь их явцуу болсон доо.

*Та намар навчисаа гэвсэн моддыг хараад өнгөрч буй зуны улиралд хоргоддог уу? эсвэл ирж яваа цаг руу тэмцүлдэг үү?*

Ирээдүйгээ харж явна, өнгөрсөн үетэйгээ зууралддаг цаг өнгөрсөн. өнгөрснөөр бахархаж болохгүй. Өнөөдөр ерөнхий боловсролын сургуульд түүхийн хичээл нэг цаг, ирээдүйн хичээл есөн цаг орох ёстой. Гэтэл манайд түүхийн хичээл арваад цаг орж байна. Бид ирээдүй рүү явах ёстой байтал толгой минь хойшоо хараад байна. Энэ нь үнэхээр орчин үед нийцэхгүй асуудал. Урт түүхтэй ард түмэн илүү хөгжинө гэж байхгүй шүү дээ.

*Таны хэлэх дуртай үг?*

Шинэ юм нь хуучнаасаа давамгайлж байх.

*Монголын оюуны чадварын анхдугаар олимпиад болж өнгөрлөө. Та Увс нутгийнх, танай төвийн удирдлагууд ихэнхи нь энэ нутгийн хүмүүс. Гэтэл сая түрүүлсэн хүүхэд нь Увсынх байлаа. Нутгаасаа оюуны чадвар өндөртэй хүмүүсийг төрүүлэн гаргахын тулд тэмцээнийг ямар нэгэн байдлаар буруу шүүсэн юм биш биз. Ер нь танай нутгийнхан ихэнхи нь IQ өндөр хөгжсөн хүмүүс байдаг юм уу?*

Оюунжсан хүмүүс тийм зүйл хийдэггүй. Тэмцээн бол шударга болсон. Оюун ухаан, шударга бус явдал хоёр гал ус шиг харш юм.

# *ХҮН БҮРИЙГ ЛАТЕРАЛ СЭТГЭЛГЭЭНД СУРГАЯ\**

Өнөөдөр 2003. 03. 04 №50(1788)

*Монгол орны хөгжил сул дорой байгаагийн шалтгаан нь ерөөсөө хүндээ, тэр тусмаа монголчуудын өрөөсгөл сэтгэлгээнд л байна. Уг хоцрогдлыг гэтлэх хамгийн сайн гарц нь хүн бүр латерал сэтгэлгээний арга барилд суралцах явдал. Би эцэстээ ийм дүгнэлтэд л хүрлээ.*

## **ТОДРУУЛАХ НЬ:**

1. Монгол төрийн жолоог атгалцаж байгаа улстөрчид латерал сэтгэлгээний SORT курсэд нэн даруй хамрагдах шаардлагатай байна. Учир нь, улс төрийн намуудын “чи, би”-дээ тулсан тэмцэл, улстөрчдийн урьд хождын хонзогнол, туйлшрал, төр засгийн дөрөвхөн жилийн настай муйхар бодлого улс орны хөгжлийг тамирдуулж гүйцлээ. Үүнийг шилжиж буй орны нэг онцлог гэх юм уу, эсвэл бүр, олон намын тогтолцооны мөн чанар хэмээн тайлбарлах юм. Энэ бол бурууг өрөөлөөс хайдаг монгол сэтгэлгээний илрэл бөгөөд бусад улс орныг харвал ийм тайлбарыг хүлээн зөвшөөрөмгүй байна.
2. Аж ахуй хөтөлж, чадах чинээгээрээ зүтгэж яваа бизнес эрхлэгчдийг латерал сэтгэлгээний SORT курсэд өргөн хамруулмаар байна. Учир нь, өнгөрсөн цагийн мэдлэгээр биш, шинэ санаачилгаар өрсөлддөг цаг аль хэдийнэ иржээ. Тэд маань нийгмийн хөгжил асар хурдацтай өрнөж байгаа орчин үед бизнесээ шинээр харж чаддаг, эрсдэлд ухаалгаар орж чаддаг, шинэ орчинд дасан зохицож чаддаг байх шаардлагатай боллоо. SORT хичээлд сууснаар аливаа асуудлыг олон талаас нь тунгааж, бүх боломжуудыг шавхан, ердийн аргаар бус, хөндлөнгөөс нь цоо шинээр хандаж оновчтой шийдлийг олох, бэрхшээлийг аль болох хохирол багатай даван туулах арга замыг олж чаддаг болно. Ийм чадвартай болчихвол ямар ч бизнест амжилт гаргаж л таарна.
3. Эрдэм мэдлэгийн оройд яваа эрдэмтэн докторууд маань латерал сэтгэлгээний

---

*Тайлбар: “Зууны мэдээ” сонинд хэвлэгдсэн “Тамд байдаг монголчуудын тогоо манаачгүй байдаг” өгцүллийг “Өнөөдөр” сонины захиалгаар дахин найруулж засварласан нь энэ болой.*

---

CORT курсэд суух ёстой болно. Учир нь, Монголоор дүүрэн эрдэмтэн байгаа хэр нь шинжлэх ухаанд байтугай улс орны хөгжилд оруулах хувь нэмэр гэж үнэндээ алга. Төр засаг аль байдгаараа л дэмжих юм. Харамсалтай нь, үр дүн гардаггүй. Учрыг нь асуухаар шинжлэх ухаанд зориулсан хөрөнгө багадсаных гэнэ. Гэтэл заавал их хөрөнгө зарж байж л үр дүнд хүрнэ гэсэн онол тааралдахгүй байна. Тэгэхээр энэ бол өөрийгөө хамгаалж буй арга юм шиг. Иймд эрдэмтдээ эхлээд бүтээлч сэтгэлгээний хомсдол хэмээх өвчнөөс салгая. Салгах арга нь тодорхой. CORT курсэд суулгаад, тун шударга шалгах. (Тэд өөрснөө хичээлд сууж, шалгуулахгүй л болов уу. Албадаж таарах байх. Ер нь аюулт өвчнийг албадаж эмчилдэг журам бий.) Түүний дараа л судалгааны төслүүд зарлая.

4. Хөдөөгийн хөдөлмөрчдийг латерал сэтгэлгээний CORT курсэд хамруулмаар байна. Учир нь, хөдөөнөөс хот руу чиглэсэн их нүүдэл хөвөрч байна. Монгол Улс даяаршиж, та бид орон дэлхийгээр аялж, өндөр хөгжилтэй орны ихэмсэг атлаа эмзэг хүмүүстэй нүүр тулан уулзаж, бас тэднийг урьж аялуулах болов. Ийм үед та бидний бусадтай харилцдаг сэтгэлгээний уламжлалт арга барил гологдон гадуурхагдаж байна. Энэ нь толгой дохиоос эхлээд л юм юман дээр тодорно. Иймээс та бид хөдөөгийн «билиг танхай» араншингаа хот маягийн «дипломат» харилцаагаар баяжуулах шаардлагатай байна.

5. Эцэг эхчүүдийг латерал сэтгэлгээний CORT хичээлд суулгамаар байна. Учир нь, тэдний сэтгэлгээний хоцрогдол хүүхдийнхээ сэтгэлгээний хөгжилд уршиг ихтэй болов. Жишээ нь, гурван настай монгол япон хоёр хүүхдийн эцэг гадаадад сарын томилолтоор явжээ гэе. Монгол хүүхэд тийм ийм тоглоом надад авчраарай гэж эцэгтээ захиана. Бас хувцас хунар, бүр хэтрээд хоол ч захиж мэднэ. Эх нь түүнийг өөгшүүлэн турхирна. өөрөө бас гархи, чулуу хавчуулна, ирснийх нь дараа бэлэг сэлт, ээмэг бөгжний бөөн үг хэл. Гэтэл япон хүүхэд шал өөр. «...аав та ажлаа л сайн хийгээрэй, ээж бид хоёрт бэлэг сэлт хайж, хурал семинараасаа оргон дэлгүүр хэсэвүүзэй. Төрийн ажил цалгардаж, эх орны маань нэр нүүр хэцүүднэ» гэдэг байх юм. Ялгаа байгаа биз. Энэ жишээг япон хүүхдэд латерал сэтгэлгээ төлөвшүүлдэг зуны сургуулийн нэгэн сурах бичгээс авлаа. Яагаад монгол, япон хоёр хүүхдийн сэтгэлгээний бүтээлч байдал ингэтлээ өөр байна вэ? Энэ бол монгол хүүхэд төрөлхийн бүтээлч бус араншингайд биш, эцэг эхчүүд та бид хүүхдээ багаас нь зөнд нь хаяж, сэтгэлгээнийх нь амьтанлиг араншинг өдөөн турхирдагт байна.

6. Багш нарыг латерал сэтгэлгээний CORT курсэд сургамаар байна. Учир нь, хүүхэд найман нас хүрч сургуульд ормогц багш нь «Номхон суу, хөдөлж үл болно, миний заасныг яг давтан хэлээрэй, тэгвэл онц тавина. Миний үгнээс

зөрөв, тэгвэл арга хэмжээ авна» хэмээн сургамжилдаг. Хичээл дээр аливаа асуудалд олон талаас нь хандах, сурагч оюутнууд өөрийнхөө санал бодлыг хэлэх, түүнийгээ хамгаалах нь хориотой. Үүний үр нөлөөгөөр манай багачууд жинхэнээсээ тоть шувуу болдог. Хэдий чинээ тоть шувуу болнов, дээд боловсролтой болох магадлал нь төдий чинээ нэмэгддэг. Төгсөлтийн болон элсэлтийн шалгалт ч үүнд бүрэн үйлчилж байна.

7. Оюутан сурагчиддаа латерал сэтгэлгээний **CORT** хичээлийг зааж эзэмшүүлмээр байна. Учир нь, тэд мэдээллийн эринд амьдрах хувь зохиолтой хүмүүс. Мэдээллийн хуйларсан их шуурган дунд зүг чигээ алдахгүйн тулд тэд маань зогсоо зайгүй бөмбөгдөх мэдээллээс ашигтайг нь шүүж авдаг, хортойгоос нь холдож чаддаг байх шаардлагатай болно. Латерал сэтгэлгээний хичээл энэ чадварыг л эзэмшүүлнэ. Ер нь сэтгэлгээ гэдэг бол тухайн хүн орчноосоо мэдээлэл аваад түүнд хариу үзүүлдэг, орчинтойгоо харилцдаг суваг юм. Энэ суваг хэд хэд байж болно. Нэг нь, гэхдээ гойд бүтээлч нь латерал сэтгэлгээ. **CORT** хичээлд сууснаар латерал сэтгэлгээний арга барилуудыг өөрийн дадал дүй болгож авах бөгөөд аливаа нөхцөлд латерал сэтгэлгээнийхээ сувгийг эхэлж ажиллуулж чаддаг болно.

8. Ерөөсөө монголчууд бид бүгдээрээ латерал сэтгэлгээний **CORT** хичээлд суумаар байна. Учир нь, эдүгээ цагт ганц хүний хийдэг юм, цөөн хүний бүтээдэг үйл гэж бараг алга болжээ. Олуулаа нийлж, олны хүчээр урагшилдаг болов. Салж сарниж бус нийлж нэгдэж байж хөгждөг. Гэтэл монголчууд бид болохоор үүний эсрэг сэтгээд байна. Өнгөрснөө муулаад, өндийснөө буруутгаад ... Энэ нь жалга дов даган тус тусдаа аж төрж, өөрийгөө бөөцийлж амиа аргацааж ирсний сүүдэр байх л даа. Улс гэр маань намуудад, намууд нь бүлэглэлүүдэд хуваагджээ. Бүлэглэл нь бас дотроо хуваагдана гээч. Залуучуудын төдийгүй оюутны байгууллагууд ийм болов. Тэд ном уншихын оронд намчирхан талцаж хэрэлдэж суудаг боллоо. Ингэж ч хөгжихгүй л дээ. Монгол хүнийг энэ өвөрмөц араншингаас нь салгая гэвэл хий хоосон уриалах бус биетэй бодитой ажил хийх ёстой. Уриа лоозонгоор улс гэрээ төвхнүүлэх гэж цаг алдаж хөрөнгө урсгадаг хуучинсаг сэтгэлгээнээсээ салмаар байна. Төрийн ордноос эхлээд **ТҮЦ** мухлагийнхан хүртэл бүгдээрээ бүтээлч сэтгэлгээ төлөвшүүлдэг **CORT** курсэд хамрагдья. Тэгвэл аливаад туйлшран туйлдаг омголон зангаа хазаарладаг болно. Тэгвэл бусдын сүүдрийг бус гэрлийг нь олж хардаг болно. Та бид бие биенийхээ сайн талыг олж харж чадвал тэр талаараа нэгдэж нийлнэ. Хагарсан ан цав ард хоцорно. Хамаг Монгол маань цэцэглэн хөгжинө.  
... Латерал сэтгэлгээний **CORT** курс ийм ач холбогдолтой ажээ.

## ӨӨРИЙГӨӨ БОДДОГГҮЙ ХҮН ХҮН БИШ

---

Монголчуудын амьдрал 2003 он №21 (024)

*-Таныг IQ гэж дуугарснаас эхлээд л манайхан энэ талаар жаахан ойлголттой болоод байгаа. Гэтэл өчнөөн олон дарга сайд нар гадагшаа явж байсан. Тэд яагаад танаас өмнө энэ тухай олж дуугараагүй юм бол?*

-Харин тийм. Өнгөрсөн жил би 6 сарын сүүлээр Сингапурт ажлаар явсан юм. Тэндэхийн номын гурван их дэлгүүрт нь орж танилцахад манай консул “Монгол орон зах зээлд ороод 12 жил болж байна. Олон ч сайд дарга ирсэн. Тийм байтал нэг ч хүн номын дэлгүүрүүдээр орж ирж байгаагүй. Та Сингапурын номын их дэлгүүрт орж ирсэн хамгийн анхны монгол хүн” гэж хэлэхэд нь би баярласан шүү. Бас бахархсан. Нэгэнт номын дэлгүүрээр ордоггүй юм чинь тэр дарга сайд чинь энэ IQ-г яаж мэдэх вэ дээ. Би Засгийн газар, УИХ-ын гишүүдтэй цуг хуралд явж байсан. Тэд хуралдаа суувал суугаад үгүй бол дэлгүүр хэсээд алга болчихдог. Аргагүй ш дээ. Манай амьдрал ядуу юм чинь. Дээр нь эхнэр хүүхэд, дүү нар нь ийм ч юм авчир, тиймийг олж ир гэдэг байхгүй юу. Гэтэл би тэгж дэлгүүр хэсдэггүй. Миний ахуй тэднээс арай өөр. Бас надад ийм характер байхгүй. Хэн нэгэн хүнд тиймэрхүү юм олоод ирээрэй гээд захирад авчираад л өгдөг. Сайд хүртэл миний төлөө үйлчилж хувцас авчирч өгдөг юм шүү. Тэр хүмүүс өөрийнхөө төлөө гүйж, өөрөө өөртөө үйлчилж байгаа нь буруу биш шүү дээ. УИХ-ын гишүүн болно гэдэг чинь Монголыг бодож УИХ-ын гишүүн болдоггүй юмаа. Өөрийгөө л боддог байхгүй юу. Энэ тухай онол ном нь гараад бүр Нобелийн шагнал авчихсан юм ш дээ. Гагцхүү тухайн хүний өөрийн гэсэн бодлыг нь Монголоо гэсэн бодолтой нь холбож өгөх хэрэгтэй. Ийм бодлого манайд дутагдаж байна. Тэгээд л сонгогдох гэж нэг юм яриад, сонгогдсон хойноо тэс өөр юм ярьдаг. Өөрийгөө боддоггүй хүн бол хүн биш. Өөрийгөө боддоггүй хүнд буу бариулаад явуулбал Монголын төлөө гээд хэнийг ч буудах нь байна ш дээ. Хуучин коммунизмын төлөө аавыгаа бууд гэхэд буудаж л байсан. С.Зоригийг ард

түмнийхээ төлөө юм хийдэг ганц сайн хүн нь байсан гээд л өнгөрсөн хойно нь магтаад байдаг. Үгүй ш дээ. Тэр хүн тувт өөрийнхөө төлөө явж байсан. Манайхан үхсэнийх нь дараа тэнгэрт тултал нь магтаж байна. Энэ бол монгол хүний философиин гажиг. Дандаа үхсэн хойно нь магтаж байдаг юм. Ингэж болохгүй дээ.

*•УИХ-ын гишүүн Гүндалай, ХЗДХ-ийн сайд Нямдорж хоёрын хоорондын маргаан олны анхааралд байгаа. Таныг ч бас үүнийг анзаарахгүй өнгөрч чадахгүй байгаа байх гэж бодож байна?*

-Энэ хоёр хүн монголчуудын анхаарлын төвд байна гэдэг нь манай улс зах зээлд ороогүй байна, хий хоосон улс төрждөг хэвээрээ байна гэсэн үг. өмнө чинь тавагтай хоол байхгүй байхад хоёр хүний тухай ярьж суудаг ямар хачин хүмүүс вэ. Хоолоо олж идэж орон гэрээ барьчихаад дараа нь бусдын тухай ярих хэрэгтэй. Би Төв аймгийн Сэргэлэн суманд очихдоо нэг өвгөнтэй уулзсан юм. Тэднийх хэдэн гүүтэй байсан ч унагануудыг нь чоно идчихээд гаднаас ирсэн хүнд аягалаад өгөх айраггүй сууж байсан. Тэгсэн мөртлөө надаас “Саддам Хусейн баригдсан уу” гэж асууж байгаа юм. Тэгэхээр нь би “Уг нь таны дэлхий дахины мэдээлэл сонирхож байгаа чинь зөв юм. Гэхдээ тэр Саддам Хусейн баригдсан үгүй нь та бид хоёрт бараг хамаагүй юм ш дээ. Энэ баруун жалганд байгаа чоныг барихад Саддам нөлөөлөхгүй биз дээ гэсэн. Уг нь бол тэр өвгөн Саддамыг сонирхохын оронд чоно яаж авлах тухай бодож аяга айрагтайгаа л үлдэх ёстой байхгүй юу. Энэ бодлоосоо хэзээ сална тэр цагт л манай улс хөгжинө. Зүгээр тэр Гүндалай гишүүн, Нямдорж сайд хоёрын тухай ярихад бидний байж байгаа царай нь энэ. Тэр нам нь, УИХ нь, гишүүн нь ялгаагүй. Өөр юу хэлэхэв.

*-Би таны “Академик боловсролоос прагматик боловсролын тогтолцоонд шилжих тухай бичсэн нийтлэлийг уншиж байсан. Боловсролын тогтолцоог үндсээр нь өөрчлөх таны санаа хэр биеллээ олсон бэ. Төр засгийн хэмжээнд дэмжиж байна уу?*

-Үүнийг маань Засгийн газар зуун хувь дэмжиж байгаа. Бид монгол хүний оюуны чадамжийг аймаг сумаар нь судалж гаргах гэж байгаа. Төсөв нь батлагдаад ороод ирсэн. Цаг үе ч бас ингэж шаардаж байна ш дээ. Манайхан чадвартайгаа доош нь дардаг байсан шиг санагддаг. Өөрийнхөөрөө ярьсан сурагч муу болж таардаг. Багш нь би ингэж заагаагүй гээд л... үүнээс болоод Монголоор нэг тоть шиг ангаахайнууд бий болчихсон байна.

*-Боловсрол бизнес хоёрыг яаж зөв хослуулах ёстой вэ. Боловсролыг хөгжүүлэх хөшүүрэг нь бизнес болчихжээ. Та үүнийг зөвшөөрөх үү?*

-Боловсрол бизнесийн төлөө оршдоггүй. Нөгөөтэйгүүр манай бизнесмэнүүдийн оюуны ерөнхий чадавхи сайн биш. Дэлхийн дэвжээнд ч ойртоогүй байна. Энд ганцхан оюун ухаан л дутагдаж байна. Түүнээс навтгар хамар, намхан нуруутай гэж голоогүй. IQ дутвал бүх юм дутдаг л байхгүй юу. Хүнд эрсдэлд орох чадвар гэж байдаг. Багаасаа эрсдэлд орж сурсан хүүхэд хожим ийм үед ингэнэ тэгнэ гэдгээ мэддэг болдог. Түүнээс биш зүгээр гүйж явж 10-р анги төгсчихөөд бизнесмэн болно гэвэл үлгэр. Харин багаас нь наймаа хийж хэн нэгний өмнө алхах гээд байгаа хүүхдээ олж хараад, мөрийг нь залж, тэр авьяасыг нь, IQ-г нь хөгжүүлэх хэрэгтэй. Тэгвэл тэр хүүхэд цаашаа явна.

*-Сүүлийн үед их дээд сургуульд суралцагсдын дийлэнхи хувийг охидууд эзэлж байна. Тэд өөрсдийнхөө байгаа өндөрлөгөөс доошоо харж гудамжинд лааз өшиглөж яваа эсрэг хүйстнээ ихээр голж, ингээд гадаад хүнтэй суух нь ихэслээ гэж яригдах болсон. Энэ талаар таны бодлыг сонсмоор байна?*

-Эмэгтэй хүн нөмөр нөөлөг хүсдэг унаган чанартай юм шиг байна лээ. Өөрөө уул байх биш уулын энгэрт ургасан яргуй байхдаа дуртай. Харин эрэгтэй хүн уул байх сонирхолтой байдаг ч Монголд тэр тоо нь цөөрөөд монголоор нэг дов толгод бий болчихжээ. Тэгэхээр эмэгтэй хүн чинь уул хайдаг юм байгаа биз дээ. Хэн сайхан уул байхаар байна түүнийг л түшнэ шүү дээ. Эмэгтэй хүн гэдэг чинь эрсдэлд орж гэр бүлээ тэжээж бас нөхөр гэж нэг юмаар нүдүүлж байх одонд төрөөгүй ээ. Эрэгтэйнхээ олсон буян дээр жаргах гэж л төрсөн. Энэ бүгдийн цаана жендерийн асуудал яригддаг. Хоёул хамтдаа тэгш хэмтэй явъя гэсэн үг. Гэтэл манайхан тэгш хэм гэдгийг буруу ойлгоод байдаг. Эрэгтэй нь хүнд ажлаа хийгээд эмэгтэй нь дутууг нь нөхөөд гарсан үр шимээ тэнцүү хуваах ёстой байхгүй юу. Түүнээс биш УИХ-ын гишүүдийн тал хувь нь эмэгтэйчүүд байна гэвэл бүр зовоосон юм болно ш дээ. Манайхны жендерийн ойлголт нь харин ч бүр эмэгтэйчүүдийг зовоох талдаа болчихжээ. Уг нь бол жендер гэдэг чинь эрчүүдээр илүү ажил хийлгээд үр шимийг нь эмэгтэйчүүдэд өг гэсэн үг байхгүй юу. Яг үнэндээ эмэгтэйчүүд эрчүүдээс илүү их ажил хийж байна ш дээ. Хүн гаргах шиг, хүнийг тээх шиг, хүнээр хүн хийх шиг тийм аварга ажил үнэндээ байхгүй. Өөрийнхөө идсэн ууснаас таслан хүүхэддээ

өгч байна. Гэтэл эрчүүд тэгж өгч байна уу. Өгөхгүй л байгаа ш дээ. Төрөлхийн ийм хүнд ажил дээр нь дахиж нэмж ажил өгнө гэдэг чинь юу гэсэн үг вэ. Миний ойлголтоор эмэгтэйчүүд жаргах ёстой.

*-Тэгвэл та эхнэрээ яг өөрийнхөөр нь байлгаж, нэг ёсондоо жаргааж чаддаг уу?*

-Манай эхнэр жаргаж л байгаа. Жаахан юм хийвэл хийчихээд, хийхгүй бол хийхгүй. Дураараа л байдаг. Ер нь эрчүүдэд хэлэхэд, эмэгтэй хүнийг дураар нь байлгаад байх юм бол өөрөө ч гоё байж эмэгтэй нь ч бас гоё байдаг юм билээ. Гэтэл хоёулаа цуг гарч мод хөрөөдье гээд дагуулаад л гарчихаж байна ш дээ. Хэрвээ ийм байх юм бол тэр жендертээ эрэгтэй хүнийг ч бас хүүхэд төрүүл гэж оруулах хэрэгтэй. Найман хүүхэдтэй болно гэвэл дөрвийг нь би гаргая, өсгөө, дөрвийг нь чи гарга гэж хэлэх хэрэгтэй.

## ***УИХ-ЫН ГИШҮҮДИЙН ОЮУНЫ ЧАДВАРЫГ ТОГТООЖ ОЛОНД ЗАРЛАХ ХЭРЭГТЭЙ***

---

Хүмүүсийн амьдрал 2003. 06. 20 (153)

***-Та хүмүүст IQ-ийн тухай тодорхой тайлбарлаж өгөөч. Энэ төвийг байгуулах санаа яаж төрөв?***

-Хүний оюуны чадавхийг IQ-гээр нь эрэмбэлдэг. Тиймээс бусад орны хүмүүс IQ-гээ өсгөх гэж байнга хичээллэж, шалгуулж байдаг. Харин манайд бол хүмүүс шар мэдээгээр оюун ухаанаа гэмтээж байна. Тиймээс оюун ухааны чадавхи багатай байна. Жишээ нь, монголд их сургуулийн математикийн ангийг төгссөн, их сургуулийн урдаа барьдаг багш Америкт очоод IQ-гийн шалгалт өгөхөд хөдөөгийн дэн буудлын үйлчлэгч хийж болно гэсэн байгаа юм. Тэгэхээр манайхан IQ-гээр хичээллэж оюун ухаанаа хөгжүүлэхгүй бол яваандаа бусдын боол болно гэсэн үг.

Би энэ төвийг байгуулах санааг амьдралынхаа явцад олсон. Америкийн нэгдсэн улс болон бусад орон IQ-г 1870 оноос хойш 133 жил хэрэглээд, хөгжүүлээд ирсэн байна. Үүнийхээ хүчээр барууны орнууд хөгжсөн байна. Хүн нь хөгжсөн учир улс нь хурдацтай хөгжсөн байна. Хүнийг хөгжүүлнэ гэхээр бие эрхтэн, хувцас хунарын хувьд биш юм. Энэ бол хүний оюун ухаан, уураг тархийг хөгжүүлнэ гэсэн үг.

***-Хүний IQ-г хэмжээд тодорхой тоогоор дүгнэдэг. Хамгийн дээд доод хязгаар нь хэд байдаг юм бол. Мөн жирийн хүний дундаж IQ хэд байдаг вэ?***

-IQ-ийн стандартчилсан тест байдаг. Тэр тестээр шалгаад дүгнэдэг. Хүний хамгийн дээд IQ одоогоор 210 хүрээд байна. Хамгийн өндөр IQ-тэй хүн бол Германы гүн ухаанч, сэтгэгч, яруу найрагч Гёте юм. Ер нь 70-аас доош IQ-тэй хүнийг төрөлхийн усан тэнэг, сэтгэх чадвар нь алдагдсан тархины гэмтэлтэй гэнэ. Харин 70-100-ийн хооронд байгаа хүнийг бойд буюу, эрүүл боловч сэтгэх чадвар удаантай гэнэ. Ийм хүн хүний үгийг хоёроос гурав хэлүүлж байж ойлгодог. Харин 100-130-ийн хооронд байгаа хүнийг ухаалаг талдаа эрүүл хүн гэнэ. 130-140-ийн хооронд бол ухаантай хүн, харин 140-160-ийн

хооронд бол гоц авьяастай гэнэ. Шарон Стоуны IQ 157 байгаа. Тэгэхээр хүн ямар нэг авьяастай л бол гоц авьяастай гэхгүй байгаа биз. Энэ бүхэн заавал IQ-ийн тестэнд орж байж тогтоогдоно. Харин 160-180 байвал сод ухаантан байна. Шатрын их мастер Роберт Фишер, Н.Коперник нар сод ухаантнууд байсан. 180-200 болбол суут ухаантан гэнэ. Харин 200-аас дээш бол аугаа суут хүн болно.

Саяхан манай төв Чингис хааны IQ-г гурван жил судалж гадаадын байгууллагуудтай холбоо тогтоож, олон зүйлийг ашиглаж байж математикийн тооцоогоор гаргаж ирлээ. Чингис хааны IQ=204 нэгж байсан байна. Аугаа суут хүн маш ховор байдаг ч Монголын цөөхөн хүн амаас ийм хүн төрсөн нь их хувь заяа юм.

***-Манай иргэдийн IQ-г тогтоож байгаа юу? Бусад орны хувьд ямар байдаг юм бол?***

-IQ клуб одоогийн байдлаар 2000 гаруй багштай, 20000 орчим сурагчтай, 3-18 нас хүртэл хамарсан, бүх аймаг, 100 гаруй суманд хүрсэн байна. Манайд иргэний IQ-г тогтоох бодит шаардлага байна. 2002 оны 8 дугаар сарын 6-ны орой Австрали улс орон даяараа иргэдийнхээ IQ-г тогтоосон байна Бүгд интернетээр бодлогоо бодоод явуулчихсан. Тэгээд газрын зураг дээр хүмүүсийн IQ-ийн түвшин, ямар байгааг харьцуулаад зурчихсан. Ийм судалгааг Америк, Герман гээд ихэнх орон хийчихсэн. Тиймээс Монгол хүний IQ-г тогтоох нь маш их ач холбогдолтой. Хаана IQ сул, хаана дээгүүр байна гэдгийг мэдээд үүнд тохируулж төрийн бодлогыг хэрэгжүүлэх ёстой. Яагаад хүний IQ сул байна гэдгийг судалж илрүүлж ажиллах хэрэгтэй байна.

***-Оюуны чадавхи төрөлхийн сайн, муу гэж байдаг уу?***

-Хүний IQ төрөхдөө адил байдаг. 1000 хүүхэд төрөхөд дөрвөн хүүхдийн IQ төрөлхийн дорой, 4 хүүхдийн IQ төрөлхийн 130-аас дээш байна. Харин үлдсэн 992 нь адилхан байдаг. Энэ бол боломж. Бурхан багшийн өгсөн хишгийг хүн бүр өөр өөрөөр ашигладаг. Хүний дундаж IQ=100-тай байх ёстой. Хэрвээ оюун ухаанаа хөгжүүлэхгүй бол IQ нь 70 болно. Хөгжүүлээд байвал 130 хүрч болно. 130-аас дээш IQ-тэй хүн бол төрөлхийн байдаг. Гадаадын орнууд ийм нарийн судалгааг сайн хийдэг учир нөгөө төрөлхийн гоц авьяастай дөрвөн хүүхдээ хөгжүүлээд түүнээсээ их ашиг олоод муу дөрвөө аваад явчихдаг. Бусад бүх хүнээ хөгжүүлээд зуугаас дээш IQ-тэй болгоход анхаардаг. XXI зууныг мэдээллийн зуун гэж байгаа ч яг агуулгаараа

бол оюун ухааны зуун юм.

*- Оюуны ухааны зуунд бид хөл нийлүүлэн алхахын тулд юу хийх ёстой юм болоо?*

- Одоо 2004 оноос эхлээд ЕБС-ийн төгсөгчдийн сурах чадварыг хөндлөнгийн мэргэжлийн манай IQ төвийн комисс шалгах учиртай. Шалгаад бүх төгсөгчдийг оноогоор нь байр эзлүүлээд оноондоо багтсан сургуульдаа орно. Саяхан энэ талаар семинар хийгдэж, уриалга гаргасан. Ингэж оюуны шалгалт нь чадвар руу эргэнэ.

Өнөөдөр монгол улс 8000 хуульчтай болсон байна. Гэтэл ажлын байр ердөө л 800 байна. Тиймээс хуульчдыг шалгаруулах хууль УИХ-аар батлагдлаа. Одоо энэ хуулийн дагуу 800 хуульчаа IQ-гээр нь шалгаж авна. Ингэхгүй бол хуульчийн IQ хулгайчийн IQ-гээс дор болох гээд байна. Сүүлийн үед хулгайч хүртэл нарийн зохион байгуулалттай бодож, сэтгэж төлөвлөдөг болж IQ нь өсч байна.

*-Тэгэхээр манай улсад хүн бүхэн л IQ-гээ өндөр хөгжүүлэх зайлшгүй шаардлага гарч ирч байгаа юм аа даа?*

-Хүн бүхэн нэг ч өдөр алдахгүй урагшлаад явахгүй бол араас чинь хүчтэй хүмүүс гарч ирээд идэх хоолыг чинь булаагаад авна гэсэн үг. IQ-ийн номуудыг унш, бодлогыг бод, дараа нь клубт хамрагдах хэрэгтэй. Хүмүүс ширээний ард суугаад нэг шил пиво уухдаа ч IQ-гээ хөгжүүлэх зүйл ярьж байх хэрэгтэй. IQ хөгжсөнөөр хүний ахуй амьдрал, бүх юм сайжирна. Тиймээс хоцорч л болохгүй. Дэлхийн тэргүүний баян Билл Гейтс ганцаараа 55 тэрбум америк долларын хөрөнгөтэй. Гэтэл монгол улсын жилийн төсөв нэг тэрбум төгрөг л байдаг. Тэгэхээр оюун ухааны чадал гэдэг ийм аугаа. Оюуны өндөр чадвартай хүн ямар ч ажлыг хийж чадна. Юуг ч амархан сурна.

*-Хүн IQ-гээ нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс гэж байдаг уу?*

-Сая “Сэтгэх чадварын улсын олимпиад” болсон. Үүнд хийсвэр, шууд бөглөдөг тестийг Улаанбаатар, Дархан Эрдэнэтийн хүүхдүүд сайн бөглөөд, бүтээлч даалгавраар хөдөөний хүүхдүүд илүү байна. Энэ юуг хэлж байна гэхээр хотжоод байх тусам ЕБС-ийн сургалт хийсвэр чиглүүлэх аястай, шалгалтанд бэлтгэх зорилготой болж байна. Дүн л чухал гэхээс наад мэдлэгээрээ амьдар гэхгүй байна. Хэрвээ шалгалтанд сэтгэл зүйн тест оруулвал халуун сэтгэл гэдэг юмаар хөдөөний хүүхэд нэгдүгээрт, захын хорооллын хүүхэд хоёрдугаарт, хотын төвийн хүүхэд гуравдугаарт орж болзошгүй байна. Тэгэхээр

хөдөөд л эрүүл оюун ухаантай хүүхэд байна. Хөгжих процесс сөрөг үр дагавартай юм байна. Хүүхдийг байгаль, эрүүл агаар, амьдралд ойрхон байлгах хэрэгтэй. Ер нь УИХ-ын гишүүдийн хүртэл IQ-г тогтоож олонд зарлах ёстой. Тэнцэж байгааг нь нэр усаар нь зарлана. Монгол улсын оюуны чадварын IQ төв бол Монгол улсын бүх хүний оюуны чадварт хөндлөнгийн үнэлгээ өгөх хуулиар хүлээсэн эрхтэй байгууллага юм. 1916 онд АНУ иргэнийхээ IQ-г тогтоосон байна. Иргэний IQ-д хүрэхгүй бол иргэний эрхээ эдлэхгүй гэж хуульчилсан байсан. Энэ их үр дүнгээ өгсөн. Ингэж байж нийгэм цэгцэрнэ.

**-Нэгэнт л IQ хэрэгтэй гэдэг нь ойлгомж-той болчихоод байхад бүх цэцэрлэг, сургуулийг IQ-ийн сургалттай болгож болохгүй юу?**

-Хувь хүн иргэний өөрсдийнх нь хийх ажил. Эцэг эхчүүд өөрсдөө багш, сургуульд санал шаардлага тавих ёстой. Улаанбаатарын гайгүй нэртэй нэг сургууль хүүхдүүдээ IQ-д явъя гэхэд нь манай сургууль өндөр IQ-тэй учир шаардлагагүй гэсэн байгаа юм. Яагаад гэхээр IQ заагаад ирэхээр хуучинсаг багшийнх нь хуучин мэдлэг багадаа гээд байхгүй юу. Тэгсэн мөртлөө тэр сургуулийн багш нар өөрсдийнхөө хүүхдүүдийг авчраад манай “Хан-Уул”-ын дэргэдэх төвд IQ-д явуулж байгаа юм даа. Төв IQ, салбар IQ-гээсээ гурав дахин үнэтэй. Хүний сэтгэл ийм байдаг юм байна шүү дээ. Өөрийнх нь хүүхэд толгойгоо цэнэглэж байхад хүний хүүхэд хоцрох нь хамаагүй байдаг байх нь. Тиймээс хүн бүр л өөрийнхөө төлөө, үр хүүхдийнхээ төлөө юм хийж ажиллах цаг болсон байна.

**-Хүүхдийг хэдэн наснаас нь эхлэн оюун ухааныг нь хөгжүүлэх ёстой юм болоо?**

-АНУ-д хүүхдийг гэдсэнд олдохоос хоёр жилийн өмнөөс IQ-г нь хөгжүүлдэг. Хоёр жилийн дараа хүүхдээ олно гэсэн эхнэр, нөхөр хоёр эмнэлэгт очоод бие сэтгэхүйгээ эрүүл болгож хоёр жилийн турш графикийн дагуу ажилладаг. Тэгээд гэдсэнд олдонгуут нь гаднаас нь ээжтэй нь ажилладаг. Ээжийг нь хөгжүүлэхээр гэдсэн дэх хүүхэд нь дагаад хөгждөг байна. Тэгээд гарангуут нь тасралтгүй хөгжүүлдэг.

Ер нь ихэнх оронд хүүхдийг хэвлийд байхаас нь хөгжүүлж эхэлдэг. Зарим хөгжилтэй оронд гэдсэнд нь байхад хүүхдийн ген, геномыг уншаад гэмтэлтэй юм уу усан тэнэг, IQ доогуур байвал эмчийн баталгаа гаргаж аборт хийдэг байна. Гэтэл манайд хүн бүр дураараа аборт хийлгэдэг. Гэтэл аборт олон хийлгэсээр байгаад нэг хүүхэд гаргахдаа хамгийн муу усан тэнэг хүүхдээ авч

үлдсэн байдаг. Зүгээр л хүний амиар хэн дуртай нь тоглож болохгүй гэсэн үг, бурханаас шийтгэл өгч байгаа нь тэр.

*-Та эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөөч, яаж хүүхдийнхээ IQ-г хөгжүүлэх вэ?*

-Аль болох IQ-ийн сургалттай цэцэрлэг сургуульд хүүхдээ явуул. Хэвлэгдэж гарсан ном, сурах бичгийг сайн унш. Гэртээ янз бүрийн оюун ухаан хөгжүүлдэг тоглоомуудаар хүүхдээ тоглуул. Баруунд оюун ухаан хөгжүүлдэг тоглоом нас насаараа янз бүр өндөр үнэтэй байдаг. Өөрөө ч бас тархиа цэнэглэх хэрэгтэй. Тэгэхээр алхам алхмаар цөмөөрөө оюун ухаан руу зүтгэх нь байна. Бүх хүнийг оюун ухаанаар нь эрэмбэлэх болно. Найз нөхөд хүртэл IQ-гээрээ нийлж найзалдаг болжээ. Урьдны тэр багын найз, нэг ангийнхан гэж найзалдаг үе өнгөрсөн. 100-тай IQ- тэй хүн 110-тай IQ-тэй хүнтэй яриа нийлдэггүй. Нэг нь оюунлаг юм яриад байхад нөгөөх нь арзаганаад марзганаад байдаг. Тэгэхээр IQ-гээ хөгжүүлэхэд хүн бүр бүх хүчин чармайлтаа дайчлах хэрэгтэй.

## *ХУУЛЬЧИЙН ҮНДСЭН ЗЭВСЭГ НЬ ОЮУН УХААН-СЭТГЭХ ЧАДВАР МӨН*

---

*УИХ-ын гишүүдэд*

**Нэг.** Хуульч хүний сэтгэн бодох чадвар гойд сайн байх ёстой. Хуульчийн үндсэн зэвсэг нь оюун ухаан болой. Харамсалтай нь манай хуульч бэлтгэдэг сургуулиуд олон арван жилийн туршид оюун ухаан, сэтгэх чадварыг огоорч, нийгмийн тухай зохиомол хийсвэр мэдлэг, хуулийн ягшмал заалт, хоосон диплом хөөцөлдсөний уршгаар гүн хямралд өртөж, 1990 оноос хойш бүр ч лавшрав.

Монгол Улсын Оюуны чадварын IQ төвөөс 2001 онд Хуульчдын мэргэжил дээшлүүлэх төвтэй, 2002 онд УБ хотын шүүхтэй хамтарч 130 хуульчийн IQ-г тогтоох тандалт судалгаа хийв. Судалгаагаар хуульчдын дундаж IQ нь 104 гарчээ. 104 гэдэг нь дээд мэргэжилтэй ямар ч хүний хувьд маш доогуур үзүүлэлт юм. Хуульчдын логик, латерал сэтгэх чадвар нэлээд сул байх ба тэд ээдрээтэй асуултад бүдэрч, олон хувилбарт бодлогод унасан байна. Шалгагдсан 130 хуульчийн 50 нь сэтгэх чадварын хувьд жирийн иргэдийн стандарт дундаж 100-аас доогуур байна. Эдгээр хуульчдад дээд мэргэжлийн диплом бүү хэл, иргэний үнэмлэх ч “ахдаж” байна. (IQ- нь 71-ээс 99 -н хооронд байвал тэр хүн мунхагдуу категорид ордог)

АНУ-д хуульчийн IQ нь 130- аас доошгүй байх ёстойг хатуу хуульчлан мөрдүүлжээ. Хуулийн мэргэжлээр их, дээд сургуульд элсэгчдийн сэтгэх чадварыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллага (ETS-боловсролын тестийн алба) нь стандарт тестээр (LSAT -хуульч мэргэжлээр сурах чадварын тест) шалган эрэмбэлж 130-аас доош IQ-тэй бол элсэх эрхийг нь хасдаг аж.

Сүүлийн үед гэмт хэрэгтнүүдийн IQ өгсөх хандлагатай байхад хуульчдын IQ нь буурах чиглэлд оржээ. Хуульчдын сэтгэх чадвар гэмт этгээдийнхээс дор орвол хууль завхарч, хулгайч завшиж, хуульчид тоглоомын хүүхэлдэй болох аюул нүүрлэнэ. Энэ бол эмгэнэл мөн.

**Хоёр:** Эрх зүйч мэргэжлээр төгсөгчдийг эрдэмтдээс бүрдсэн орон тооны бус байгууллагаар дахин шалгах нь ээ. Үүнийг дэмжинэ, гагцхүү энэ байгууллага нь хөндлөнгийн, хараат бус байх ёстой.

Хуульчийг тодруулах шалгуур үзүүлэлт нь :

1. Оюуны чадавхи, сэтгэх чадвар
2. Мэргэжлийн мэдлэг, мэргэшсэн байх
3. Ёс зүй гэсэн дараалалтай байвал цаг үеийн шинэ шаардлагад нийцнэ.

Сэтгэх чадвар сайтай, чадварлаг хуульчийн нийгмийн үнэлгээ сүүлийн үед эрс өндөрсөж байгаа нь баримт юм. Төгс хууль гэж хэзээ ч, хаана ч байхгүй. Тэгэхлээр хуульчийн чадвар л гойд чухалчлагдах болно. Мэдлэг хуучирдаг, тэр тусмаа хуулийн мэдлэг бүр ч түргэн хуучирдаг. Хуулиа цээжээр мэддэг, ёс зүйн алдаа гаргадаггүй атлаа сэтгэх чадвар сул, нөхцөл байдлын мэдрэмжгүй, гэмт хэрэгтний амыг дагасан унхиагүй хуульч олширвол байдал улам дордоно, хууль нь гууль болно. Сүүлийн үед ийм байдал иргэний хэрэг дээр олонтаа илрэх болов. Хуулийн цоорхойг овжноор ашиглаж дажгүй амьдардаг нийгмийн бүлгүүд үүсчээ.

Иймд хүсэмжлэх нь: Та нөхөд “Хуульчдын сонгон шалгаруулах журмын тухай” хуулийг хэлэлцэхдээ сэтгэдэг, чадварлаг хуульч төрүүлэх энэ цаг үеийн захиалгыг анхаарч, хууль нь хуульчийн оюун ухаанаар амилдаг гэдгийг хатуу санаж, “сэтгэх чадвар, оюуны чадавхи” гэдэг хуулийнхаа гол ноён нурууг ягштал мөрдөж, эдгээр үгсийг хуулиндаа аль болох олон удаа тусгаж өгнө үү.

Сэтгэдэг хуульч л жинхэнэ хуульч гэгдэх цаг үе ирлээ. ХХI зуун бол сэтгэдэг, чадварлаг хуульчийн эрин мөн. Хуулийн үг өгүүлбэр цээжилснээр хуульч болохгүй, хуулийг ойлгож, тайлж байж хуульч болно. Сайн хуультай, муу хуульчтай байснаас муу хуультай, сайн хуульчтай байсан нь хамаагүй дээр. Сэлэм барьсан олон мунхаг хуульчдыг ном тэвэрсэн цөөн ухаалаг хуульчаар солих цаг айсуй... Оюунлаг хуульч л хуулийг боловсруулдаг, тайлбарладаг, хэрэглэж чаддаг.

# *ЭМЭГТЭЙ ХҮН НӨХРӨӨСӨӨ ДЭЭГҮҮР IQ-ТЭЙ БОЛ ӨӨРТ НЬ НӨМӨР БОЛОХООР ИЛҮҮ ЭР ЛҮҮ ШИЛЖЧИХДЭГ*

---

Хүмүүсийн амьдрал 2003. 10 сар №40(173)

*-Гэр бүл салалтад IQ ямар нөлөөтэй байх вэ? Ер нь салалтыг багасгахын тулд хүмүүсийн оюуны түвшин буюу IQ-аар дамжуулж нөлөөлж болох уу?*

-Мэдээж гэр бүл салалтад хосуудын оюуны чадавхийн түвшин нөлөөлнө. Яагаад гэвэл, нэг хүн шиг байж нэгдэж амьдрах ёстой хосуудын аль нэг нь нөгөөгөөсөө оюуны чадвараар доогуур байвал тэдэнд үл ойлголцох зүйл гарч ирнэ. Тэгэхээр ганцхан хайр сэтгэл байвал бусад бүх юм болчихно гэж болохгүй. Жишээлбэл, гэр бүлд эд баялгийн нөлөө гэж байдаг. Эд баялаг чинь цаг үеэ дагаад өсөөд өөрчлөгдөөд байгаа хүмүүсийн хэрэгцээ шүү дээ. Үүний ар талд түүнийг хураах оюуны чадвар гэж юм байх ёстой. Оюуны чадвар сайтай нь илүү мөнгө олж хэрэгцээгээ хангана. Тийм учраас гэр бүлийн амьдрал, хайр сэтгэлийг оюуны чадвараас салгаж үзэх арга байхгүй.

*-Хамтын амьдралаа эхлэхээр шийдээд байгаа хосуудад зориулаад юу гэж зөвлөх вэ?*

-Залуу хосууд аз жаргалтай байх л гэж ханилан сууж байгаа учраас эхлээд бие биеэ тэвчээртэй судал. Ганцхан эмэгтэй нь ч биш эрэгтэй нь ч бас бүсгүйнхээ эерэг болон сөрөг тал, удам судрыг нь судал. IQ нь ямар түвшинд байна, аливаа асуудлыг хаанаас нь яаж авч үзэж байгаа зэргээс нь эхлээд хар. Хэрвээ IQ-ийн хувьд нэлээд зөрүүтэй хэрнээ гэр бүл болоод үр хүүхэд гаргаад амьдрал эхэлчихсэн бол IQ-аар дээгүүр нь нөгөөдөө нөлөөлж өсгө. Үнэхээр хайртай бол өсөж тэнцүү болно. Харин жинхэнэ хайр сэтгэлгүй суучихсан бол IQ-ийн хол зөрүү амьдралд их төвөг учруулна. Энэ нь хэрүүл, үл ойлголцол мэтээр илэрч улмаар салалтад хүргэнэ.

Айл гэр болно гэдэг бие бие рүүгээ харж суухын нэр биш, харин хоёулаа нэг зүг рүү харж суухын нэр юм гэж ард түмэн өөрсдөө сургасан байдаг. Энэ чинь юмыг үнэлэх адил үнэлэмжтэй бол гэсэн үг. Барууныхан хүүхдээ

багаас нь оюун ухааныг нь хөгжүүлж, өөрийнх нь сэтгэлгээний хэлбэрийн дагуу мэргэжлийн чиг баримжааг нь олгодог. Тэгээд иймэрхүү зан төлөвтэй, сэтгэлгээний иймэрхүү хэлбэртэй, тэдээс тэд орчим IQ-тай хүнтэй амьдралаа холбовол сайн гээд тодорхой хэлж өгдөг ажээ.

***-Манайд энэ аргыг нэвтрүүлэх боломж хэр байна вэ?***

-Манайд сэтгэл судлал гэдэг юм бараг алга байна л даа. Зөвлөлтийн сэтгэл судлалыг дагнаад авчихсан. Тэр нь хувь хүн төрөхдөө коммунист төрдөг. Хүн төрсөн л бол бүгд адилхан үзэл бодолтой, зан характертай байх ёстой гэж үзсэн. Энэ явцуурлаас болоод манайд сэтгэл судлал хөгжөөгүй. Харин одоо л энэ талаар яригдаж, ажил хийгдэж эхлээд байна. Зөвлөгөө өгөх төвүүдтэй болж байж хосууд чиг баримжаа авдаг болох ёстой.

***-IQ-аараа хол зөрүүтэй хүмүүс бие биедээ хайр сэтгэлтэй болдог уу?***

-Хайр сэтгэлийн эхлэл нь дурлал шохоорхол гэж байна. Нөгөө хүнийнхээ IQ-г өөрийнхтэйгээ харьцуулж үзээд хайр үүснэ гэсэн ухамсартай үйл явц байхгүй. Автоматаар шууд л гал асчихна. Тэр гал нь өөрөө явсаар байгаад хайр болж дүрэлзэнэ. Гэхдээ мэдээж, нэг удаа уулзаж арван үг солиод л бие биенийхээ IQ-г ойролцоогоор танина шүү дээ. Тэгээд хэн нэг нь өөрөөс нь IQ-аар дутуу бол үг яриа зөрөхөөс эхлээд гологдоно. Тэгэхээр IQ-аар хол зөрүүтэй хүмүүс бие биедээ хайртай болно гэж бараг байдаггүй.

***- Гэр бүлд хосүүдэн аль нэг нь IQ-аараа давуу гэр бүл байвал илүү сайн гэсэн юм байх уу?***

-Амьдрал дээр байгаа бодит үнэнээс зугтах учиргүй байх аа. Оюун ухаан судалдаг хүний хувьд энэ асуултад хариулья. Эрэгтэй хүн төрөлхөөсөө илүү хол хардаг учраас ойрын хараа сул, тулгамдсан асуудалд хандахдаа муу байдаг. Ийм эр хүн өөрөөсөө арай доогуур оюуны чадвартай эмэгтэйд шохоорхдог нь судалгаагаар ажиглагдсан. Их тогтвортой гэр бүлийн дийлэнх нь эрэгтэйгийнх нь оюун чадвар буюу IQ-нь илүү байгаа гэж тогтоогдсон.

Эрэгтэй хүн төрөлхөөсөө өөрийгөө уул гэж төсөөлдөг. Бусдыг өөрийнхөө нөмөрт хааж байх учиртай гэж. Тэгээд өөрөөсөө жаахан намхан уулыг нөмөрлөх дуртай. Тэр нь гэр бүл дээр илэрнэ. Харин үүний эсрэг эмэгтэй нь өөрөөсөө доогуур оюуны чадвартай эртэй гэр бүл болсон бол нөмөрлүүлэх биш, өөрөө уул нь болчихоод болж өгдөггүй. Эмэгтэй хүний өөрийн нь төрөлхийн нандин чанар нь тэр уулын нөмөрт байх юм шүү дээ. Ийм гэр бүл тогтвор багатай байдаг.

***-Заавал эхнэрээсээ дээгүүр албан тушаал, орлоготой биш гэртээ суугаад эхнэрээрээ тэжээлгэдэг эр хүн уул нь байж болох уу?***

- Яг энэ амьдралаас жинхэнэ эмэгтэй хүний өвөрмөц нандин чанар харагддаг. Яагаад гэвэл. сэтгэлдээ буулт хийж энэ маань надад түшиг болж байгаа юм шүү, хань минь юм шүү, эсвэл нэг үе дажгүй сайн явсан юм шүү, эсвэл ерөөсөө нөхөртэй хүн гэж харагдах гэсэн олон олон шалтгаанаар тэр эрэгтэйтэй амьдраад явдаг. Хэрвээ тийм эмэгтэйд нөхрөөс нь илүү оюун чадвартай өөрт нь уул болохоор хэмжээний эрэгтэй таарвал нөгөө жижигхэн нөмөргүй уулыг орхиод шилжчихдэг. Ер нь ажиглалтаас хараад байхад оюун чадвараар дутуу хүнтэй ханилах нь эмэгтэй хүнийг их ядраадаг. Тийм ч учраас эмэгтэйлэг, нийгмийг чимдэг, өвөрмөц чанар нь бүдгэрчихдэг. Эмэгтэй хүн гэр бүлийг нуруун дээрээ үүрэхэд зориулагдаагүй учраас бүх хариуцлага, ажлаа тэгш хувааж хийнэ гэдэг жендер биш. Гэтэл эмэгтэйчүүд маань өөрсдөө хүртэл бүх ачаагаа тэнцүү хуваах гээд зүтгээд байх юм. Номоороо бол эрчүүд илүү хийгээд үр дүнг нь тэнцүү хуваах ёстой. Эмэгтэйчүүд чинь жаргах гэж ирсэн хүмүүс гээд хэлсэн ч болно.

***-Яг одоо манай эрчүүд бүсгүйчүүдтэйгээ адилхан сурч боловсроод, ажиллаад явж байгаа боловч оюун чадвараар сул юм уу гэж ажиглагддаг. Та цүннийг юу гэж үзэж байна вэ?***

-Одоо манайд 1870 онд буюу 133 жилийн өмнө үеэ өнгөрөөсөн боловсролын системийг хэрэглэж байна. Энэ нь цээжлэх, дуурайх зэрэг бүтээлч биш идэвхгүй чадварт илүү тохироод байгаа юм. Эрэгтэй хүн байгалиасаа энэ чанаруудаас илүү бүтээлч чанар луу идэвхждэг онцлогтой. Харин эмэгтэй хүн дуурайх, цээжлэх тал руугаа илүү идэвхждэг онцлогтой. Бид боловсролын системийг сууриар нь өөрчилж эрэгтэйчүүдээ идэвхжүүлэх зүйлээр баяжуулахгүй бол энэ байдал өөрчлөгдөхгүй шүү дээ. Тэрнээс биш манай эрчүүд оюун чадвараар муу биш.

***-Охид бүсгүйчүүд гадаад үзэмж, мэдлэг боловсролдоо өдөр ирэх тусам анхаараад эрчүүд нь хуучин байдалдаа сэтгэл хангалуун байгаа нь цүнтэй холбоотой юу?***

-Нийгмийн олон хүчин зүйлтэй холбоотой. Наад тал нь сайн сайхны үнэлэмж гажигтай байна. Биеийн хар хүч, морины хүч, болхи бүдүүлэг байдлыг илүү үнэлдэг хэвээрээ. Монгол бөх гэхэд л хөлсөө урсгаад хоорондоо тулаад зогсчихдог хэвээрээ. Өнөөгийн монголын нийгмийн үнэлэмж нь дэлхийн

үнэлэмжээс хол хоцорсон байна. Дуурийн театрт очдог хүмүүсээс бөхийн өргөөнд очдог нь хэд дахин их байгаа хэвээрээ. Бөхийн өргөө Дуурийн театр хоёрт байгаа эрчүүлийг харьцуулаад үз. Нийгмийн үнэлэмж нь өөрөө оюун ухааныг үнэлэх тал дээр харьцангуй сул байгаа учраас эрчүүдийг үлбэгэр, хар хүчтэй, бүдүүлэг байх руу түлхээд байна.

*-Гэр бүл болохоор шийдээд мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах гэсэн хүмүүс олон байдаг. Танайх тэдэнд туслах боломжтой юу?*

-Тийм шүү. Залуу гэр бүлүүд ийм юмаар их дутдаг. Зарим хүмүүс надаас ирж зөвлөгөө авдаг л юм. Зөвлөгөө өгөөд, мэргэжлийн чиг баримжаа үзүүлэх шаардлагатай байгаа. Одоохондоо бидэнд боловсон хүчнээс эхлээд бэлэн болоогүй зүйл их байна. Яваандаа бүх салбарт хөгжөөд, зөвлөгөө өгөх төвүүд бий болгох шаардлагатай байгаа.

*-Өөрсдийгөө таарамжтай гэр бүл болох эсэхээ мэдэхийг хүсэж байгаа хүмүүст зөвлөгөө өгөхгүй юу? Ер нь хүнийг оюун ухааны чадвараар нь эцэг эх болоход бэлэн эсэхийг нь мэдэж болох уу?*

-Манайхан орчин нөхцөлөөс болоод зурхай, лам гээд явчихдаг. Бид бол хүн бүрийг оюун ухаанаа сайн хөгжүүл л гэж хэлнэ. Ухаантай, оюуны чадвар адилхан хүмүүс юмыг нэг янзаар хүлээн авч, адилхан бодож сэтгэж, нэг адил шийдвэр гаргана. Тэнд ойлголцохгүй зүйл гарахгүй. Бат суурьтай гэр бүл болно. Хамгийн энгийн жишээ бол эмэгтэй нь IQ-ийн хувьд илүү буюу тогтворгүй гэр бүлд өссөн хүүхэд ноён нуруу муутай байдаг. Хүүхдийн хүмүүжилд бас нөлөөлж байгаа биз.

Юм бүхэн оюун ухаантай холбоотой болохоор эцэг эх болоход бэлэн эсэхээ мэдэж бололгүй яах вэ. Тэнэг хүмүүс хоорондоо суугаад үр хүүхэд гаргахаар тэнэгийн генетикийн код удамшдаг нь нотлогдсон баримт гэдгийг хэлье.

*-Яагаад бүх гэр бүлд ямар нэг хэмжээгээр хэрцүүл гардаг юм бэ?*

-Оюуны чадварын зөрүүгээс шалтгаалаад хэрүүл гарч байна. Оюун чадвараа хөгжүүлж тухайн нэг асуудлыг олон талаас нь ойлгоогүйгээс болж байна. Монгол хүмүүсийг сэтгэлгээний айн 30 хувийг эзэлдэг латерал сэтгэлгээнд сургах хэрэгтэй байна. Энэ нь шавхаж сэтгэх буюу юмыг олон талаас нь бодож үзэх арга.

Ер нь гэр бүл чинь улсын үндэс болохоор салалтыг багасгахын тулд оюунлаг гэр бүлийг олон болгох хэрэгтэй. Тогтвортой гэр бүл бүхэн оюунлаг

байсан. Энэ нь тэр айлд оюуны үнэт зүйлс, хүний нандин чанарууд цогцолсон, халуун дулаан уур амьсгалтай байхыг хэлж байгаа юм. Заавал дээд мэргэжил эзэмшсэн биш жирийн нэг малчин айл ч гэсэн оюунлаг байж болно.

*-Оюун чадварынхаа хэмжээнээс тухайн хүний муу чанарууд нь хамаардаг болов уу? Жишээ нь, IQ-ийн иймэрхүү түвшний хүнээс иймэрхүү зан ааш гарч болох юм гэсэн судалгаа байгаа байх л даа?*

-Уг нь байгаа, байх ч ёстой. Гэхдээ энэ салбар манайд дөнгөж үүсч эхлээд байна. Барууны орнууд манайд судалгаагаа тэр болгон бэлэн дэлгээд үзүүлдэггүй. Ямар ч гэсэн тэд энэ талаар их нарийн судалгаа хийсэн байгаа Түүнийгээ ч төрийн бодлогодоо сайн хэрэгжүүлж байгаа. Тэгээд ч судалгаан дахь ард түмний нарийн нандин нууцыг бидэнд дэлгэхгүй л дээ. Манайд өөрсдөө энэ талаар судалгаа хийх боломж байгаа, хийх ч ёстой.

*-Гэр бүл тогтвортой байхад нөлөөлдөг нэг зүйл нь секс гэдэг. Тэгвэл оюун ухаан нь секстэй ямар холбоотой вэ?*

-Оюун ухааны талын баримжааг хэлье. Секс гэдэг бол хүний амьдралын их аз жаргалтай, амттай мөч юм. Үүний гоё сайхныг амсъя гэвэл оюун ухаанаа улам хөгжүүлэх хэрэгтэй гэж судлаачид баталсан байгаа. Оюун чадвар хэдий чинээ сайн хөгжсөн байна, тэр хүний сексээс авах мэдрэмж нь төдий чинээ илүү амтлаг байна. Харин оюун чадвар нь доогуур сул байх тусам түүний сексээс авах таашаал амьтныхтай төстэй байдаг гэнэ, сонин байгаа биз!

Хүүхэд олох үед хосууд ямар араншин гаргах нь төрөх хүүхдэд тэр хэвээрээ өвлөгддөг гэж нэг эрдэмтэн бичсэн байна. Дэлхий нийтээр бүтээгдэхүүний чанарт их анхаарах боллоо. Хөлдөө таарсан гутал өмсөхийн тулд нэг итали эмэгтэй 250 гутал өмсөж үзэж байж нэгийг нь сонгодог байна. Гуталчин энэ дундаас сонгогдохын тулд гутал үйлдвэрлэхэд их нарийн хандаж байхад хүүхэд үйлдвэрлэхэд яагаад хайхрамжгүй санамсаргүй тохиолдол болгож байна вэ. Манайхны хувьд хүүхэд үйлдвэрлэх нь санамсаргүй гэнэтийн тохиолдлын чанартай байх нь их учраас 1000 хүүхэд тутмын 10 нь, зарим нутагт 40 нь тэнэг төрж байна. Дэлхий нийтэд энэ тоо 3 орчим гэж тэмдэглэгдсэн байдаг.

## ***МИНИЙ IQ-Г АРД ТҮМЭН Л ТОГТООНО***

---

ҮНЭН 2003. 10. 10 №201

*-Хүмүүний оюун ухааныг Та төрөлхийн өгөгдөхцүн хэмээн зарлан тунхагладаг. Тэгвэл цүсэл хөгжлийнх нь түүх гэж заавал байх ёстой гэдэгтэй Та санал нийлэх үү?*

-Нийлнэ ээ. Оюун ухаан бол дор хаяж л нэг сая жилийн түүхтэй. Сармагчины бус босоо хүний үеэс эхтэй.

*-Шинжлэх ухаанд бол хүн галыг олсноор оюун ухаанаа хөгжүүлэх эхлэлийг тавьсан гэж үзээд байдаг?*

-Өө, үгүй, үгүй. Оюун ухаан бол онолоороо, орчлонгийн хууль жамаараа хүн дээр илэрсэн байгаа нь тэр. Тэгэхдээ энэ илэрсэн оюун ухаан бол сэтгэдэггүй байжээ. 750 мянган жилийн турш сэтгэдэггүй, зөнгөөрөө явж ирж. Харин 250 мянган жилийн өмнөөс сэтгэлгээ үүсчээ.

*-Сэтгэлгээг ч Та бас орчлонгийн хуулиар цүсчээ гэх гээд байна уу?*

-Тэгэлгүй яахав. Дандаа хөгжлийнхөө хуулиар л явж байгаа юм. Тэгээд ч одоогоос 50 мянган жилийн өмнө мэдлэг буюу шинжлэх ухаан үүссэн.

*-Хэдийгээр энэ бүхэн орчлонгийн болоод оюун ухааны өөрийнх нь хөгжлийн зүй тогтол ч гэлээ бие биеэсээ урган саданссан ахан дүүс л юм байна. Харин боловсрол хэзээ цүсч вэ?*

-Тав орчим мянган жилийн өмнө үүссэн гэдэг юм. Тэгэхдээ тэртээх 50 мянган жилийн өмнө үүссэн мэдлэгийг чинь та нарт зааж байгаа юм. Гэтэл монголчууд бид шууд л боловсролыг барьж авсан. Энэ нь тийм ч сайнгүй шүү.

*-Яагаад тэр вэ?*

-Аливааг араас нь хөөвөл гүйцэхгүй шүү дээ. Урдаас нь л угтахгүй бол болохгүй.

*-Гүйцчихвэл яах вэ?*

-Гүйцэхгүй л дээ. Хөгжлийн хуулийг сөрж болохгүй. Баруунд бол боловсролыг одоогийн бидний хэрэглээд байгаа энэ утгаар үнэлэхгүй. Огт

өөр. Оюун ухааныг нь л үнэлдэг болсон. Манай боловсрол бол хийсвэр шүү дээ. Энэ тухай би ном бичсэн. Одоо л бид оюун ухаан руугаа явах гэж байна даа. Энэ бол хүн өөрийгөө олж байгаа нь тэр.

*-Таныг ойлгож байна л даа. Үүнийг ярих нь утгагүй ч байж магадгүй. Гэхдээ Та Чингис хааныг хэн гэж боддог вэ?'*

-Чингис хааныг би хүн гэж боддог. Тэгэхдээ тэр жирийн монгол хүн биш, маш өндөр оюун ухаантай хүн. Үүнийг бид зөвхөн түүхийн бэлгэдлийн утгаар нь хэлээгүй. IQ-г нь гаргасан юм.

*-Тухайн үедээ Та хэвлэл мэдээллээр энэ тухай зарлаж байсан л даа. Гэхдээ дахин тодруулаач?'*

-Чингисийн IQ нь 204 нэгжтэй юм билээ. Энэ бол аугаа их суут хүн байсны бодит баталгаа. Ийм хүн тэрбум хүнд нэг тохиоддоно.

*-Монголчууд тухайи үед нэг тэрбум хүрч байсан гэж үү?'*

-Үгүй. Монголчууд хэзээ ч түүхэндээ тэрбум хүрч байгаагүй. Үсрээд л 100 сая биз дээ. Одоо дэлхий дээр амьдарч байгаа нь 10 сая шүү дээ. Харин дэлхийн хүн нийтдээ 80 тэрбум хүрнэ. Одоо зургаан тэрбум нь л амьд байгаа биз дээ.

*-Тэгвэл одоо монголчууд дотроос манай Чингис хаан шиг хүн төрсөн үү?'*

-Төрөөгүй байна.

*-Төрөх үү?'*

-Оюун ухааны хөгжлийн хичээлийг л маш эрчимтэй хийвэл төрөх боломжтой. Одоо тэгээд манайхаас бусад орны хүмүүс бүгд л оюун ухаанаа хөгжүүлэх хичээлийг зааж байна. Манай хойд хөрш Орост л гэхэд жилийнх нь сургалт есөн мянган долларын өртөгтэй Ломоносовын сургууль нэртэй хаалттай хувийн дунд сургууль хичээллэж байна шүү дээ.

*-Яагаад заавал хаалттай гэж...?'*

-Тийм үнэтэй сургуульд нийгмийн дээд хэсгийнхэн л хүүхдээ зорьж сургана биз дээ.

*-Та холбоо тогтоох уу?'*

-Тогтоох гэж байгаа.

*-Хэзээ тэр вэ?'*

-Тун удахгүй ээ. Тэгэхгүй бол манайхны сургалтын арга барил яг л морин тэрэг шиг байна. Ийм хурдаар орчин үед яаж хорвоог туулах юм бэ,

ер нь. Тиймээс Москвагийн Ломоносовын дунд сургуулиас бид багш урина.

*-Ер нь дэлхийн хэмжээнд Чингис хаан шиг хэмжээний хүн хэд байна даа?*

-80 орчим хүн бий. Тэгэхдээ энэ нь аугаа суут гэдэг категорт багтах юм шүү дээ.

*-Энд эмэгтэй хүн бий юу?*

-Одоогоор байхгүй байна. Тэгэхдээ аугаа суутаас доогуур бол олон категори бий шүү дээ. Суут гэсэн категорид нь бол ганц нэгхэн эмэгтэй бий байх. Ер нь бараг байхгүй дээ.

*-Энэ нь юутай холбоотой вэ?*

-Юм юмтай л холбоотой. Тэгээд ч олон талын үндэслэлүүд шинээр гарсан.

*-Годорхой яриач?*

-Ерөөсөө тархи шиг нарийн эрхтэн байхгүй юм байна.

*-Тэгвэл орчин цед эмэгтэйчүүд хүчирхэгжиж байгааг Та юу гэж хэлэх вэ?*

-Тархины глиал буюу холбогч эд гэж байдаг юм байна. Глиал нь орчуулагдахгүй байна л даа. Генитэй холбоотой үг болохоор. Тэгээд л тэр глиал холбогч бол тархинд буй мэдээллийг холбодог үүрэгтэй. Орчин үеийн эмэгтэйчүүдийн хүчирхэгжиж байгаагийн шалтгаан нь ерөөсөө л тархиных нь мэдээлэл холбогч хүчирхэгжиж байгаатай холбоотой юм билээ.

*-Эрчүүд, эмэгтэйчүүдийн ялгаа удахгүй арилна гэх гээд байна уу?*

-Арилна. Засарна. Эдгэрнэ.

*-Яг хэзээ тэр вэ?*

-Одоо ер нь боловсролын системд өөрчлөлт хийгээд ирэхээр нийгмийн шилжилтийн үетэй холбоотой ийм үзэгдлүүд арилна л даа.

*-Эрчүүд ямагт хүчирхэг хэвээр байх нь Таны бодлоор бас л орчлонгийн жам уу?*

-Тийм ээ. ертөнцийн жамыг хэн ч тийм амархан эвдэхгүй дээ. Эвдэх гээд байгаа хүн өөрөө л зовно. Оюун ухааныхаа энгээс хэтэрсэн зүйл рүү тэмүүлсэн хүн зовлонгоо өөрөө эдэлдэг нь үнэн л биз дээ. Хэн ч түүний өмнөөс зовохгүй.

*-Амьдралд амжилт гаргаж яваа бүсгүйчүүдийг тэгвэл Та юу гэж хэлэх вэ?*

-Тэд бол өөрийгөө хурцалж, басхүү золиосолж чадаж байгаа хүмүүс...

*-Харин ч тэднийг магтан дуулмаар юм биш үү. Тэдэнд оюун ухааных нь чадвар ч тусалж л байгаа шүү дээ?*

-Магтаж, бахархаж болно оо. Үүнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ оюун ухааны чадварыг хэмждэг л дээ. Ийм бодитой хэмжүүр IQ-д бий.

*-Сонирхуулаач*

-Хүний IQ 130-аас дээш бол сайн. 0-70 байвал усан тэнэг, 71-100 байвал сул талдаа, сулавтар эрүүл гэсэн үг, 100-130 бол ухаантай талдаа эрүүл, 131-140 бол ухаантай, 141-160 бол гоц авъяастан, 161-180 бол сод ухаантай, 181-200 бол суутан, 201-ээс дээш бол аугаа суут байдаг.

*- Их нарийн юм аа?*

-Өө, нарийн байлгүй яахав. Эд чинь тэгээд дотроо задарна гээд боддоо.

*-Таны IQ хэд вэ?*

-Би өөрийнхийгөө тогтоож болохгүй. Ард түмэн л тогтооно.

*-Гэхдээ та өөрөө тогтооё гэж бодсон уу?*

-Бодсон. Минийх бол ердийн үедээ 130 юм шиг байна лээ. Бэлтгэчихвэл 130 гарна, ийм л юм.

*- Би уншсан л даа. Таны бичсэн «Монголын хөгжлийг бурхнаас асууя» номноос Оросын суут математикч Л.Эйлер бурхан байдаг гэдгийг математикийн аргаар батлах гэж олон удаа оролдсон агаад оролдох бүрдээ л «Бурхан байхгүй» гэсэн дүгнэлтэд хүрээд байсан гэж. Тэгэхээр Та ч бас математикч хүн болохоор ийм асуултад ингэж л хариулах байх. Харин математик бол сэтгэлгээний харъяат болохоор гаргалгаа нь ямагт сэтгэл зүрхний харъяат байдаг бурхныг, бурхны орон зайд яаж хүрэх вэ гэж надад санагдаад байна?*

Тийм ээ. Үүнийг бол би хүлээн зөвшөөрнө. Яг үнэн шүү. Гэхдээ сэтгэл зүрх гэдэг чинь аварга юм. Тэгээд халуун сэтгэл гэж их гоё юм бий. Энэ ч бас оюун ухаантай холбоотой л асуудал.

*-Та ч бүр өмчилж гүйцэх юм аа?*

-Үгүй, чи боддоо. Ухаантай, тэнэг хоёр хүний сэтгэл зүрх шал өөр мэдрэхүйтэй байна биз дээ.

*-Тэгвэл хүний сэтгэл хэдийд цуссэн юм бэ?*

-Хожмоо, хожим. Арав хорин мянган жилийн өмнө л үүссэн. Энэ бол маш түвэгтэй том сэдэв. Тийм болохоор би сэтгэл зүрхний тухай сэдвээс

айдаг юм.

*-Айдаг гэнэ ээ?*

-Тийм ээ. Дахин хэлье. Энэ бол маш том сэдэв. Маш том ухагдахуун.

*-Бас маш том шинжлэх ухаан шүү дээ?*

-Тийм шүү. Маш хурдацтай хөгжиж байна.

*-Шашин бол сэтгэлийн шинжлэх ухаан гэдгийг Та хүлээн зөвшөөрнө биз дээ?*

- Үгүй. Шинжлэх ухаан биш. Шашныг шууд л шашнаар нь ойлго. Гэтэл манайхан Далай ламыг хүртэл буруу ойлгоод байдаг. Аргагүй шүү дээ. IQ нь хүрэхгүй юм чинь.

*-Түүнийг Та юу гэж ойлгодог вэ?*

XIV Далай лам Данзанжамц бол их сайхан сэтгэлтэй оюун ухаантан юм байна. Гэтэл түүний дэргэд Гитлер бол харьцуулшгүй муухай сэтгэлтэй оюун ухаантан шүү дээ.

*-Таны өрх гэр, халуун ам бүлийн «гал тогоо» руу орохоос өмнө хайрыг, хайр дурлалын тухай ойлголтыг тань асууж байгааг минь өршөөгөөрэй. Та энэ хоёр цгийг тус тусад нь салгаж ойлгодог уу, эсвэл нэг зүйл гэж боддог уу?*

-Хайр бол ерөөсөө хүний бас амьтны оюун ухааны нэг илрэл байхгүй юу.

*-Өөр хоорондоо эвцэлдсэн ганцхан л ойлголт юм гэж үү дээ?*

-Нэгссэн ч байж болно. Нэгсээгүй ч байж болно. Хоорондоо төстэй ч байж болно. Огт төсгүй ч байж болно. Зөн билэг мэдрэмжээрээ ч явж болно. Гэхдээ хайр бол дурлалынхаа илрэл нь л болж харагдана даа.

*-Тэгвэл дурлалыг Та тодорхойл доо?*

-Дурлал гэдэг бол оюун ухаанд үе үе маш хүчтэй манарч байдаг оюун ухааны зөнтэй холбоотой чадвар юм. Их огцом үүсдэг. Огтын төсөөлөлгүйгээр ирдэг. Хүн дурлачихаад дурлалаа удирдана энэ тэр гэсэн юм байхгүй. Миний хувьд дурлал үе үехэн харагдаж байдаг гал шиг санагддаг. Тэр гал дээр л хайр гэдэг юм нь тогтож байвал үгүй мөн гоё болно оо доо. Энэгүй бол жирийн хайр болно доо. Тэгээд хайр дурлалууд дотроо хамгийн сайн нь жинхэнэ дурлал байдаг юм байлгүй.

*-Хоосон чанарын тухай Та хэр уншсан бэ?*

-Уншсан. Бүр энэ тухай зорьж судалдаг хоёр судлаачийнх нь номыг уншсан.

*-Оюун ухааны нүдэнд харагдашгүй тэр их өндөр төвшний ухагдахуун ойлголтууд, сургаал номлолуудын дэргэд бүдүүлэг ахуй ч гэж хэлмээр бидний энэ амьдрал юухан ч юм бэ дээ гэмээр санагдаж байх юм уу?*

-Санагдалгүй яахав. Хоосон чанарын сургаалууд бол ёстой гайхамшиг юм билээ.

*-Хоосон чанарыг төгс эзэмшихсэн чадвартай гэгээнтнүүдийг Та юу гэж боддог вэ?*

-Энэ бол маш ховор тохиолдол. Тэгэхдээ одоогоор ийм чадвартай хүмүүс албан ёсоор бүртгэгдээгүй байгаа шүү дээ. Тиймээс домгийн шинжтэй гэж болно. Ард түмний сэтгэлгээний уран санаа шиг л яригддаг л даа, яг үнэндээ бол.

*-Оюун ухаан ер нь хэдэн чадвартай юм бол?*

-Сонин асуулт байна. 120 чадвартай. Одоогоор мэдрэгдэж байгаа нь шүү дээ. Эндээс 40-ийг нь төрөлхийн шинжтэй гэдэг юм. Үлдсэн 80 нь үүсмэл болж таарах нь л дээ, тэгэхээр. Өөрөөр хэлбэл, хүн оюун ухааныхаа гуравны хоёр хувийг сургалтын аргаар бүрдүүлж болно гэсэн үг.

*-Оюун ухааны хамгийн гол зарчим нь юу вэ?*

-Ерөөсөө хүний оюун ухааныг бие махбодиос нь салгаж болохгүй гэсэн зарчимтай. Тэгэхээр оюун ухаант хүн өөрийгөө, биеэ хайрлах хэрэгтэй болж таарч байгаа биз. Үнэхээр ч оюун ухааны гүйцэтгэгч нь бие л байдаг шүүдээ.

*-Эрх чөлөө гэж юу вэ?*

-Яахав дээ, эрх чөлөө гэдэг нь яг цаагуураа бол оюун ухааны оршин байх хэлбэр л байхгүй юу. Тийм учраас оюун ухаан өөрөө дээд эрэмбийн эрх чөлөөг хүсэмжилж оршдог. Нийгмийн амьдралд ороод ирэхээрээ л угаартаж байгаа юм. Тэгэхдээ энэ эрх чөлөө бол бодит амьдрал дээр нийгэмтэйгээ зохицож байх ёстой. Бусдад хор болохооргүйгээр хязгаарлаж байх учиртай юм, хүн эрх чөлөөгөө.

*-Улс төржүүлж байгаа юм биш шүү. Гэхдээ манай өнөөгийн нийгэмд хамгийн их адал явдал цусгэгч хүмүүний эрх чөлөөний тухай ойлголтыг асуучихмаар санагдаад байна. Тухайлбал УИХ-ын нэгэн гишүүн, . . .?*

-Цаг завтай болохоороо энэ тухай жич ярилцаж болох юм. Бидний энэ ярилцлагад ийм сэдэв нийцэхгүй байна. Бид хүмүүний хамгийн дээд эрэмбэ,

хөдөлгүүр оюун ухааны төлөө л ярилцаж байна шүү дээ. Та бид хоёр дээд эрэмбийн юм ярьж байна гэсэн үг.

*-Та гунидаг уу?*

-Гунилгүй яахав. Гунина аа. Гуниглана гэдэг чинь оюун ухааны их том тайтгарал юм л даа. Оюун ухаан тухайн тохиолдсон зүйлийг өөрийнхөөрөө хүлээж авч чадахгүй болсон ийм үед л оюун ухаан тайвширдаг. Гарцаагүй тайвширдаг. Их сайхан боддог.

*-Тэгвэл шаналдаг уу?*

-Шаналах ч хаашаа юм бэ дээ. Залуу байхдаа бол шаналдаг л байж. Одоо бол тойроод гарчихдаг болжээ. Тэгэхээр шаналахгүй байхад зориулагдсан сэтгэлийн өөрийн гэсэн технологитой болчихож гэсэн үг мөн биз дээ.

*-Ганцаарддаг уу?*

-Ганцаардана шүү. Хааяа хааяа ганцаарддаг. Тэр нь миний хэлж байгаа юмыг хүмүүс нэг их ойлгохгүй байгаа болохоор ганцаардаад байдаг.

*-Оюун ухаан, сэтгэл хоёр ямар сэжмээр холбогддог юм бэ?*

-Оюун ухааныг сэтгэл шүүх ёстой. Тэгэхлээр сайхан сэтгэлтэй оюун ухаан муухай байхгүй нь ээ дээ.

*-Хар өнгөөр давалгаалаад байдаг оюун ухааныг Та юу гэж боддог вэ?*

-Ёстой муухай юм даа. Ийм хүнээс би аль болохоор зайлсхийдэг. Их хэцүү санагддаг. Бидний сэтгэл зүрх, оюун ухаан чинь тэдэнтэй шатар нүүхэд зориулагдаагүй юм шүү дээ.

*-Шатар тоглодог уу?*

-Тоглодог.

*-Хэр сайн бэ?*

-Өөрөөсөө муу хүнтэй шатар тоглож болохгүй. Энэ бол оюун ухааны өөрийнх нь хууль шүү дээ.

*-Найз гэж хэн бэ?*

-Ихэнхдээ л цагийн садаа.

*-Бүхэлдээ тэр цу?*

-Үгүй, надад ярьж суудаг ухаантай цөөн хэдэн нөхөд бий. Тэднийгээ би цагийн садаа гэж хэзээ ч боддоггүйг минь заавал бичээрэй.

*-Та хэнтэй найзалдаг вэ гээд асуучихаж болох уу, тэгвэл?*

-Номтой л их найзалдаг даа. Ном бол миний багш юм. Бас би Монголын

хамгийн том хоёр эрдэмтэнтэй багш шавийн барилдлага тогтоосноороо бахархаж явдаг.

*-«Ном бол хаан ширээнээс ч үнэтэй» гэж хэлсэн У.Шекспирийн үг Танд их ойрхон байдаг юм биз дээ?*

-Ёстой үнэн. Надад ном бол хаан ширээнээс ч үнэтэй.

*-Гэхдээ Та бол Монголд оюун ухааныг хөгжүүлэх өөрийн гэсэн сүлжээг бараг байгуулчихлаа. Боловсрол гэх зэрэг нийгмийн салбарт нэлээд шинэчлэлт хийхийг зорьж байгаа. Гэхдээ шийдвэр гаргах төвшинд очёё гэж хаа нэгтээ бодогдох юм уу?*

-Үгүй. Оюун ухаан ярьдаг хүн чинь улс төрд орж болохгүй. Улс төр бол их хатуу орчин шүү дээ.

*-Та бас Монголд боловсрол эзэмшсэн. Таны цөийнхний ихэнх нь гадаадад боловсрол эзэмшсэн байдаг. Энэ нь Таны сонголт байсан уу?*

-Тэр үед надад гадаадад суралцах боломж их байсан. Монгол Улсад ирсэн бүх хуваарийн нэг дэхийг нь сонгох эрх надад байсан шүү. Учир нь би 1972 онд улсын математикийн олимпиадын аварга болчихсон бас ч гэж том амьтан байлаа. Гэхдээ би МУИС-ийн математикийн ангийг сонгосон. Герман ч юм уу, Орос ч юм уу аль нэгэн гадаадын оронд очиж суралцахыг хүсээгүй. Энэ нь ч одоо эргээд бодоход их оносон санагддаг. Мэргэжил олж авахыг биш, сэтгэдэг болохыг л зорьж байжээ, тэр үед би.

*-Мэргэжлийг Та «доош нь» хийсээр байна уу?*

- Мэргэжил бол төдий л сайн биш. Хуучирдаг. Оюун ухааныг хааж бооно. Харин сэтгэлгээ бол хөгжүүлдэг шүү дээ.

*-Оюун ухаанаараа таашаах гэдэг үйлдэл байдаг?*

-Байдаг. Яг байдаг. Ёстой байдаг. Оюун ухаанаараа таашааж, баясана гэдэг бол ухаантнуудын хувьд юунаас ч эрхэм. Тийм учраас би ухаантай хүмүүстэй ярилцах дуртай байдаг. Оюунлаг баясал гэж байгаад байгаа юм.

*-Зарим ухаантнуудыг хүмүүс хэвийн биш хүн гэж тодорхойлдог?*

-Тэр бол худлаа. Массын зүгээс л тэгж хэлдэг. Ухааныг нь ойлгодоггүй байхгүй юу. Мэргэд бол эрүүл. Ёстой эрүүл саруул оюун ухаантнууд байдаг.

*-Тэдний оюун ухаан төрмөл үү, таримал уу?*

-Суурь нь төрмөл. Өөрөөр хэлбэл, удамшлын генетикийн кодоороо дамжаад өгөгдчихдөг өгөгдөхүүн юм л даа.

*-Та ямар генетикийн кодтой хүн бэ, ингэхэд?*

-Би ээжийнхээ 34-тэйд нь, эцгийнхээ 20-тойд төрсөн морь жилтэй хүн юм байна. Тэгэхдээ миний төрсөн он, сар, өдөр, цаг нь яг он солигдож, хуучин нь улирах, шинэ нь ирэх мөчтэй яг давхцдаг юм. Би 1955 оны нэгдүгээр сарын 01 -ний 01 цагт төрж байжээ.

*-Генетикийн хувьд ч Та их өвөрмөц өгөгдөхүүн юм аа?*

-Миний ээж Цэрэн гэдэг хоёр хүүхэдтэй эмэгтэй байжээ. Нутгийнхан маань манай ээжийг их ухаантай эмэгтэй юм болохоор нь Цэцэнхүү гэдэг байж. Ухаантай эмэгтэйчүүд чинь ихэнхдээ л нөхөргүй байдаг шүү дээ. Одоо ч тийм. Тэгээд яахав, тийм нэг хувь тохиол болж, ертөнцөд би төрж л дээ. Европт бол ийм тохиолдлыг алга ташин хүлээж авч, ээжээр минь бахархана биз дээ, хүмүүс. Гэвч бидний өсч төрсөн хөдөө тиймгүй. Нутаг усаар нэг шуугихгүй юу даа. Тэгээд аав маань залуу хүн юм чинь Увс аймгийн Завхан сумаас нүүгээд Төв аймагт ирж амьдарч л дээ.

*-Таны бага нас яаж өнгөрсөн бэ?*

-Би гурван нас хүрч байж хэлд орсон. Урьд нь бол манай нутгийнхан намайг «Сайхан хүү юм. Даанч хэлгүй» гэж харуусдаг байсан гэсэн.

*-Ээж тань хүүгээ цг хэлэхийг сонсоод анх их л баярласан байх даа?*

- Нэг өдөр тэмээ саагаад зогсч байж л дээ, ээж маань. Гэтэл гэнэт би «Мөөм» гэж хэлсэн гэдэг. Ээж «Юу вэ?» гээд гайхаж л дээ. Тэгэхэд би «Мөөм» гэж дахиж хэлээд ээж «Ээж» гэж хэлэхэд нь давтаад «Ээж мөөм» гэж хэлсэн гэдэг. Энэ хоёр үгийг дагаж давтаж хэлээд л, би ердөө долоохон хоногийн дотор хэлд орсон гэдэг. Тэгээд таван настайдаа мянгын доторхи тоог цээжээрээ тачигнатал нь ямар ч төвөггүй нэмж, хасч сурчээ.

*- Тэгээд арай сургуульд орсон юм биш биз?*

- Орсон. Тэгээд «хөөгдсөн».

*-Яагаад тэр вэ?*

-Намайг уг нь ээж эгчтэй маань хамт сургуульд оруулчихгүй юу. Гэтэл би багшийнхаа ширээн дээр гарч зогсоод, багшийнхаа амыг барьж байгаад «одоо би заана аа» гэж томорч л дээ.

*-Тэгээд л хөөгдчихөө юу?*

-Тэгэхэд багш маань намайг тэврээд, хичээлийн эрхлэгч дээр орсон. «Хэтэрхий бага хүүхэд байна. Гэрт нь буцаая» гэж хэлсэн.

*-Тэгээд хэдийд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөв?*

-Хойтон жил нь.

*-Шууд л онц сураад эхэлсэн цу?*

-Тэгсэн. Тэгэхдээ би нэгээс наймдугаар анги төгстлөө гэрийн даалгавар хийж ерөөсөө үзээгүй. Үргэлж л тоглож явдаг хүүхэд байлаа.

*-Өгөгдөхүүн тань дэндүү баян юм даа?*

-Баян гэх нь хаашаа бол? Азтай л юм даа.

*-Одоо Та аавтайгаа уулздаг уу?*

-Би өрх гэрийнхээ дотор аав гэж дуудаж үзээгүй ч аавтайгаа уулзсан. Яг одоогоос таван жилийн өмнө аав өөрөө ирсэн. Надаас тусламж хүссэн. Би тусалсан. Одоо аав маань дажгүй, Шадивланд амьдарч байгаа.

*- Та дүү нартай юу?*

- Дүү нар бий. Аавын маань хүүхдүүд болохоор тэд бол миний дүү нар юм л даа. Саяхан нэг дүү маань аав болжээ. Би баяр хүргэсэн.

*- Та өөрийнхөө ийм амьдралыг юу гэж дүгнэдэг бол. Дүгнэлт хүнд л дээ. Гэхдээ сонирхмоор санагдаад байна.*

-Хорвоод байгаа юм бүхэн ойлгож мэдэрч чадах юм бол сайхан байдаг.

*-Ширээний тань ном юу вэ?*

-Мишель Монтень бол ярилт байхгүй. За тэгээд Лев Толстой бол сайн.

*-Номын сан тань нийт хэдэн номтой вэ?*

-Хорин мянган ном элбэг бий. Хагасыг нь би сургуулийнхаа номын санд хандивласан.

*-Гэр бүлээ танилцуулаач?*

-Би дөрвөн хүүтэй. Хамгийн бага нь ЕБС-ийн есдүгээр анги. Бусад нь бол бүгд «Хан-Уул» дээд сургуулийг төгссөн. Бас нэг хүү маань одоо суралцаж байгаа.

*-Заавал өөрийнхөө сургуулийг төгсгөдөг нь ямар учиртай юм бэ?*

-«Хан-Уул» дээд сургууль бол Монголын хөгжлийг чиглүүлнэ гэдэг уриатай, урагшаа зүтгэж буй шинэ хамт олон. Том хүү маань оюун ухааны хөгжлийг нийгэмд түгээх, түүнийг хянах зорилгоор төрийн бус байгууллага байгуулсан.

*-Та ачтай юу?*

-Ачтай. Ач маань гурван настай.

*-Эхнэрээ танилцуулаач?*

-Миний эхнэрийг П.Цогзолмаа гэдэг. Сургуулийн маань эдийн засаг аж ахуйн албыг өрх гэрийнхээ албатай давхар зохицуулдаг. Үүний ачаар л би

ахуй амьдралын ямар ч зүйлд санаа зоволгүйгээр Монголынхоо хүн ардад оюун ухааныг түгээх үйлсэд зүтгэж явна.

*-Таныг бас афоризм зохиодог байх гэж төсөөлөөд байна?*

-Гурав дөрөвхөн л юм байгаа. Бодомж дундаас төрсөн юм.

*-Хэлж өгөөч?*

-Хүн бидэнд байгаа юмнаас хамгийн үнэтэй нь оюун ухаан. Уг нь амьдрал гэдэг чинь сэтгэл гэсэн үг л дээ. Оюун ухаанаас ангид аз жаргал гэж үгүй ээ. Өнгөрснийг баталгаажуулахаасаа илүүтэй ирээдүйгээ цогцлоох шийдвэр гаргаж бай.

*-Тэгвэл ухаант мэргэдийн хэнийх нь хэлсэн, ямар цгэнд дуртай вэ?*

-Өө, их олон бий. Ёстой боть ботиороо бий. Б.Паскалийн «Хүн нь бодож сэтгэхийн тулд л бүтээгдсэн юм шүү», Л.Толстойн «Ухаантай үйл бүхэн ёс суртахуунтай байдаг», В.Публийн «Олон түмнийг оюун ухаан л хөдөлгөнө» гэх зэрэг үгс одоо сэтгэлд хамгийн ойр санагдаж байна.

*-Монголын нийгмийг яг одоо юу хөдөлгөж байна вэ гээд асуучихмаар санагдлаа?*

-Ерөөсөө оюун ухааныг хөгжүүлэхийн төлөөх тэр хүчин л удирдаж байна.

# *МОНГОЛ УЛС ДЭЛХИЙН ӨНДӨР IQ-ТЭЙ (ОЮУНЫ ЧАДАВХИТАЙ) ОРНЫ АНГИЛАЛД БАГТЖЭЭ*

Өдрийн сонин 2003. 11. 05 № 265 (1454)

Умард Ирландын сэтгэл судлалын профессор Ричард Лунн, Финландын улс төр судлалын профессор Тату Ванханен нар хамтарсан судалгааныхаа үр дүнг нэгтгэж “IQ ба үндэстний баялаг” бүтээлийг 2002 онд хэвлүүлсэн байна.

Энэхүү судалгаагаар дэлхийн 185 орны хөгжлийн гол чухал индикатор үзүүлэлтүүдийг 1820 оноос 1998 он хүртэл 178 жилээр тооцоолж математик-статистикийн арга хэрэглэн регрессийн тэгшитгэл зохиож, улмаар эдгээр орны оюуны илтгэцүүрийн судалгаануудыг ашиглан улс орнуудын оюуны чадамжийн коэффициент IQ-г үнэлэн гаргажээ.

1. Хон Конг	107	2. Өмнөд Солонгос	106
3. Япон	105	4. Хойт Солонгос	104
5. Тайван	104	6. Сингапур	103
7.Словен	103	8. Австри	102
9. Герман	102	10. Итали	102
11. Нидерланд	102	12. Люксембург	102
13. Швед	101	14.Швейцар	101
15. Бельги	100	16. Хятад	100
17. Шинэ Зеланд	100	18. Их Британи	100
19. Унгар	99	20. Польш	99
<b>21. Монгол</b>	<b>98</b>	22. АНУ	98
23. Дани	98	24. Исланд	98
25. Франц	98	26. Норвеги	98
27. Австрали	98	28. Канад	97
29. Чех	97	30. Эстони	97
31. Финлянд	97	32. Латви	97
33. Литва	97	34. Испани	97

35. Аргентина	96	36. Беларус	96
37. Орос	96	38. Словак	96
39. Украйн	96	40. Уругвай	96
41. Вьетнам	96	42. Мальт	95
43. Молдав	95	44. Португал	95
45. Израйл	94	46. Румын	94
47. Соломоны Арал	94	48. Армен	93
49. Болгар	93	50. Чили	93
51. Ирланд	93	52. Казакстан	93
53. Гүрж	93	54. Македон	93
55. Бруней	92	56. Кипр	92
57. Грек	92	58. Малайз	92
59. Коста Рика	91	60. Тайланд	91
61. Албани	90	62. Хорват	90
63. Перу	90	64. Турк	90
65. Камбож	90	66. Колумб	89
67. Лаос	89	68. Суринам	89
69. Венесуэл	89	70. Азербайжан	87
71. Бразил	87	72. Ирак	87
73. Йордан	87	74. Киргизстан	87
75. Мексик	87	76. Баруун Самао	87
77. Сири	87	78. Тажикстан	87
79. Тонга	87	80. Туркменистан	87
81. Узбекистан	87	82. Бирм	86
83. Ливан	86	84. Филиппин	86
85. Боливи	85	86. Куба	85
87. Марокко	85	88. Панам	85
89. Парагвай	85	90. Ангол	84
91. Доминикан	84	92. Эль Сальвадор	84
93. Фижи	84	94. Гвиней	84
95. Индонез	84	96. Иран	84
97. Кирибати	84	98. Маршалын арал	84
99. Микронез	84	100. Никарагуа	84
101. Шинэ Гвиней	84	102. Пуэрто Рико	84

---

103. Тунис	84	104. Вануат	84
105. Югослав	84	106. Гондурас	84
107. Ливи	84	108. Афганистан	83
109. Белиз	83	110. Египет	83
111. Кувейт	83	112. Оман	83
113. Саудын Араб	83	114. АН Эмират	83
115. Йемен	83	116. Бахрейн	83
117. Бангладеш	81	118. Энэтхэг	81
119. Мавритан	81	120. Пакистан	81
121. Сейшелийн арал	81	122. Шри Ланк	81
123. Сент Люси	81	124. Мальдив	81
125. Эквадор	80	126. Тринадад Тобаго	80
127. Коморын арал	79	128. Гватемал	79
129. Мадагаскар	79	130. Багамын арал	78
131. Барбадос	78	132. Бутан	78
133. Кабо Верде	78	134. Балба	78
135. Катар	78	136. Замби	77
137. Антиго Барбуд	75	138. Доминик	75
139. Сент Христофер ба Невис	75	140. Сент Винсент	75
141. Гренад	75	142. Мавритан	74
143. Конго	73	144. Уганда	73
145. Ботсван	72	146. Чад	72
147. Ямайка	72	148. Кени	72
149. Лесотго	72	150. Мозамбик	72
151. Намиб	72	152. Өмнөд Африк	72
153. Свазиленд	72	154. Танзани	72
155. Гайти	72	156. Судан	72
157. Зааны ясан эрэг	71	158. Гана	71
159. Малави	71	160. Бурунди	70
161. Камерун	70	162. Руанда	70
163. Алжир	69	164. Бенин	69
165. Мали	69	166. Тога	69
167. Төв Африкийн БНУ	68	168. Жибути	68
169. Сомали	68	170. Эритри	68

---

171. Буркина Фасо	67	172. Нигер	67
173. Нигери	67	174. Габон	66
175. Гвиней	66	176. Зимбабве	66
177. Гвиней Бисао	66	178. Заир	65
179. Сенегал	65	180. Гамби	65
181. Либери	65	182. Сьерра Лион	63
183. Этиоп	63	184. Сан Томе ба Принсипи	59
185. Гвиней(Экватор)	59		

Эдгээр эрдэмтэд үндэстний оюуны чадавхийн загвартаа тухайн орны газарзүйн байрлал, цаг агаарын бүс, үндэстний нас буюу цаг хугацаа, байгаль орчны бохирдол, үндэстэнд буй удамшлын хүчин зүйлс, (үүнд: арьсны өнгө, нүд ба үсний өнгө, нүд, шүд, биеийн хэлбэр, тархины хэмжээ, удамшлын өвчнүүд, цусны бүлгийг хамааруулжээ), хүн амын эрүүл мэндийн байдал, төрөлт, нас баралт, орон зайн шилжилт, боловсролын төвшин, эдийн засгийн өсөлт, ядуурал, улс төрийн шинэчлэл гэх мэт хүчин зүйлсийг анхаарч үзсэн байна. Асуудалд тун буурьтай ханджээ..... аргагүй биз, эмзэг асуудал л даа.

### Тайлбар

**Нэг:** Эдгээр профессорууд нь үндэстнүүдийн оюуны чадавхийг олон жил дагнан судалж буй дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэд билээ. Тэд 300 тал хуудас бүхий эрдэм шинжилгээний энэхүү даацтай бүтээлдээ 378 эх үүсвэр, НҮБ, Дэлхийн Банкны болон холбогдох бусад судалгааг ашиглажээ. Олон үндэстний оюуны чадавхийн уралдаанд 185 орноос манай улс IQ=98 оноогоор 21-д орсон байна. Энэ бүлэгт АНУ, Дани, Франц, Исланд, Австрали, Норвеги улсууд багтаж байна. Эдгээр нь бүгд өндөр хөгжилтэй орнууд бөлгөө.

Үндэстний IQ-нь 101-ээс дээш бол оюуны тэргүүлэгч, IQ- нь 97-оос 100 бол өндөр IQ-тэй орнууд гэх мэтээр ангилах үндэстэй. Ингэвэл Монгол улс одоогоор өндөр IQ-тэй орнуудын ангилалд багтаж байна.

Уг номын 147-р талд “Улс төр, эдийн засгийн холын хараатай шинэчлэл хийж буй Монгол улсын тухайд Хятад, Хойт Солонгос, Вьетнамаас илүү хурдтай хөгжиж эдийн засгийн өсөлт олох боломж бий. . . .” гэсэн байна. “IQ and the wealth of nations. Richard Lunn and Tatu Vanhanen 2002. PRAEGER. Westport, Connecticut London”

Үүнийг үзээд би вээр “Тэгэх ёстой, Монгол хүн угийн сэргэлэн л дээ, ямартаа л дэлхийг донсолгож байв гэж, манай залуусыг гадаадынхан толгой сайтай гэж үнэлдэг нь давхар батлагдав, 21-р зуун бол оюун ухааны эрин, энэ чинь оюуны өндөр IQ-тэй улсын хувьд харьцангуй давуу тал нь улам тодроно гэсэн үг, монголчууд биднийг мэдээллийн шинэ эрин ивээж байна, одоо оюун ухааныг эрхэмлэн дээдлэх хөдөлгөөнийг өрнүүлж бүх ард түмнийг хамарсан бодит ажил үйлс болгоод ойрын 10 жилийн дотор үндэстнийхээ IQ-г ядаж 3 нэгжээр өсгөж оюуны тэргүүлэгч орон болох зорилт тавьцгаая, ийм сайхан боломж бэлэн байна, учир нь монгол хүнд IQ-н унаган давуу тал бий, монголд оюуны сэргэн мандал ирлээ дээ” хэмээн бодож ихэд баярлав.

Баярлахгүй байхын ч аргагүй. Монголчууд бид оюуны чадварын дэлхийн уралдаанд тун дээгүүр давхисан байна шүү дээ . . . Өндөр IQ-тэй Монгол Улсын иргэн танд баяр хүргэе.

**Хоёр.** АНУ-ын үндэстний  $IQ=98$  байгаа нь зохиогчдын нотолж буйгаар тус улсын хар арьстнуудын  $IQ=85$ , Испани гаралтнуудын  $IQ=92$ , цагаан арьстаны  $IQ=100$  бөгөөд математикийн жигнэсэн дундаж нь 98 гэнэ. Үүнийг тогтоохдоо 1914 оноос хойшхи олон удаагийн IQ тестийн дүнг давхар ашиглажээ. Заримыг нь цойлдон дурдвал, 1933 оны 1000 хүүхэд, 1949 оны 1215 хүүхэд, 1947 оны 13-18 настныг хамарсан тусгай судалгаа, 1972 оны 64000 хүн, 1978 оны 10000 хүн, 1996 оны 18-аас 70 настанг хамарсан их судалгаа гэх мэт, тэр ч бүү хэл 300000 цэргийн албан хаагчдын IQ-ийн түвшинг харгалзжээ.

**Гурав.** Монгол Улсын Оюуны чадварын-IQ төвөөс сүүлийн гурван жилд иргэдийн IQ-г тогтоох талаар байнга судалгаа хийж байна. Зөвхөн өнгөрсөн хичээлийн жилд гэхэд л 18000 орчим хүүхэд IQ-ийн түвшингээ 3 удаа тогтоолгож “Оюуны хөгжил-IQ” хичээлд хамрагдсан болно. Бас тусгай судалгаа ч явуулсан. 2001 онд 1198 сурагч, 790 насанд хүрэгчдийг шалгахад хүүхдийн дундаж  $IQ=101,1$  насанд хүрэгчдийн  $IQ=101,4$  ерөнхий дундаж  $IQ=101,2$  байв.

**Дөрөв.** Дурдан буй номын нэр нь ч гүн утга агуулгатай. Тодруулбаас суут эдийн засагч Адам Смитийн сонгодог бүтээл нь “Үндэстний баялаг” нэртэй. Энэ бүтээл нь “жам ёсны эрх чөлөө”-г тунхагласныхаа ачаар аж үйлдвэрийн эриний эдийн засгийн хөгжлийн онолын эх суурь болсон билээ. Тэгвэл мэдээлэл-оюуны эринд жам ёсны эрх чөлөөнд тулгуурласан оюуны хөгжил нь үндэстний баялаг бөгөөд оюун ухаан нь тухайн орны ирээдүйн

хөгжлийн эх булаг болох учиртай. Иймд европын хоёр профессор маань олон жилийн судалгааныхаа үр дүнг “IQ ба Үндэстний баялаг” хэмээн нэрлэжээ. Энд IQ ба Үндэстний баялаг гэсэн дараалалтай байна. Учир нь “оюун ухаан” тэргүүлэгч бөгөөд түүнийг шүтсэн улс үндэстний баялаг нэмэгдэнэ, бас оюун ухаан нь өөрөө үндэстний хамгийн үнэт баялаг билээ.

Хүн бүр адилгүй, хүлэг болгон жороогүй гэж монголын ард түмэн сургасан. Тэгэхлээр хүн бүр адилгүй юм чинь хүмүүсийн нийтлэг болох үндэстэн болгон адилгүй байх нь ойлгомжтой билээ, үүнийг эрдэмтэд нотолж байна.

Оюун мэдээллийн шинэ эринд үндэстнүүд оюун ухаанаараа уралдаж, оюун тархи булаацалдах хүчтэй өрсөлдөөнд оров. IQ өндөртэй үр хүүхэдтэй болох гэж эцэг эхчүүд санааширна, IQ өндөртэй суралцагч олох гэж сургуулиуд үзэлцэнэ, IQ өндөртэй ажилтан авах гэж компаниуд арцалдана, IQ өндөртэй иргэдтэй болох гэж засгийн газрууд тэмцэлдэнэ, IQ-гээ өсгөх гэж хүн бүр тэмүүлнэ.

# **МОНГОЛЧУУД ОЮУНЫ ЧАДАВХИАРАА ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ**

Өдрийн сонин 2003. 12. 09 №293 (1482)

**Нэг. Үндэстний оюуны чадавхид газарзүйн бүс, цаг агаарын нөхцөл нөлөөлдөг тухай:**

Хүний оюун ухаан нь байгалиас эх үүсгэвэртэй юм. (Энд хиймэл оюун ухааныг орхив) Хүн бээр 24 цаг тасралтгүй оюунаа хөвчлөн ажиллаж чадахгүй, хоногт дунджаар найман цаг орчим унтаж, тархины үйл ажиллагааг саармагжуулан амраах ёстой. Тархины эрчимтэй ажиллах орчны температур гэж бий, тэр нь хүний биеийн температураас 2-3 дахин дор байх учиртай, өөрөөр хэлбэл, 12-18°C болой. Энэхүү дулаан нь зохиомол бус, байгалийнхаараа байвал тархинд илүү зохимжтой юм. 16°C-ээс бага зэрэг сэрүүвтэр байхдаа ч гэмгүй. Тархины амрах орчны температур үүнээс нэлээд бага буюу сэрүүн (биед мэдэгдэхүйцээр) байх учиртай, гэхдээ бас л байгалийнх байвал нэн сайн. Оюун тархины ажиллах ийм эрс тэс орчин, тодруулбаас өдөр нь их халуун бус, шөнө нь сэрүүвтэр байдаг тийм байгалийн нөхцөл энэ дэлхий дээр хаана байна вэ гэвэл сэрүүн бүс юм. Халуун орны хүмүүсийг бодвол сэрүүн бүсийнхний оюуны дундаж илтгэцүүр өндөр байдаг нь “Цаг агаарын болон байгалийн нөхцөл хүний оюуны чадварт нөлөөлдөг гэдгээр тайлбарлагдана хэмээн бид үзэж байна..” IQ and the wealth of nations. Richard Lunn and Tatu Vanhanen 2002. PRAE-GER. Westport, Connecticut London” 165-166 дугаар талд

Миний бие дэлхийн экватор дээр хэд хонож билээ. Гадаа өдөр нь 35°C, шөнө нь 30°C, харин тасалгаа маань сэрүүцүүлэгч сэнстэй байв. Агаар нь нэг л хачин, зохиомол, хиймэл, цээжинд наалдацгүй, оюун тархины ажиллах чадвар үнэхээр л сул болчихдог юм билээ... Монгол хүний бие зуны цагт нэг л нозооромтгой болчихдог, аагим халуун өдөр ажил дээрээ ном унших, тэр тусам ТОО бодох ч амаргүй дээ. . . Говийнхон ажлаа өглөө, оройн сэрүүнд л амжуулдаг, монголчууд намар, өвөл, хаврын гурван улиралд л илүү эрчимтэй сууж ажилладаг. Энэ бүхний цаана байгаль, цаг агаарын маш хүчтэй, ул суурьтай нөлөө байгаа хэрэг.

Монгол улс дэлхийн хойт хагасын сэрцүн бүсэд байрладаг нь монгол хүний оюуны чадавхи өндөр байх байгалийн СУУРЬ нөхцөл юм. Тариа ногоо ургуулах, таван хошуу малаа адгуулахад жилийн дөрвөн улиралтай манай орны цаг агаарын эрс тэс байдал багагүй хүндрэл учруулдаг нь эргэлзээгүй. Гэтэл энэ нь оюун тархины эрчимтэй ажиллахад харин ч дэм тус болдог байна. Өдөр шөнийн цаг агаарын эрс тэс ялгаа нь төмс ургахад сөрөг нөлөөлдөг бол толгой ажиллахад эерэг нөлөөлдөг ажээ. Хүн бээр уг нь төмс ургуулж бус, толгойгоо ажиллуулж амьдрах ёстой л доо.

XXI зуун бол оюун тархины эрин. Энэ эринд үндсэн хөрөнгө, үйлдвэрийн том байр, идэш хоол, эрчим хүчийг шүтэхгүй, шүтлэгийн энэ маяг XX зуунтайгаа хамт ард хоцорсон. Одоо XXI зуунд оюун тархийг шүтнэ, онч мэдлэгийг шүтнэ. Тэгэхлээр монголчууд бид төөрч төөрч эцэст нь төрлөө олов бололтой, биднийг эх нутгийн маань тэнгэр нь, байгаль нь ивээж байна. Бид халаглаж суух биш, ханхалзаж суух цаг ирлээ.

**Хоёр. Зүүн хойт Азийн бүс нутаг дэлхийд оюуны чадавхиараа тэргүүлж байгаа тухай:**

**Дэлхийд оюуны чадавхиараа тэргүүлж буй зургаан орныг жагсаавал:**

Эзэлсэн байрны дугаар	Улсын нэр	IQ
1	Хонконг	107
2	БНСУ	106
3	Япон	105
4	Хойд Солонгос	104
5	Тайвань	104
6	Сингапур	103

Эдгээр орнууд зүүн хойт ба зүүн өмнөд азийн бүс нутагт хамаардаг билээ, Хонконг, Тайвань, Сингапурын үндсэн хүн ам нь хятад бөгөөд тэр тусмаа зүүн хойт Хятадаас гаралтай хүмүүс эдгээр улс руу нүүн шилжих нь элбэг тохиолддог байна.

**Нэгдсэн дүгнэлт:** Зүүн хойт Азийнхан оюуны чадавхиараа дэлхийд тэргүүлж байна.

**Гурав. Жүүдүүд ухаантай нь ухаантай, гэхдээ...**

Еврейчүүдийг ухаантай гэдэг нь үнэн бололтой. Учир нь Ричард Лунн, Тату Ванханен зэрэг мэргэжлийн судлаачдын бүтээлд дараахь баримт дурдагджээ. Еврейг дөрөв хуваана. Үүнд: Англи, Америк, Европ, Азийнх

гэх бөгөөд хамгийн ухаантай нь Англи-Америкийн жүүдүүд гэнэ. Тэдний IQ нь 110-115 нэгж, харин Европын жүүдүүд 100-105 орчим IQ-тэй, Азийнх нь 88 нэгж IQ-тэй аж.

**Тодотгол:** Эдүгээ үндэстэн гэдэг нэр томъёог тодорхой хил хязгаарын дотор “улс үндэстэн”-ий хүрээнд ойлгох болов. Тухайлбал, Америк үндэстэн гэхэд АНУ-ын оршин суугчид л түүнд хамаарна, тэд тун олон язгуур үндэстнээс бүрдэнэ. (тухайн хүний гарал, язгуур гэвэл өөр) Үүнчлэн жүүд гэдгийг Израиль улсаар төлөөлүүлэн ойлгоно. Монгол ч ялгаагүй, Монгол улсын хүрээнд л яригдана, тэр нь ч зөв. Ингэхлээр Израиль улсын хувьд барууны жүүд нь 100 нэгж IQ-тай, Азийнх нь 88 нэгж IQ-тай, жигнэсэн дундаж нь 94. Энэ бол монгол үндэстний IQ-аас дөрвөн нэгж доогуур тоо.

### **Дөрөв. Баруун Европынхон сүрхий нь сүрхий, гэхдээ л**

Дэлхийн 185 улс үндэстэнг оюуны чадварын коэффициентээр нь байр эзлүүлэхэд 7-20 дахь байрт баруун Европын 12 орон (16-д Хятад, 17-д Шинэ Зеланд) оржээ. Эдгээр орон 99-өөс 102 нэгж үндэстний IQ-тай бөлгөө. Ер нь баруун Европчуудын оюуны дундаж илтгэцүүрийг 100 гэж үздэг байна. Тэдний дунд баруун Германынхан 103 нэгжээр түрүүлдэг бөгөөд гагцхүү зүүн германчууд 95 нэгж IQ-тай учраас улсын дүнг гаргахад доош татагдаж (энэхүү тооцоог гаргах үед Баруун Герман нь 59,5 сая, зүүн тал нь 16,6 сая хүнтэй байсан) ХБНГУ-ын үндэстний IQ нь 102 нэгж болжээ. Баруун Европын хүн ам нь нэлэнхүйдээ хөгшрөлд автсан. Оюунлаг дээд хэсэг нь АНУ-руу шилждэг, бас улстөрийн бодлого нь ардчилсан үнэт зүйлсээс, эдийн засаг нь чөлөөт зах зээлийн тогтолцооноос түдгэлзэх хандлагатай байгаа зэргээс үүдэн тус бус нутгийн оюуны чадавхи цаашид нэмэгдэх бололцоо багасч, харин ч буурах хандлагад автсан байна.

### **Тав. Хоёр хөршийн оюуны чадавхийн тухай:**

ОХУ-ын оюуны илтгэцүүр нь 96 нэгж ажгуу. “Ах” нар маань “дүү” биднээс оюуны чадамжаараа хоёр нэгж дутуу ажгуу. “Ах нь ямагт илүү ухаантай байдаг” гэсэн онол байхгүй ажээ. “Ахын сургаал алт” хэмээхдээ монгол хүн латерал сэтгэж давхар утгаар ойлгодог, үүнд сайн ахаас бол сурна, дутуу ахыг бол тойрно, “өмнө ургасан чихнээс хожуу ургасан эвэр” ч гэж ярилцдаг. Орос хүний IQ-г тогтоохдоо Москва хавийн хүмүүст тулгуурласан байх бөгөөд тэд орос үндэстнийхээ нэлээд дээд, оюунлаг төлөөлөл нь юм. Ингэхээр ОХУ-ын IQ харин ч дээгүүр тогтоогдсон байж мэднэ, ямар ч гэсэн 96-аас их биш.

БНХАУ-ын IQ=100. Үүнийг бид онцгой анхаарах ёстой. XXI зуунд Хятад

хүчирхэгжин хөгжих нь мэдэгдэж байна. Ямартай ч манай тооллын өмнөх V зуунаас манай тооллын XV зуун хүртэлх 2000 жил Хятадынх байжээ. Энэ үед шинжлэх ухаан технологийн хөгжлөөрөө Хятад орон дэлхийд гарцаагүй тэргүүлж байсан, цөөн баримт түшвэл: Хятадын астрономчид Юпитерийн саруудыг 365 онд нээсэн байхад европчууд, 1609 онд Германы астрономич Саймон Мэриус, 1610 онд Галилей нээснээр мэдэх болжээ. Хэвлэлийн болон цаасны технологийг 1440-өөд оны үед Германд Гутенберг анх нээсэн гэж бидэнд ойлгуулсан. Тэгвэл Хятадад 105 онд Цай Лун гэгч энэхүү технологийг хэрэглэж байж. Математикт гэхэд л Хятад, Вавилонд манай эриний өмнөх 3000 онд сампин хэрэглэж байсан бол Европод манай эриний 950 оны үед нэвтэрчээ. Хоорондох зай нь 4000 жил болж байгаа биз. Европчууд даяарчлалын нөлөөгөөр евроцентризмээсээ татгалзаж байна, харин монголчууд бид үүнийг мэдрэхгүй байх шиг. (Евроцентризм- аливаа юмс үзэгдлийн төв нь, эх нь Европ гэдэг номлол бөгөөд үүнийгээ үл зөвшөөрөгчийг хатуу ширүүнээр гэсгээн шийтгэдэг, XX зуунд ихэд дэлгэрч, Монголд хүчтэй халдварласан, шинжлэх ухаанч бус бурангуй үзэл)

### **Зургаа. Бидэнд ямар боломж байна вэ? Өөрсдийгөө зүйрлэвээс:**

Монгол улс зүүн хойд Азийн бүс нутагт харъяалагддаг бөгөөд энэ бүс нутагт амьдран суудаг уугуул хүмүүс нь дэлхийд IQ-гээрээ тэргүүлж байна. Эндээс Монгол улс дэлхийд оюуны чадавхиараа тэргүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гарна. Харин тэргүүлж байна, тэргүүлэгч нь байх ёстой атал биднийг доош нь оруулаа. бид заргалдана гэх мэт дүгнэлт гарахгүй. Зүүн хойт Азийн бүс нутагтаа хамгийн бага IQ-тай нь Монгол улс болжээ. (Монгол үндэстний IQ=98) Энд л гол учиг байна, бид өгөгдсөн боломжийг дутуу ашигласан бололтой, үлгэрлэвээс аав ээжийн буянаар, агаар усны ачаар төрөлхийн цовоолог төрсөн гүйлгээ хар ухаантай, тэгсэн атлаа түүнийгээ дутуу ашигладаг, амь амьжиргаа нь тааруу, айраг пиво эргүүлсэн, айл хунараар хэссэн шиг цаг нөхцөөж байдаг зарим бор бааз, бүдүүлэгдүү хүн таардаг. Бид үндэстнийхээ хувьд тиймэрхүү л нэгэн юм шиг. Монгол хүн соёл иргэншлээрээ дэлхийн тэргүүний төвшнээс нэлээд хоцрогджээ. Гэхдээ л миний бодлоор хэл соёл мэтийг сурч болно, сурч ч байна. Харин унаган давуу талыг нь сурч болохгүй, тэрээр байгалийн хишиг, тэрээр өвлөгдөнө,...

Хэнэггүй, гудиггүй энэ монгол хүн өөрийнхөө оюуны төрөлхийн давуу талыг нэг л өдөр мэдрэнэ дээ. Тэгээд хөдлөнө, хөдлөхөөрөө ёстой үзүүлж өгөх биз, монгол хүний оюуны төрөлхийн давуу талыг соёл иргэншлийн элементүүдээр баяжуулбал дэлхийд цахиур хагалах нь гарцаагүй. Тэгэх болтугай, тэр ерөөл бат оршиг ээ хэмээе.

*- IQ буюу оюуны илтгэцүүрээс яриагаа эхлэх үү?*

-Оюуны илтгэцүүр гэдэг цоо шинэ зүйл биш. Монголчуудын дунд аль эрт байсан ойлголт. Манайхан оюуны цараа гэж ярьдаг тэр л юм. Буддын гүн ухаанд оюуны царааг олон эрэмбээр эрэмбэлж байсан. Харин XIX зууны үеэс баруун Европт үүнийг шинжилж, тоогоор илэрхийлэх аргыг сэтгэл судлаачид олсон.

Ингээд 1905 оны үед Францын эрдэмтэн А.Бине хүний оюуны чадавхийг илэрхийлдэг тест зохиосон юм билээ. Тестын тоон оноогоор IQ-г тогтоож, энэ нь улам нарийвчлагдсаар өдгөө дэлхийн жишиг тогтсон.

Олон удаагийн нарийн туршилтаар зохиогдсон «гүйх» ухаан шаардсан тэдгээр тестүүдээр хүний оюуны үзүүлэлт нь дунджаар яг л гардаг юм даа.

*•Мэдлэг боловсрол, оюуны чадварын хоорондын ялгааны талаар ярина уу?*

-Хүн сая жилийн түүхтэй. Өөрөөр хэлбэл оюун ухаан дор хаяхад сая жил «наслажээ» гэсэн үг. Түүнээс 750 орчим мянган жилийн дараа оюун ухаант хүн сэтгэдэг болсон гэдэг. Тэгэхээр оюун ухаан сэтгэхүй хоёр чинь өөр зүйл байгаа биз дээ. Түүний дараа өдгөөгөөс 50 мянган жилийн өмнө буюу оюун ухаант хүнээс хойш 950 мянган жилийн дараа мэдлэг үүссэн гэж үзэж байна.

Харин боловсрол тавхан мянган жилийн түүхтэй, бүр хойно гарсан зүйл. Ингээд үзэхэд оюун ухаан анхдагч, сэтгэлгээ хоёрдогч дараа нь мэдлэг, эцэст нь боловсрол орж байна. Монголчууд урдахыг нь биш, ард талыг нь эрхэмд үзчихсэн хүмүүс шүү дээ. Тиймээс өнөөдөр Монголын боловсрол оюун ухаанаасаа хөндийрчихсэн, оюунлаг бус, хоосон улбагар-үлбэгэр болоод байгаа юм. Өндөгөөр ярих юм бол доторх шар, цагаан нь гоожчихсон, хоосон хальс гэсэн үг.

Оюун ухаан хүний дотор байдаг, харин боловсрол гадна нь байдаг зүйл. Гэхдээ боловсролыг оюун ухаанаас салгаж болохгүй. Боловсролгүй бол оюун

ухаантай байсан ч болчихоор мэт ойлгох нь явцуу үзэл. Их оюун ухааныг боловсрол мэдлэгээр тэтгэх ёстой.

Нөгөө талаар оюун ухаантай хүнийг боловсролоор дэмжсээр байгаад ухаантай болгочихно гэвэл худлаа. Хүнд тархины хэм хэмжээ гэж бий. Тэр хэмжээгээрээ л сэтгэнэ. Хичнээн доктор, академич болгоод ч тэр явахгүй. Одоо хар, сүүлийн үед хичнээн олон бакалавр, магистр гарч байна. Гэтэл оюун ухаан нь нэмэгдэхгүй л байна. Ингэж хэтэрхий туйлширч болохгүй ээ. Хоорондоо эд чинь холбоотой. Гэвч оюун ухаан анхдагч. 185 орныг оюуны чадвараар нь жагсаасан олон улсын судалгаа гарсан. Энэ судалгааны эхний хэдэд Ази, хамгийн сүүлд Африкийн орнууд орсон байсан.

*- Тэгэхээр газар зүйн байршил бус нутаг IQ-д нөлөөлдөг байх нь ээ.*

-Нөлөөлнө өө. Оюун ухаан чинь өөрөө байгалийн бүтээгдэхүүн. Зарим нутгийн морьд хурдан байдаг шиг зарим бүс нутгийн үндэстэн маш ухаантай байдаг. Барууныхан үүнийг маш сайн судалсан.

*•Оюун ухаан заавал IQ клубт хөгжих ёстой биш байх. Өөрөөр хөгжүүлэх арга бий юу?*

-Оюун ухааныг ингэж, тэгж хөгжүүлнэ гэж яг таг заах хэцүү. Харин уралдах, өрсөлдөх нөхцөлд л хөгждөг нь үнэн юм. Тэгэхгүй бол тэгс ингэсхийгээд л залхуураад орхино. Оюун ухааныг ажиллуулдаг гол арга нь оюуны өрсөлдөөн. Энэ өрсөлдөөнийг хаана хийх вэ гэхээр олуулаа, хүмүүс дунд л хийнэ. Өөрөөр, гэртээ суучихаад л оюун ухаанаа хөгжүүлнэ гэвэл болхи арга. Яахав, ном товхимол хэрэглэж болно л доо. Төдий л хол явахгүй. Тэр хүнд өрсөлдөх хүн байна уу, байхгүй. Иймээс клубуудээр л хөгжүүлбэл дээр юм.

*-Клубууд аль хэр түвшинд ажиллаж байна вэ?*

-Одоогоор улсын хэмжээнд 3000 гаруй багштай, мөн төдий хэмжээний клуб ажиллаж байна.

Эдгээрт хорин мянга гаруй хүүхэд хичээллэдэг. Жилээс жилд арав арван мянгаар нэмэгдэж байна шүү дээ. Тэд жилд гурван удаа IQ -гээ тогтоолгодог. Нийгэм тэр чигээрээ оюунжиж байгаа нь олзуурхууштай шүү.

*• Тэгвэл тодорхой хугацааны дараа монголчуудын оюуны хөгжлийн үзүүлэлт аль хэр түвшинд хүрсэн байх бол? Хөрс суурь нь тавигдаад байгаа энэ ажлын цр дүн нь хэдэн жилийн дараа гарах вэ?*

-Үүний үр дүн арван жилийн дараа тод харагдана. Учир нь энэ хүүхдүүд

шал өөрөөр сэтгэдэг шинэ үеийнхэн болно.

Одоо бидний үеийнхэн яаж байна? Оюунаасаа хөндий, шугаман сэтгэлгээтэй болчихоод байгаа шүү дээ. Энэ хүүхдүүд аливааг олон талаас нь өргөн хүрээтэй сэтгэдэг, оюун ухаан нь нилээд хөгжсөн иргэд болж төлөвшинө.

Чухам энэ үеэс Монголд оюуны чадвар жинхэнэ эрч хүчээ авна даа. Иймээс одооноос хүн бүр цаг алдалгүй оюунаа хөгжүүлж эхлэхгүй л юм бол 5-10 жилийн дараа ажлын байран дээрээ тогтоно гэсэн ойлголт бараг байхгүй болно. Учир нь тэр үед хүнийг оюуных нь чадвараар л шалгана. Энэ жил л гэхэд хуульчдийг оюуны чадавхиар нь дахин шалгаруулах болчихоод байна.

Найман мянга гаруй хуульчдаас 800-г нь шалгаруулах хэрэгтэй болчихож. Оюун ухаанаар нь л шалгана.

Манай хуульчдын IQ=103 гараад байгаа нь хулгайчийн оюуны чадвараас дор орчих гээд байгаа юм, үүнийг засууштай . . .?!!

*-Оюуны чадвараар нь нэг ёсны зиндаа тогтоож байна гэсэн үг үү?*

-Тийм. Ингэхээс ч өөр аргагүй, хоосон диплом хөөцөлдөж, оюун ухааныхаа хөгжлийг орхигдуулдаг хортой үр дагаврыг халмаар байна.

*-Энэ нь хүний нэр төрд халдсан хэрэг болохгүй юу?*

-Тэгэхээр зах зээлийн гол өрсөлдөөн нь оюун ухаан. Хувийн ч бай, төрийн ч бай байгууллагууд өрсөлдөхийн тулд маш оюунлаг хүнтэй байж таарна. Ингэх ч ёстой. Энд ямар ч сөрөг нөлөө байхгүй.

*-Оюун ухаанаар нь шалгаруулж ажилд авдаг болсоноор танил тал, найз нөхөд, садан төрлийн холбоог чухалчилдаг сөрөг үзэгдлийг арилгаж чадах уу?*

-Чадна. Тэгэх ч ёстой. Олон компани хувийн сургуулиуд дампуурлаа л гэнэ. Эцсийн эцэст оюуны сонголт хийж чадаагүй, найз нөхөд, садан төрөл, нэг намынхнаа эрхэмд үзсэнээс л ийм болсон хэрэг.

*•Оюуны чадварын хувьд монгол хүний онцлог юу вэ?*

-Монголчууд төрөлхийн өндөр авъяастай улс. Хоёр том гүрний дунд хавчигдаж, олон зуун жил дарлагдсан, аль өнгөтэй өөдтэйгээ алдсан ч гэлээ бид өдгөө монголоороо үлдэж чадсан шүү дээ. Энэ чинь бидний давуу тал. Цэнэглэдэггүй л болохоос биш Монгол хүн маш оюунлаг. Харин сэтгэлгээ талдаа сул шүү. Үүнд нийгэм нөлөөлсөн. Сэтгэлгээ гэдэг чинь хүнтэй цуг төрөхгүй шүү дээ. Дараа нь л суралцдаг зүйл. Чингис хааны IQ=204 гэж тогтоогдсон. Энэ нь Монгол нутаг оюун ухааны өлгий гэдгийг харуулж

байгаа нэг нотолгоо.

*-Монголын хамгийн өндөр IQ-тэй хүмүүс хэн хэн бэ?*

-Одоо монгол улсын хэмжээнд ухаантай буюу 130-140-ийн хооронд IQ-тай хүмүүсийг бүтээлээр нь шалгаруулж байгаа. Өнгөрсөн жил Монгол улсын төрөлхийн оюуны чадвартай арван хүнийг тодруулсан. Тухайлбал онолын физикийн Намсрай академич, анхны ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн, сэтгүүлч Ч.Эрдэнэ гэх зэргээр нэрлэх байна.

*-Төмөр замд гол төлөв инженерүүд ажилладаг. Тиймээс тэд IQ өндөртэй байх. IQ-гээ цааш нь хөгжүүлэх гэвэл яах ёстой вэ?*

-Төмөр замын систем бол тогтвортой. Өнгөрсөн жил бид сэтгэх чадварын улсын олимпиадыг Эрдэнэт хотод зохиоход төмөр замын удирдлага вагон гаргаж үйлчилэн, биднийг дэмжиж байсан. Үүнд талархахаас өөр аргагүй. Тэгэхээр төмөр замын удирдлага өнөөдөр оюуны хөгжлийг дэмжиж байна гэж ойлгож болно. Одоо харин цааш нь бүх шатныхаа оюуны чадварыг хөгжүүлэх талаар эрчимтэй ажиллах хэрэгтэй. Иймийн тулд оюуны чадварын IQ төвтэй хамтран ажиллана гэвэл бид туслахад бэлэн, иж бүрэн хөтөлбөр бий. Бас нэг зүйлийг чухалчлан хэлэхэд Төмөр замын тавдугаар цэцэрлэгийн багш нар одоо манай сургалтад сууж байгаа.

*-Оюунаараа тэргүүлэгч орон болж, оюун ухааныг баялгаа болгохын тулд ямар хөшүүрэг хэрэгтэй вэ?*

-Манай нийгэм чинь өнгөрсөн үеүүддээ оюун ухаанаасаа хөндийрчихсэн, түүнийг үнэлдэггүй байж. Үүнээсээ л маш түргэн салмаар байна. Монгол хүн их мэдрэмжтэй юм. Гуравхан жилийн хугацаанд оюунаа хөгжүүлэх ажил ийм эрчтэй явагдаж байна. Одоо бараг хүн бүр л оюун ухаан гэж ярьдаг болж. Энэ нь бага үндэсний мэдрэмжтэй чанар шүү дээ. Энэ тал дээр Засгийн газар ч дорвитой ажил зохиосон. «Монгол хүний оюуны чадавхи» хэмээх яам дундын зөвлөгөөн, семинарыг ШУБЯ, ЭМЯ хамтран зохион байгууллаа. Монгол хүний оюуны чадварыг судлах улсын төсөл зарлаж, зардлыг нь гаргаж өглөө. Одоо судлаж байна. Аймаг сумаар нь гаргана. Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оюуны хөгжлийн хичээлийг оруулах шийдвэр гаргамаар байна. Төрийн зүгээс бүрэн нээлттэй боллоо. Харин одоо ард түмэн л ахиж дөхмөөр байна. Хуучнаасаа хурдан салаасай гэж бодох юм.

*-За, IQ ийм байж. Харин латерал сэтгэлгээг та тодруулаач?*

-Латерал сэтгэлгээ гэдэг чинь тал талаас нь юмыг шавхаж сэтгэнэ гэсэн үг. Монгол хүн аливаа юманд ганцхан талаас нь өрөөсгөл хандаад сурчихсан. Тухайлбал манай нам ялбал миний амьдрал сайжирна гэдэг. Яалаа гэж. Нэг нам ялах нь тэр хүний амьдрал сайжрах, үгүйд бараг нөлөөгүй. Өөрөө л амьдралаа сайжруулах хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр амьдрал сайжирна гэдгийг дан ганц нам мэтийн хөндлөнгийн хүчин зүйлд даатгаад байж болохгүй. Олон талаас бодох хэрэгтэй. Юмыг олон хувилбараар харж, бүтээлчээр, шавхаж сэтгэх нь латерал сэтгэлгээний мөн чанар гэж ойлгож болно.

# ҮНДЭСТНИЙХЭЭ ОЮУНЫ ЧАДВАРЫГ IQ ТЕСТЭЭР ШАЛГАЖЭЭ

---

Засгийн газрын мэдээ 2004. 02. 11 №35 (1545)  
(IQ төвийн ажилтан Б.Баяртай хамтарч)

Австрали улсад 2002 оны наймдугаар сарын 6-ны шөнө орон даяар үндэсний IQ тестийг “Nine” харилцаа холбооны агентлаг хариуцан явуулжээ.

Тестийг хүн бүхэн бөглөх боломжийг хангаж өгсөн бөгөөд хүмүүс оюун ухааны илтгэцүүрийн төвшингөө тогтоох бүрэн боломжтой байжээ. Үндэсний IQ тестэд интернэтээр 43 мянга, гар утас ашиглан 20 мянга гаруй, нийт 63 мянган хүн бүртгүүлж оролцжээ.

Nine агентлаг нь үндэсний IQ тестийн дүнг дараах үзүүлэлтүүдээр тус тус танилцуулсан байна

Үүнд:

*Газарзүйн байршил*

*Аль гараар бичдэг*

*Тамхи татдаг, татдаггүй*

*Архи хэрэглэдэг эсэх*

*Нүдний шил зүүдэг эсэх*

*Үсний өнгө*

*Нүдний өнгө*


*Мах иддэг, иддэггүй*

*Биеийн өндөр*

*Хүйс*


*Насны ангилал*


Эндээс та бүхэнд 100 хүн тутмын дундаж IQ-гээр тооцож газарзүйн байрлалаар үнэлгээ өгсөнийг харуулав.



Тус улсын зүүн урд болон далай эргээр буй хотуудад оюун ухаан төвлөрсөн нь зургаас харагдаж байна. Хотуудын IQ нь янз бүр ажээ.

Энэхүү тестэд насны ангилал, биеийн өндөр гэсэн үзүүлэлтээр IQ оноог гаргаж графикаар харуулсныг үзүүлэв.





Биеийн өндөр хэвийн байх нь оюуны чадавхид эерэг нөлөөлдөг байна.

Харин хэт өндөр юм уу намхан хүмүүсийн оюуны чадвар төдийлөн сайн биш байдаг нь батлагджээ. Насны хувьд хүний оюун ухаан байнга өсөх зүй тогтолтой байгаа нь нэлээд сонирхолтой юм. Ер нь өглөх, зөнөх гэдэг ойлголт устаж байх бололтой. Оюун ухаанаа байнга дасгалжуулбал өглөхөөс сэргийлж болох ажээ.

Мөн хүйс, шил зүүдэг эсэх, ямар төрлийн согтууруулах бүтээгдэхүүн хэрэглэдэг эсэх зэрэг үзүүлэлтүүдийг тооцож IQ-оноог гаргасныг доор харуулав.

- Эрэгтэйчүүд - 112
- Эмэгтэйчүүд - 108
- Нүдний шил хэрэглэдэг - 112
- Нүдний шил хэрэглэдэггүй - 109
- Шар айраг хэрэглэдэг - 114
- Дарс - 114
- Огт хэрэглэдэггүй - 108

Тестэд амжилттай хариулсан хүмүүсийг ажил мэргэжлээр жагсаавал:

Тестийг

Багш нарын-71%

Тайз дэлгэцийн алдартануудын-65%

Оюутнуудын -64%

## Барилгачидын - 62%

нь тус тус зөв хариулсан байна.

Эцэст нь дурдахад энэ тестэд Жон Аткинс хэмээх программист залуу 151 оноо авч тэргүүлжээ.

Үүнтэй адилаар Германы “BBC” телевиз, Нидерландын “Eyework” агентлаг, Их Британи, Франц, Испани, Шинэ Зеланд зэрэг улсын харилцаа холбооны байгууллагууд үндэсний IQ тестүүдийг 2000-2003 оны хооронд зохион байгуулж явуулсан байна.

Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.ninetsn.com](http://www.ninetsn.com) сайтаар зочлоорой.

## МОНГОЛ ХҮНД ОЮУНЛАГ СПОРТ Л ИЛҮҮ ОЙР

---

Өдрийн сонин 2004. 02. 19 №044, 045, (1546, 1547)

Манай сумочид Японд гялалзсан сайхан амжилт гаргалаа, баярлахгүй байхын аргагүй... Гэтэл манай хөл бөмбөгчид оны өмнөхөн Мальдивт очоод 12:0-р хожигдсон бөлгөө. Яагаад спортын заримд нь гялалзтал түрүүлж, заримд нь салам хожигдов? Үүний ард бодит хүчин зүйл байгаа биш биз....?

Миний танил нэгэн эрдэмтэн надад доорхи түүхийг ярьсан юм. Эрдэмтэнийг Э гэе, тэрээр нэг дүүтэй байжээ. Э гуай багадаа уралдааны морь унах хообийтой, дүүтэйгээ уралдах морь булаацалдана, бас саваа мод унаж уралдаад хоцрохоороо дүүгээ шийтгэж уйлуулдаг байв гэнэ. Энэ бол 1940- өөд оны үе шүү. Нэг өдөр эцэг нь Э-г дуудаад (тэр үед Э 9 настай байж) “Хүү минь, чи юунд дүүтэйгээ уралдах морь, унах саваа булаацалдана, хэрэггүй бусуу, чи толгой томтой хүүхэд шүү, ямартаа л хүмүүс чамайг араг толгойг гэхэв, ийм зантгар толгойтой хүн морь унадаггүй, ном унадаг юм... чи бол ном эрдмийн л хүн, хэрэвзээ спортоор хичээллэе гэвэл сур, шатар мэтийн оюун ухаан илүүтэй шаарддаг төрөлд нь биеэ бэлтгэ, харин дүү чинь шоовон толгойтой, хөл урттай хүүхэд, түүнд ном зохихгүй, морь саваа зохино, яваандаа явганаар хурдалдаг болж ч мэднэ, жаахан ноцолдож ч магад. Чам шиг зантгар толгойтой, богино хөлтэй хүүхэд мориноос унах, хөл дэгээнд сөхрөх, бэртэх нь элбэг, хөлөөрөө газар хороох нь бага, гэтэл жижиг толгойтод ийм зүйл цөөн тохионо. Чи заяагдсан давуу талаа ашиглаж эрдэм ном хөө, энэ муу дүү чинь намайг дагаг, ийм хүн ном сурахгүй ээ, аав нь хоёр хүүгээ мэднэ” гэжээ. Э гуай тэр цагаас хойш мориноос холдож, явганаар хурдалдаг тоглоомоо орхиж, номруу ойртсоор эдүгээ манай нэртэй том эрдэмтэн болсон билээ. Дүү нь малаа хөөцөлдсөөр, морь уяж, сумын наадамдаа зодоглосоор, үе үе хөлөөрөө таваргадаг уралдаанд оролцсоор нутагтаа насыг барсан ажгуу...

Аливаа улс үндэстэн, пүүс, өрх гэр, хувь хүн өөрийн гэсэн давуу талаа хэдий чинээн эрт мэдэрч, ямар хэмжээнд ашиглаж чадна, тэр хэрээр хөгжлийн

эрч нь нэмэгддэг.. Энэ бол зүй тогтол. Эдийн засгийн ухаанд харьцангуй давуу талын онол гэдэг нэрээр Д.Рикардогийн үеэс нэлээд үндэслэгджээ. Д.Рикардогийн онол гэгчийг огтоос сонсоогүй хөдөөгийн жирийн монгол малчин, эрдэмтэн Э – н эцэг тэр гуай” хоёр хүүд нь өөр өөрийн гэсэн харьцангуй давуу талууд гэж байна, түүнийг нь ашиглах нь ирээдүйтэй”.. гэдгийг зөн совингоороо мэдэрч байжээ дээ, бодохноо нь ... эцэг бүр ийм байвал мөн ч чухал даа,.. даанч...?

Э гуайн давуу тал бол төрөлхийн оюуны өндөр чадавхи буюу IQ-н дажгүй сайн үзүүлэлт юм, бас Э-гийн дүүд ч гэсэн харьцангуй давуу тал байна, тэр нь хурдан морь унахад илүүтэй тохирсон савлах нь бага шоовон толгой, салхи зүсэхүйц зууван нүүр, богино цээж , урт хөл...Энд би вээр тэр нь сайн, энэ нь муу гэж дүгнээгүй, гагцхүү бодит байдлыг зүгээр л тоймлож байна, ойлгох биз.

Э гуай эрдэм хөөхийн оронд морь мал хөөцөлдсөн бол яах байсан гээч...., дажгүй малчин, магадгүй, хөдөлмөрийн баатар ч болсон байхыг үгүйсгэхгүй, эсвэл морь, тэмээнээсээ унаж гэмтэж бэртээд эрэмдэг болсон байж ч магад,... ганц тагш нэрмэлд сэтгэл нь хөөрөөд унаагаа нэг ташуурдчихна, савалгаа ихтэй том толгой биеэ чирээд газарт ойчно... хэтрүүлэг гэвэл та өөрөө толгой дээрээ 3 литр устай сав хулчихээд мориныхоо хар хурдаар нь үсэргээд үзээрэй... яах бол...? Гарцаагүй л ойчно доо... Э гуайн дүүг эрдэм номын мөрд оруулсан бол яах байсан гээч, магадгүй, эрдэмгүй эрдэмтэн болсон байхыг үгүйсгэхгүй, эсвэл...хэрээс хэтэрсэн ачаа үүрэх гэж тархиа тамласаар эцэст нь сэтгэцийн гажигтай болж эмнэлгээр насаа бардаг хувь тавилантай эвлэрсэн байж ч магад. Хувь хүний тухайд ийм байдаг бол үндэстний тухайд ямар бол?, лавтайяа бусадтай харьцуулахад тод ялгарах ерөнхий шинж, харьцангуй давуу тал гэж үндэстэн бүрт байж таарна.

Монгол үндэстний харьцангуй давуу тал нь: “Оюуны төрөлхийн өндөр чадвар” болох нь мэдэгдэж байна. Дунд зэргийн нуруу, бахим бие, зантгардуу толгой, богиновтор хөл,. ахардуу гар... дүгнэвээс,... Монголчуудад ерөнхийдөө IQ өндөртэй үндэстний шинж тод ажиглагдаж байна, үүнийг дэлхийн оюун ухааны талын бүтээлүүдэд ч хүлээн зөвшөөрсөн байна. Харамсалтай нь, бид өөрсдөө үүнийгээ төдий л олж ухаарахгүй байх шиг, өөрийгөө олоогүй үндэстэн өрөөлтэй өрсөлдөнө гэж юу байхав, жишээ хэлье.

Монголчууд сагс, гар, хөл бөмбөг, гүйлт, цанын спортоор дэлхийн олимпод байтугай тивдээ, бүсдээ ерөөсөө гавихгүй байна. Монгол хүний тагдгардуу

цул бие дээш үсрэхэд төдий л зориулагдаагүй бололтой, харуудын дэргэд бидний үсэрдэг, самбараас ойсон сагсны бөмбөгийг тэдэнтэй булаацалдана гэж ер нь юу байхав, энэ бол барахгүй даваа ...Монгол хүний богино хуруутай бахим гарт сагсны бөмбөг тогтох магадлал бага юм, гэтэл Майкл Жорданы гар бол сагсны бөмбөгний хувьд соронзон л гэсэн үг. Энэ ялдамд АНУ-ын сагсан бөмбөгийн шигшээд “хар”-ууд тоглодог бөгөөд тэдний дундаж IQ-нь 85 нэгж, харин цагаан арьстнуудынх 100 нэгж байдгийг сонордуулъя.

Зантгардуу (биетэй нь харьцуулахад) толгойтой, бондгордүү биетэй монгол хүн хурдлан дэгдэхэд төдий л зориулагдаагүй бололтой, гүйлээ гэхэд хурд нь их биш байх, учир нь том толгой нь жин хүнд, салхины эсэргүүцэл их, ганхах савлах нь далайцтай, ийм үед бүдэрч ойчих нь элбэг, худал гэвэл та өөрөө толгой дээрээ том гээчийн түмпэн барьчихаад гүйгээд үз,...Тэгээд ч алцгардуу, бас майга гээч, богино хөлөөр газар хороох нь бага биз, харуудын хоёр алхах зайг бид гурав алхаж таарна.

Спортыг оюунлаг ба оюунлаг бус гэж хоёр хуваана. Монгол хүнд оюунлаг спорт ойр, харин оюунлаг бус нь холовтор бололтой. Та амьдралыг сайн ажигла даа ...Оюунлаг нь шатар, сумо, байт сур гэх мэт бол оюунлаг бус нь гүйлт үсрэлт оролцдог биеийн хар хүч, бяраар аагладаг, өөрөөр хэлбэл амьтанлаг талдаа илүү ойр тэдгээр төрлүүд юм. Бод л доо гүйнэ, хурдална л гэнэ, хүн вээр Кенгуругаас хурдан гэж үү?, барилдана, ноцолдоно л гэнэ, хүн бээр бар арсланг дийлэх гэж үү?, гэтэл эдгээр амьтад шатар тоглож, нум, сур харваж чадах уу?. Энэ дашрамд бөхийн тухай хэдэн үг хэлье.

Монгол бөх бол уг нь оюунлаг талдаа илүүтэй хамаарах спортын төрөл юм. Уран мэхийг уралдуулан хүчийг үзье гэдэг биз дээ...Наадамчид хар бяраар аагласан, мэх арга багатай болхи бөхийг уяа бөх, унхиагүй мах, ухаан нь уландаа орсон годил, олныгоо баясуулахын оронд өөрийгөө бодсон золиг гэх зэргээр шүүмжилдэг билээ. Өмнөх үеийн аварга, арслангуудын бие хаа нь одоогийнхноос шал өөр харагддаг, тэд одоогийн манай бодибильдингийн тамирчид мэт булчин шөрмөс нь зангирсан, илүү сул махгүй, ёстой л уран мэхийг уралдуулан түмэн олноо баясгадаг хүмүүс байжээ, гэтэл сүүлийн үед энэ байдал бараг алга болов, хааяа л ганц хоёр бөх ийм байна. Үүний харгайгаар монгол бөхийн дотоод агуулга ядуурч, ялзарч, нэр төр хөөх, мөнгө олох бизнес болон хувирлаа. Үүний харгайгаар нийгмийн оюунлаг хэсэг, сэхээтнүүд монгол бөхөөс дайжиж, сумо мэт оюунлаг спортуу хошуурах болов. Ер нь

МОНГОЛ БӨХ БОЛ УГААСАА ОЛОН ЗУУН УРАН МЭХТЭЙ, СУМОТОЙ ЗҮЙРЛЭХИЙН АРГАГҮЙ “ГАНГАН” СПОРТ ЮМ БИЛЭЭ, ХАРАМСАЛТАЙ НЬ МОНГОЛ БӨХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО АЛДАГДАН, ЭРИН ЦАГИЙНХАА ДУУДЛАГА, ЭРЭЛТ, ШААРДЛАГААС ТАСРАН ХОЦРОВ .

Монгол бөхийг хөгжүүлэх бодлогод ноцтой алдаа байна, тэр нь монгол бөхийг оюун ухаанаас холдуулсанд оршино. Оюун ухаанаас хөндийрсөн ямар ч үйл явц уруудах тавилантайг, тийм цаг үе ирсэнийг бөхчүүд, бөх судлаачид, бөх сонирхогч, хөгжөөн дэмжигчид бүгдээрээ ухаарах хэрэгтэй. Энэ янзаараа байвал монгол бөхийн ирээдүй мухардмал хэвээрээ байх болно.

IQ өндөртэй хүн аливаа ажил үйлийг хийхдээ арыг нь, эцсийн үр дагаврыг нь заавал хардаг, аливаад ухаан жолоогүй, ум ум хумгүй зүтгэнэ гэж бараг байхгүй, монголчууд ийм хэт улайрдаг хүнийг “хүн” гэдэггүй, “улайрсан бух” гэдэг, тэгэхлээр “сагсан бөмбөгт харуудтай өрсөлдөж хамаагүй өндөр үсэрвэл буухдаа нуруу ууцаа гэмтээж мэднэ, тэмцээнд нэг түрүүлж улсаа мандуулах ч гайгуу хэвтэнэ, насаараа гэмтэл авбал би л хохирно, гол нь тив, газар үзэх...” гэдэг бодол монгол хүний толгойд байж л байх, энэ нь ч зөв, энэ ертөнцөд түмэн жаргалан бий, олимпод түрүүлэх, олныг баясуулах, одон тэмдэг зүүх, орон газар үзэх,... гэхдээ л түүний дотроос чухам жаргалан нь эрүүл энхийн нэг л жаргалан билээ... Д. Нацагдорж яг л онож хэлсэн дээ, IQ өндөртэй хүн, бас IQ өндөртэй үндэстэн гэдэг цаанаа л өөр болохыг эндээс би ажигламуй.

Манай хөл бөмбөгчид Мальдивийн өнгөт арьстанд 12:0 хожигдлоо, аргагүй ээ, тэд чинь төрөлхийн толгой жижиг, хөл урт, хурдлан үсрэх хообийтой, дээд бус, доод эрхтний ажилд илүү зохицсон хүмүүс, (Монголчууд IQ-н үзүүлэлтээрээ дэлхийн 185 орноос 98 оноогоор 21-д орсон бол Малдивчууд 81 оноогоор 124-т оржээ.) Шунгинан ирж буй хүнд гээчийн хөл бөмбөгийг толгойгоороо мөргөдөг, нэг бодлын мангар ч гэмээр нөгөө бодлын эргүү өвчинтэй болох гэсэн хүний үйлдэл ч гэмээр сонин арга-технологи бий, ажиглажээ суухад, энэ аргыг манай хөл бөмбөгчид бараг хэрэглэдэггүй, хэрэглэвч голдуу мөрөөрөө мөргөдөг юм билээ. Тэгэхлээр манай баг Мальдивчуудад хожигдох нь мэдээж хэрэг, тоглоомд хожихын төлөө тархи толгойгоо золиослодог нь бид биш, бид бол өөр хүмүүс, бидний IQ тэдний IQ-ээс даруй 17 нэгж илүү бөлгөө. Өндөр IQ-тэй нь толгойгоо хөгжүүлбэ, бага IQ-тэй нь бие бялдраа хөгжүүлбэ, энэ бол хэн хэнд нь өлзийтэй бөгөөд нэг ёсны даяарчлалын үед бий болох үндэстнүүдийн төрөлжилт, дагналт юм.

Зарим нөхөд Мальдивчуудаас даагаа нэхнэ, хариугаа авна гэх аястай мэдэгдэл хэлж байна лээ, энэ тухайд би вээр дараах саналыг дэвшүүлнэ. Яваандаа хөл гар нь урт, бие булчин нь том, толгой тархи нь жижгэвтэр, IQ-н хичээлээс дайждаг, хогон мэдээлэлд автамхай, холын бодол багатай хүүхдүүд олширохоор тэднээсээ түүж шигшээд гайгүй баг бүрдүүлж Мальдивийнхнаас даагаа нэхье, тэр болтол түр хүлээзнэвэл ямар бол? гэхдээ хөрөнгийг нь гадаадынхан өгч байгаа бол өөр хэрэг, авах нь зөв, газар орон үзэхгүй юу, харин өөрөө гаргаж байгаа бол өөр хэрэг, хөрөнгө хүч хайран байна...

Монгол үндэстэн бол төрөлхийн оюуны өндөр чадавхитай үндэстэн юм. Энэ бол бидний харьцангуй давуу тал. Тэгэхлээр бидний монголчууд өнгөт арьстануудтай хөл, бөгсөөрөө тэмцэлдсэнээс цагаан арьстануудтай толгой тархиараа өрсөлдвөл илүүтэй онох бус уу? Ой шугуйд үсрэн дүүлэн аж төрсөөр биеийн доод хэсэг нь илүүтэй хөгжсөн өнгөт арьстнууд (тэд), хээр талд, морь унаж, дуу дуулж, хорвоогийн алаг эрээнийг хоёрхон чавхдсан дээр уянгалуулан бясалгасаар биеийнх нь оройн дээд хэсэг хөгжингүй болж гүйцсэн монголчуудтай (бидэнтэй) толгойгоорой (IQ-рээ) өрсөлдөө гээгүй байхад бид тэдэнтэй, хөл бөмбөгөөр, хөл бөгсөөрөө тэмцэлдэх гээд байдаг нь хэр зохимжтой вэ?

Зориулагдаагүй үйлийн төлөө бие оюунаа зольж, бусдын доог болох нь зайлшгүй тулгарсан зүйл гэж үү? Үүний оронд зориулагдсан үйлдээ хүч оюунаа сорьж бусдыг алмайруулан баясгах нь дээр бусуу..

## *БОЛОВСРОЛЫН ХУВЬСГАЛ ХАЯАНД ИРЛЭЭ*

---

Өдрийн сонин 2004. 09. 21 №234 (1736)

*-Оюун ухаан гэдэг нь нэг ойлголт уу, эсвэл өөр өөр ойлголт уу?*

-Үгнээс нь харахад л хоёр өөр үг байгаа биз дээ. Хосолж байж нэг утга гаргана. Тэр нь оюун ухаан. Гэхдээ ер нь уг үндсээрээ бол хоёр өөр ойлголт шүү. Хоорондоо маш нарийн ялгаатай, бас маш гүнзгий холбоотой. Жишээ нь, тэр гуай их оюунлаг хүн шүү, эсвэл тэр гуай их ухаалаг хүн шүү гэхэд ялгаатай утга тодорно. Оюунлаг шийдвэр, ухаалаг шийдвэр гэхэд бас л ялгаатай шийдвэрүүд юм. Энэ асуудлаар гүнзгий бөгөөд тодорхой мэдлэгтэй болъё гэвэл тархи судлалын ухааныхантай уулзах хэрэгтэй. Миний хувьд гэвэл алс нь танай сонинд нэг эссэ маягийн материал бичиж өгнө.

*-Та тэр материалаа өөр сонинд өгөхгүй гэж амлалаа шүү?*

-Амалъя, амалъя. Танай сонин л Монголдоо анх удаа Оюун ухаан, IQ, Оюуны хөгжил гэж дуугарсан. Мэдрэмж сайтай, эрин цагийнхаа дуудлагад зохицож, чөлөөтэй сэтгэж байгаа чинь сайн хэрэг. Том сонин гэдэг том л байх учиртай, үүнийгээ мартав.

*-"Өдрийн сонин" яагаад энэ асуудлаар бусдаасаа түрүүлж дуугарсан гэж та бодож байна вэ?, Учир нь юундаа байгаа бол?*

-"Өдрийн сонин"-ы захиалагч, уншигчид чинь оюунлаг хүмүүс байхгүй юу. Та нар сулбагар, үлбэгэр, долигоносон, далдагнасан, цаг үедээ ууссан, навсайсан, навтайсан, цоорхойтой, ноорхойтой юм бичвэл уншигчид чинь уурлах байлгүй. Та нөхөд уншигчдынхаа энэ шаардлагыг байнга санаж байх хэрэгтэй. Итгэл алдав аа? ...

*-Оюуны хөгжил-IQ хичээлийн үр дүн ямархуу байх юм?*

-Өнгөрсөн хичээлийн жилд л гэхэд 3000 гаруй багш, 26000 орчим сурагч багачууд оюунаа тусгай хөтөлбөрийн дагуу хөгжүүлсэн. Энэ ажлын үр дүнгийн талаар эцэг, эх, багш, сурагчдаас өөрсдөөс нь асуух нь зөв. Тэд үнэнийг шууд хэлчихдэг хүмүүс шүү.

*-Оюуны хөгжлийн хичээлийг төр, засгаас хэрхэн дэмжиж байгаа бол?*

-Өнгөрсөн дөрвөн жилд ажилласан Засгийн газар бүхий л шатандаа оюуны хөгжлийг дэмжсэн гэж хэлж болно. БСШУЯ-аас Сэтгэх чадварын олимпиадыг Улсын төрөлжсөн олимпиад болгосон, Улсын мэргэжлийн хяналтын албаны удирдлагууд оюуны хөгжил л гойд чухал гэж үзэж боломжит бүх аргаар дэмжихээ илэрхийлсэн, боловсролын шинэ стандартаар “Оюуны хөгжил-IQ” хичээлийг ЕБС-иуд үндсэн хичээлээ болгож сургуулийнхаа хөтөлбөр-хуваарьтаа оруулах бололцоотой болсон гээд багагүй ахиц дэвшил гарлаа. Зөвхөн энэ хичээлийн жилд гэхэд л одоогийн байдлаар хэд хэдэн ЕБС, цэцэрлэг байгууллагаараа Оюуны хөгжлийг эрхэмлэгч хамт олон болох хүсэлтээ ирүүлж, батламжаа авч, хичээлээ эхэлж байна.

*-Манай төрийн томчууд энэ талаар ямархуу мэдрэмжтэй явдаг бол? Танд мэдэгдэв үү?*

-Одоогийн УИХ-ын дарга Н.Энхбаяр өнгөрсөн онд Ерөнхий сайдын өрөөндөө намайг хүлээн авч уулзахдаа “Оюун ухааныг шүтэх нь бидний монголчуудын хөгжих хамгийн дөт зам байх” гэж онцлон тэмдэглэж байсан. Тэрээр “Оюунаа хөгжүүлэхийн зэрэгцээгээр бүтээлч сэтгэлгээнд шамдан суралцъя” гэж ард түмэндээ хандаж уриалсан нэгэн. Одоогийн Ерөнхий сайд Ц.Элбэгдорж АНУ-аас ирмэгцээ миний өрөөнд өөрөө ирж, “Харвардад оюун ухаан гэж ярьж байна, та нар энд бас ярьж эхэлсэн чинь сайн хэрэг...” гээд манай IQ төвөөс хэвлүүлсэн бүх номыг худалдан авсан шүү, лав л 100000 төгрөг хол давсан байх, бас сүүлийн 3 жилд миний бичиж хэвлүүлсэн бүх өгүүлэл, нийтлэлийг хуулбарлан авсан,... ер нь оюунлаг хүмүүс их өөр байдаг юм шүү, гуравхан үгэн дээр л хэл амаа ололцоно, ойлголцоход их амар.

*-Манай боловсролын өнөөгийн байдал танд хэр таалагдаж байна вэ?*

-Би энэ талаар олон удаа бичсэн, одоо өөр хүний үг сонсвол дээр.

*-Хэний үг... гэж?*

-Ерөнхийлөгч Н.Багабанди энэ хичээлийн жилийн нээлтэд зориулж хэлсэн үгэндээ “Мэдээлэл оюуны багтаамж сайтай, чанартай, өрсөлдөх чадвартай, бүтээлч боловсролыг сонгон эзэмших орчин цагийн шаардлагад боловсролын ужгирч тогтсон, үеэ өнгөрөөсөн арга барил чөдөр тушаа болсоор байгааг эрх биш ухаарах цаг ирлээ... “Номлох”, “Цээжлэх” боловсрол хорьдугаар зууны хамт улиран үлджээ...” гэж онцлон дурдсан байна лээ.

**- "Эх орон-Ардчилал" эвслээс монголын хүүхэд бүрт 10000 төгрөг өгнө гэж амласан. Та энэ талаар ямар бодолтой байна вэ?**

-Хэрэвзээ энэ их мөнгийг өгч чадвал сайн л байна. Харин өгөхдөө тодорхой зориулалт заавал онох байх. Жишээ нь хүүхдийнхээ оюуны хөгжилд зориулна ч гэх юм уу, эс тэгвэл эцэг эх хоёр нь хүүхдээрээ дамжуулан ая тааваараа амьдрах арга хэрэгсэл болгочихвол эцэстээ ажил хийх хүн олдохгүйд хүрч ч мэднэ, сул мөнгөний сөрөг үр дагавар гэж бий шүү !!!

**- "Оюуны хөгжил-IQ"-г олон түмэнд эцэг эх, сурагч багачуудад товчлон хүргэх үзүүлэн таниулах материал байвал эвтэйхэн болов уу гэж бодох юм?**

- "Оюуны хөгжил-IQ" хичээлийн суурь баримтлал, XXI зууны боловсролын чиг хандлагыг харуулсан томоохон үзүүлэн-материалыг IQ төвөөс бэлтгэсэн. Одоогоор эрэлт захиалга ихтэй байгаа, аймаг, хотын ЕБС, цэцэрлэгүүд захиалгаа өгч байна, түрүүч нь худалдаж авч сургуулиа чимэглэж эхэлсэн, сургуулиудаас нийслэлийн 14, 16, 18, 20, 28, 45, 46, 51, 78, 84, "Ирээдүй" цогцолбор, "Арвис", "Сэтгэмж", "Орчлон", "Гурван тамир" зэрэг сургуулиуд, цэцэрлэгүүдээс 15,113,122,141, 147,161 гэх мэт, аймгуудаас Говь-Алтай, Баянхонгор, Ховд, Дорноговь, Булган, Хөвсгөл, Завхан, Говьсүмбэр, Дорнод, Хэнтий, Орхон аймгийн сургуулиуд захиалгаа өгөөд байна.

**- Оюун ухаанаа хөгжүүлэх ажлаас тэр түдгэлзвэл яах бол?**

-Та оюун ухаанаа хөгжүүлэхээс нэг өдөр татгалзвал хүн гэдэг эрхэм нэр танаас мянган өдрөөр холдоно. Бас ажилгүй болох магадлал эрс нэмэгдэнэ.

**- Ажилгүй болно гэдэг чинь юу гэсэн үг вэ? Ажилд оюун ухаан тийм их хамаатай гэж үү?**

-Хоёулаа онол ярилгүй, амьдрал ярья. Манай улсад хуульчдыг сонгон шалгаруулах хууль хэрэгжиж эхэлсэн. Анхны даваа нь сэтгэх чадварын шалгалт. Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл сурталчилгааны үндэсний төвөөс эрхлэн хэвлүүлсэн "Хуульчдын сорилгын хураамж"-д Сэтгэх чадварын тест оржээ. Тэгэхээр та хуульчийн ямар ч гоё, бүр докторын ч дипломтой байлаа гээд энэхүү Сэтгэх чадварын тестэд бүдэрвэл өнгөрлөө гэсэн үг. Энэ давааг 10-аас 1 нь л давж, 9 нь унадаг дэлхийн жишиг бий, Монголд 100-аас 1 нь л давах байх. Тэгж байж хуульчдын энэ замбараагүй байдал цэгцэрнэ. Ийм төрлийн хөндлөнгийн магадлах шалгалт багш, эмч нарт, төрийн ажилтнуудад хүрнэ. Замбараагүй

олон сургууль, учиргүй олон мэргэжилтэн, бүгдээрээ шахам доктор, бүгдээрээ дарга болох хэнээтэй, бас бие биендээ аархан аарцаглахыг нь яана. ЕБС-ийн төгсөгчид бүгдээрээ шахам А үнэлгээтэй болсон гэсэн. Энэ бүгдийг цэгцлэх цаг ирлээ.

-Та уншигчдадаа хандаж юуг зөвлөхсөн бол?

-Оюун-мэдээллийн эринд боловсролын үүрэг улам ихэсч бас агуулга нь өөрчлөгдөж байна, ингэхлээр хуучнаараа байж яагаад ч таарахгүй. Залуус маань үүнийг мэдрээд, хөдлөөд, хараад, хүлээгээд байх шиг. Тэгэхээр боловсролын бүх шатны байгууллагын удирдлага, багш сурган хүмүүжүүлэгчид та бид эрх биш нэгийг бодож, хоёрыг хийх ёстой. Одоо дээшээ бусдын ам харж ажил хийдэг цаг биш. Боловсролын хувьсгал үүд тогшиж байна. Энэ хувьсгалыг хүлээн авахаас өөр гарц байхгүй гэдгийг ухаарч, монголын боловсролыг оюунжуулахын төлөө хамтран зүтгэе гэж уриалж байна.

## *ЯЛЛАДАГ ХУУЛЬЧДЫГ СЭТГЭДЭГ ХУУЛЬЧДААР СОЛЪЁ*

---

Өнөөдөр 2004. 09. 23 № 223 (2267)

*Манай орны тухайд хуульчид, шүүгчдийн IQ, сэтгэх чадварын түвшинг тогтоон мөрдцүлэх хэрэгтэй болсон мэт ...*

*АНУ-д хуульчийн IQ-н доод зааг нь 130 нэгж байх бөгөөд цүннийг бүх шатандаа маш хатуу мөрддөг байна. Харин Монголын дээд боловсролтой хуульчдын IQ нь 103 орчим ажгуу. Энэ бол жирийн гүйх хар ухаантай, боловсролгүй хүний IQ-ээс ихээхэн доогуур тоо шүү. Анхаартугай...*

Манай хуулийн салбарын шинэчлэл зөв голдрилдоо орлоо. Ажлын хатуу хүтүүг үүрч, шахалт дарамтыг тэсвэрлэн зүтгэсэн хүмүүст талархахын ялдамд цаашид анхаарах чухал зүйл байгааг хатуухан, халуухан хэлье гэж бодов.

Хүмүүс манай хуульчдын IQ нь хулгайч, гэмт хэрэгтний IQ-ээс дор оржээ хэмээн ярьж байна, үнэхээр ч Монголын хуульчдын оюунлаг чанар, сэтгэх чадвар энэ цаг үеийн шаардлагаас илт тасран хаягдсан нь улам бүр тодрон мэдэгдэх болов. Үүнд хуульчдыг бэлтгэдэг манай сургалтын хэв маяг, арга зүй, зааж буй хичээлийнх нь, бас сурах бичгийнх нь дорой түвшин, багш нарынх нь сэтгэлгээний хоцрогдол, мөн өмнөх үеэс гүн бат уламжилсан хар толбо, мэнгэнүүд нөлөөлж байна... Хар толбо. мэнгэ нь юуны өмнө социалист хууль нь агуулгаараа ялладаг хууль байснаас үүсэлтэй юм.

Үүний уршгаар хуулийн салбарын шинэчлэл эсэргүүцэл, бэрхшээлтэй тулгарч, нийгмийн захиалгаас хоцорч, олон түмний дунд "хуульч хүн л тэнэгдүү байдаг, тэд л болхи толхи арга хэрэглэдэг, түүнийг нь ашиглан хуульчдыг яаж ч гутаан доромжилж болно" гэх маягийн хортой санаархал газар авч байна. Үүнд хуульчид, хүн бүр хатуу дүгнэлт хийвэл зохино.

Хуульч гэж ер нь хэн бэ? Ямар хүнийг хуульч гэдэг вэ? Үүнд хуульч гэдэг бакалавр, магистр, докторын диплом чухал биш. Хуульчдыг цаасан хавтсаар баталгаажуулдаг цаг үе аль хэдийнээ ард хоцорсон. Ийм учраас УИХ-аар өнгөрсөн онд «Хуульчдыг сонгон шалгаруулах» хууль батлагдсан билээ. Одоо энэ хууль хэрэгжих шатандаа хэл үг ихтэй байна Хэл үг гарсаар

байгаа нь хуулиндаа бус, хуульчиддаа байна. Үүний цаад уг нь хуульч гэдэг нэр томъёог хуучнаараа ойлгосон хэвээрээ байгаад л оршино. Баримт хэлье. Хүний амь бүрэлгэсэн ноцтой хэрэг гарчээ ... Эзэн холбогдогч нь тогтоогдохгүй удлаа. Баримт, гэрч байсаар атал гэмт этгээд олдохгүй байна. Үүний уршгаар олон мөрдөн байцаагч ажлаасаа халагдав. Ажлаа муу мэддэг, хэргийн газарт буруу хазгай үзлэг хийсэн, унхиагүй нөхрийг ажилгүй болгох нь зөв юм, хууль журам ийм бөлгөө. Хуульч тэр гуай хуульч биш, ажилгүй хүн боллоо. Одоо асуулт тавья. Дээд боловсролтой, хуулийн мэргэжилтэй, хашир туршлагатай гэгддэг атлаа ажилгүй болсон тэр гуайг хуульч гэх үү? Эсвэл хуульчийг хуульчийн ажлаас нь хусуулчихаад ял завшин олны дунд инээмсэглэж, бас ийм хэрэгт мэргэжиж яваа гэмт этгээдийг хуульч гэх үү? Тэр гэмт этгээд тушаал дэвшин энэ хэргийн мөрдөн байцаагч болчихсон явахыг ч үгүйсгэхгүй...

Хууль ашиглан хуульчдаар тоглодог, хуульчдыг бөмбөг болгон ашиглаж зугаацдаг бүлэг хүмүүс буй болох нь ээ. Энд эдгээр бүлэг хүмүүс нь хуульч уу?, эсвэл эдгээр бөмбөгөн хуульч нь хуульч уу? Жишээ:

Бөхчүүд маань хоёр талцаж маргахдаа хуульчдаар бөмбөг хийж, бамбай болгон тэднийг уландаа гишгэн тохуурхаж, өөр өөрсдийнхөө хүссэн шийдвэрийг гаргуулдаг боллоо. Хууль гэдэг нь хэн хүний хүслийг хангагч эд хогшил. хуульч гэдэг нь тэрхүү эд хогшлыг олж цуглуулдаг, тэгээд биеэ үнэлдэг бусармаг этгээд болж таарлаа. Бөхчүүдийн IQ, сэтгэх чадвар нь хуульчдынхаас илүү болохыг эндээс харж болно, бас хуулийг хуульчид л өөрсдөө завхруулж байгааг мэдэж болно, бас манай хуульчдын мэргэжлийн ёс зүй ямархуу доод түвшиндээ орсныг ажиглаж болно.

### *Мэргэжлээ хайрладаггүй хүн хүнийг хайрлах болов уу?*

Дурдаж буй гэмт хэргийн тухайд хэргийн үйлдэгчийг олох, тогтоох нь хамгийн чухал. Хэрэвзээ хэрэгтэн тогтоогдвол түүнд оноох ял шийтгэл нь тодорхой, тийм хэрэгт тийм шийтгэл оногдуулна гээд хуулинд биччихсэн байгаа юм чинь, ядах юу байхав, энэ ажлыг компьютер гүйцэтгэж чадна, энэ ажлыг бичиг үсэгт тайлагдсан хэн ч хийж чадна. Хэрэг үйлдэгчийг харсан, тэр ч бүү хэл өөрөө ноцолдсон, хэлсэн үгийг нь тогтоочихсон гэрч бэлэн байсаар атал уг хэрэг илрэхгүй байна. Ямар хэргийн тухай ярьж байгааг унишгч та гадарлав уу? Онолын хувьд тэр гэрчээс ердөө л нэг асуултанд тодорхой хариулт авахад л гэрчийн хэн болох нь тодрох учиртай. Гагцхүү

асуултаа л олох ёстой. Энэ бол сэтгэдэг хуульчийн хийх ажил. Бидэнд сэтгэдэг хуульч үгүйлэгдээд байна. Гэтэл хуульчийн дипломтой хүн олон байна, тэд бол сэтгэдэг бус, яладаг хуульчид юм. Эдүгээ цаг дор яладаг хуульчийг хуульч гэхээ больсон, тэднийг компьютерээр орлуулж байгаа, ялын хэм хэмжээг алдахгүй оноодог программ хангамж бэлээхэн буй. Эдүгээ цаг дор сэтгэдэг хуульчийг л хуульч гэдэг болсон шүү. Мэдтүгэй.

Гэтэл хуулийн сургуулиуд хуучин шинэ баахан хуулийг хагас дутуу цээжлэхчээн аядсан ангаахайнуудыг бөөндөж байна. Эдгээр ангаахайнууд нь сэтгэдэггүй, боддоггүй, гэхдээ бичиг үсэгт тайлагдсан бөлгөө. 1970-аад онд хуулийн сургуульд дээд тооны хичээл оруулах гээд чадаагүй дээ. Багш оюутан хоёр хамтраад л эсэргүүцчихсэн ... Тэр дээр үед л сэтгэдэггүй оюутан л сайн хуульч болдог гэсэн балай зуршил тогтсон байж. Үүний уршиг одоо гарч байна. Манай нэртэй хуульч энэ талаар юу гэж хэлэв? «Ер нь 1990 оноос өмнөх үед тооны хичээлд сайн, толгойтой хүүхдүүд хуулийн сургуульд явдаггүй, гол төлөв тооноос зугтсан нь хуулийн сургуульд хуваарилагддаг байсан учир тэр үед бэлтгэгдсэн олонх хуульчид маань сэтгэх чадвар буюу одоогийн хэллэгээр IQ-н хувьд гологдох болжээ» гэсэн байх аж (Өдрийн сонин. 2004.07.29. №187).

Хуулийн сургуулиудад оюунлаг чанар гойд ихээр дутагдаж байх шиг, тийм сул орчноос сул л мэргэжилтэн гарна, тийм хүмүүс оюун сэтгэхүй шаардсан ажил, маргаан мэтгэлцээнээс зугтах атлаа бохир муухай хэрүүл уруулд дуртай байдаг. Тэд хоосон зар сурталчилгаа, хийсвэр хөнгөн амьдралыг шүтэх бөлгөө. Тэд авилга, хээл хахуульд гойд мэдрэмтгий нийгмийн онцгой бүлэг мөн.

Эрх зүйн дээд боловсрол олгодог сургуулиудын элсэлтийн шалгалтын агуулгыг өөрчилж, зах зээлийн жам голдрилд нь оруулмаар санагдана. Элсэгчдийн хоосон цээжлэх чадварыг бус, оюуны сэтгэх чадварыг нь илүү анхаармаар байна, энэ чинь дэлхийн жишиг, ингэж чадвал ядаж л хуульчдын хүйсний гаж харьцаа засрахсан. Хуульчдыг сонгон шалгаруулах ажил эхэлсэн нь сайн хэрэг. Шалгалтын материалыг нь үзэхэд, ихэвчлэн хуулийн яг таг мэдлэг, үг үсгийн байрлал хөөцөлдсөн, ерөнхийдөө яладаг хуульчдыг түлхүү дэмжих чиглэлтэй байх юм. Ингэж огтоос болохгүй. Үүнийг яаралтай засах ёстой, илүү сэтгэдэг нь хохирч, дутуу сэтгэдэг нь завшиж байж таарахгүй ээ.

Харин хууль зүйн үндэсний төвөөс саяхан бэлтгэсэн «Хуульчдын сорилгын

хураамж»-д Хуульчдын сэтгэх чадварыг шалгах ТЕСТ-ийг бүтэн бүлэг болгон оруулсан нь сайшаалтай. АНУ-д хуульчдын сэтгэх чадварыг 3 цаг 25 минут үргэлжилдэг LSAT (монголоор, хуульчдын сэтгэх чадварын тест) хэмээх маш сонирхолтой тестээр хөндлөнгийн, мэргэжлийн, биеэ даасан, хараат бус байгууллагаар шалгуулдаг байх юм. Ингэж байж шударга тодруулалт болдог ажээ.

LSAT шалгалт нь хуульч хүний зайлшгүй эзэмшвэл, зохих оюуны суурь чадваруудыг (логик болон аналитик шалтгаан, үндэслэл дэвшүүлэх чадвар, ээдрээтэй сэдвийг ойлгох, тэрхүү сэдвийн дотоод зөрчлийг нь гярхай мэдэрч гогцоог асуулт тавьж өрсөлдөгчөө сөхрүүлэх гэх мэт) шалгадаг юм.

LSAT шалгалтанд бүдэрвээс тэр хүнийг хуульч байхад оюуны чадвар нь дутна гэж үздэг байна. Тийм сул, сулбагар хүнд хуулийн сэлэм бариулвал мод чулууг ч голохгүй, хамаагүй аль тааралдсанаа цавчиж, хашгичиж, орилон аягүй бол өөрийгөө ч цавчих аюултай. Үүний уршгаар сэлэм хугарч ч мэднэ. Тэгвэл иргэдийн толгойд «хууль гурван хоногийн настай» гэсэн ойлголт бүрэлдэнэ, хууль нь гууль болно гэж ихэд сэрэмжилдэг байх юм. Эндээс хуулийг гууль болгогчид нь ард түмэн биш, хуульчид өөрсдөө байх магадлал харагдана. Би гайгүй гэсэн таван хуульчид дараах логик шалтгааны тестийг бодохыг санал болгосон бөгөөд хоёр минутын дотор зөв хариуг олох учиртай юм. Манай таван хуульч бодох нь бүү хэл, тестээ ойлгохгүй байсаар хугацаа дуусаж билээ. Энэхүү тест “Хуульчдын сорилгын хураамж”-ын 617 дахь хуудсанд байх бөгөөд сонирхуулбал: Гэрлэхээсээ өмнө хамт амьдарч байсан хосуудын салалтын түвшин нь гэрлэхийн өмнө хамт амьдарч байгаагүй хосуудын салалтын түвшнээс хоёр дахин өндөр байна. Ийнхүү гэрлэхийн өмнө хамт амьдрах нь хосуудын цаашид салахгүй байх боломжид сөргөөр нөлөөлж буйг баталж байна. Энэ тухай дараах таван хувилбарын аль нь бусдаасаа илүү нарийвчлалтай, бүрэн дүүрэн хариулт болох вээ?

A/ Хоёр нөхцөл байдлын хоорондын хамаарлын суурь дээр каузаль шалтгааны дүгнэлт хийсэн

B/ Зөвхөн салсан хосуудын баталгаан дээр бараг бүх хосуудыг хавтгайруулсан

C/ Амжилттай гэрлэсэн хосуудыг үл хайхарсан

D/ Хасах замаар нийтлэг содон шинжийг тусгаарлаж, энэ шинж нь судалгааны дүнтэй шалтгаанаар холбогдсон

Е/ Төлөөлөх чадваргүй загвар дээр нийтлэг дүгнэлт хийсэн.

Хуульч, шүүгчдийг сонгон тодруулах ажилд монгол хүний оюуны чадавхи, сэтгэлгээний чадваруудын асуудлаар мэргэжиж буй мэргэжлийн байгууллагыг хөндлөнгөөс нь оролцуулахгүйгээр, бүхнийг өөрөө хийж, бүх хариуцлагыг өөрөө үүрэх нь хоцрогдсон арга барил мөн. Хөндлөнгийн шударга үнэлгээ ашиглахгүйгээр, өөрсдөө өөрсдийгөө тодруулахад булхай гарцаагүй орж таарна, хүн л юм чинь, учирч байсан улаан нүүр, дахин учрах хүний нүүр байж л таарна. Тэр тусмаа хуульчид үүнийг бүр ч сайн мэднэ, ингээд л хуулиа хуульчид өөрсдөө завхруулах. эхлэл тавигдана, тавигдаж ч байна. Ийм байхад үг хэл яалаа гэж багасах билээ. Манай хуульчид, шүүгчид, ажил хариуцсан нөхдүүд хөндлөнгийн шударга үнэлгээнээс айн цэрвэх хэрэггүй мэт. Хөндлөнгийн үнэлгээ чинь зах зээлийн өөрийнх нь хэрэглэдэг үндсэн арга, илүү шударга байдаг учраас л хүмүүс ийм механизмийг олсон хэрэг, «ҮНЭН»-ээс бултах биш, «ҮНЭН»-рүү ойртъё, «ШУДАРГА»-аас дөлөх биш, «ШУДАРГА»-руу дөхье, ажил төрлөө цэгцэлье гэвэл ухрах биш, урагшлах учиртай.

Хуульч, шүүгчдийг сонгон шалгаруулахад хуулийн мэдлэг ч чухал, хууль хэрэглэх чадвар ч чухал, бүр чухал нь тэдний сэтгэх ерөнхий чадвар. Иймд хуульч, шүүгчдийг сонгон шалгаруулахдаа тэдний IQ, сэтгэх чадварыг нь илүүтэй анхаарч мэргэжлийн байгууллагын туслалцаа, оролцоог хөндлөнгөөс нь оновчтой зөв ашигламаар байна. Хуульчдын сорилгын хураамжийн оршилд «...Хуульчдыг сонгон шалгаруулдаг гадаад орнуудын практикийг ажиглахад тэдгээр оронд юуны өмнө хуульчдын сэтгэх ерөнхий чадварыг илүү чухалчилдаг байна. Ингэхдээ хөндлөнгийн, мэргэжлийн байгууллагын хяналтанд үндэслэдэг аж. Энэ нь хөгжингүй зах зээлийн зүй тогтол болохоор манай орны практикт нэвтрэх нь зайлшгүй гэжээ. Энэ бол дэвшил ойртсоны дохио, одоо ухарч, дүлэгнэж, гацаж огтоос болохгүй, эрчтэй урагшлах ёстой. Бидэнд хүн ялладаг “ангаахай” хуульчид хэрэггүй ээ, бидэнд бусдын тоглоом болдог бөмбөгөн хуульчид хэрэггүй ээ, бидэнд хуулийг амилуулдаг, хуулийн цоорхойг бусдад ашиглуулдаггүй, тодруулбаас хуулийг онож хэрэглэх өндөр чадвартай сэтгэдэг хуульчид л хэрэгтэй. Ялладаг хуульчийг Сэтгэдэг хуульчаар солих цаг болсон бус уу...? Эцэст нь, би вээр энэ удаад чадварлаг цөөн хуульч, гайгүй хэдэн багшийн хөдөлмөрийг ор тас үгүйсгэж байгаа юм биш шүү гэдгээ хэлье. Гагцхүү та нарыг маань үерийн бохир ус хаман авч шаварт хутган булингартуулах вий гэдгээс сэргийлж үүнийг бичивэй...

# **МОНГОЛЧУУД ТӨРӨЛХИЙН УХААЛАГ ГЭДГИЙГ ДЭЛХИЙ ДАХИН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРДӨГ**

---

81-р суваг 2003. № 11.12 (389-390)

*Танайхаас Монголын хамгийн өндөр IQ-тэй хүмүүсийг шалгаруулсан. Энэ ажил одоо цргэлжилж байгаа юу?*

Монголын төрөлхийн өндөр оюуны чадамжтай хүмүүсийг тодруулсан. Эдгээр хүмүүсийг бүтээлээр нь шалгаруулсан. Хүн төрөхдөө янз бүрийн оюуны чадавхитай төрдөг байна. Мянган хүний IQ нь 130-аас дээш байдаг, үлдсэн нь 70-130-ын хооронд байдаг. Хүмүүсийг багаас нь IQ тестээр шалгаад гаргах арга бий. Хамгийн гол нь IQ өндөртэй хүн бүтээлч байдаг. Би IQ өндөртэй хүн гээд юу ч хийхгүй бол тэр хүн хөгжихгүй. Иймд хүн төрөлхтөний төлөө, монголынхоо төлөө юм хийсэн байхад тэр бүтээлээс нь хүний чадавхи илт харагддаг бөгөөд хүн өөрийн чадварыг гаргаж чадсан болно. Жишээ нь П.Очирбат, Л.Түдэв, Х.Намсрай гэх мэтийн арван хүнийг тодруулж гаргасан.

*Манай улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат нилээд IQ өндөртэй хүнд тооцогдож байсан?*

П.Очирбат гуай төрөлхийн өндөр оюуны чадавхитай гэдгийг тодруулахдаа Монгол улс зах зээл рүү шилжих торгон үед төрийг маш сайн удирдсан. Энэ нь одоогийн төр удирдахаас илүү хүнд байсан. Энэ маш хүнд үед нэг ч хүний хамраас цус гаргалгүйгээр төрийг удирдана гэдэг тэр хүний төрөлхийн ухаан. Энэ нь тухайн хүнийг улс төрийн шинжлэх ухааны талаар дүгнэж гаргасан хэрэг. Мөн П.Очирбатыг дэлхийн 2000 шилдэг оюунлаг хүмүүсийн жагсаалтад бичсэн байдаг. Энэ номонд Монголоос ганцхан П.Очирбат гуайн тухай тэмдэглэж бичсэн байсан нь энэ хүний хэр оюуны чадавхитайг харуулж байгаа хэрэг юм.

*Нэг үеэ бодвол манайхан IQ-ийн талаар нилээд өндөр мэдлэгтэй болжээ. Үүнийг таны гавьяа зүтгэл гэхэд хүмүүсийн санал нийлэх байх. Энэ талаар та юу гэж хэлэх вэ?*

Өнгөрсөн зуун жил барууны өндөр хөгжсөн туршлага бол оюун ухааныг шүтсэнд байгаа юм. Өнөөдөр дэлхийн оюун ухааныг цуглуулах гэж Америкчууд

оролдож байна. Энэ утгаараа АНУ дэлхийн оюун ухаантнуудыг цуглуулж хөгжих гэж байгаа шүү дээ. Түүн шиг Монгол хүний оюун ухааныг хөгжүүлэх юм бол хаанаас ч хоолоо олж идэх чадалтайгаар үл барам Монгол орноо дээд зэргээр хөгжүүлж чадна. Монгол хүн унаган авьяас билэгтэй. Эрс тэс уур амьсгалтай Төв Азийн Чингисийн удмын Монголчууд бол төрөлхийн оюун ухаанлаг. Чингис бол оюун ухаанаараа төр барьж, өөртөө оюун ухаантай хүмүүсийг цуглуулж байсан. Сартуулуудыг хүртэл 12-р зуунд бүслээд авчихсан байсан шүү дээ. Тэдний үр сад болж хоёр ерөнхийлөгч маань хоёулаа сартуул гаралтай билээ.

***Хөдөө орон нутагт IQ-ийн талаар ямар бодлого явагдаж байгаа вэ?***

160 гаруй сумын сургуулиудад манай оюуны хөгжлийн клубууд ажиллаж байгаа. Энэ жил бид Монгол улсын хэмжээнд Сэтгэх Чадварын Улсын анхдугаар их уралдаан хийх гэж байна. Үүнийг ард түмэн, төр засаг маань дэмжиж оюун ухааны судалгаа хийгдэж байна.

***Манайхан энэ чигээрээ IQ-г хөгжүүлж хүн ардаа оюун ухаанжуулахын төлөө яг юуг анхаарвал илүү цр дүнтэй гэж та үздэг вэ?***

Хамгийн эхлээд монгол хүнийг оюунлаг эрүүл төрүүлэх явдал маш чухал байгаа. Өөрөөр хэлбэл цус холилдохгүй байх. Мөн архи тамхины хордлогогүй хүүхэд тээж төрүүлэх явдал. Дараа нь төрсөн эрүүл хүнийг оюун ухаанаар нь хөгжүүлэх үйл явц чухал. Ер нь оюун ухаан хаана их байна, тэнд хөгжил байдаг. Оюун ухаангүй газар бууралт, сөнөлт явагддаг.

***Та IQ-ийн талаар манай сониноор дамжуулан хүүхэд залууст юу гэж зөвлөмөөр байна?***

Бид төрөлхийн оюун ухаанлаг хүмүүс. Үүнийг дэлхий нийт ч хүлээн зөвшөөрдөг. Оюун ухаан бол газар бүхэнд гарч байдаг юм биш. Жишээ нь зарим газрын хүлэг хурдан, зарим газрын эмэгтэйчүүд царайлаг байдаг. Бүх газрын хүлэг хурдан биш, түүн шиг Төв Азийн энэ хэсэг дээр оюун ухааны шинэ тэсрэлт байгаа юм. Оюун ухаан бол бие хүнээр дамжин гардаг. Оюун ухаан 24 цаг ажиллаж чаддаггүй. 12 цаг амарч, 12 цаг ажиллаж байдаг. Ажиллаж байгаа үедээ харьцангуй дулаан 18-20 хэм. Шөнө амарч байхдаа хасах талдаа бол сайн байдаг. Шөнө нь хасах, өдөр нь нэмэх хэмтэй байна гэдэг маань хойд өргөрөг. Тэгэхээр манай орны энэ эрс тэс уур амьсгал

гэдэг тааламжгүй зүйл биш. Эндээс оюун ухааны шинэ түрлэг төрж буцалж гарах давуу талтай. Тийм учраас манай эцэг эхчүүдэд хандаж хэлэхэд хүүхдүүдээ, залуучууддаа оюун ухаанаа төлөвшүүлэн, хөгжүүлэх нь зүй ёсны хэрэг юм. Бид бүгд оюун ухаанжвал манай улс орон хөгжин дэвших нь зайлшгүй шүү дээ.

# **МЭДЛЭГТЭЙ МӨРТЛӨӨ СЭТГЭДЭГГҮЙ ХҮМҮҮСЭЭР МОНГОЛ ДҮҮРЧЭЭ**

---

Зууны мэдээ 2004.10.21 1249(1759)

*Сүүлийн үед IQ гэж их ярих боллоо. Үүнийг зарим хүн ойлгоход бэрх зүйл хэмээн тодорхойлдог. Та үүнийг энгийнээр тайлбарлана уу?*

IQ бол оюуны чансаа юм. Тодорхой аргаар хүний оюун ухааны чансааг тоон хэлбэрээр тогтоодог юм. Шатарчин Г.Каспаров тийм чансаатай, ийм өндөр чансаатай бөх гээд л ярьдаг шүү дээ. Ийм л энгийн зүйл.

*IQ ямар хэрэгтэй юм бэ?*

Та өөрийгөө хэр чадвартай оюун ухаантай хүн бэ гэдгээ мэдэхийг хүсэх нь лавтай. Үүнд IQ хэрэг болно.

*Улс орноо хөгжүүлэхэд мэдлэг, боловсролтой хүмүүс хэрэгтэй гэдэг. Манайд дээд боловсролтой хүн олон байна. Гэтэл тэдэнд улсаа хөгжүүлэх нь байтугай хийх ажил олдохгүй байна. Энэ ямар учиртай юм бол?*

Оюуны чадвар хүнд боломж байдлаар заяадаг. Энэ боломжийг хөгжүүлэх, эс хөгжүүлэх нь тухайн хүний мэдлэг, боловсролоос ихэд хамаарна. Мэдлэг бага бол яаж ч мэрийгэд хол явахгүй. Оюуны дажгүй чадвартай атлаа боловсрол нимгэн, үүнээсээ болоод хүн, малын тоосонд дарагдан амьдарч яваа эгэл борчууд олон байгаа. Үүнийг хэн хүнгүй харж, мэдэрч байгаа болохоор боловсролын араас хошуурсан юм. Мэдлэг боловсролыг үгүйсгэж болохгүй л дээ. Гэхдээ аливаа зүйлийг хэт туйлшруулахаар утгаа алддаг. Ийм л явдал болсон.

*Нэг л ойлгож өгөгхгүй юм. Хүн бүр өндөр боловсролтой байх муу зүйл гэж үү. Тэгвэл хоёр, гурван дээд сургууль төгссөн хүмүүс цагаа дэмий црсэн болж таарах нь ээ?*

Оюун ухаан боловсрол, сэтгэлгээ гурвыг хамтад нь хөгжүүлбэл илүү үр дүнд хүрдэг. Бид боловсролд голлон анхаарч сэтгэлгээг хөгжүүлэхийг мартсан. Энэ бол том алдаа. Бидний дунд дажгүй боловсролтой мөртлөө сэтгэлгээ муутай хүн олон байна. Дорж мэдлэг боловсрол сайтай залуу шүү, юу ч

асуусан хэлээд л өгдөг. Толгой ч гавал шүү. Даанч хувийн зохион байгуулалт байхгүй, байнга л архи уух юм хэмээн халагладаг. Мөн яаж ч үглээд хүмүүс ажлаа сайн хийхгүй юм, хүний төлөө бус өөрийнхөө төлөө амьдарч байгаа биз дээ гэсэн яриа алхам тутамд сонсогддог билээ. Энэ чинь өнөө сэтгэлгээг хөгжүүлэлгүй орхисны уршиг юм шүү дээ.

*Монгол хүнийг олон талын мэдлэгтэй, тэгсэн атлаа түүнийгээ хэрэглэх чадвараар сул гэж гадаадынхан шүүмжилдэг. Тэгэхээр энэ нь сэтгэлгээтэй холбоотой байх нь ээ?*

Яг зөв. Оюун ухаан сэтгэлгээ хоёрыг орхичихоод ганц боловсролыг, тэр тусмаа хийсвэрдүү хэлбэрийг нь туйлшруулан шүтчихээр ийм болсон хэрэг. Ийм улсын иргэд их ярьж, бага хийдэг, их үймүүлж, бага бүтээдэг гаж араншинтай болдгийг хүн судлалын шинжлэх ухаан аль хэдийнээ нотолчихсон. Үүний уршгаар тухайн улс дэлхийн хөгжлөөс хоцрон гээгддэг гэдэг нь гашуун боловч үнэн тодорхойлолт.

*Нэгэнт сэтгэлгээний тухай өгцүлж байгаа юм чинь хүний тархинд шууд бууж ойлгогдохоор ярилцъя. Та дээрх тайлбараа ямар нэг юмаар зүйрлэн тайлбарлаж болох уу?*

Бололгүй яахав.

*За тэгвэл хөгжил дэвшил бол хурд гэдэг утгаар нь монгол тархийг машинтай зүйрлэе, болох уу?*

Болж байна.

*Бидний тархи буюу монгол машин маань яаж ажиллаж байна вэ?*

Манай монгол машины эд ангиуд нь энд тэнд салан гээгдсэн, мотор нь ойрдоо дэгэн догон ажиллах болсон. Бас жолооч (сэтгэлгээ) байхгүй. Тэгсэн атлаа тэвшин дээр нь баахан ачаа аччихсан. Ачааны ихэнх нь хуучин таваар (мэдээлэл) байна. Та ийм машинаар ажил хийж чадах уу. Яахав, өнөө маргаашийг өнгөрөөсөн байдлаар ойр зуур явж болох юм. Харин хөгжлийн тухай санасны гарз.

*Өөрсдийгөө ийм болгочихсон гэдгийг бодоогүй юм байна шүү. Бүхнийг мэддэг гээд л цээжээ дэлдэж явдаг хүн монголд олон байгаа даа?*

Сэтгэлээр унаж болохгүй. Ямар ч хүнд нөхцөлд гарц байдаг юм.

*Яаж монгол тархийг хөгжлийн төлөө ажилладаг болгох вэ?*

Одоо энд л монголчууд хамтарч ажиллах хэрэгтэй. «Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй» гэдэг үгийн гол санаа энд л гарна.

Юуны өмнө машинаа засч сэлбэж тос, бензин хийж замд гарахад бэлтгэе. Манай монгол машин тийм ч муу биш шүү. Дараа нь жолоочоо (сэтгэлгээ) хайж олъё. Энэ нөхөр ихэд эмнэгшсэн байгаа. Тэгээд ачаагаа (мэдлэг, боловсрол) дахин сайтар шалгаж, хэрэг бага атлаа зай их эзэлдэг, хуучирч муудсан ачаагаа (мэдээлэл) шинээр сольё. Ингэсэн байхад монгол машин хол явна шүү.

*Хүн оюуны чансаандаа таарсан ажил хийх ёстой гэж япончууд ярьдаг юм билээ. Надад бол нэг л биелэмгүй санагдаад байх юм?*

Хүн оюуны чансаа, чадвараа хэр гэдгийг тогтоох нь өөрт нь төдийгүй улс орны хөгжилд тустай. Барууны өндөр хөгжилтэй орнууд иргэдийнхээ IQ-г тогтоож тусгай жагсаалт гаргасан байдаг. 111 онооны чансаатай хүн ийм ажил хийх боломжтой гээд л. Уг нь бид үүнийг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлага байна. Манайд хүн хийх ёстой ажлаа хийдэггүй. Зарим нь ажлаа ч мэдэхгүй, заримд нь ажил нь хөнгөдөөд л. Энэ бүхэн улсын хөгжилд тээг болоод байгаа юм.

*Манайхан мундаг боловсролтой болжээ. Харин энэ боловсрол амьдралд тус болж чадаж байна уу?*

Манайд зөвхөн мэдлэг өгдөг боловсрол байна. Гэтэл мэдлэгийг чадвараар баяжуулах ёстой байдаг. Хүүхдийг өөрөөр нь бодуулж, сэтгүүлэх арга илт дутагддаг. Америкт өөрөө сэтгэж байгаа хүүхдийг их үнэлдэг болжээ.

*Тэгвэл хүүхдийг өөрөө сэтгэдэг болгоё л доо. Хичээлийн хөтөлбөрийг нь өөрчлөөд, амархан хийчих ажил юм биш үү?*

Тийм амар ажил биш. Багш нар үүнд гол нөлөө үзүүлэх юм. Гэтэл тэд хүүхдийг хэн ч шаардахгүйгээр сэтгэдэг болохыг үнэн сэтгэлээсээ хүсэхгүй байна. Одоо дунд сургуульд ганц хариутай бодлого л боддог. Үүнийг нь нэг сайн хүүхэд самбарт гарч ирээд л боддог. Бусдадаа сэтгэх боломж өгөхгүй байна. Уг нь олон хариутай бодлого бодуулбал бүгдэд тустай. Хүүхдүүд залхууралгүй сэтгэнэ шүү дээ. Энэ чинь л жинхэнэ бодит мэдлэг болно. Амьдрал өөрөө баян. Гэтэл ганц хариу гаргадаг хүн яаж сайн сэтгэж амьдрах юм бэ. Бид хүүхдүүддээ ийм боловсрол олгочихоод сайн хүн бол гэж загнах эрхгүй.

*Хүн 16 нас хүртлээ оюун ухаан нь эрчимтэй хөгждөг, цүнээс хойш буурдаг гэсэн. Тэгвэл мэдлэг, боловсрол, сэтгэлгээ гурвын ялгааг дөнгөж сая мэдэрсэн хүн яах вэ. Оюун ухаанаа хөгжүүлэх найдваргүй болж байна гэсэн үг үү?*

Энэ ойлголт хуучирсан. Австрали, Австри, Германд хийсэн судалгаагаар өөр дүн гарсан. Тэгэхээр та санаа зоволтгүй. Хүний оюун ухаан тасралтгүй хөгждөг, бүр 40-50 насанд нь чадвар нь улам нэмэгддэг нь батлагдсан.

*Хүүхдийн тархийг багаас нь хөгжүүлэх хэрэгтэй гэж зарим эрдэмтэн ярьдаг. Гэтэл зарим нь хэт ачаалал өгч болохгүй гээд л үгүйсгэдэг. Багадаа ном их уншиж хичээлээ өдөр шөнөгүй давтсан хүүхдийн үс нь зулгарч унах төдийгүй их сонин сэтгэлгээтэй болсон байдаг л даа. Тэгэхээр эцэг, эхчүүд хаширлаад байх юм. Яг аль нь зөв юм бэ?*

Багаас нь сэтгэхүйг хөгжүүлж тархины багтаамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Үүнийг шинжлэх ухаан бүрэн нотолсон. Харин хэт их ачаалал өгч болохгүй. Зөв, сонирхолтой аргаар хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх ёстой юм.

*Шинжлэх ухаан нотолсон юм бол хүүхдээ «гамнаад» байх шаардлагагүй юм байна. Тэгвэл хүүхдээ яаж сургах ёстой вэ?*

Сэтгэн бодох чадвар шаардсан тоглоомоор наадуул. Би нэг, хоёр настай хүүхдийг ярьж байна. Хүүхдээ бага гэж битгий гол. Зарим тохиолдолд танаас илүү сэтгэдэг юм. Хүүхэд тоглоомоо эвдэлдэг ч юм уу, эсвэл өөр газар аваачаад тавьдаг. Үүнийг хориглох хэрэггүй. Хүүхэд сэтгэж байгаа юм шүү дээ. За тэгээд сургуульд орлоо. Хүүхдэд бага зэрэг мэдлэг өгнө. Тэгээд үүн дээр нь сэтгүүлж сургах ёстой. Гэтэл бид дөрөвдүгээр анги хүртэл нь сонирхолтой, сонирхолгүй олон хичээл заадаг, тархинд мэдлэг болж үлддэг нь маш бага. Барууны орны хүүхэд бага мэдлэгтэй ч хачин гоё сэтгэж байна.

*Явал хүүхэд сайн сэтгэж сурдаг юм бэ? Эсвэл төрөлхийн сайн сэтгэдэг хүүхэд гэж байдаг юм уу?*

Монголчуудад энэ огт хамаагүй зүйл. Яагаад гэвэл бидний тархи үнэхээр агуу. Иймд монгол хүүхдийг сайн сэтгэж сургахад бэрхшээл гарах ёсгүй юм. Гагцхүү монгол хүүхдийн сэтгэхүйд тохирсон сургалтын арга нэвтрүүлмээр байна.

*Хүмүүс тэгмээр байна, ингэмээр байна гээд л сайхан ярьдаг. Та тодорхой, хэрэгжиж болох арга нэрлэж чадах уу?*

Ер нь дэлхийн боловсролын практикт хэрэглэж буй гол арга бол номд байгаа мэдээллийг буцааж багшид хэлж өгөхгүй байх. Номд байгаа тэр мэдээллийг хүүхдийн тархинд хүчээр цавуудаж тогтоох хэрэггүй. Монголчууд цавуудаж тогтоох энэ аргын сонгодог жишээнд ордог. Багш нэг юм заадаг,

түүнийгээ үг үсэггүй цээжлүүлж яриулдаг. Тэгээд дүгнэдэг. Сайн цээжилсэн нь онц авдаг. Харин үүнийг эсрэг талаас нь бодсон хүүхдэд муу дүн тавьдаг шүү дээ. Ёстой л би заасан, тэр цээжилсэн болоод л өнгөрч байна. Үнэндээ бид байгалиас заяасан сайн тархитай тулдаа л ийм гажуудлыг бага боловч дааж Азийн зүрхэнд амьдарсаар байна. Бодит байдал дээр өндөр боловсрол, мэдлэгтэй мөртлөө сэтгэдэггүй хүмүүсээр Монгол дүүрчээ. Сэтгэхгүй бол хөгжихгүй гэж үг бий. Оюун ухааныг нь сэргээхгүй мэдээлэл өгч залхуу байдал бий болгоод байна. Гэтэл шатрыг хүмүүс залхууралгүй тоглоод л байдаг биз дээ. Ирээдүйн амьдралдаа бүрэн ашиглах мэдээлэл өгөх тийм хичээл оруулья.

***Бид гадны ололт, дэвшлийг шууд хуулбарлах нь зөв үү? Энэ асуудал их маргаантай байдаг юм л даа?***

Монгол хүний сэтгэхүйн хөгжлийн замыг зөв тавиад өгөхөд л болно. Тэртэй, тэргүй монгол сэтгэхүй тухайн ололтыг шууд хуулбарлахгүй. Монголчлох гэж үг бий. Энэ чинь жинхэнэ бүтээлч монгол сэтгэлгээ. Манайхан микро автобусны моторыг фургон машинд тавьж байна. Хурд гэж янзтай. Үүнийг харсан солонгосчууд ангайж байна шүү дээ. Эдүгээ еврей, монгол хүний оюуны чадвар агуу гэдгийг нэртэй эрдэмтэд хүлээн зөвшөөрчихөж.

***Еврей, монголчуудад төстэй тал бий юу?***

Үйлдвэрлэлд тун дургүй. Өөрөөр хэлбэл хар ажил хийх үнэн голоосоо дургүй гэсэн үг. Генд нь шингээстэй учир үүнийг өөрчилж чадахгүй. Харин хүний үйлдвэрлэсэн зүйл дээр тоглох дуртай. Хуучнаар панзчины сэтгэлгээтэй адил юм. Ингэж сэтгэдэг нэг хүн байх ямар ч ашиггүй. Харин бүгд ийм сэтгэлгээтэй болбол улс хожно.

***Уучлаарай, та бэлэнчлэх сэтгэлгээг сурталчлаад байгаа юм биш үү, гэтэл бид цүний эсрэг олон жил тэмцэж байгаа. Өөрсдөө бүх юмаа үйлдвэрлэж суръя гээд л. Гэтэл та цүнийг цүцүйсгэж байна?***

Аливаа зүйл хоёр талтай. Гагцхүү сөрөг талаа давуу тал болгож чаддаг байх хэрэгтэй. Үүнд монгол тархи тус болно. Ер нь монголчууд эртнээс тархиныхаа ачаар л түүхийн хуудаснаас арчигдалгүй амьдарч ирсэн.

***Та бэлэнчлэх сэтгэлгээний талаар хариулсангүй?***

Бид бусдаас илүү сэтгэх чадвартай тархитай байж хар ажил хийх хэрэг байна уу. Өөрсдийгөө зовоолгүй мөнгө олох олон арга байна. Жишээ нь, хоёр их хөршийнхөө үнийн зөрүүн дээр тоглож чадвал мөн ч их мөнгө олно. Энэ амаргүй нь мэдээж. Гэтэл үүнийг хийж чадах агуу тархи хэнд байна вэ,

бидэнд. Яг л Жорж Сорос шиг. Тэр ширхэг зүү ч үйлдвэрлэдэггүй. Харин мөнгөний ханш дээр тоглоод л их мөнгөтэй болсон нэгэн. Ажилчдынх нь олонх нь еврей нар. Агуу тархийг ашиглаж чадаж байна. Монголчууд хэзээ ч хятадууд шиг газар тариалан эрхлээд амьдрахгүй. Яагаад гэвэл, генд нь шингэсэн онцгой зүйл үүнийг хүсэхгүй байна. Жишээ авъя.. Малчин хүн сайн бэлчээр хайж явдаг. Хаана малаа бэлчээвэл сайн бол, дараа нь хаана бэлчээх вэ гээд тархиа ажиллуулж сэтгэж байна. Тэгж яваад сайхан ногоотой газар олно. Дараа нь өөр газар хайгаад л нүүчихнэ. Бэлэн юм хайж буйн нотолгоо шүү дээ. Гэтэл өнөөгийн шүүмжилж байгаагаар тэр малчин яах ёстой юм бэ. 100 метрийн цаахна сайхан өвстэй газар байхад би бэлэн юм хэрэглэхгүй гээд л хятадууд шиг өвс тариад суух болж байна уу. Монголчууд хэзээ ч ингэдэггүй л байхгүй юу. Байгаль бидэнд боломж олгож байна, тэр хэрээр тархи онцгой ажиллаж байна. Тэгэхээр бэлэнчлэх сэтгэлгээг арай өөрөөр тодорхойлох цаг болж.

*Даяаршил бидэнд ашигтай юу. Зарим хүн даяаршил жижиг улсад ямар ч ашиггүй. Бусдад уусаад алга болно гэдэг. Энэ талаар та юу хэлэх вэ?*

Сөрөг талыг нь давуу тал болгоход л бидэнд асуудал гарахгүй. Ингэх чадвар монголчуудад байна. Гагцхүү өөрсдөдөө итгэх хэрэгтэй. Би чадна, бүтээнэ гэж. Даяаршлын ачаар бүх юм тэр дундаа эдийн засаг нээлттэй болж байна. Улс хоорондын үнийн зөрүүн дээр ажиллах боломж нээгдлээ. Үнэ ханш, бирж, чанарын зөрүү гээд олон боломж байна. Ер нь бид анзаардаггүй болохоос бүх зүйлд зөрүү гардаг. Үүнд л монгол сэтгэлгээг ашиглая.

*Таныхаар бол бид биеэ зовоолгүй амьдраад байж болох нь ээ?*

Тэгэлгүй яахав. Бид гүйцэтгэх хар ажлыг нь биш, харин хэрхэн хийх аргыг нь зааж өгөөд суух ёстой юм. Энэ бол эцэг өвгөдийн минь бидэнд үлдээсэн үнэт эрдэнэ болох монгол тархины давуу тал.

*Монголчууд яаж сайн тархитай болсон юм бэ?*

Төв Азийн бүс нутаг бол бидний оюун ухааныг тэжээгч юм. Бид жилийн дөрвөн улиралтай, амьдрахад хэцүү юм гэж ярьдаг. үнэн хэрэгтээ энэ чинь бидний давуу тал. Байгаийн эрс тэс уур амьсгал бидний тархийг хөгжүүлж байна. Зун халуун л гэдэг. Хоёр, гурван сар дараалаад 30 хэм халуун болдоггүй биз дээ. Халуун ч биш, хүйтэн ч биш тийм сайхан налгар өдөр олон бий. Энэ чинь тархины эко орчинд сайн нөлөө үзүүлдэг. Төв Азид хүн үүссэн. Тэгэхээр

бүх юмны эх суурь нь (источник) бидэнд байна гэж ойлгоход хилсдэхгүй. Агаарт тэр, шороонд ч тэр байна шүү дээ. Оюуны генетик кодын эхлэл тавигдсан нутагт бид амьдарч байгаа юм шүү.

*Аливаа улсын хөгжилд хүн амын тоо нөлөө үзүүлдэг гэх юм. Уг нь олон хүнтэй болох тусам манайхны хэлдгээр хоолны сав нэмэгдэх юм биш үү. Энэ ямар учиртай юм бол?*

Монголчууд шиг ийм сайн тархитай ард түмэн хүн амаа өсгөх хэрэгтэйг барууны эрдэмтэд нотолдог. Гадаадад амьдарч байгаа монголчууд удахгүй буцаж ирнэ. Яагаад гэвэл, генд нь буй онцгой чанар нутагт нь дуудаж байна. Олонхи нь юм сураад Монголдоо буцаж ирэхийг хүсдэг юм билээ. Нэг л өдөр халуун ам бүлээрээ цугларч юу чаддагаа үзүүлж өгөх вий.

*Хэдэн хүнтэй болбол Монгол улс эрчимтэй хөгжих зам тавигдах вэ?*

Дор хаяж арван сая хүнтэй байх шаардлагатай. Үүнийг дагаад зах зээл ч нэмэгдэнэ, маш сайн сэтгэлгээтэй хүн ч төрнө.

*Тэгвэл ч сайхан л байна. Яг хэзээ ийм цаг ирэх бол?*

Тун удахгүй. Монгол хүний дахин давтагдашгүй генийн онцлог энэ хугацааг наашлуулж чадна. XIII зуунд монгол хүний тэр онцгой генийг байгаль дэлхий, сансар огторгуй ивээсэн. Энэ нь монголчууд дэлхийд ноёлох боломжийг тавьж өгсөн юм. Одоо энэ байдал давтагдах сайхан боломж гараад байна.

*Өв тийм үү, сонсоход их таатай байна. Ямар боломж юм бэ? Бид ашиглаж чадах болов уу?*

Даяаршил бидэнд ийм боломж олгож байна. Энэ чинь ямар ч өршөөлгүй жинхэнэ өрсөлдөөн. Одоо унаган давуу талтай хүн л ийм байдалд амархан дасан зохицож амьдарна. Интернет биднийг дэлхийтэй холбочихож байна. Мэдээлэл авах, ашиглах боломж бүрэн нээгдсэн. Маш олон мэдээлэл авна гэсэн үг. Түүнээс өөрт ашигтайг нь сонгож ашиглах чадвар бидний халаасанд байгаа. Одоо бидэнд нэг зүйл дутагч байна.

*Юу юм бэ?*

Биднийг чиглүүлээд өгөх сайн удирдлага, сайн засаглал хэрэгтэй байна. Тодруулбал, төрөө оюунжуулах шаардлагатай. Монголчууд ухаантай учир хэнийг дагахаа мэддэг. Одоо л төр, засгийн удирдлага маань зөв чиглүүлээд өгвөл хөгжих сайхан боломж гараад ирлээ. Энэ боломжийг алдвал бид сэргэн мандахаа дахиад л олон зуун жил хүлээх болно. Энэ бол бодит үнэн.

## *ЧИНГИС ХААНЫ СЕКСИЙН ЧАДВАР БА МОНГОЛЧУУД БИДНИЙ ИРЭЭДҮЙ*

---

Зууны мэдээ 2004.11.16 1271(1781)  
Зиндаа 2004. XI сар 137(93)

*Чингис хааны цр удмын талаар хэд хэдэн сонирхолтой материал барууны хэвлэлцүдэд нийтлэгджээ. Тухайлбал, Sunday Star Times сэтгүүлийн 2004 оны 6 сарын 20-ны дугаар, Kitchener-Waterloo Record сэтгүүлийн 2004 оны 8 сарын 9-ний дугаарын 631 цүтэй нийтлэл, New York Times сэтгүүлийн 2004 оны 6 сарын 13-ны 1172 цүтэй нийтлэл хэвлэгджээ. Тэдгээрийн заримаас уншигч танд товчлон сонирхуулъя.*

Оксфордын их сургуулийн голлох генетикч Брайан Сайксын “Adam’s Curse” номонд “Монголын эзэн хаан Чингис 40 жилийн турш Ази тив даяар маш олон эмэгтэйчүүдтэй холбоотой байсны нөлөөгөөр өнөөдөр түүний Y эр хромосомыг дэлхий дээр дор хаяж 16 сая хүн тээж явна. Эдгээр хүмүүс зөвхөн Ази тивд төдийгүй дэлхийн олон оронд байх боломжтой. Энэхүү Y хромосом нь эцгээс хүүд уламжлагддаг бөгөөд Ази тивийн янз бүрийн 16 газар орноос судлаачид эрэгтэй хүмүүсийн ДНК-ийн загварын шинжилгээ хийж, хүн амын 8 хувь нь ийм Y хромосомтой байгааг илрүүлээ. Чингис болон түүний цэргүүд нь замдаа таарсан эмэгтэйчүүдтэй сексийн өргөн холбоо тогтоодог байж. “ хэмээн бичжээ.

Генетикч Брайан Сайкес **“Чингис хаан бол хүн төрөлхтний түүхийн хамгийн амжилттай, Альфа эр хүн юм”** хэмээн дүгнэлт хийжээ ( Грек цагаан толгойн эхний энэхүү үсгээр англи хэл дээр нэг дүгээр зэргийн гэсэн утгыг давхар илэрхийлдэг.). **Чингисийн ген нь супер -Y төрөлд хамаарна хэмээн тэр үзэж байна.**

Зарим үндэстэн ястнууд өөрсдийгөө Чингисийн шууд угсаа гэж үздэг бөгөөд Афганистан, Пакистаны хил орчим нутагладаг Хазара үндэстнүүд ингэж тооцдог. Үнэхээр ч энэ үндэстний хүн амын барагцаалбал гуравны нэг нь ийм хромосомтой байдаг аж. Харин Чингисийн шууд угсаа Монголчуудын хувьд байдал ямар байна вэ?

Өнөөдөр Монголчууд бараг овоггүй байгаа. Гэвч Засгийн Газар нь иргэдээ шинэ нэртэй болохыг албадсан хууль гаргажээ. Монголчууд Чингис нэрэнд дуртай бөгөөд Улаанбаатарт гэхэд Чингистэй ижил нэртэй хүн 500 гаруй бий аж. Бас маш олон хүмүүс Чингисийн овгийн Боржигиныг овог болгож аваад байна. “ хэмээн бичжээ.

Сайкес үүний өмнө хэвлүүлсэн номондоо “Дэлхийн хүмүүс Төв Азийн гаралтай 7 эмэгтэйгээс анх үүсчээ” гэж бас дүгнэсэн юм. Чингис хаан албан ёсны 4 хүүтэй бөгөөд тэд нь эцгийнхээ бодлогыг уламжилж эзэнт улсаа өргөжүүлэхийг чармайж байжээ. Түүний хоёр ач хүү нь Монголын нутгийг Унгар, Польш хүртэл тэлж, Хятадын эзэн хааны гэр бүлийг үндэслэхэд хүртэл оролцсон юм. Өдгөө Ази тивийн иргэдтэй Канад, Америк, Англи, Австраличууд гэх мэт олон орны хүмүүс гэр бүл болохыг онцгойлон сонирхдог болжээ. Магадгүй 100 жилийн дараа, 2104 онд хүн амын дотор супер-Ү хромосомтой эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин улам ч ихсэх биз. Түүнчлэн хүмүүст ДНК-ийн шинжилгээ хийж, генийн санд бүртгэх үйл ажиллагааг хууль эрх зүй, боловсрол, генеалоги зэрэг олон салбарт зөвшөөрч ч магад.Магадгүй, Улаанбаатарт ийм Ү хромосомтой эрчүүдийн 7 хоногийн баяр ч зохиох байх...

Ингэж судлахад асар олон гишүүдтэй, гэр бүлийн, ураг удмын том холбоо гарч ирж ч болно. Нэг бэрхшээлтэй тал нь гэвэл Чингис хааны байлдаанч, хүчирхийлэгч зан араншин хүмүүсийн генээр дамжин удамших явдал юм. Хамаатан гэр бүлүүдийн хоорондын харилцаа зарим үед хүндрэн, зөрчил үүсч, Монголын цагдаа нарын ажил ихсэж ч болох. Чингисийн олон угсаатнуудын хэн нь Хятадын эзэн хааны суудлыг өвлөх, хэн нь Европ, Азийн хоорондын Торгоны замыг эзэмших талаар зөрөлдөж ч мэднэ... гэж өгүүлжээ.

Чингис хааны удам угсааны 16 сая эрэгтэй хүүхэд бий бөгөөд тэд нар өнөөдөр амьд, Чингисийн хромосомыг тээж яваа хэмээн генетикч баталж байна. Тэрбээр цааш нь бичихдээ “Чингисийг 65-тай нас барах үед эзэнт улс нь Өмнөд Хятадын тэнгисээс Персийн булан хүртэл үргэлжилж байв. Түүний хууль ёсны 4 хүү, 2 ач нь мөн л секс ажиллагаа хийж байлаа. Хубилай хаан нь Өмнөд Хятадыг хяналтандаа авч Хятад хаадын Юань ургийг бий болгожээ. “ хэмээн дурдсан байна.

Өнөөдөр генетикчид, судлаач нар Чингис хааны секс идэвхжилийн давтамж ба хөвгүүд төрөлтийн хоорондын холбоо хамаарлыг судалж, яагаад

хөвгүүд олон төрсний шалтгааныг хайж байна. Гэрлэлтийн эхний жилд гэрлэсэн хосууд сексийг илүү ихээр хийдэг байтал охидоосоо хөвгүүд олон төрсөн нь сонин. Зарим судлаачид “Богино хугацаанд сексийг олон удаа үйлдсэнээр эрэгтэй хүний цусан дахь тестостероны түвшин нэмэгдэж, Y хромосом давамгайлах боломжийг нэмэгдүүлдэг” гэж үзэж байна.

1980-аад онд Сайкс болон Оксфордын хамтран ажиллагч Роберт Хеджес нар эртний чулуужсан яснаас хүний ДНК-г гаргаж авах аргыг нээсэн юм. Энэ нь биологийн шинжлэх ухааны аргуудыг археологийн материалууд дээр хэрэглэн удамшлын тухай судлах боломж олгодог. Тэр үеэс эхлэн Сайкс хүний генетикийн түүхийг судлах ажиллагаандаа уг аргыг ашиглаж эхэлжээ.

...1000 жилийн дараа гэхэд Чингисийн Y хромосом нь амьд хадгалагдан үлдэж чадсанаар үл барам олширч чадсан байна. Генетикчид эволюцийн хөгжлийн диаграммыг судлах явцад Y хромосом олон удаа давтагдан таарч байжээ.

Өнөөдөр зарим судлаачид Y хромосом ирээдүйд устаж алга болно гэж үздэг байна. Тэд “энэ хромосом нь бусад хромосомын адилаар бусадтайгаа нэгдэж чаддаггүй. Энэ хромосом нэг эрэгтэйгээс нөгөө эрэгтэйд дамждаг ч генетикийн хувиргалт хийх замаар мутацийн (мутаци гэдэг нь амьд эсүүдийн дотор явагддаг өөрчлөлтүүд юм.) үйл явцыг өөрчлөн засаж чадахгүй. Түүнээс гадна Y хромосом бол бусад хромосомтой харьцуулахад мутацийн өндөр зэрэглэлтэй бөгөөд эрэгтэй хүний germ шугамын эсүүд болон тэдгээрийн ДНК нь эр үрийн шингэний гаргалтыг хэвийн байлгахын тулд маш хурдан хуваагдаж байдаг. ДНК хуваагдах үед мутацийн ихэнх ажиллагаа явагдана. Ийм болохоор Y хромосом нь тогтвортой биш” хэмээн дүгнэж байна.

Мэргэжилтнүүдийн тооцож үзсэнээр 125 мянган жил буюу ойролцоогоор хүний 5000 үеийн дотор эрэгтэй хүний үр удмаа үлдээх дундаж чадвар одоогийнхоос нэг хувиар илүү байсан аж. Харин Y хромосомтой мутаци явагдахад эрэгтэй хүний үр удмаа үлдээх чадвар буурдаг нь тодорхой болсон байна.

Саяхан Японы судлаачид эрэгчин хулганы оролцоогүйгээр, хоёр өндөгний нэгдлээс хулгана гаргаж авлаа. Партногенетикийн аргаар сүүн тэжээлтнийг хуулбарлахаас хамгаалдаг hitherto бүхий генетикийн ул мөр гэж нэрлэгддэг системийг өөрчлөх боломжтойг энэ туршилт харуулж байна. Ирээдүйд хүмүүс ч бас хоёр өндөгний нэгдлээс төрөх боломжтой. Гэхдээ эсийн хуулбар хийх

замаар биш. Төрүүлэгч нь хоёулаа эмэгтэй байсан ч тэдгээрийн генийг янз бүрийн хэлбэрээр нэгтгэн огт өөр шинэ хүнийг бий болгох боломж бий. Эрэгтэй хүнтэй амьдардаггүй, ижил хүйстэн эмэгтэйчүүд ч ийм замаар дундаасаа төрөх хүүхдийн биологийн төрүүлэгчид болох боломжтой юм байна.” хэмээн уг нийтлэлд бичжээ.

Чингисийг судлаач Jack Weatherford-ын дүгнэснээр “Чингис хаан байлдахдаа “Дайн гэдэг бол тэмцээн биш юм. Хоёр хүний хоорондын амь өрссөн тулаан. Дүрмээр тоглодог хүнд ялалт ирэхгүй. Дүрмээ өөрөө зохиож түүнийгээ өрсөлдөгчдөө тулган хүлээлгэж тоглож чадвал ялалт ирдэг.” гэж сургадаг байж. Гэтэл Иракт явуулсан дайныг нэг хэсэг нь дэмжиж, нөгөө хэсэг нь эсэргүүцэн, хуваагдмал байдалтай байгаа Америк өнөөдөр Осам Бин Ладен болон түүний алан хядагчидтай тэмцэхдээ хуучин дүрмээр тоглосоор байна. Тиймээс ч дийлэхгүй, дийлдсээр байна... гэх зэргээр эдгээр нийтлэлд өгүүлсэн ажээ.

Монголын Ирээдүй Судлалын нийгэмлэгийн ажлын хүрээнд эдгээр нийтлэлийг анхааралдаа авч, нийтлэлд өгүүлсэн баримтууд нь монгол хүний, монгол улсын ирээдүйтэй хэрхэн холбогдох талаархи судлаачдын саналыг сонсох зорилгоор дараах асуудлыг та нөхдийн анхааралд дөхүүлж байна.

1. Брайан Сайкес, Роберт Хеджес нар бол мэргэжлийн генетикч- судлаачид юм, Тэд эрдэмтний ёс зүйг л баримталдаг хүмүүс, тэд нар судалгааны үр дүнгээ хэн нэгний таашаалд нийцүүлэх, эсвэл аль нэгэн хоцрогдсон үзэл суртлаар баглан хүлж, өөрөө өөрийгөө егүүтгэдэг “эрдэмтэд” биш юм. Эдгээр нэрт гарвал зүйч- судлаачдын ажилд манай эрдэмтэд хүндэтгэлтэй хандана гэдэгт найдаж байна.
2. Дэлхийн хүмүүс Төв Азиас гаралтай 7 эмэгтэйгээс үүсэлтэй гэдгийг мөшгөвөл ямар дүгнэлтэнд хүрэх бол? Монголчууд төв Азид нэн эртнээс суурьшсан унаган, уугуул хүмүүс үү, эсвэл энэ нутагт уул гүвээг даван нүүж ирсэн суугуул хүмүүс үү? Манай эрдэмтэд монголчуудын гарал үүслийг судлан тодруулахдаа голдуу түүхэн талаас нь, түүхийн янз бүрийн сурвалж бичгийг ашигласаар өдгөө хүрлээ. Сурвалж бичгийг хүн л бичнэ, тэр хүнд тухайн цаг үе нь нөлөөлж таарна, . ингээд монголчуудын гарал үүслийн талаар олон янз сурвалж бичиг зохиогдсон биз, зохиогдсон юм чинь зохиол л байж таарна. Тэгэхлээр, түүхийн сурвалж бичгүүдийг жинхэнэ шинжлэх ухааны суурь өгөгдөхүүн-материалуудаар тухайлбал,

гарвал зүйн судалгаагаар баяжуулан арвижуулбаас ҮНЭН-д ойртох магадлал эрс нэмэгдэнэ, ингэж байж монголын түүх судлалд шинжлэх ухаанч хандлага нэвтэрч, та бид олон ҮНЭН-ээс нэг ҮНЭН-рүү хазайх учиртай.

3. Хромосом дотор организмын удамшин өвлөгдөх шинж чанарыг тээгч ДНХ(дезрибонуклейны хүчил) агуулагддаг. Ингэхлээр Чингисийн супер Y хромосом гэдэг нь Тэмүүжингээс аль өмнө байж, магадгүй Чингисийн үед идэвхжиж, мутацид орж, шинэ өвөрмөц чанартай болсон, тэгээд ДНХ дотор нь батжин суурьшиж, улмаар хойч үед нь удамшиж буй тийм онцгой шинж бүхий хромосом байх. Монголын нууц товчоонд Тэмүүжингийн угшил Бөртэ чинуас эхэлдэг. Цаашлаад Лу Алтантовч-д өгүүлснээр “...үнэн худлыг ялган засаглагч, сайн аашт, өнгө сайт Маха Самади хаан”-д хүрдэг. Ямар ч байсан удам сайт. Түүнээс чинагш дурандвал, тэртээ алсад СҮМЭР-ийн соёл иргэншил сүүмэлзэнэ,... үүнийг хөөвөл мөн ч их юм байгаадаа, ...тэр их юманд сэтгэж л хүрнэ...Энэ бол сэтгэдэг, бясалгадаг түүхчийн хийх ажил. Сэтгэгч Пьер де Шарден “...хүн говиос үүдэлтэй..” гэсэн бол Айвор Монтагью “...Монголын түүхэн нутаг нь үндэстнүүдийн эх хэвлий...” гэжээ. Ч.Эрдэнэ “...европын соёл нь бүхэлдээ Грекээс угшилтай..” гэж 10-аад жилийн өмнө бичиж байв, сэтгэн бясалгасаар, ухан уудалсаар саяхан “..Өвөг монгол метафизик ба эртний грекийн шинжлэх ухаан нэг угшилтай байж магад сонин сэжмүүд байх бөгөөд цаашид нарийвчлан судлах ёстой. Жишээ нь, зөн билиг, зохирлын ухаанаас эхлээд мал аж ахуй, нум агсахуй, нүүх суухын эрдэм хүртэл салаа салбаруудыг ивээн хариуцсан грек-ромын нэн алдарт Аполло бурхан угтаа Бөртэ Чинуа-аас угшилтай гэх язгуур домогтой бөгөөд үнэхээр Зеус-Хасын үр зөвхөн Монгол Алтай, Хангайн уул хадны сийлбэр дурсгалуудад үй олноор цогцлон хадгалагджээ...” хэмээх дүгнэлтэд хүрсэн байх аж. Түүхэн Монгол нутаг бол их замын эхэн, их аяны өлгий, соёл иргэншлийн хэвлий байх магадлал эндээс харагдана, ямар ч атугай, өөрийн үндэс угсаагаа дутуу үнэлэх нь хэтрүүлэхээс долоон дор гэдгийг тэмдэглэе, ялангуяа, өнөөгийн монголчуудын хувьд тун чухал, ...бөхийж, бөгтийж, хоцорч, хохирч явснаас гэдгийг, гийж, сэтгэж, сэргэж явцгаая.

4. Чингис, түүний удмынхан ялан дийлэхийн ид хавыг амсаж толгой гэдгэр явсаан, гэхдээ хүчинд автсан бусад ард олныг тэгтлээ хэрцгийгээр яргалан хороож байгаагүй гэдгийг Оксфордын генетикч нотолж байх шиг, харин ч манайхан тэдэнтэй ах дүүгийн гүн бат холбоо тогтоож, эзэнт гүрнийхээ цаашдын он удаан жил оршин тогтнох суурь үндсийг тавьцгаасан нь баримт юм. Тэд амгалан тайвныг хүснэ, манайхан засаглалаа удаан хадгалахыг хүснэ, хоёр талын сонирхол ингэж нийлнэ. Мэдээж хэрэг, тэдгээр ард түмэн нуруулаг туруулаг охид, царайлаг өнгөлөг бүсгүйчүүд, оюунлаг ухаалаг хүүхнүүдээсээ эхлээд аль л өнгөтэй өөдтэйгээ шилж сорчлон Чингисийн баатруудад бэлэглэн өгч ая тал засаж, бас үндэс угсаагаа сайжруулах далд бодлоор худ ураг болцгоож байжээ. Энэ бол хүний л ёс, хүргэн сайт хүйтэнд дажрахгүй гэдэг бусуу, баатар зоригт хүргэнтэй болдоггүй юмаа гэхэд галын зээтэй хоцорвол хоёр хөгшин хожих бус уу? Чадал муут нутгийн залууг хүргэн гэж царайчилж байхын оронд чадал сайт монгол эрийн хөлд суух нь өлзийтэй, өгөөжтэй байж таараа, ...тэгээд ч нутгийн эрчүүд нь манайханд ялагдахаараа ийш тийшээ ум хумгүй зугтан зайлаа байлгүй. Ийм замаар супер Y хромосом тархжээ, ингэж нэгэн төрлийн генийн сонгон шалгаруулалт явагджээ.
5. Монгол хүний тархи **хэмжээгээрээ** дэлхийд тэргүүлж байгаатай энэхүү Y хромосом холбоотой юу? Монгол хүний тархи дунджаар 1382 грамм, монгол европын хольцтой Ленин мэт нь 1340 грамм, цэвэр европ цусныхан 1330 грамм, халуун орныхон 1280 грамм тархитай гэнэ. Тархины хэмжээ, оюуны чадамжийн хооронд корреляц хамаарал байдаг нь илэрхий, харин тодорхой тохиолдолд ийм биш, тодорхой ганц нэг тохиолдлыг ерөнхийтэй хутгаж, үзэл сурталжуулан завхруулж, сэтгэл зүй болон удамшил (гарвал) зүйн ухааныг улс төржүүлэх хандлагаас ангижрая.
6. Чингисийн супер Y хромосом нь гагцхүү эр талаа л дагаж өвлөгддөг аж, энэ нь манай монгол овгийн уламжлалтай тохирч байх шиг, цагаан ястантайж гэдэг нь Y хромосомын өвлөгдөх чанартай хэрхэн холбогдох бол?
7. Монгол Улсын Оюуны чадварын IQ төвөөс санаачилсан “Оюуны хөгжил-IQ” хичээл, энэ чиглэлээр өрнүүлж буй үйл ажиллагаа жирийн монгол хүний сэтгэлд дотносон нийцэж, эрчээ авч улс орныг нэлэнхүйд нь хамарлаа, **ЯАГААД ИНГЭВ?**, шинийг эсэргүүцдэг, хөгжлийг чаргуудан чангаадаг хэмээгдсэн энэ ард түмэн яахаараа ингэж огцом идэвхжив?

20-р зууныг дуустал хүн төрөлхтөн үндсэндээ махбод болон эрчмийг шүтэж, түүний төлөө бүхий л хүч нөөцөө шавхаж байлаа. Гэтэл монгол хүн угаасаа махбод, эрчмийн төлөө тэгтлээ шүлэнгэтэн зүтгэж байсангүй ээ, баян нэг зуданд, баатар нэг суманд, эдээр биеэ чимэхээр эрдмээр биеэ чим гэх зэргээр хэлэлцэх бөлгөө. 21-р зуунд хөгжлийн тухай ойлголт гүнзгийрч, хүн төрөлхтөний сэтгэлгээ махбод-эрчмийн цаана байгаа **оюун ухаан** —руу чиглэх болов, Энэхүү оюун ухааныг эрхэмлэн дээдэлж, **оюуны баялаг —ийг эдийн баялаг-аас** илүүд үздэг нь монгол хүний суурь өгөгдөхүүн ажээ. Ийнхүү эрин үеийн дуудлага, монгол хүний унаган чанартай нийцэж байх мэт.

8. Германы тархи судлаач О.Фогтс “...хэрвээ байгаль цаг уурын ноцтой өөрчлөлт гарахгүй бол монголчууд 21-р зуунд оюун ухааны чадамжаараа дэлхийд тэргүүлнэ” гэж өнгөрсөн зууны дундуур бичиж байж. Тэгвэл, хагас зуун жилийн дараа буюу 2002 оны байдлаар, Умард Ирландын сэтгэл судлалын профессор Ричард Лунн, Финляндын улс төр судлалын профессор Тату Ванханен нарын судалгаагаар Монгол улс дэлхийн өндөр IQ -тай орны ангилалд багтсан төдийгүй Монголчууд оюуны чадавхиараа дэлхийд тэргүүлэх боломжтой нь нотлогдлоо..( RICHARD LYNN and TATU VANHANEN. **IQ and the wealth of nations.** Praeger. Westport Connecticut London. 2002 ) .Энэ бүхэнтэй Оксфордын гарвал зүйчдийн судалгааны үр дүнг холбож монгол уншигч та дотор хүнтэйгээ ярилцана уу.
9. 21-р зуун бол Азийн зуун. Азид бидний монголчууд оюуны чадамжаараа яагаад ч бусдаасаа доогуур орохгүй нь илэрхий, учир гэвэл, хятад хүн “...хай, 1 монгол 3 хятадтай тэнцэнэ, гэхдээ 3 монгол нийлэхээрээ 3 хятадад ялагдана...” гэх, ийм санааг япон, солонгосчууд ч бас хэлэх. Тэгэхлээр, монголчууд та бид толгой гэдгэр, харц дээгүүр байж, ая эвээ хичээвээс тэнгэрийн цаг өөрөө морилон ирэх нигууртай биш биз? Монголчуудын тэнгэрийг шүтэх үзлийн уг сурвалж нь домог бясалгалын гэхээсээ илүүтэй энэхүү супер Y хромосомтой холбоотой байж мэднэ. Үнэхээр ч супер Y хромосом бол аргагүй л тэнгэрийн бэлэг- байгалын хишиг мөн, мөнх тэнгэрийн хүчин дор-их суу залийн ивээл дор гэх нь гарвал зүйн ухааны үндэстэй байж болох уу?
10. Хүний хөгжлийн ирээдүй маш сонирхолтой болж байна, тухайлбал, хүнийг

хувилах, хоёр эмэгтэйгээс хүн буй болгох, нано технологиор хүний насыг уртасгах, хүнийг үйлдвэрлэх гэх мэт. Үүнээс үүдэн сүүлийн үед энэ мэт ажилбаруудын сөрөг үр дагаварыг багасгах, хүний унаган давуу талыг хадгалан мөнхжүүлэх, эдгээр салбарыг зөв ёс суртахуунтайгаар хүний өөрийнх нь төлөө хөгжүүлэхэд эрдэмтэд анхаарлаа хандуулах болов. Ийм эгзэгтэй үед монгол хүнд хадгалагдаж буй хүний удамшлын онцгой давуу талуудын үнэ цэнэ нэмэгдэх төдийгүй хүн-хувилал болон хүн-үйлдвэрлэлд эх материал болохыг ч үгүйсгэх аргагүй. Үүнээс бид цэрвэх бус харин ч давуу талаа товойлгон зоригтой оролцвол онох биш биз? Манай судлаачид айдас хүйдэснээсээ салж, цаг үеэ мэдэрч, арай дөмөгхөн хөдөлж зоригломоор санагдана, алийн болгон үзэл суртлаар өөрийгөө баглан хүлэх юм?, хэнээс, юунаас айж бэмбэгнэн хулчигнах юм?,...өрөө төлчихсөн,... одоо бусдаас, тэр тусмаа өөрсдөөсөө доогуур оюуны чадавхитай хүмүүсээс эмээж, тэдний амыг харж байж дуугарах бодит шаардлага байхгүй ээ.

11. Монгол эр хүн “Би чамаас яавч дутуу биш, би Чингисийн удмынх, миний дотуур Чингисийн цус урсаж байна” хэмээн цээжээ балбах нь олонтаа. Үүний ард ямар нэгэн генээр өвлөгдсөн онцгой чанар байгаа биш биз?, ингэж цээжээ балбах нь үндэстэн бүрт байх ерөнхий шинж үү?, эсвэл монгол хүнд л байна уу, монгол хүнд тийм нэг бусдаас давуу, эрмэг шинж өөрт нь мэдрэгдээд байгаа биш биз? ”Монголын хүн амын генийн сан“ бүтээлийн тэргүүн боть “ Удамшлын полиморф хэлбэршил ба генийн давтамжууд“ нэрээр хэвлэгдлээ, Ази тивийн монгол төрхтнүүд болон Америкийн индианчуудын генийн сан нь өнөөгийн монголчуудын өвөг генийн сангаас энэ монгол нутагт үүссэн болох нь тогтоогдлоо, цаашлаад монголчууд үндсэндээ хоёр ээжээс үүсэлтэй байж болохыг манай мэргэжлийн генетикчидийн судалгаа харуулав. Америкийн индианчуудын оюуны чадавхи тухайн бүс нутагтаа хамгийн өндөр болох нь батлагдсан байна. Энэ бүхний ард юу байна вэ?

12. XXI зуун бол Оюун ухааны эрин бөгөөд энэ цаг болвоос Монголчуудын сэргэн мандлын үе гэж үндэсний судлаачид дүгнэж байна. Энэ нь жирийн нэг таавар уу? эс бөгөөс жирийн бус зөн совин уу?

Ард түмэн бол хүүхэд л гэсэн үг, ухааруулах, удирдахад арга хэрэгтэй гэж мэргэд сургажээ, манай үеийн оюунлаг хүмүүс (хуучнаар бол сэхээтнүүд)

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ УХАМСРЫГ СЭРГЭЭХ, БЭХЖҮҮЛЭХ ТАЛ ДЭЭР ХОЛЫН ХАРААТАЙ, УХААЛАГ ЧИГ БАРИМЖААТАЙ БАЙЖ ГЭМЭЭ НЬ ДАЯАРШЛЫН ШУУРГАНД БИД ХАМТДАА АЖРАХГҮЙ ХЭМЭЭН БОДОХ ЮМ.

Эцэст нь энэхүү материалыг бэлтгэхэд туслалцаа үзүүлсэн Монгол улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны ажилтан, Адуучин Боржгин Баярбатын Очирбат, Хан –Уул дээд сургуулийн багш Х.Энхбат нарт талархлаа илэрхийлье.

## ГАРЧИГ

ОЮУН УХААНЫ ЧИГЛҮҮЛЭГЧ.....	3
МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭЭ!.....	7
МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫГ ОЮУНЖУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛД.....	10
БҮТЭЭЛЧ БУС, ХИЙСВЭР АКАДЕМИК БОЛОВСРОЛООС БҮТЭЭЛЧ БӨГӨӨД ОЮУНЛАГ ЧАДВАРЫН БОЛОВСРОЛ РУУ.....	18
БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ХОМСДОЛ.....	28
ГАДНЫХАН МОНГОЛЧУУДЫГ АМЬТАНЛАГ СЭТГЭХҮЙТЭЙ ГЭЖ ДҮГНЭДЭГ.....	33
ОЮУН УХААН, СЭТГЭХ ЧАДВАР БА МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫН ХОЛБООНЫ ТУХАЙ.....	37
ОНОЛЫН ХУВЬД МОНГОЛЫН 2 САЯ 400 МЯНГАН ХҮН ДОТОР АУГАА СУУТАН БАЙХ МАГАДЛАЛ МАШ БАГА.....	42
ТАМД БАЙДАГ МОНГОЛЧУУДЫН ТОГОО МАНААЧГҮЙ БАЙДАГ НЬ ЛАТЕРАЛ СЭТГЭЛГЭЭНД СУРАЛЦААГҮЙНХ . . .	48
ЧИНГИС ХААНЫ ОЮУНЫ ИЛТГЭЦҮҮРИЙН ДООД ХЭМЖЭЭ 204 ГЭДГИЙГ МОНГОЛД АНХ УДАА ТОГТООЖ ЗАРЛАЛАА.....	53
ХҮН БҮРИЙГ ЛАТЕРАЛ СЭТГЭЛГЭЭНД СУРГАЯ.....	56
ӨӨРИЙГӨӨ БОДДОГГҮЙ ХҮН ХҮН БИШ.....	59

УИХ-ЫН ГИШҮҮДИЙН ОЮУНЫ ЧАДВАРЫГ ТОГТООЖ ОЛОНД ЗАРЛАХ ХЭРЭГТЭЙ .....	63
ХУУЛЬЧИЙН ҮНДСЭН ЗЭВСЭГ НЬ ОЮУН УХААН СЭТГЭХ ЧАДВАР МӨН .....	68
ЭМЭГТЭЙ ХҮН НӨХРӨӨСӨӨ ДЭЭГҮҮР IQ-ТЭЙ БОЛ ӨӨРТ НЬ НӨМӨР БОЛОХООР ИЛҮҮ ЭР ЛҮҮ ШИЛЖЧИХДЭГ .....	70
МИНИЙ IQ-Г АРД ТҮМЭН Л ТОГТООНО .....	75
МОНГОЛ УЛС ДЭЛХИЙН ӨНДӨР IQ-ТЭЙ (ОЮУНЫ ЧАДАВХИТАЙ) ОРНЫ АНГИЛАЛД БАГТЖЭЭ .....	86
МОНГОЛЧУУД ОЮУНЫ ЧАДАВХИАРАА ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ .....	92
МОНГОЛЧУУД ОЮУНЛИГ ХҮМҮҮС .....	96
ҮНДЭСТНИЙХЭЭ ОЮУНЫ ЧАДВАРЫГ IQ ТЕСТЭЭР ШАЛГАЖЭЭ .....	101
МОНГОЛ ХҮНД ОЮУНЛАГ СПОРТ Л ИЛҮҮ ОЙР .....	105
БОЛОВСРОЛЫН ХУВЬСГАЛ ХАЯАНД ИРЛЭЭ .....	110
ЯЛЛАДАГ ХУУЛЬЧДЫГ СЭТГЭДЭГ ХУУЛЬЧДААР СОЛЪЁ .....	114
МОНГОЛЧУУД ТӨРӨЛХИЙН УХААЛАГ ГЭДГИЙГ ДЭЛХИЙ ДАХИН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРДӨГ .....	119
МЭДЛЭГТЭЙ МӨРТЛӨӨ СЭТГЭДЭГГҮЙ ХҮМҮҮСЭЭР МОНГОЛ ДҮҮРЧЭЭ .....	122
ЧИНГИС ХААНЫ СЕКСИЙН ЧАДВАР БА МОНГОЛЧУУД БИДНИЙ ИРЭЭДҮЙ .....	129